

# ПОЛИТОЛОГИ XVII

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№17 (505)

XVII

ISSN 2227-6904

Key title: Политологи

## РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ:

**Эрхлэгч:** профессор Ж.Төртогтох  
**Нарийн бичгийн дарга:** доктор Ц.Батболд  
**Гишүүд:** профессор С.Базарпүрэв  
доктор Д. Бумдарь  
профессор Ц.Ганболд  
профессор Ё.Довчин  
дэд профессор Ц.Мөнхцэцэг  
доктор Д.Мягмарсүрэн  
дэд профессор Ч.Өлзийсайхан  
дэд профессор Я.Төгөлдөр  
доктор Д.Ундрах  
доктор Г.Цэнд-Аюуш

**Техник редактор:** Т. Есүхэй

## Хаяг:

Улаанбаатар хот, Залуучуудын өргөн чөлөө, МУИС-ийн хичээлийн II байр  
Шинжлэх Ухааны сургууль, Улс төр судлалын тэнхим

**Утас:** 976 - 75754400 (2317)

# **POLITOLOGY XVII**

**SCIENTIFIC JOURNAL**

**№ 17 (505)**

**XVII**

**ISSN 2227-6904**

Key title: Politology

## **EDITORIAL BOARD**

- Editor in chief:** Turtogtokh Janar, National University of Mongolia
- Secretary:** Batbold Tserendash, National University of Mongolia
- Board members:** Bazarpurev Sambuu, National University of Mongolia  
Bumdari Dagva-Ochir, National University of Mongolia  
Ganbold Tseren, National University of Mongolia  
Dovchin Yondon, National University of Mongolia  
Munkhtsetseg Tserenjamts, Mongolian State University of Education  
Myagmarsuren Dashzevge, National Academy of Governance  
Ulziisaikhan Chuluun, National University of Mongolia  
Tuguldur Yanjiv, Mongolian University of Science and Technology  
Undrakh Davaadorj, National University of Mongolia  
Tsend-Ayush Galsanpiljee, National University of Mongolia

**Technical Editor:** Yesukhei Tumurbaatar

**Address:** Department of Political Science, School of Arts and Sciences, National University of Mongolia, Zaluuchuud avenue, Ulaanbaatar, Mongolia

**Phone:** 976 – 75754400 (2317)

# ПОЛИТОЛОГИ XVII

Эрдэм шинжилгээний бичиг

№ 17 (505)

---

## АГУУЛГА

- 5 Өмнөх үг
- 6 Тогтвортой хөгжлийн талаарх тодорхойлолтууд, тэдгээрийн онцлог  
*С.Базарпүрэв, Б.Насанбат*
- 17 Үндэсний ухамсрыг судлах онол, арга зүй  
*М.Мөнхзул*
- 22 Монгол дахь иргэний хөдөлгөөний асуудлыг онолын үүднээс авч үзэх нь  
*Ц.Батболд, Б.Батбаатар*
- 50 Иргэний нийгмийн байгууллагын санхүүжилтийн зарим асуудалд  
*Ё.Довчин, Г.Адъяадэлгэр*
- 59 Сонирхлын бүлэг улс төрийн бодлогын субъект болох нь  
*Г.Цэнд-Аюуш, Н.Ариунаа*
- 65 Парламент хоёр танхимтай байх асуудалд  
*Г.Цэнд-Аюуш, Д.Сүхболд*
- 75 Улс төрчийн эрх зүйн ба ёс зүйн хариуцлага: Зааг ялгаа, ач холбогдол  
*Д.Оюунчимэг, Д.Ундрах*
- 83 Ардчилсан сонгуулийн үндсэн зарчим, хэрэгжилт  
*Д.Түмэнжаргал*
- 102 Гадаад бодлого ба дипломат ажиллагааны харилцан хамаарал  
*Д.Долгорсүрэн*
- 111 Аман-Мэдээлэл(А-М) ба Цахим-Аман-Мэдээлэл (Ц-А-М)-д өгөх  
Сонгогчдын үйл байдлын хариулт  
*Зэн-У Хотта, Масато Эгучи*
- 122 Монгол Улсын Үндсэн хуулийн өөрчлөлтийн талаар улс төрийн намуудын  
баримталж буй бодлого, төслүүдэд хийсэн харьцуулалт  
*Ч.Өлзийсайхан, Ц.Батболд, Д.Ундрах*
- 138 Эрх мэдлийн мэдрэмж ба түүний хэвшмэл хандлагад үзүүлэх нөлөө:  
харьцуулсан судалгаа  
*Б.Хишигням, Д.Бумдарь, Д.Бадамдаш*
- 149 Судалгааны арга зүй, нэр томъёо  
*А. Жамбал*
- 165 Зохиогчдын тухай товч

# POLITOLOGY XVII

SCIENTIFIC JOURNAL

№ 17 (505)

---

## CONTENTS

- 5 Foreword
- 6 Sustainable development concepts and its specifics  
*Bazarpurev.S, Nasanbat.B*
- 17 Theories and methodologies to research national consciousness  
*Munkhzul.M*
- 22 To consider civil movement of Mongolia from theoretical perspective  
*Batbold.Ts, Batbaatar.B*
- 50 For the issue of civic society organizations' finance  
*Dovchin.Yo, Adyadelger.G*
- 59 Interest groups as a state policy subject  
*Tsend-Ayush.G, Ariunaa.N*
- 65 For the issue of bicameral parliament  
*Tsend-Ayush.G, Sukhbold.D*
- 75 Legal and ethical responsibility of politicians: difference and importance  
*Oyunchimeg.D, Undrakh.D*
- 83 Basic principles of democratic election and its fulfillment  
*Tumenjargal.D*
- 102 Interrelationship between foreign policy and diplomacy  
*Dolgorsuren.D*
- 111 Voting Behavior Responses to WOM (Word-of-Mouth) and EWOM (Electronic Word-of-Mouth) Information  
*Zen-U Hotta, Masato Eguchi*
- 121 Comparative analysis of political parties' drafts on the constitution of Mongolia  
*Ulziisaikhan.Ch, Batbold.Ts, Undrakh.D*
- 134 Power and its main factors: Non-conscious priming of the feeling stereotype and responsibility  
*Khishignyam.B, Bumdari.D, Badamdash.D*
- 145 Research methodology and terminology  
*Jambal.A*
- 161 Contributors**

## ӨМНӨХ ҮГ

МУИС-ийн Улс төр судлалын тэнхимээс эрхлэн гаргадаг “Политологи” эрдэм шинжилгээний сэтгүүлийн ээлжит дугаар эрхэм уншигч та бүхний гар дээр очиж байна. Сэтгүүлийн маань энэхүү дугаар нь өмнө гарсан цувралуудын ололт, амжилт, туршлага дээр суурилсан болно.

Дэлхий дахины улс орнуудын харилцаа, хамтын ажиллагаа өргөжин тэлэхийн хэрээр улс төрийн мөн чанар, агуулга улам бүр гүнзгийрч түүний үүрэг роль өсөн нэмэгдсээр байгаа билээ.

Ийм учраас улс төрийн мөн чанарыг ойлгон таниулах, энэ талаарх зөв үнэлэлт дүгнэлтийг өгөх улс төрийн мэдлэгийг бий болгодог улс төрийн шинжлэх ухааны гүйцэтгэх үүрэг их юм. Эдүгээ улс төрийн шинжлэх ухааны онол-арга зүй, судалгааны аргахэрэгсэл, улам нарийсан хөгжиж онолын болон эмпирик судалгаа шинжилгээний мэдлэгүүд даяаршиж байна.

Улс төрийн мэдлэгийн даяарших үйл явц нь дэлхий дахин, бүс нутаг, улс орнуудад ардчилсан хөгжлийн ололт амжилтыг баталгаажуулах, түүнийг хөгжлийн шинэ шатанд гаргахад чухал үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд цаашид ч гүйцэтгэсээр байх болно.

Монголд шинээр үүсэн төлөвшиж буй улс төрийн шинжлэх ухааныг хөгжүүлэх үйлсэд энэ салбарын эрдэмтэн судлаачид ихээхэн хүчин чармайлт гаргаж байдгийн тодорхой нэг илрэл нь энэхүү сэтгүүл юм. Сэтгүүлийн эл дугаарт улс төрийн онол, үзэл баримтлал, улс төрийн институт, ардчиллын онол, практик, харьцуулсан улс төр, эмпирик судалгаа, улс төрийн түүх, нэр томъёоны тайлбар зэрэг улс төрийн шинжлэх ухааны олон чухал сэдвүүдээр эрдэмтэн судлаачдын бичсэн өгүүллүүдийг нийтэллээ.

Манай сэтгүүл дугаар тус бүрдээ улс төр судлалын салбарт сурч буй магистрант, докторант, удирдагч багш нарын эрдэм шинжилгээний хамтарсан бүтээл, өгүүллэгүүдийг байнга нийтэлдэг. Мөн манай сэтгүүлд гадаад, дотоодын судлаачдын өгүүллийг байнга хэвлүүлдэг. Ийнхүү бид сэтгүүлийнхээ чанарыг сайжруулж олон улсын түвшинд хүргэх зорилт тавин ажиллаж байна.

## РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ

**ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТАЛААРХ ТОДОРХОЙЛОЛТУУД,  
ТЭДГЭЭРИЙН ОНЦЛОГ**

**С.Базарпүрэв**

МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,  
Улс төр судлалын тэнхимийн профессор

**Б.Насанбат**

МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,  
Улс төр судлалын тэнхимийн докторант

**Түлхүүр үг:** Тогтвортой хөгжил, эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчин, ёс зүй

**Товч агуулга:** Энэхүү өгүүлэлд тогтвортой хөгжлийн талаарх ялгаатай тодорхойлолтуудыг авч үзэх, тэдгээр тодорхойлолтуудын үндсэн санаа болон хэрэгжүүлэх үйл явц нь ёс зүйн агуулгатай байдаг болохыг илэрхийлэхийг зорьлоо. Өөрөөр хэлбэл, тогтвортой хөгжилд хүрэхийн тулд ёс зүйн үнэт зүйлсийн боломжит нөлөөллийг тодорхойлох, хүчтэй ёс зүйн зарчмуудыг бий болгож мөрдөх шаардлага буйг илэрхийлэхийг хичээв.

**Танилцуулга:** Тогтвортой хөгжлийн талаарх үзэл санаа нь орчин үед бий болсон шинэ үзэл санаа биш, харин мянга мянган жилийн туршид байгаль орчинтой ойр амьдарч ирсэн ард түмэн, нийтлэгүүдийн өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлж ирсэн үнэт зүйлийн нэг хэсэг нь л юм. Тухайлбал<sup>1</sup>, Канадын уугуул иргэдийн уламжлалт сургаал тогтвортой байдлын асуудлыг ихээхэн чухалчилж мөрддөг бөгөөд үе үе хоорондын эрх тэгш байдлын тухай асуудалд онцгой анхаарсан байдаг. Уг сургаалд “Бид зөвхөн өөрсдийн оршин тогтнохуйн төлөө амьдрахгүй, харин дараагийн долоон үеийн оршин тогтнох боломжийг хангах үүрэг хариуцлага хүлээнэ. Бид байгальтай хэрхэн харьцдаг арга ухаан хийгээд байгалийн үнэт баялаг ургамал, мал амьтан, эрдэс бодисыг долоон үедээ уламжлуулан өгөх ёстой” гэсэн байдаг. Өөрөөр хэлбэл, өнөө үеийнхэн нь дараа үеийнхээ сайн сайхан байдалд саад болох, хохирол учруулах зүйлийг хийхгүй байхыг эрхэмлэж иржээ. Манай Монголын уламжлал соёлд ч гэсэн байгальд

---

<sup>1</sup>Д.Наранцэцэг. “Тогтвортой хөгжил: Канад, Монголыг харьцуулан судлах нь”. Тогтвортой хөгжил: XXI зууны Монгол-Канадын харилцаа. ЭШБХ-ын эмхэтгэл. УБ., 2008. 20-21 дэх тал

хөнөөлгүй аж төрөх, байгалийн зүй тогтол, аяад өөрсдийн амьдрал, үйл ажиллагаагаа нийцүүлэх, хойч үедээ байгалиа байгаагаар нь өвлүүлэх зэрэг олон зэрэг хандлагууд бий.

Өнөө үед тогтвортой хөгжлийг хүн төрөлхтөн цаашид илүү аз жаргалтай бөгөөд удаан оршин тогтнохын тулд экологийн тэнцвэрт байдал, нийгмийн тэгш байдал, эдийн засгийн өсөлтийн альныг ч орхигдуулахгүйгээр авч явах асуудалд хэмээн тодорхойлж байна. Энэ бол хүн төрөлхтний ирээдүйг илүү аюулгүй бөгөөд сайн сайхан байлгах явдал нь байгаль, нийгэм, эдийн засгийн гурван тулгуурт үйл ажиллагаанаас хамаарч буйг онцлон, энэ хүрээнд ажиллахыг эрмэлзэж буй олон улсын хэмжээний санал санаачлага юм.


**Онолын үндэслэл ба арга зүй:** “Тогтвортой хөгжил” нь нийгмийн хөгжлийн талаарх нэлээд “загварлаг” концепцуудын нэг бөгөөд үүнийг нийгэм, хүмүүнлэгийн болон байгалийн шинжлэх ухааны судлаачид тал бүрээс нь судлаж, тодорхойлж байдгаараа онцлогтой. Бидний хувьд тогтвортой хөгжлийг тодорхойлсон судлаачдын зарим тодорхойлолтыг тайлбарлах, түүнчлэн харьцуулан шинжлэх үндсэн дээр нийтлэг утга агуулгыг илэрхийлэх зорилго тавин ажиллав. Энэ хүрээнд нийгэм-хүмүүнлэгийн судалгаанд түгээмэл хэрэглэгддэг герменевтик болон харьцуулах аргыг голчлон ашигласан болно. Мөн шинжлэх ухааны судалгаанд өргөн хэрэглэгддэг анализ синтез, индукц дедукцийн аргыг ашигласан.

Тогтвортой хөгжилийг тодорхойлсон тодорхойлолтуудаас хамгийн их ишлэгддэг нь "ирээдүйн үеийнхээ хэрэгцээгээ хангах боломжийг алдагдуулахгүйгээр өнөө үеийнхэн нь өөрсдийн хэрэгцээгээ хангах явдлыг хэлнэ"<sup>2</sup> гэсэн тодорхойлолт юм. Энэхүү тодорхойлолтыг анх 1987 онд Дэлхийн эдийн засгийн хөгжлийн зөвлөл (WCED) –өөс хэвлэсэн Брундтландын тайланд анх тусгасан. Уг тайланд хүн амын хэрэглээний хурдацтай өсөлт ба байгалийн нөөц баялаг хоёрын хооронд зөрүүтэй байдал үүссэн бөгөөд үүнийг зохицуулахгүй бол дэлхий нийтээрээ устан үгүй болох аюултай болохыг анхааруулсан. Брундтландын тайланд тэмдэглэсэнээр, хөгжлийн энэхүү тэнцвэргүй байдлыг засахын тулд хоёр үндсэн арга замыг мөн тодорхойлжээ. Үүнд, Нэгдүгээрт, бүх хүн төрөлхтний үндсэн хэрэгцээг хангаж, ядуурлын бүх төрлийг утсгах. Хоёрдугаарт, байгалийн нөөц баялаг хязгаарлагдмал тул хөгжлийн зарим үйл ажиллагаанд хязгаарлалт тогтоох явдал юм.

---

<sup>2</sup>Brundtland Report, Our Common Future & United Nations General Assembly, 1987, p. 43.

Дээрх тодорхойлолтоос гадна Лондонгийн Их Сургуулийн профессор Дэвид Пирсегээр ахлуулсан судлаачдын баг тогтвортой хөгжлийн талаарх 40 гаруй тодорхойлолт байгаа болохыг тэмдэглэсэн байдаг<sup>3</sup>. Эдгээр тодорхойлолтууд нь тогтвортой хөгжлийн үзэл санааны үндсэн тулгуур ойлголтын альныг нь онцолсноос хамаарч хоорондоо ялгаатай байдаг. Тэдгээр тодорхойлолтуудыг ерөнхийд нь дараах байдлаар ангилж болно. Үүнд:



**Байгаль орчны аспектыг чухалчилсан тодорхойлолтууд:**

XX зууны үед судлаачид байгаль орчны тогтвортой байдал ба эдийн засгийн хөгжлийг нэг нэгэнд нь хамаатуулан тайлбарладаггүй байв. Өөрөөр хэлбэл, байгаль орчны нөөцийг ашиглах замаар эдийн засгийг хэрхэн хөгжүүлэх тухай асуудалд гол анхаарч харин байгаль орчныг нөөцийг хадгалан хамгаалах, аривлан хэмнэх асуудлыг чухалчладаггүй байв. Шинжлэх ухааны судалгаа, шинжилгээнд тулгуурлан байгалийг улам бүр эзэмшиж захиргаандаа байлгах, илүү их ашиг хүртэхийн тулд төрөлх байдлыг хувирган өөрчлөхийг эрмэлзэж байв. Энэ хирээр байгаль дэлхий өөрийн өнгө төрхөө алдаж, амьд байгалийн зүйл бүрт аюул, бэрхшээл тулгарч эхлэв. Ийнхүү 1900 оны дунд үеэс судлаачид “Хүн байгалийг өөрийн дураар эзэмшиж, захирахыг хүссэн ирээдүйгүй хандлагаа өөрчлөх шаардлагатайг олж анзаарах болов. Энэ хүрээнд анхлан судласан эрдэмтэд нь Р.Карсон, К.Боулдинг, Д.Мэйдоувс нар мөн.

Р.Карсон “Чимээгүй хавар”<sup>4</sup> бүтээлдээ эдийн засгийн өсөлт - хөгжил ба байгаль орчны доройтлын харилцан хамаарлыг анхлан авч үзсэн. Зохиогч бүтээлдээ “хортон устгахад ашиглаж буй хорт бодисууд нь байгаль орчны доройтлын нэг шалтгаан болж байгаа болохыг анхлан дэвшүүлсэн байна. Тэрээр “pesticide” буюу хортоной тэмцэх хэрэгсэл нь үнэн хэрэгтэй “biocides” буюу амьд бүх зүйлийг устгагч бодис болж байгаа бөгөөд дан ганц ургамал, амьтан

<sup>3</sup>www.nps.gov/sustain/spop/def.html

<sup>4</sup> Уг бүтээл нь бүх цаг үеийн хамгийн алдартай шинжлэх ухааны 25 бүтээлийн нэг юм, 20 зууны 100 шилдэг бүтээлийн нэг



хортохоос гадна хүнд мөн сөрөг нөлөө үзүүлж буйг нотлохыг зорьжээ. Өөрөөр хэлбэл, тэрээр бүтээлдээ байгалийн экосистемд хортон устгах үйл ажиллагааны сөрөг үр дагавар нь ургамал, амьтан, түүнчлэн хүнд хэрхэн нөлөөлж, хордлого, хорт хавдар, бусад олон өвчлөлийн үндэс болж буйг дэлгэрэнгүй авч үзсэн. Гэвч тэрээр тухайн үеийн химийн компаниудын хүчтэй эсэргүүцэлтэй тулгарч байсан хэдий ч байгаль орны асуудлыг бүх нийтийн анхаарлын төвд оруулахад хүчтэй нөлөө үзүүлжээ. Түүний бүтээл гарсны дараа олон арван хэлэлцүүлэг, маргаан өрнөж үр дүнд нь хөдөө аж ахуйн салбарт хортон устгах бодисыг хэрэглэхийг зогсоож, улмаар АНУ-ын байгаль орчныг хамгаалах агентлаг байгуулагдаж, байгаль хамгаалах олон иргэний хөдөлгөөнийг идэвхжүүлжээ.

Үүний дараа К.Боулдинг эдийн засгийн тогтолцоог хөгжүүлэхдээ экологийн хязгаарлагдмал нөөцийн хамгаалах шаардлагыг тодорхойлсон. Тэрээр уг эссэндээ нээлттэй эдийн засаг, хаалттай эдийн засаг хэмээх ойлголтуудыг тайлбарласан. Түүний үзлээр, өнгөрсөн үеийн эдийн засаг нь нөөцийг шавхагдашгүй хэмээн тодорхойлж, түүнд нийцүүлэн ажиллаж байсан нээлттэй эдийн засаг (cowboy economy)<sup>5</sup> юм. Харин ирээдүйд “хаалттай эдийн засаг”-тай болох бөгөөд нөөцийн хязгаарлагдмал, олборлолт бохирдлоос үүдэлтэй шинэ шинэ асуудлууд бий болно. Тиймээс өнөө үеийн хүмүүс нь “тогтвортой эдийн засаг”-т шилжихийн тулд үйлдвэрлэлийн болон хэрэглээний хандлагаа дахин нягтлан үзэх ёстой болохыг тайлбарласан. Тэрээр “earth” хэмээх ойлголтын оронд “spaceship earth” хэмээн ойлголтыг ашигласан нь дэлхий ертөнц хязгааргүй буюу хязгааргүй нөөцтэй (хүн төрөлхтний амьдрал үргэлжилсээр байх болно) гэсэн хандлагыг өөрчлөхийг эрмэлзэж байсны илрэл юм. Түүний дэвшүүлсэн үзэл санаанд тулгуурлан эдийн засгийн шинэ зарчимууд бий болсон бөгөөд тэдгээрт, байгаль орчныг хамгаалах үйлсэд хувийн хэвшлийг дэмжих, урамшуулах, хүлээсэн үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, байгаль орчны үнэлгээг үйл ажиллагаандаа тусгах, ногоон технологи, инновацийг дэмжих зэрэг шинэ агуулгууд бий болжээ.

Д.Мэйдоувс нарын бичсэн “Өсөлтийн хязгаарлалт” бүтээл нь үнэн хэрэгтээ судалгааны тайлан юм. Ромын клубын захиалгаар хийсэн уг судалгаагаар дэлхийн хязгаарлагдмал нөөц бүхий нөхцөлд эдийн засгийн үйл ажиллагаа болон хүн амын өсөлт энэ эрчээр явагдсаар байвал ямар үр дүнд хүрэхийг урьдчилан тооцоолон (компьютерийн загварчлалын судалгаа) үр дүнг нь нийтэд

---

<sup>5</sup> cowboy хэмээх үг нь чөлөөтэй, тэгш талыг илэрхийлдэг тул нээлттэй эдийн засгийг тэрээр “cowboy economy” хэмээн нэрлээсэн байна.

танилцуулсан юм. Уг бүтээлийн гол санаа нь дахин сэргээгдэхгүй нөөцийн хомсдол нь нийгмийн хөгжилд сөрөг нөлөөтэй болохыг нотлоход чиглэдэг. Тэдгээр судлаачдын олж тогтоосноор, хүн ам өсөхийн зэрэгцээ аж үйлдвэрийн капитал эрчимтэй өсөж, хүнсний хэрэгцээ нэмэгдэнэ. Энэ нь нөгөө талдаа мөн л нөхөн сэргээгдэхгүй нөөц баялагийн эрэлтийг бий болгож байдаг. Тэгвэл манай дэлхий эдгээр эрэлт хэрэгцээг хэр удаан хугацаанд хангаж чадах уу вэ? гэдэг асуулт гарч ирдэг. Энэ асуултанд хариулахын тулд MIT –ын судлаачидттай хамтран компьютерийн аргаар тооцооллын судалгаа явуулжээ. Судалгааны явцад тэдэнд урьдчилан таамаглаагүй зүйл тохиолдсон нь сэргээгдэхгүй нөөцийн хомсдолоос шалтгаалан загварчлалын судалгаа нь амжилтгүй болсон явдал байв. Тиймээс тэд энэхүү судалгаагаа ном болгон хэвлүүлсэн бөгөөд гол зорилго нь (ер нь Мальтусизмыг баримтлагчдын) нийгэм, орон нутгийн, олон улсын эрх бүхий байгууллагуудад сануулга өгөх явдал байсан. Өөрөөр хэлбэл, хүн төрөлхтний хэрэглээний чиг хандлагыг өөрчлөхийг эрмэлзэж байв<sup>6</sup>. Дээрх судалгааг World3 компьютерийн загварыг ашиглан "хүн ам, хүнсний үйлдвэрлэл, үйлдвэржилт, бохирдол, дахин ашиглах боломжгүй байгалийн нөөцийн хэрэглээ" гэсэн 5 хувьсагчид тулгуурлан хийжээ. Судалгааны үед эдгээр хувьсагчуудын тоо өсөхөд нөхөн сэргээгдэхгүй нөөцийн хэмжээг багасгах байдлаар хэр удаан хугацаанд хүн төрөлхтөн оршиж чадахаа тооцоолж үзсэн. Зохиогчид гурван хувилбарын хүрээнд таван хувьсагчдын өсөлтийн чиг хандлагыг өөрчилснөөр тогтвортой эерэг төлөвийн загварыг бий болгох зорилготой байв. Хувилбаруудын хоёр нь 21-р зууны дунд үеээс эхлэн удааширч улмаар сүүл үе гэхэд сүйрсэн бол харин гурав дахь хувилбар нь "тогтворжсон ертөнц" -ийг үүсгэсэн байна. Өөрөөр хэлбэл, "Өсөлтийн хязгаарлалт" номын зохиогчдын тооцоолсноор хүн төрөлхтөн хэрэглээний хандлагаа өөрчлөхгүй бол 2072 он гэхэд орших боломжгүй болох аюултай юм. Харин хэрэглээний чиг хандлагаа өөрчилж чадваас устах аюулд бус хөгжлөө хэвийн үргэлжлүүлэх боломж ч мөн бий болох нь судалгааны үр дүнгээр илэрхий болсон.

Ромын клубынхан дээрх бүтээлдээ дэлхий дахин нийтээрээ хүсч буй тэнцвэрт төлөв байдлыг тайлбарлахдаа "тогтвортой" буюу "sustainable" гэсэн нэр томъёог орчин үеийн агуулгаар анх хэрэглэсэн байдаг. Тэд дэлхийн дахиныг аврах

---

<sup>6</sup> Ийм зорилгоор үйл ажиллагаа явуулдаг нөлөө бүхий байгууллагын нэг нь Лестер Браун (Lester Brown)-ын байгуулсан "World Watch Institute", "Earth Policy Institute" зэрэг ТББ юм. Эдгээр нь дэлхийн дахинаа байгалийн баялгийг ашиглахтай холбоотой асуудлыг судлаж, хэрэглээний чиг хандлагын хувьд ашигтай хувилбаруудыг танилцуулж байна. Энэ мэт санаачлагуудыг НҮБ-ээс тууштай дэмждэг.

хөгжлийн шинэ загварыг эрэлхийлж түүнийгээ дээрх байдлаар томъёолсон байна. Үүнд: 1-рт, Гэнэтийн гай гамшигт тохиолдоход бэлэн буюу даван туулах чадвартай байх, 2-рт Хүн төрөлхтний анхдагч хэрэгцээ болсон материалаг хэрэглээг хангахдаа ирээдүй хойч үеийнхээ эдлэх боломжийг багасгахгүй байх явдлыг чухалчилсан.

Дээрх судлаачдаас гадна АНУ-ын Оберлин коллежийн профессор Дэвид Опп<sup>7</sup> “Тогтвортой байдал гэдэг нь микробоос эхлэн ургамал, амьтан гээд дэлхий дээрх бүхий л зүйлсийн талаар ойлгох, судлах, анализ хийх мэргэн ухаан ба үйл ажиллагааг илэрхийлнэ. Бид энэхүү үзэл санааны тусламжтайгаар дэлхий ертөнцөө илүү гүн танин мэдэж, хүний амьдралын зорилгыг илүү сайжруулж, өөрчилнө” хэмээсэн нь маш энгийн ойлголмжтой хирнээ дээрх утгыг бүрэн илэрхийлсэн сайн тодорхойлолт болсон байдаг.

### **Нийгмийн аспектыг чухалчилсан тодорхойлолтууд:**

Тогтвортой хөгжлийн асуудлыг нийгмийн аспектээр тодорхойлсон анхны тодорхойлолтыг 1980 оны эхээр Лестер Браун (Lester Brown)<sup>8</sup> хийж байжээ. Түүний тэмдэглэсэнээр, “тогтвортой хөгжил гэдэг тогтвортой нийгмийн тухай асуудал бөгөөд тогтвортой нийгэм нь ирээдүй хойч үеийнхээ амьдрах боломжийг багасгахгүйгээр өнөө үеийхэн нь өөрсдийн хэрэгцээгээ хангах явдал юм”. Түүний энэхүү тодорхойлолт нь өнөө үеийн хүмүүсийн гол зорилго бол ач зээ болон тэдний үр хүүхдүүдэд дэлхий дээрх бүх өв (баягалийн баялаг, шинжлэх ухаан, шударга ёс, ёс суртахуун, амьд байгаль)-ийг үлдээх, хүлээлгэн өгөх явдал бөгөөд үүнийг л тогтвортой байдал хэмээн ойлгож болох юм. Үүний тулд нийгэм бүхэлдээ хамтын ажиллагаанд тулгуурласан, нийгмийн төрөл бүрийн институтийг дэмжэн, хөгжүүлэх асуудлыг чухалчилсан байдаг. Энэ хүрээнд ядуурлын бүх төрлийг эцэслэх, шударга ёсыг тогтоох хөгжүүлэх, олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх, энх тайвныг сахин хамгаалах, олон янзын соёлыг хадгалан хамгаалах, өндөр хөгжилтэй орнуудын санаачлагаар буурай орнуудад тусламж үзүүлэх зэрэг ажлууд далайцтай хийгдэж байна.

---

<sup>7</sup> David Orr, Professor, Oberlin College, Ohio. Тэрээр 1987 оноос “ногоон кампус” хөдөлгөөнийг санаачилж, улмаар анх 1996 оноос их сургуулийн орчныг “ногоон” дизайнаар хөгжүүлэх ажлыг эхлүүлсэн. Түүний байгуулсан оюутны хотхон нь бохир усаа өөрийн нөөцөөр цэвэршүүлдэг, нарны цахилгаан хураагуураар эрчим хүчний асуудлаа бүрэн шийдсэн байгууламж юм. Түүний энэ санаачлагыг дэлхийн олон арван их сургуулиуд дэмжин ажиллаж, нийгэмд шинэ давалгаа бий болсон байна. Дэвид Опп нь Ecological Literacy (SUNY, 1992), Earth in Mind (1994/2004) зэрэг бүтээлээрээ олны танил болсон. Одоогоор түүний удирдаж буй “The Oberlin Project” төсөл нь Оберлин хотын үйлдвэрүүд болон коллежуудаар дамжуулан байгаль орчинд ээлтэй нийгэмлэг, бүлгүүдийг бий болгох, бий болсон бүлгүүдийг дэмжих зорилготой ажилладаг.

<sup>8</sup> World watch Institute, Earth policy Institute-ийг үүсгэн байгуулагч.

Түүнчлэн Ж.Пирайн (1977), Т. Хэйс (1978), 1980-аад оны эхэн үед тогтвортой байдлын талаар цуврал бүтээл туурьвсан Бравн, Кливленд, Күүмэр зэрэг судлаачид Тогтвортой хөгжил нь байгаль орчин, экологийн асуудлаас илүүтэйгээр хүн төрөлхтний сайн сайхныг бий болгох шударга ёс, эрх тэгш байдал, зөв шударга улс төрийн үйл ажиллагаа, өөрчлөлтийн хэм хэмжээ, үнэт зүйл, зорилгоос хамаах болохыг өөрсдийн бүтээлээр илэрхийлэн гаргасан байдаг.

#### **Эдийн засгийн аспектыг чухалчилсан тодорхойлолтууд:**

Байгаль орчин- эдийн засгийн аль альных нь талбарт “ялагч-ялагч” байхын тулд үйлдвэрлэлийн үйл явцад гарах бохирдол болон хаягдлыг бууруулах асуудлыг энэ чиглэлийн төлөөлөгчид гарган тавьдаг. Тухайлбал, Порттерийн таамаглалаар “Зах зээлийн урамшууллыг дэмжсэн байгаль орчны бодлого нь үйлдвэрлэлд байгальд ээлтэй шинэ технологи нэвтрүүлэх, үйлдвэрлэлийн явцад гардаг бохирдол болон хаягдлыг багасгах гол арга болох юм”. Харин үүнд улс төрийн бодлогын шинэчлэл, олон нийтийн дэмжлэг чухал үүрэгтэй. Улс төрийн бодлогод байгальд ээлтэй технологи-үйлдвэрлэлд татварын хөнгөлөлт үзүүлэх, зээл тусламжид нэн тэргүүнд хамрагдах бололцоо олгох зэрэг нь багтдаг. Энэ бүхний цаад утга санаа нь “эдийн засгийн салбарт байгалийн нөөцийг хэмнэх, үрэлгэн хэрэглээг хязгаарлах” гэсэн агуулгатай.

Энэ чиглэлийн судлаачид тогтвортой хөгжлийн үндэс бол байгаль орчны болон эдийн засгийн урт хугацааны харилцан хамаарал (нөөцийг дээд зэргээр хэмнэх, үр ашигтай зарцуулах, байгальд хөнөөлгүй технологи хөгжүүлэх, ашиглах )болохыг чухалчилдаг.Үүнээс гадна Шведийн “Баягалийн алхам” хөдөлгөөний үүсгэн байгуулагч доктор Карл Хенри Роберт (Karl Henri-Robert) “Тогтвортойгоор хөгжинө гэдэг бол хөгжлийн шугаман үйл явцаас цикль үйл явц руу шилжих шилжилт юм. Бүх шугаман үйл явц ямар нэг цэгт хүрээд төгсдөг бол цикль хөдөлгөөнд төгсгөл байдаггүй” гэсэн нь бид байгалиас нөөц авч бүтээгдэхүүн гаргаж хэрэглээд үлдснийг нь хог хаягдал хэмээн хаях бус дахин боловсруулан ашиглах буюу үйлдвэрлэлийг цикль болгох шаардлагатайг онцолсон байдаг.

Эдийн засгийн чиглэлийг онцолсон тодорхойлолтууд дотор ч тогтвортой хөгжлийг ёс зүйтэй холбон тайлбарласан судлаачид бий. Тухайлбал, "тогтвортой байдлын үзэл баримтлал нь ёс зүйн суурьгүй бол тогтвортой байдлыг бий болгож чадахгүй. Үүний адил тухайн компани тогтвортой байдлын зарчмуудыг баримталдаггүй бол ёс зүйтэй компани гэж тооцогдохгүй. Ёс зүйн зарчим,

тогтвортой байдал гэсэн хоёр ойлголт нь хоорондоо нягт холбоотой"<sup>9</sup> гэсэн байдаг.

### **Дээрх гурван аспектыг хамтад нь авч үзсэн тодорхойлолтууд:**

Тогтвортой хөгжлийн асуудлыг байгаль, нийгэм, эдийн засгийн аспектаар нь хамтад нь авч үзэж тодорхойлсон тодорхойлолтууд олон бий. Тэдгээрийн дотор дараах гурван судлаачийн санааг дурьдахад таатай байна. Үүнд:

Сиэтлийн их сургуулийн профессор Дэвид Мак Глоскей (David McCloskey) “Тогтвортой байдал нь нөөц баялаг болон түүний ашиглалт тэнцвэртэй байгаа бол, байгалийн системүүдийн амьдрах чадвар, олон янз байдал, бүхэллэг байдал нь ямар нэг хэмжээгээр хамгаалагдсан эсвэл нөхөн сэргээгдэж байгаа бол, тухай орон нутгийн бие даасан байдлыг дэмжиж байгаа бол, тухайн нийтлэгийн соёлыг хадгалан хамгаалахад туслаж байгаа үед хангагдаж, ирээдүйн сайн сайхны баталгаа болно” гэсэн буйг анхаарууштай.

Түүнчлэн судлаач Х.Вольф (Hazel Wolf) “Цэвэр агаар, цэвэр ус, аюулгүй цэцэрлэгт хүрээлэн, бага өртөгтэй орон сууцууд, боловсрол, хүүхэд хамгаалал, нийгмийн халамж, эмнэлгийн үйлчилгээ, ажилгүйдлийн даатгал, тээвэр харилцаа холбоо, амралт соёлын төвүүд, задгай сансар, чийглэг газар... Энэ бол тогтвортой хөгжил юм” гэсэн нь энгийн бөгөөд оновчтой илэрхийлэл юм. Мөн “Тогтвортой хөгжил нь хүмүүс хоорондоо болон биосфертэй яаж хамгийн сайнаар харилцах тухай үзэл баримтлалуудын нэг юм. энэ нь эдийн засаг, нийгмийн болон хүрээлэн буй орчны зорилтуудыг нэг цэгт уулзуулдаг”<sup>10</sup> гэсэн буй.

### **Ёс зүйн хариуцлагыг чухалчилсан тодорхойлолтууд:**

Энэхүү хэсэг нь уг өгүүллийн үндсэн санааг агуулж байгаа болно. Өөрөөр хэлбэл, хүн төрөлхтний хөгжлийн гол баримтлал нь тогтвортой хөгжил мөн юм бол түүнийг хэрэгжүүлэхийн тулд бид ёс суртахуунаа ямар нэг хэмжээгээр өөрчлөх, хийж буй сонголтоо аль болох ухаалаг байлгах, хойч үедээ хор хохирол учруулахгүй байхаар хийх шаардлагатай гэсэн санаа юм. Тийм ч учраас энэ тухай судлаач Паул Ховкин (Paul Hawken) тодорхойлохдоо бид “Дэлхийг орхин өөр газартай боллоо ч илүү сайнаар хэрэгцээгээ хангаж чадахгүй. Тиймээс хүрээлэн буй орчин болон “амьдрал”-д хохирол учруулахгүй байж, муу үйлдлээсээ салж өөрчлөгдөх ёстой” юм.

---

<sup>9</sup>Huggins, J. (2009). *The Morality of Sustainability*. California.

<sup>10</sup>“Уул уурхай, ашигт малтмал ба тогтвортой хөгжлийн төсөл” (MMSD). П.Очирбат. Тогтвортой хөгжил ба хэрэглээний экологи. УБ.,2004. 11 дэх талаас дам ишлэв.

Тэгвэл бидний ёс суртахууны өөрчлөлт хаанаас, юунаас эхлэх вэ? Бид итгэл үнэмшилээ өөрчлөх замаар ёс суртахуунаа өөрчлөх боломжтой. Нэн тэргүүний өөрчлөх итгэл үнэмшилийг судлаач Роберт Гилман “Тогтвортой хөгжил гэдэг нь өнөөдөр болон ирээдүйг ижил үнэ цэнэтэй гэж үзэх үзэл юм. Бид үүнийг алтан дүрэм болгон хэрэгжүүлвэл өөрсөддөө хүсч буй сайн сайхан бүхнийг ирээдүй хойч үедээ мөн хүснэ гэсэн үг юм” хэмээн тодорхойлсон байдаг.

Тогтвортой хөгжлийн үндэс нь ёс зүйн агуулгатай болохыг олон судлаач өнөө үед тайлбарлах болсон бөгөөд “Хямгач байх (prudence), зохистой ашиглах (temperance), хатуужилтай байх (fortitude), шударга ёсыг хэрэгжүүлэх явдлыг ёс зүйн суурь хэмээн онцолж байна<sup>11</sup>. Энэ нь аливаа нөөцөд дээд зэргээр хямгач хандах, хаягдлыг хамгийн багаар гаргах, үрэлгэн хандлагаа өөрчлөх, бэрхшээл тулгарахад даван туулна, өөрчлөгдөнө, нөхцөл байдлыг сайжруулж чадна гэсэн сэтгэлийн хүчтэй-хатуужилтай байх, шударга хувиарлах, тэгш хандах буюу хэнийг ч орхигдуулахгүй байх явдлыг эрхэмлэн асуудалд хандана гэсэн үг юм.

### **Тогтвортой хөгжлийн талаарх Монголын судлаачдын тодорхойлолтууд:**

Манай улсын хувьд бодлогын түвшинд тогтвортой хөгжлийн үзэл санааг агуулсан баримт бичгүүд<sup>12</sup> цөөнгүй батлагдан хэрэгжиж буй ч эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр хэвлэгдсэн нэг сэдэвт бүтээл дутагдалтай байна. Өөрөөр хэлбэл, тогтвортой хөгжлийн боловсрол<sup>13</sup>, тогтвортой хөгжлийн төлөөх боловсрол<sup>14</sup> гэсэн талаас нь судлах хандлага түгээмэл байна. Түүнчлэн тогтвортой хөгжлийн талаарх үзэл санааг байгаль орчин, уул уурхайн салбартай холбон авч үзсэн П.Очирбат<sup>15</sup>, Б.Чинзориг<sup>16</sup> зэрэг судлаачийн цөөн тооны бүтээл байна. Харин доктор Ц.Адьяасүрэн “Тогтвортой хөгжилд хүрэх замд” бүтээлээс өөрөөр тогтвортой хөгжлийн асуудлыг улс төрийн бодлогын талаас нь судласан судалгааны бүтээл, шууд холбогдох өгүүлэл, илтгэл байхгүй байна. Өөрөөр хэлбэл дэлхий дахинаа энэхүү үзэл санааг судлах ажил эрчимтэй хийгдэж, тэр

---

<sup>11</sup>Basel Chen. Moral and Ethical Foundations for Sustainability: A Multi-disciplinary Approach Journal of Global Citizenship & Equity Education, Vol 2, No 2 (2012)

<sup>12</sup>Монгол улсын XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр-1998  
Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал-1994  
Монгол улсын хөгжлийн үзэл баримтлал-1996

Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030

<sup>13</sup> П.Очирбат, Ш.Баясгалан, Б.Чинзориг. Тогтвортой хөгжлийн боловсрол. УБ.,2004.  
ШУТИС. Тогтвортой хөгжлийн боловсрол. УБ.,2004

<sup>14</sup> Тогтвортой хөгжлийн боловсрол. Мэргэжил дээшлүүлэх модуль хөтөлбөр. УБ.,2010  
Тогтвортой хөгжлийн талаарх үзэл санааг хичээлийн хөтөлбөрт тусгах нь. УБ.,2009

<sup>15</sup> Тогтвортой хөгжил ба хэрэглээний экологи. УБ.,2004.

<sup>16</sup> Б.Чинзориг. Тогтвортой хөгжлийн хэв шинж, загварын судалгаа. Уул уурхайн компаний жишээн дээр. Диссертаци. УБ.,2011

хэмжээгээр хөгжлийн бодлогод зөв зүйтэй тусган хэрэгжүүлж байхад манай улсад тогтвортой хөгжлийн асуудлыг судалдаг мэргэшсэн судлаачид өгүүлэгдэж байна.

Манай судлаачдын дунд “Sustainable development” хэмээн энэхүү нэр томъёог “тэнцвэртэй хөгжил”<sup>17</sup>, “тулхтай хөгжил”<sup>18</sup> хэмээн хэрэглэх нь зөв гэх мэтээр ялгаатай томъёолууд бий. Бидний хувьд ингэж өөр өөрөөр нэрлэх нь ач холбогдолгүй бөгөөд улс орон өөрийн ирээдүйн хөгжлийг нийгэм, эдийн засаг, байгаль орчин гэсэн гурван хүчин зүйлээс хамааруулан тайлбарлаж буй бол “тогтвортой хөгжил” хэмээн нэрлэх нь зүйтэй.

Ийнхүү манай судлаачдын дунд нэр томъёоны ялгаатай байр сууриуд бий хэдий ч үндсэн үзэл санааны хувьд адил ойлголттой байдаг. Тогтвортой хөгжлийн талаарх тэдний тодорхойлолтуудаас онцлон дурьдвал доктор П.Очирбатын тодорхойлсноор, “Тогтвортой хөгжлийн үндсэн зарчим нь хүмүүний амьдралыг сайжруулж, энэхүү сайжралаа урт хугацаанд тогтворжуулах явдал юм. Ирээдүйдээ хандах хандлага нь бидний үр хүүхдүүд эх эцгийнхээ амьдарч байснаас илүү сайхнаар амьдрах боломжийг үлдээхэд чиглэнэ. Үүний тулд шийдвэр гаргахдаа нийгэм, эдийн засаг, хүрээлэгч орчин засаглалын зорилгуудыг нэгтгэх шаардлагатай” гэжээ. Энэхүү тодорхойлолт нь хойч үед өнөөгийнхөөс илүү сайн сайхан амьдрах бололцоо буй бөгөөд харин түүнийг нь өнөө үеийнхэн нь бий болгож өгөх учиртай гэсэн ёс суртахууны хариуцлагын асуудлыг илэрхийлсэн байдаг.

**Дүгнэлт:** Дээрх тодорхойлолтын утга санаанууд нь нэг талаас ерөөлийн буюу хүн төрөлхтөн сайн сайхан амьдрах боломж буйг нөгөө талаас заналхийлсэн буюу хэрэв хандлагаа өөрчлөхгүй бол удахгүй устан үгүй болно гэсэн агуулгатай байдгаараа онцлог.

Түүнчлэн тогтвортой хөгжлийн тухай асуудлыг судлахдаа байгаль, нийгэм, эдийн засгийн аспектыг гол болгон ёс зүйн асуудлыг анхаарахгүй орхидог тал бий. Гэвч тогтвортой байдлыг бий болгоход хүмүүсийн ёс суртахууны үүрэг, ач холбогдлыг бодитойгоор үнэлэх явдал чухал болоод байна. Тогтвортой хөгжлийн үзэл санааны гол цөм нь “өнөөдрийн хүн төрөлхтөн ирээдүй хойч үеийнхээ сайн сайхан байдал, эдлэх боломжуудыг алдагдуулахгүй тулд үйл ажиллагаандаа ухаалаг, хариуцлагатай хандах ёстой” гэсэн санаа юм. Маш товчоор хэлбэл, бид ирээдүйн хүн төрөлхтний өмнө ёс суртахууны хувьд хариуцлага хүлээдэг гэсэн үг юм. Аль ч улсын хуулинд “дараа үеийнхнийхээ өмнө өнөө үе нь хариуцлага

---

<sup>17</sup> Ц.Адьяасүрэн. “Тогтвортой хөгжилд хүрэх замд”. УБ.,2004

<sup>18</sup> Д.Дагвадорж. Эдийн засаг, Бизнес ба Хөгжлийн асуудал. УБ.,2002

хүлээнэ” гэсэн заалт байхгүй бөгөөд хэдий эрх зүйн хувьд ийм төрлийн хариуцлага журамлагдаагүй байж болох ч бид ёс суртахууны хувьд тийм л үүрэгтэй.

Тиймээс тогтвортой хөгжлийн үзэл санаанд агуулагддаг ёс зүйн аспектыг нарийвчлан судлаж, сурталчлах улмаар холбогдох мэргэжлийн ёс зүйн кодоод тусгаж өгөх нь зүйтэй. Ингэснээр тогтвортой хөгжил жинхэнэ утгаараа бий болох боломжтой. Тогтвортой хөгжлийн тухай асуудлыг ёс зүйгээс салангад авч үзснээр бид хэлбэр төдий өөрчлөлтүүдийг богино хугацаанд хийж чадах ч гэлээ тогтвортой байдалд хүрч чадахгүй. Харин тогтвортой хөгжлийг ёс зүйн агуулгаар тайлбарлаж, хэрэгжүүлвээс илүү үр дүнд хүрч чадна.

**Key words:** Sustainable development, ethical issue, economics, society, environmental.

**Abstract:** Sustainable development has been defined in many ways, for example social aspect, environmental aspect and economics aspects. Although, the social dimension tends to address the issues of public health and safety, the quality of life, the impact of development on the local community, etc.; little or no very significant explanation has institutionally been rendered on ethical issues relating to sustainability. However, sustainability and ethical principles are intertwined because sustainability concepts cannot be applied without strong ethical principles.

**Ашигласан ном, материал:**

Fritjof Capra. Sustainable living, Ecological literacy and the Breath of life. Canadian Journal of environmental education. 12,2007.

Orr, D. W. Environmental education and ecological literacy. Education Digest, 1999. 55(9).

Brundtland Report, Our Common Future & United Nations General Assembly, 1987.

Basel Chen. Moral and Ethical Foundations for Sustainability: A Multi-disciplinary Approach. Journal of Global Citizenship & Equity Education, Vol 2, No 2 (2012)

Ц.Адъяасүрэн. “Тогтвортой хөгжилд хүрэх замд”. УБ., 2004

Б.Чинзориг. Тогтвортой хөгжлийн хэв шинж, загварын судалгаа. Уул уурхайн компаний жишээн дээр. Диссертаци. УБ., 2011

П.Очирбат. Тогтвортой хөгжил ба хэрэглээний экологи. УБ., 2004.

Д.Наранцэцэг. “Тогтвортой хөгжил: Канад, Монголыг харьцуулан судлах нь”. Тогтвортой хөгжил: XXI зууны Монгол-Канадын харилцаа. ЭШБХ-ын эмхэтгэл. УБ., 2008.

С.Базарпүрэв, Б.Насанбат. “Тогтвортой хөгжил ба ёс суртахууны хариуцлагын асуудал”. Мэргэжлийн ёс зүй. ЭШБХ. УБ., 2018.

[www.nps.gov/sustain/spop/def.html](http://www.nps.gov/sustain/spop/def.html)



**ҮНДЭСНИЙ УХАМСРЫГ СУДЛАХ ОНОЛ, АРГА ЗҮЙ****М.Мөнхзул**

ХААИС-ЭЗБС-ХААХЭЗТэнхимийн ахлах багш

**Түлхүүр үг:** Үндэстэн, үндэсний ухамсар, соёл, улс төрийн өөрчлөлт, улс төрийн ухамсар.

**Товч агуулга:** Өнөө үед олон улс оронд үндэсний ухамсар сэргэж, үндэстнүүд өөрийгөө таньж мэдэж, үндэсний чадамжаа ашиглан нийгмийн дэвшилд хүрэх эрмэлзэл нь өсч, үндэсний шинжээ ашиглах гэсэн үндэсний өөрийн ухамсар сэргэж эхэлж байна. Энэ нь үндэсний ухамсарт хандах шинэ хандлагыг бий болгож, улс үндэстний тусгаар тогтнолыг эрхэмлэсэн шинэ сэтгэлгээг бий болгож байна.

Үндэсний ухамсар ба улс төрийн ухамсрын гол ялгаа нь соёл ухамсрын асуудалтай холбоотой байдаг. Үүнээс үүдэн соёл нь төр үүсэхээс өмнө байсан уу? Эсвэл хожим үүссэн үү? гэсэн асуулт гарна. Үндэсний ухамсар нь тухайн үндэстэнд хамаарах хамаарал, эх хэл, үндэсний соёлоо дээдлэх үзэл, үндэсний үнэт зүйлийг эрхэмлэх эрмэлзэл, үндэсний бахархал, эрх ашгаа ухамсарлах ухамсар байдаг байна. Үндэсний ухамсар нь юуны өмнө үндэсний сэтгэл зүйн дээд түвшин нь болдог. Сэтгэл зүй бол ухамсрын анхдагч системчлэгдээгүй хэлбэр юм. Үндэсний сэтгэл зүй нь үндэстний зан авир, үйлийг тодорхойлж, үндэсний ухамсар нь түүнээс нөөцөө олж авдаг байна. Үндэстний өөрийгөө ухамсарлахын анхдагч хүчин зүйл нь үндэсний мэдрэмж юм. Учир нь үндэсний мэдрэмж иргэн бүрт сууснаар үндэсний ухамсар төлөвшинө. “Хэн нэгэн тодорхой зорилготойгоор мөхөөх гутаах, үгүйсгэх үйлдэл гаргалаа ч түүнийг нь эсэргүүцэх үзэл ард түмний зүрх сэтгэлд хадгалагдан оршиж байх”<sup>1</sup> энэхүү мэдрэмжээс эх оронч ухамсар бий болно. Үндэсний сэтгэл зүй, үндэсний мэдрэмж, эх оронч ухамсар, үндэсний ухамсар зэрэг нь системчлэгдвэл үндэсний үзэл болдог байна. Үндэсний үзэл нь дэлхийд өөрийн эзлэх байр суурийг зохих түвшинд авч үзэхээс гадна төрөө хамгаалан бэхжүүлэх улс төрийн хөтөлбөр юм. Үндэсний эрх ашгаа

---

<sup>1</sup> Түмэндэмбэрэл, Д. (2015). Үндэсний үзэл, эх оронч үзэл. Улаанбаатар. 30 дахь тал.

дээдлэх энэхүү үндэсний үзлээс өөрийн үндэсний адилсалаа тодорхойлох эх сурвалж бий болно. Үндэсний ухамсрын улс төрийн шинж нь хүмүүсийн өөрийн хувийн чанар, тухайн үндэстэн, угсаатны улс төрийн хамаарлаа ухамсарлах үндэсний адилсалд суурилдаг байна.

Үндэсний ухамсар нь ердийн болон онолын ухамсар гэсэн хоёр түвшинтэй. Үндэсний ердийн ухамсар нь үндэстний ердийн төсөөлөл, хэрэгцээ, хүсэл зориг, сонголтын үр дүн болдог. Энэ нь дотроо 3 бүтэцтэй. 1.Үнэлэмж. Үнэлэмж нь тухайн үндэстний хэрэгцээ сонирхол, үзэл бодол, мэдрэмж, өөрийгөө аль нэг бүлэгт хамааруулж буйг ухамсарлах хэлбэрийг хэлнэ. 2.Уламжлал. Уламжлал нь өмнөх үеийнхний үнэлэмжийг илэрхийлдэг учраас одоо үед үнэт зүйлийн хэмжээнд байр суурь эзэлдэг. 3.Сэтгэл хөдлөлийн хэв шинж. Бага үндэстэнд өөрийн үндэс угсааг хамгаалах зорилготой ондоошил үүсэх сайн талтай боловч үндэсний дээрэнгүй үзэл цэцэглэх анхдагч нөхцөл нь болдог.

Үндэсний “анхдагч” ердийн ухамсар нь хүмүүсийг өөрийгөө тодорхой үндэсний ба угсаатны бүлэгт хамааруулж буйг ухамсарлах хэлбэрээр илэрдэг. Үндэсний мэдрэмж, санаа бодол, сэтгэлгээний хэм хэмжээ ба үнэлэмж нь ердийн түвшинд илэрдэг. “Уламжлал нь тогтвортой, өвөрмөц байдаг учраас хойч үеийнхээ ухамсрыг зохицуулах ба тогтворжуулах үүрэгтэй байдаг”<sup>2</sup>. Аливаа үндэстний хувьд уламжлалаа хадгалах нь өөр соёлын нөлөөнд орохоос хамгаалдаг ба уламжлалаар дамжуулан тухайн үндэстэн өөрийн соёлын онцлогоо авч үлддэг байна. Мөн үндэстний эв санааг нэгтгэх, үндэсний ухамсрыг сэргээх чухал нөхцөл нь болдог байна.

Үндэсний ухамсрын нэр хүндийг унагахад хүргэдэг зүйлүүд бол үндэстний учир утгагүй хийрхэл, туйлшрал, хүчирхийлэл, түрэмгийлэл, зөрчилдөөн юм. Үүнээс үзвэл үзвэл угсаатны соёл болон улс-улс төрийн хил заагийн нийлэх асуудлыг бүрэн хэрэгжүүлэх боломжгүй болох нь харагдаж байна. Энэ бүхнийг хэрэгжүүлэх гэсэн оролдлогын улмаас үүссэн зөрчил нь эцэс төгсгөлгүй дарангуйлал, үл ойлголцол бий болгодог байна.

Үндэсний ухамсрын илрэх үйл явц нь хоорондоо холбоотой боловч нөгөөтэйгүүр эсрэг тэсрэг байдлаар илэрдэг. Нэг талаас нэг үндэстэнд харьяалагдаж буй угсаатнуудыг нэгтгэн ойртуулах зорилтыг гүйцэтгэдэг бол нөгөө талаас тэднийг бие биенээс нь тусгаарлах буюу эсрэгцэн үзэх байдлыг бий болгодог байна. Учир нь үндэсний ердийн ухамсар нь тэдний зан байдалтай холбоотойгоор үзэн ядалт, хут хуучинсаг үзэл, арьс өнгөний үзэл зэргээр илэрдэг.

---

<sup>2</sup> Поздняков.Э.А. (1994). Нация, национализм, национальные интересы. Москва. Стр 32

Үндэсний ердийн ухамсрын онцлог шинж бол сэтгэл хөдлөл хөөрлийн шинжтэй хэв маягтай байдаг. Үүний нэг илрэл нь үндэстний дээрэнгүй үзэл юм. Энэ үзэл нь өөрийн үндэстнээ бусдаас дээгүүр дэвшилттэй гэж дэвэргэн үзсэний үндсэн дээр бий болдог байна. Энэ нь том үндэстнүүдийн хувьд бусдаас өөрийгөө илүү, давамгай, соёлын өндөр түвшинд байдаг гэх бардамнал бий болж, улмаар бага буурай улс үндэстнүүдийг өөрийн соёлд татагдан орж албаар захирагдаж байх ёстой гэсэн үзлийг бий болгодог. Үндэсний ердийн ухамсрын янз бүрийн хэлбэр бол нийгмийн сэтгэл зүйд байгаа янз бүрийн ухамсрын хэлбэрүүд юм. “Эрч хүчтэй татар”, “төлөв даруу белорусь”, “бардам зантай черкес”, зоримог өөртөө итгэлтэй осетин”<sup>3</sup> гэх мэтийн үзэл одоо болтол байсаар байна гэж дүгнэсэн нь үүнтэй холбоотой. Энэ үзэгдлүүд нь хамгийн энгийн түвшинд эхэлж яваандаа төр улсын хэмжээнд очдог байна.

Үндэсний онолын ухамсрыг судлаачид үндэсний үзэлтэй холбон авч үзэж, “өнгөрсөн түүх, өнөөдрийн байдал, үндэсний хөгжлийн зорилгын нийлбэр, түүнд хүрэх хөтөлбөрийн эерэг үнэлэмж”<sup>4</sup> хэмээжээ. Энэ нь онолын түвшинд үндэсний ухамсар нь тодорхой нийгэм, улс төрийн байр сууринаас хэрэгждэг ба улс төрийн хувьд тодорхой чиг баримжаатай олон түмний үндэсний ердийн ухамсрын нийлц болдог гэсэн үг болж байна.

Бие хүн бүр заавал дагаж мөрддөг хэм хэмжээ, итгэл үнэмшил, үнэлэмж ба үйл байдлын загвартай байдаг. Энэ байдлаас өөрийн үндэстэн нь сонгомол давуу гэсэн үзэл бий болох боломжтой болж энэ нь үндэсний ухамсар дээд түвшинд хүрэх магадлалтай болно гэсэн үг. Үндэсний онолын ухамсрыг төлөвшүүлэх явдал нь үндэсний сонирхол, эрх ашиг, түүнчлэн улс төрийн бодит амьдралд оршиж байгаа зөрчлүүдийг шийдвэрлэхэд тус дөхөм болно.

Үндэсний ухамсар нь биологийн категори биш, удамшлаас хамаарахгүйгээр нийгэм-эдийн засаг, соёл, улс төрийн хүчин зүйлийн нөлөөгөөр бий болдог байна. Өөрөөр хэлбэл, “үндэстнийг тодорхойлдог эдийн засаг, нийгмийн, оюуны, соёлын бүрдлүүд нь үндэсний ухамсрын агуулга болдог”<sup>5</sup> байна. Үндэсний ухамсар бол хүний оюун санааны ертөнц, ухамсрын төрлийн нэг чухал шинжийнхээ хувьд тодорхой улс төрийн орчинд төлөвшдөг байна. Учир нь

---

<sup>3</sup> Волков.Г.Н. (1974). Этнопедагогика. Чебоксары. Стр 3.

<sup>4</sup> Анатольевна.О.К. (2007). Человеческое измерение глобализирующего мира: нравственный аспект. Москва. Стр 23

<sup>5</sup> Японская национальная психология. (1981). Москва. Стр 28

хүний “үндэсний хамаарал гэдэг нь хүн өөрийгөө ямар үндэстний хүн гэж бодож байгаагаар тодорхойлогдоно”<sup>6</sup> гэж үзжээ.

Үүнээс үзвэл үндэсний ухамсар төлөвшихөд хамгийн чухал объектив хүчин зүйл дотор нийгэм-улс төрийн хүчин зүйл гэдэг нь харагдаж байна. Тухайлбал, “хүн төрөхдөө тухайн үндэстний төлөөлөгч болж төрөхгүй, харин бие хүн болж өсөн төлөвшсөн нийгэм-улс төрийн тодорхой орчин нь хүнийг тухайн үндэстний хүн болгодог байна”<sup>7</sup>. Энэ хандлага нь үндэсний ухамсар бодгалийн хэлбэрээр байдаг, түүнийг бүрдүүлэгч нь улс төр, нийгмийн тодорхой орчинд байгаа аль нэгэн угсаатны бие хүн байдаг байна.

Үндэсний ухамсар нь ерөнхий боловсролын систем, ахуй амьдралын болон эдийн засаг, соёлын хэвшил, үзэл санааны үнэт зүйлс гэх мэтийн зүйлтэй харилцан нөхцөлдсөн холбоотой байдаг. Иймээс улс төрийн аливаа үйл явдалууд үндэсний ухамсарт ихээхэн нөлөөлдөг байна. Аливаа үндэстний түүхэн хөгжил, нийгмийн дэвшлийн дагуу үндэсний ухамсар төлөвшдөг. Тодруулбал үндэсний ухамсар нь үргэлж хувьсан өөрчлөгдөж байдаг байна. Түүнд янз бүрийн хүчин зүйл нөлөөлж, агуулга, улс төрийн үүрэг нь өөрчлөгдөж улмаар үндэсний ухамсар ч өөрчлөгдөнө. Гийм учраас үндэсний бол хүний нийгмийн ахуйн амьдрал, нийгмийн, соёлын тусгал болдог улс төрийн ухамсрын өвөрмөц тал нь болдог.

Үндэсний ухамсар бол үндэстний нэг шинж нь юм. 1960-аад оноос философич, угсаатан судлаачдын хооронд энэ асуудлаар маргаан өрнөж, үүний үр дүнд “үндэсний ухамсар”, “угсаатны ухамсар” гэсэн асуудал нь угсаатан судлал болон философийн онолын судалгааны бүтээлүүдэд гарах болсон. Тэдгээрт үндэсний ухамсрыг үндэстний нэг чухал шинж гэж үзэх болсон байна. 1988 онд Л.М.Дробижева “үндэсний ухамсар нь хүнийг аль үндэстний хүн болохыг тодорхойлж өгдөг нарийн бүтэцтэй үзэгдэл мөн бөгөөд түүний бүтцэд үндэсний хэв маяг, газар нутаг, соёл, хэл, түүх орно”<sup>8</sup> хэмээн үзжээ. Энэ нь үндэсний ухамсарт танин мэдэхүйгээс гадна сэтгэл хөдлөлийн зүйлс, өөрийн үндэсний соёл, түүхийн үнэт зүйлтэй харилцах харилцаа орохоос гадна сонирхол багтдаг гэсэн үг юм.

### **Дүгнэлт**

Үндэсний ухамсар тун зөрчилтэй сэдэв учраас түүнийг судлах онолын судалгаа нь ч нарийн төвөгтэй зүйл юм. Үндэсний ухамсар бол хүн эргэн

---

<sup>6</sup> Японская национальная психология. (1981). Москва. Стр 28

<sup>7</sup> Обновление: межнациональные отношения и перестройка. (1989). Ленинград. Стр 62

<sup>8</sup> Маркс,К,Э (1980). Сочинения. Москва. Стр 29

тойрныхоо ертөнцтэй харилцах харилцааны зүгээр нэг үр дүн биш, харин бодит байдлаар шалтгаалцсан, харилцан нөлөөлцсөн байдаг. Аливаа үндэстний нийгмийн хүрэн дэх бодит байдлын өөрчлөлт иргэний үндэсний ухамсарт нөлөөлж байдаг. Үндэсний ухамсар нь үндэстэн өөрийн гарал үүсэл, угсаа гарал, түүх, соёл, хөгжил дэвшил, доройтолт ба сэргэн мандалт зэргийг үнэн зөвөөр нь мэдэхийн зэрэгцээ түүний шалтгаан, учир холбогдлыг ухаарна гэсэн үг. Үүнээс үзэхэд үндэстэн өөрийгөө таньж мэдэх нь чухал үйл явц юм. Энэ ухаарах нь цаашдын чиг хандлагыг зөв тодорхойлоход тусална.

**Abstract:** Nowadays in many countries, national identity is awakening, awareness of its nation, aspiration for social progress through its national potential, as well as national self-awareness using national qualities, is being restored. This creates a new attitude to national consciousness and a new sense of national independence.

### **Conclusion**

Since the theme of national consciousness is very contradictory, its theoretical investigation presents a certain complexity. National consciousness is not simply the result of a person's communication with the world around him, but an objectively dependent and mutually conditioned phenomenon. Changes in reality that occur in the social sphere of any nation have their influence on the national civic consciousness. National consciousness means that the nation, in addition to true knowledge of its origins, race, history, culture, development, progress, decline and rebirth, realizes and understands the causes and their significance. Hence it is very important for the nation to know oneself. This helps to determine the future trends correctly.

### **Ашигласан ном, материал:**

- Түмэндэмбэрэл.Д. (2015). Үндэсний үзэл, эх оронч үзэл. Улаанбаатар.
- Анатольевна.О.К. (2007). Человеческое измерение глобализирующего мира: нравственный аспект. Москва.
- Волков.Г.Н. (1974). Этнопедагогика. Чебоксары.
- Маркс.К,Э (1980). Сочинения. Москва.
- Обновление: межнациональные отношения и перестройка. (1989). Ленинград.
- Поздняков.Э.А. (1994). Нация, национализм, национальные интересы. Москва.
- Японская национальная психология. (1981). Москва

**МОНГОЛ ДАХЬ ИРГЭНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ АСУУДЛЫГ  
ОНОЛЫН ҮҮДНЭЭС АВЧ ҮЗЭХ НЬ**

**Ц.Батболд**

МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,  
Улс төр судлалын тэнхимийн дэд профессор

**Б.Батбаатар**

МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,  
Улс төр судлалын тэнхимийн докторант

**Товч утга:** Энэ өгүүлэлд өнөөгийн Монголын нийгэмд гарсан 2003-2009 оны хөдөлгөөнүүдийн идэвхжлийг мөн чанар агуулгыг танин мэдэхийн тулд нийгмийн хөдөлгөөний онолын хүчин зүйлстэй холбон авч үзэхийг зорьсон. Энэ утгаар нь Монгол дахь хөдөлгөөний асуудлыг онолын үүднээс тодорхойлж, хөдөлгөөн үү? эсвэл сонирхлын болон шахалтын бүлэг үү? гэдгийг тогтоох, хэрэв хөдөлгөөн бол онолын хувьд аль шатандаа яваа нийгмийн өөрчлөлтийн улс төрийн үйл явц вэ гэдгийг тодруулах зорилго тавьсан.

**Түлхүүр үг:** Хөдөлгөөн, хувьсал, нийгмийн хөдөлгөөн, нийгмийн хөдөлгөөний бүтэц, хөдөлгөөний хамрах хүрээ, framing буюу хөдөлгөөн байгуулагдах хүрээ, харьцангуй ядуурлын онол, нөөцийн дайчилгааны онол, удирдагч, нийгмийн өөрчлөлт.

**Танилцуулга:** Энэ өгүүлэлд өнөөгийн Монголын нийгэмд гарсан “иргэний” хөдөлгөөнүүдийн идэвхжлийн мөн чанар, агуулгыг танин мэдэхийн тулд нийгмийн хөдөлгөөний онолын хүчин зүйлстэй холбон авч үзэхийг зорьсон. Тиймээс зарим улс төрчид, судлаачид хөдөлгөөн гэхээс илүүтэй шахалтын бүлэг гэж үзэж байхад, нөгөө хэсэг судлаачид хөдөлгөөн мөн, гэхдээ нийгмийн шаардлага, зорилго чиглэл нь нэгдмэл бус, тодорхой нэгдмэл зохион байгуулалтад орж чадаагүй учраас нийгмийн хөдөлгөөний эхлэлийн шатанд яваа иргэний хөдөлгөөн гэж үзэх явдал байдаг. Заримдаа социал бүлгийн ашиг сонирхлыг хамгаалахын тулд, эсвэл тодорхой улс төрийн сөрөг хүчний захиалгаар шахалт үзүүлэхээр зохион байгуулагдсан сонирхлын бүлгээс иргэний хөдөлгөөнийг ялгахад хэцүү байдаг. Энэ утгаар нь Монгол дахь хөдөлгөөний асуудлыг онолын

үүднээс тодорхойлж, хөдөлгөөн үү? эсвэл сонирхлын болон шахалтын бүлэг үү? гэдгийг тогтоох, хэрэв хөдөлгөөн бол онолын хувьд аль шатандаа яваа нийгмийн өөрчлөлтийн улс төрийн үйл явц вэ гэдгийг тодруулах зорилго тавьсан. Энэ хүрээнд нийгмийн хөдөлгөөний зорилго, зорилт, бүтэц, үүрэг, үйл ажиллагааны арга хэрэгсэл, хамрах хүрээ болон хөдөлгөөний онолын хандлагууд, хөдөлгөөн нь нийгмийн өөрчлөлтийн гол хүчин зүйлс болох талаар товч авч үзсэн. Ингэснээр академик мэдлэг, онолын хүрээнд Монгол дахь хөдөлгөөний мөн чанар, ангилал, нэршилд шинжилгээ хийж дүгнэлт гаргасан.

### **Хөдөлгөөний онолын үндэслэл:**

Энэ өгүүлэлд нийгмийн хөдөлгөөний талаарх онолын үндэслэлүүд, хөдөлгөөний хөгжлийн тодорхой үе шатуудыг авч үзсэнээр Монголын өнөөгийн иргэний хөдөлгөөн хэмээн нэрлэгдэж буй нийгэм улс төрийн үйл явцад нөлөөлж болох иргэний нийгмийн хүчин зүйлсийг онолын үндэслэлтэйгээр авч үзсэн.

Нийгмийн хөдөлгөөн нь нийгмийн өөрчлөлтийг авчрахийн тулд зохион байгуулалттай үйл ажиллагааг явуулах шаардлагатай гэж Ж.Женкинс<sup>1</sup> уламжлалт хэлбэрээр тодорхойлсон байна. Энэ хандлагаар Женкинс, 1983: Макадам болон Сноу, 1997: 18-25; Маккарти болон Залд, 1977:1217-18; Тарроу, 1998: 4-6; Вилсон, 1973:3-4 (Jenkins, 1983; McAdam and Snow, 1997:xviii–xxv; McCarthy and Zald, 1977:1217–18; Tarrow, 1998:4–6; Wilson, 1973:3–4)<sup>2</sup> судалжээ. Гэхдээ зарим эрдэмтэд П.Бурштейн<sup>3</sup>, Эйнвард болон Холландер, 1995; Гиугни, 1998, 1999; Хубертс, 1989; Лофланд, 1993:347-8 нар тэдгээр хөдөлгөөний агуулга, зорилго шаардлагууд нь үнэхээр нийгмийн өөрчлөлтийн шалтгаан болж байгаа эсэхийг авч үзсэн байна. (Burstein, Einwohner, and Hollander, 1995; Giugni, 1998, 1999; Huberts, 1989; Lofland, 1993:347–8), (Женкинс, 1983: Макадам болон Сноу, 1997: 18-25; Маккарти болон Залд, 1977:1217-18; Тарров, 1998: 4-6; Вилсон, 1973:3-4).<sup>4</sup>

Нийгмийн хөдөлгөөнийг судалж буй эдгээр судлаачид удаан хугацааны турш түүнд бий болсон асуудлууд болон иргэдийн оролцоонд анхаарлаа их хандуулж байсан ажээ. Зарим судлаачид нийгмийн хөдөлгөөний үр дүнд илүү анхаарлаа хандуулж байхад, өөр нэг хэсэг судлаачид нь нийгмийн хөдөлгөөний өөрчлөлтөд

---

<sup>1</sup> Jenkins, J. Craig. 1983. "Resource mobilization theory and the study of social movements." *Annual Review of Sociology* 9:527–53.

<sup>2</sup> Thomas Janoski, Robert R. Alford, Alexander M. Hicks, Mildred A. Schwartz. *The Handbook of Political Sociology states, civil societies, and globalization*. Cambridge University Press 2005. P 331.

<sup>3</sup> Burstein, Paul. 1985. *Discrimination, Jobs, and Politics: The Struggle for Equal Employment Opportunity in the United States, 1940–1980*. Chicago: University of Chicago Press.

<sup>4</sup> Thomas Janoski, Robert R. Alford, Alexander M. Hicks, Mildred A. Schwartz. *The Handbook of Political Sociology states, civil societies, and globalization*. Cambridge University Press 2005. P 331-332.

анхаарлаа хандуулж байв. Сүүлийн үеийн нийгэмд явагдаж буй өөрчлөлтийн үйл явцад нийгмийн хөдөлгөөн нь онцгой хувь нэмэр оруулсан гэж тэдгээр судлаачид үздэг.

### **Хөдөлгөөний тухай ойлголт, тодорхойлолт, нэр томъёоны асуудал**

Хөдөлгөөний тухай ойлголт, нэр томъёонуудыг ажиглахад нийгмийн хөдөлгөөн, иргэний хөдөлгөөн, иргэний эрхийн хөдөлгөөн, тусгаар тогтнолын хөдөлгөөн, ардчилсан хөдөлгөөн, энх тайвны хөдөлгөөн, апертейд буюу арьс өнгөөр ялгаварлан гадуурхахын эсрэг хөдөлгөөн, феминизм буюу эмэгтэйчүүдийн эрхийн төлөөх хөдөлгөөн зэрэг маш олон хэлбэр, агуулга, хамрах хүрээгээр хоорондоо ялгаатай шинж чанар, зорилгыг илэрхийлсэн байдаг ажээ. Эдгээр ойлголтуудыг нэгтгэн хөдөлгөөн гэж ерөнхийд нь нэрлэж болох боловч, эрдэм шинжилгээний болон бусад ном зохиолууд, хэвлэл мэдээллийн хэрэгслэлүүдийн мэдээлэлд, хүмүүсийн ам дамжсан ярианы хэлэнд ч хамрах хүрээ, зорилго, шинж чанараар нь ялгаж, тодотгосон нэрээр нь нэрлэсэн байдаг. Энэ утгаар Монголын ардчилсан шилжилтийн жилүүдэд үүссэн нийгмийн хөдөлгөөний шинж чанар, хамрах хүрээ, зорилго чиглэлийн агуулгыг ажигласан олон нийт, хэвлэл мэдээллийн хэрэгслэлүүд “иргэний хөдөлгөөн” гэж нэрлэжээ. Энэ нэр томъёог улс төрийн шинжлэх ухааны онол, арга зүйн үүднээс оновчтой нэршил мөн эсэхийг тодорхойлох нь энэ сэдвээр судалгаа хийж байгаа судлаачдын эн тэргүүний үүрэг юм.

А.Гидденс “Орчин үеийн нийгэмд хувьсгалт идэвхийн зэрэгцээгээр социал хөдөлгөөний бусад олон хэлбэрүүд бий. Тэдний зарим нь удаан жилийн түүхтэй, зарим нь дөнгөж үүсч байдаг. Бүхэлдээ бол социал хөдөлгөөн нь цаг ямагт сөрөн зогсдог албан ёсны бюрократ байгууллагын адилаар орчин үеийн ертөнцийн салшгүй шинж болсон юм<sup>5</sup> гэжээ. Томас Жаноски “Нийгмийн хөдөлгөөн нь эрх мэдлийн хуваарилалтад өөрчлөлтийг авчрах зохион байгуулалттай үйл ажиллагаа”<sup>6</sup> гэж тодорхойлсон. Энэ нь нийгмийн хөдөлгөөний талбарын бодит байдал болон нийгмийн хөдөлгөөний өөрчлөлтийн онолыг боловсруулах арга зүйн стратегийг авч үзэхэд хүргэдэг. Иргэний хөдөлгөөн нь нийгмийн өөрчлөлтөд нөлөөлөх буюу саад болж буй институцийн зохион байгуулалтыг даван туулахыг эрмэлзсэн хэсэг бүлэг хүмүүсийн хамтын чармайлт юм.

---

<sup>5</sup> А.Гидденс. Социологи. УБ., 2006. НШУС. Социологийн танхим. Тал 524

<sup>6</sup> Thomas Janoski, Robert R. Alford, Alexander M. Hicks, Mildred A. Schwartz. The Handbook of Political Sociology states, civil societies, and globalization. Cambridge University Press 2005. P 331-332.



Аливаа хөдөлгөөнийг тогтсон институтийн хүрээнээс гадуур хамтын үйлдлийн тусламжтайгаар нийтлэг ашиг сонирхлыг хэрэгжүүлэх зорилгоор нэгдсэн хүмүүсийн оролдлого гэж тодорхойлж болно. Хөдөлгөөний өөрийнх нь янз бүрийн шинж чанартай холбоотойгоор энэ тодорхойлолтыг хангалттай өргөн, эсвэл явцуу хүрээнд авч үзэх нь зохимжтой юм. Эдгээр хөдөлгөөнүүдийн олонх нь жижгэвтэр хэдхэн арван хүнтэй байдаг бол заримд нь хэдэн мянга, бүр сая хүн ч оролцож байдаг. Зарим хөдөлгөөн тухайн улсын төдийгүй олон улс орнуудын иргэдийг хамарсан өргөн хүрээтэй ч байдаг. Хамрах хүрээгээр нь хөдөлгөөнийг глобаль, нийгмийн, иргэний гэж ангилж болно:

- Глобаль хөдөлгөөн нь олон улс орнуудын иргэдийн эрх ашгийн үүднээс үүссэн байдаг. Энэ нь тухайлбал, дайны эсрэг “Энх тайвны хөдөлгөөн”, арьс өнгөөр ялгаварлан гадуурхахын эсрэг дэлхий нийтийн “Апертейд хөдөлгөөн” гэх мэт.
- Нийгмийн хөдөлгөөн нь тухайн улс орны дотоод дахь олон нийтийн эсэргүүцлийн нэгдэл дээр үүсдэг. Энэ нь тухайлбал, дайны эсрэг, иргэний эрхийн төлөөх, засгийн газрын бодлого шийдвэрийн эсрэг, эсвэл нийгмийн шударга ёсыг тогтоохын төлөөх гэх мэт. Хэрэв нийгмийн хөдөлгөөний шаардлагыг эрх баригчид хүлээн авахгүй тохиолдолд энэ нь хувьсалт тэмцэлд хүргэж, засаглалыг хүчээр өөрчлөх эрсдэл агуулдаг.
- Иргэний хөдөлгөөн нь тухайн улс орны дотоодын янз бүрийн асуудлуудаас үүсдэг бөгөөд эдгээр хөдөлгөөнүүд нь нэгдмэл бус, зарим тохиолдолд хоорондоо мөргөлдөх шинжтэй байдаг. Энэ нь тухайлбал, үндэстэн хоорондын зөрчил, улс төрийн, эдийн засгийн, нийгмийн болон экологийн янз бүрийн хүчин зүйлсийн хүрээнд гарч ирдэг боловч нийгмийн хөдөлгөөнөөс ялгарах гол онцлог нь нийгмийн гишүүдийн олонхийн дэмжлэгийг авч чадаагүй, хэсэг бусаг шинжтэй төдийгүй хоорондоо зөрчилдөх хандлагатай байдаг.

Заримдаа нийгмийн тодорхой бүлгийн ашиг сонирхлыг хамгаалахын тулд шахалт үзүүлэхээр зохион байгуулагдсан сонирхлын бүлгээс иргэний хөдөлгөөнийг ялгахад хэцүү байдаг.<sup>7</sup> Янз бүрийн сонирхлын бүлгүүд, улс төрийн зорилго бүхий шахалт, дарамтын бүлгүүдийн зорилго нэгдэх үед хөдөлгөөний шинж чанар үүсэх бөгөөд тэд нэгдсэн зохион байгуулалтад орох үед хөдөлгөөний шинж чанар нийгмийн гишүүдийн олонхийг хамарч нийгмийн хөдөлгөөн үүсэх нөхцөл бүрддэг байна.

<sup>7</sup> А.Гидденс. Социологи. УБ., 2006. НШУС. Социологийн танхим. Тал 525

А.Гидденс ...“хөдөлгөөн болон албан ёсны байгууллага хоёрын ялгаа нэн тогтворгүй”<sup>8</sup> гэж үзсэн байна. Гэхдээ Ц.Батболд “Бюрократ онолын үндэс” бүтээлдээ ...“Сайтар зохион байгуулагдсан иргэний хөдөлгөөнүүд ч ихэнхдээ бюрократ ёсны шинжийг бүрэн бүрдүүлдэг”<sup>9</sup> гэжээ. А. Мелуччи (1989) “Ийм маягаар иргэний хөдөлгөөнүүд нь аажмаар албан ёсны байгууллага болон хувирч, мөн хэдийгээр ховор тохиолддог ч байгууллагууд нь социал хөдөлгөөн болон сэргэн тогтож болдог”<sup>10</sup> гэж үзсэн байна.

Хөдөлгөөнүүдийн үйл ажиллагаа нь олонх орнуудад хуулийн гадуурх үзэгдэл гэж тооцогддог. Иргэний хөдөлгөөний үйл ажиллагааны үр дүнд заримдаа хуулийг бүрэн буюу хэсэгчлэн өөрчилдөг. Олонх орнуудад тухайлбал, эдийн засгийн эсэргүүцлийн хэлбэр болох үйлдвэрийн ажлын байранд суугаа ажил хаялт зэрэг нь өнөөг хүртэл хуулийн гадуурх үзэгдэл юм. Гэвч өнөө үед ажил хаялт нь үйлдвэрлэлийн зөрчлийг шийдвэрлэхэд хэрэглэж болох тактик болон хувирсан. Зарим ардчилсан улс орнуудад иргэдийн жагсаж нэгдэх үйл явц, эсэргүүцлээ илэрхийрэх хэлбэрийг хуулиар зохицуулахыг оролддог. Гэвч энэ нь ихээхэн хязгаарлагдмал шинжтэй зохицуулалтууд байдаг бөгөөд хэрэв энэ эрх чөлөөг хэт их олговол нийгмийг задлан самууруулж, улс орны удирдлагыг сулруулан нийгмийн хөгжлийн эрчийг сулруулах болно гэж үзэж болгоомжлох хандлага илүү давамгайл байдаг.

Нийгмийн хөдөлгөөний богино хугацааны болон шууд үр дүнгийн тухай маш олон судалгаа байдаг. Тэдгээр судлаачдын судалгааны хандлага болон судалгааны үр дүнгийн талаар ангилан авч үзвэл дараах хандлагууд ажиглагдаж байна. Үүнд:

- Нийгмийн давхрааны өөрчлөлт (Фендрих, 1993; Макадам,1988), (Fendrich, 1993; McAdam, 1988)
- Хууль, бодлого батлах (Бурштейн, 1985; Бурштейн болон Фреуденберг,1978; Костайн,1992) (Burstein, 1985; Burstein and Freudenberg, 1978; Costain, 1992),
- Хууль ба бодлогын хэрэгжилт (Баттон, 1989; Хандлер, 1978) юм, (Button, 1989; Handler, 1978)

---

<sup>8</sup> А.Гидденс. Социологи. УБ., 2006. НШУС. Социологийн танхим. Тал 525

<sup>9</sup> Ц.Батболд. Бюрократ онолын үндэс. УБ.,2013. Тод Магнат ХХК.

<sup>10</sup> Melucci, A. (1989). Nomads of the Present: Social Movements and Individual Needs in Contemporary Society, ed. J. Keane and P. Mier. London: Hutchinson Radius.

Гэхдээ эдгээр судалгаануудын тун цөөхөн нь эдгээр үйл явцыг олон хувьсагчтай тогтолцоонд байршуулж, тухайн нийгмийн нөлөөллийг хянаж байдаг.<sup>11</sup>

### **Нийгмийн хөдөлгөөний бүтэц**

Ирвин Гоффмэний 1974 онд гаргасан нэг сэдэвт “Frame analysis: An essay on the organization of experience” бүтээлд хөдөлгөөний бүтэцэд нийгмийн хамрах хүрээ гэдэг ойлголт, үг хэллэгийг анх нийгмийн шинжлэх ухаанд нэвтрүүлсэн юм. И.Гоффмэний хувьд хамрах хүрээ нь аливаа үйл явдал ба түүн дэх өөрсдийнхөө оролцооны идэвх гаргасан танин мэдэхүйн бүтэцтэй байдаг. Энэхүү хамрах хүрээний хандлага нь Гоффмэний анх дэвшүүлсэн санааны нарийвчилсан дүн шинжилгээ бөгөөд маш их хичээл зүтгэлд тулгуурлан бүтсэн юм. Энэ нэр томъёо нь хувь хүн болоод түүний бусадтай харилцах харилцааг өдөр тутмын амьдралын зан үйлээс бүрддэг бөгөөд хүмүүсийн ихэнх хэсэг нь хүрээний үйл явцад тодорхой ухамсарын зорилгогүйгээр оролцдог<sup>12</sup> гэж үзсэн байна.

Ихэнх дүн шинжилгээнд хүн төрөлхтөн аливаа үйл явдлын тодорхой элемент дээр хэрхэн тулгуурлаж, чухам юу болж буйг яаж ойлгож давж туулах тухай онцлон тэмдэглэсэн байдаг. Нийгмийн ухаан ба улс төрийн шинжлэх ухааны аль алинд нь хөдөлгөөнд оролцогч иргэд хэрхэн идэвхи зүтгэл, ухамсартайгаар энэ хүрээг бий болгох гэж хичээж буй болон бусдын хүрээнд өөрийн хүрээг хэрхэн шингээж байгаад онцгой ач холбогдол өгөхөд нийгмийн хамрах хүрээний тухай ойлголт чиглэж байдаг ажээ.

Нийгмийн хөдөлгөөний хамрах хүрээ үүсгэхэд хамгийн багадаа дараах гурван хэсэгтэй холбоотой байдаг: Энэ нь сэтгүүлчдийн хэм хэмжээ, улс төрийн оролцогчид болон нийгмийн соёлын нөхцөл байдал зэрэг юм. Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь хөдөлгөөний оюун санааны хүрээг үүсгэхэд их нөлөөтэй бөгөөд ХМХ-ийн хоорондын өрсөлдөөн, нөгөө талаар сөрөг элитүүд мэдээллийг тэтгэх зэрэг нь хөдөлгөөний хамрах хүрээг нэмэгдүүлдэг.

1. Мэдээний үйлдвэрлэлийн практикт сэтгүүлчид тодорхой асуудлуудын хүрээнд хэрхэн нөлөөлж болох тухай мэдээллийн таваас доошгүй хэсэг байдаг:

- нийгмийн гол үнэт зүйлс ба хэм хэмжээ

---

<sup>11</sup> Thomas Janoski, Robert R. Alford, Alexander M. Hicks, Mildred A. Schwartz. The Handbook of Political Sociology

states, civil societies, and globalization. Cambridge University Press 2005. P 331

<sup>12</sup> Goffman, E. (1974). Frame analysis: An essay on the organization of experience. Cambridge, MA: Harvard University Press.

- зохион байгуулалттай бүлгүүдийн дарамт шахалт гаднах сонирхлын бүлгүүдийн дарамтууд,
  - бодлого боловсруулагчид
  - сэтгүүлчдийн мэргэжлийн дэг журам
  - үзэл суртал, улс төрийн чиг хандлага зэрэг болно.
2. Франчайзын хоёр дахь боломжит нөлөө нь элитүүдээс гардаг бөгөөд үүнд сонирхлын бүлгүүд, засгийн газрын бюрократууд, корпорациудын улс төрийн оролцоо юм. Эмпирик судалгаанаас үзэхэд элитүүдийн ярилцлага, өгүүлэл нийтлэлүүдийн нөлөөлөл нь сэтгүүлчид болон бодлогын талбар дахь олон тоглогчдын хооронд холбоотой асуудлуудад хүчтэй нөлөө үзүүлэх боломжтой болохыг харуулж байдаг.
  3. Эцэст нь, нийгмийн соёлын хам сэдэв нь хүрээг бий болгож чаддаг. И. Гоффмэний хүрээний утга нь соёлын үндэс суурьтай гэж үздэг. Хэвлэл мэдээллийн хүрээнээс хамаарах хамаарлыг "соёлын сэргэн мандалт"<sup>13</sup> эсвэл "үнэнч ярих" гэж тодорхойлсон.<sup>14</sup>

### **Хөдөлгөөний хамрах хүрээ**

Нийгмийн шилжилт хөдөлгөөний онолч, эрдэмтэд аливаа шилжилтэнд уг хөдөлгөөнд оролцогчид хоорондоо нэгдэж ажиллахын тулд хэрхэн өөрсдийгөө дайчилдаг тухай үзэл баримтлалын хүрээний онолыг ашигладаг. Энэ хандлага нь 1980 онд рационализм ба байгууллагын хандлагыг үндсээр нь “тас цохин” өөрчилж, 1990 оноос нийгмийн шилжилт хөдөлгөөний гол хандлагуудын нэг болсон юм. Жонстон болон Ноүкс нар, Виллиам Гамзон, мөн Дэвид Сноу ба Робэрт Бэнфорд нар энэхүү үйл явцыг системчлэхийг эрмэлзэж байсан бөгөөд бусад хамтран ажиллагсаддаа ихэд итгэл найдвар хүлээлгэж байжээ.

Дэвид Сноу, Робэрт Бэнфорд нар 1988 онд нийгмийн хөдөлгөөний хамрах хүрээний хамгийн түгээмэл хэв шинжийг дэвшүүлжээ. Хувь хүнийг нийгмийн хөдөлгөөнд оролцуулахын тулд нийгмийн хөдөлгөөн нь нийгмийн хүрээний үндсэн гурван үйл ажиллагаанаас бүрддэг гэжээ.<sup>15</sup>

<sup>13</sup> Gamson, W. A. & Modigliani, A. (1987) The changing culture of affirmative action. *Research in Political Sociology*, 3, 137–77

<sup>14</sup> Snow, D. A., & Benford, R. D. (1988). Ideology, frame resonance, and participant mobilization. In B. Klandermans, H. Kriesi, & S. Tarrow (Eds.), *International social movement research. Vol. 1, From structure on action: Comparing social movement research across cultures* (pp. 197–217). Greenwich, CT: JAI Press.

<sup>15</sup> Snow, D. A., & Benford, R. D. (1988). Ideology, frame resonance, and participant mobilization. In B. Klandermans, H. Kriesi, & S. Tarrow (Eds.), *International social movement research. Vol. 1, From structure on action: Comparing social movement research across cultures* (pp. 197–217). Greenwich, CT: JAI Press.

1. Үүнд тухайн үеийн үйл явдлын түгээмэл шинжийг эрэлхийлсэн ямар нэг эргэлзээгүй онолын хүрээ байх ёстой.
2. Хөдөлгөөн нь нийгмийн хүрээний нь аливаа асуудлыг урьдчилан шийдвэрлэх, шилжилт хөдөлгөөнийг урагшлуулах аргыг бий болгоно.
3. Эцэст нь Нийгмийн хүрээнээс идэвхитэй хүмүүсийг нийгмийн хөдөлгөөнд оролцуулах гол хөдөлгүүр болгох нарийвчилсан бодлогод төвлөрдөг.

Иймэрхүү харилцаа холбоо, итгэл үнэмшил бий болгох нь эхний хоёр үзэл бодолд ч мөн зайлшгүй шаардлагатай юм. Энэхүү ойлголтын механизм нь нийгмийн хөдөлгөөний бодлогод шилдэг удирдагч нарыг илүү ихээр шаардаж байдаг. Ингэснээр шударга бус байдал болон бусад таагүй зүйлсийг устгаж, зохистой хариуг бий болгохын тулд баримт нотолгоо бүхий үйл явдлыг онцгойлон тэмдэглэдэг. Удирдагчид аль болох зөв зохистой үзэл баримтлалыг нийгмийн хүрээнд бий болгохын төлөө илүү их хүчин чармайлттайгаар ажиллаж эхэлдэг. Нийгмийн хөдөлгөөний энэ ойлголт нь чадварлаг гишүүний дэвшүүлсэн үзэл санаа хэр бодитой, боломжтой байна вэ гэдгийг судалдаг янз бүрийн элементийн тоо хэмжээнээс шалтгаалдаг.

Сноу ба Бэнфорд нар нийгмийн оролцоо бол хөдөлгөөний чухал элемент юм гэж үзсэн. Хувь хүний харилцааны хүрээнүүдийн хооронд эв нэгдэл, харилцан хамаарал үүссэн үед "хүрээний тэгш байдал" үүсдэг<sup>16</sup> нь "хүрээний цуурай" үүсгэдэг бөгөөд нэг хүрээнээс нөгөө рүү шилжих бүлгийн процессын хурдасгагч болдог. Үүнд нөлөөлөх буюу хязгаарлах нөхцлүүдэд дараах зүйлс орно:

1. Хүрээний бат бөх, бүрэн бүтэн, нарийвчлалтай байдлын хүчин чармайлт чухал. Хүрээний гурван үндсэн үүргийг тодорхойлсон бөгөөд эдгээр ажлуудыг хийхэд оролцогчдыг дайчлах хэрэгтэй гэж заасан. Эдгээр нь дараах гурван үүрэгтэй байна:
  - Хүрээний асуудлыг тодорхойлж оношлохдоо бурууг хүлээдэг байх
  - Стратеги, тактикийн асуудлаар таамаглалд тулгуурласан шийдвэр гаргах
  - Тэмцлийн оновчтой үйлдлээр хүрээний үйл ажиллагааг идэвхжүүлэн уриалах.
2. Санал болгож буй хүрээ нь итгэл үнэмшлийн хоорондын томоохон холбоо юм. Төвлөрөл: хүрээ нь итгэл үнэмшлийн тогтолцооны хүрээнд бага

---

<sup>16</sup> Snow, D. A.; Rochford, E. B.; Worden, S. K.; Benford, R. D. (1986). "Frame alignment processes, micromobilization, and movement participation". *American Sociological Review*. 51 (4): 464

хэмжээний иерахитай байж болно. Хүрээний үнэт зүйлс, итгэл үнэмшлийг холбодог тогтолцоо нь хязгаарлагдмал эрх мэдэлтэй байна.

3. Оролцогчдын бодит байдал нь хүрээний харилцаа холбоо юм. Хүрээ нь оролцогчдоос хамааралтай төдийгүй тэдэнд мэдээллүүдийг мэдээлэх ёстой. Оролцогчдын итгэл үнэмшил, найдвартай байдал нь түүхэн домог зүйн үнэнч сэтгэгдэлд нийцэж байдаг.

С.Тарроу: Өнөөгийн эрин үеийн цаг хугацаа, нийгмийн өөрчлөлттэй холбоотой үүсч болзошгүй нөхцөл байдал зэргийг харгалзах нь хүрээний эсэргүүцлийн циклийн мөн чанар юм гэжээ.<sup>17</sup> Сноу ба Бэнфорд нар дээр дурьдсанчлан зохистой хүрээг бий болгосны дараа нийгмийн хөдөлгөөнд зайлшгүй шаардлагатай нийгмийн томоохон өөрчлөлтүүд нь хүрээгээ тэлэх боломжийг олгодог<sup>18</sup> гэж үзсэн.

Нийгмийн хөдөлгөөний шахалт, шаардлагаар төрийн бодлогод өөрчлөлт орсоноор нийгмийн өөрчлөлт явагддаг. Зураг 1-д нийгмийн хөдөлгөөнийг багтаасан нийгмийн бүтцийн ерөнхий хүрээг тодорхойлсон бөгөөд нийгмийн хөдөлгөөн нь төрийн бодлогод хэрхэн нөлөөлж байгааг харуулсан.

Энгийн хялбар байдлаар нийгмийг дөрвөн салбар болгон хуваасан:<sup>19</sup>

1. Нийгмийн хөдөлгөөн;
2. Хууль тогтоох байгууллага, Засгийн газар шүүх болон агентлагууд зэрэг төрийн байгууллагууд;
3. Улс төрийн сонирхол, сонирхлын бүлгүүд гэх мэт улс төрийн сонирхол бүхий байгууллагууд;
4. Олон нийтийн харилцаа, боловсрол, эдийн засаг, нийгмийн халамж, шашин шүтлэг, гэр бүл зэрэг нийгмийн бусад байгууллагууд.

Нээлттэй, ардчилсан, олон ургальч нийгэмд нийгмийн эдгээр дөрвөн салбар нь зөрчилдөөн, хэлцэл, өөрчлөлтийн интерактив системийг бүрдүүлдэг. Дэглэмийг зохион бүтээгч улс төрийн институциуд нь төр, захиргааны салбар байгууллагуудад хяналт тавих эрх зүйн хэм хэмжээгээр хязгаарлагддаг байна. Энэхүү бүдүүвч нь улс төрийн тогтолцоо, төрийн бодлогын өөрчлөлтөд нөлөөлөх нөлөөллийг судалдаг ч түүний учир шалтгааны загварыг гаргаж өгдөггүй; Харин

---

<sup>17</sup> Tarrow, Sidney G. 1994. *Power in Movement: Social Movements, Collective Action and Politics*. New York: Oxford University Press.


<sup>18</sup> Snow, D.A., & Benford, R.D. (1988). Ideology, frame resonance, and participant mobilization. In B. Klandermans, H. Kriesi, & S. Tarrow (Eds.), *International social movement research*. Vol. 1, CT: JAI Press.

<sup>19</sup> Form, William. 1985. *Divided We Stand: Working Class Stratification in America*. Urbana: University of Illinois Press.

боломжит өөрчлөлт хийхэд хөдөлгөөнд оролцогч талууд, гол байгууллагуудыг тодорхойлох схем юм.

Тухайн хөдөлгөөний хувьд, уламжлалт институт болон бусад гурван салбар нь гадаад зохион байгуулалтын орчин бөгөөд хөдөлгөөний харилцан үйлчлэлийн явцад түүний зорилго, үнэт зүйлсийг ахиулж байдаг. Бидний хандлага бол нийгмийн хөдөлгөөнөөс өмнө байсан макро эдийн засгийн бүтцийг одоо байгаа макро болон микро бүтцээр дамжуулан нийгэмд гарч буй шинэчлэлийг (тодорхойлогдох ёстой) тодорхойлж, нийгмийн хөдөлгөөний үр дүнд шинжилгээ хийж том бүлгүүдэд хариу өгөх болно (Blau, 1994: 6-р бүлэг).

Зураг 1. Нийгмийн хөдөлгөөн нь төрийн бодлогод нөлөөлөх нь



**Эх сурвалж:** J.Craig Jenkins and William Form. Social Movements and Social Change. Thomas Janoski, Robert R. Alford, Alexander M. Hicks, Mildred A. Schwartz. The Handbook of Political Sociology states, civil societies, and globalization. Cambridge University Press 2005. P 334

Хөдөлгөөний нийгмийн харилцан үйлчлэлийн үр дүнд асуудлыг шийдвэрлэх зохион байгуулалтын тохиромжтой аргачлалыг анхаарч үзэх, эсвэл зохистой сонголт хийхэд саад тотгор учруулдаг хязгаарлалтуудыг албадан өөрчлөхөд хүрдэг байна (Form, 1990)<sup>20</sup>.

<sup>20</sup> Form, William. 1990. "Institutional analysis: An organizational approach." Pp. 257–71 in Maureen T. Hallinan, David M. Klein, and Jennifer Glass (ed.), Change in Societal Institutions New York: Plenum.

## Нийгмийн хөдөлгөөний онолууд

Олон социологчид нийгмийн хөдөлгөөний талбарын язгуур үндсийг нийгмийн сөрөг хариу үйлдэл, Францын хувьсгалын аймшиг шиг, олон нийтийн бадарсан уур хилэнгээр хөдөлгөөнийг төсөөлж судалдаг. Тард (1989), Ле Бон (1977) нар энэ санааг эсэргүүцэж, тэдгээр судлаачид, онолчдод зориулж мэтгэлцэхэд ойр дөхөм эхлэх цэгийг бий болгосон ч үнэн хэрэгтээ тэдний бүтээл олон нийтийн сэтгэл судлалын нэг салаа мөчир төдий л байсан юм.<sup>21</sup>

Нийгмийн хөдөлгөөний эртний онолчид болох К.Маркс, Ф.Энгельс нарт юу хувь хүнийг хамтын үйл ажиллагаанд оролцоход хүргэдэг вэ гэсэн асуулт ердөө тулгардаггүй байв. Оронд нь тэд үүнийг хувь хүний сонголт гэж үзэхээсээ илүүтэй нийгмийн бүтцийн хөгжил бэлэн болсны тэмдэг гэж загварчилж байлаа. Гэвч тэд олон нийтийн үйл ажиллагааг нийгмийн бүтцээс үндэстэй гэж үзэж байсан хэдий ч Маркс, Энгельс нар олон нийтийн үйл ажиллагаанд оролцоход шаардлагатай нөөц, түүний соёлын хэмжүүр ба улс төрийн ач холбогдол зэргийг дутуу үнэлж байсан. Хүмүүс нийгмийн анги нь сөргөлдөгч талтайгаа бүрэн зөрчилдөөнд орсон үед хамтын үйл ажиллагаанд оролцдог гэж тэд үзжээ. Пролетарийн хувьд капитализм тэднийг том хэмжээний үйлдвэрүүдэд багаж хэрэгслээ эзэмших эрхгүй, хүчээр ажиллуулж байсан нь хамтаараа тэмцэх эх сурвалжуудыг бий болгосон гэсэн үг юм.<sup>22</sup>

Эдгээр эх сурвалжууд дунд ангийн ухамсар, үйлдвэрчний эвлэл байв. Энэ нь пролетариудыг анги болгон үйлдвэрчний эвлэлүүдийг улс төрийн хэлбэртэй болгосон үйлдвэрүүд дэх нийгэмжсэн үйлдвэрлэлийн хэмнэл байсан. Энэ сэдвээр олон илүү сайн (бас илүү харанхуй) томъёолууд байдаг хэдий ч Маркс үүнийг Коммунист намын тунхагтаа хамгийн товч тодорхойгоор оруулжээ.

Сайн дурын дэмжигч нь хөрөнгөтөн байдаг аж үйлдвэрт тэмцэлдээнээс болж хөдөлмөрчдийн тусгаар болсныг тэдний хувьсгалт нэгдлээр орлуулдаг. ... Тэдний тэмцлийн жинхэнэ үр жимс нь шууд үр дүнд биш харин ажилчдын тасралтгүй тэлэх нэгдэлд оршино. (Такер, эд 1978; 481 ба 483)

Маркс айж санаа зовнидог идэвхтнүүдтэй холбоотой асуудлыг бас авч үздэг байсан: яагаад түүх бослого гаргах бодит нөхцөлийг бүрдүүлчихээд байхад босвол зохих бүлгийн гишүүд ихэвчлэн ийм алхам хийдэггүй вэ? Гишүүдийн

---

<sup>21</sup> Sidney G. Tarrow. Power in Movement: Social Movements and Contentious Politics. L., 1994. Cambridge University Press. 15-16

<sup>22</sup> Sidney G. Tarrow. Power in Movement: Social Movements and Contentious Politics. L., 1994. Cambridge University Press. 16



үлэмж хэсэг хамтран ажиллахгүй бол ажилчдын хөдөлгөөн амжилтанд хүрэхгүй гэдэг асуудалтай холбоотойгоор тэр “хуурамч ухамсар” гэдэг онолыг гаргаж иржээ. Үүгээрээ хэрэв ажилчид “Түүх”-ийн зааснаар үйлдэж чадаагүй бол энэ нь тэд ангийн дайсныхаа бий болгосон үл тоохын мананд халхлагдан үлдсэнийх гэсэн санаатай байлаа. Энэ онол хангалтгүй байсан бөгөөд учир нь хэн ч хэний ухамсар хуурамч, хэнийх жинхэнэ гэдгийг хэлж чадахгүй юм. Капитализмын зөрчил туйлдаа хүрч, өөртэйгээ адил бусадтай хамтран зүтгэсэн он жилүүдээс гарсан эв санааны нэгдэл ажилчдын нүдийг нээж тэдний жинхэнэ сонирхлыг харуулахад асуудал өөрөө шийдэгдэнэ гэж Маркс бодож байжээ гэж Сидни Тарроу үзжээ.

С.Тарроу 1994 онд бичсэн “Power in Movement: Social Movements and Contentious Politics” бүтээлдээ: “Капитализм хөгжихийнхээ хэрээр ажилчдын дунд янз бүрийн хэсгүүдийг үүсгэж, тэднийг капиталист ардчилалд нэгтгэх механизмыг бий болгосон. Үндсэрхэг үзэл болон үндэсний үйлдвэрлэлээ хамгаалах үзлийн үүднээс ажилчид ангийн зөрчлөөс илүүтэй хамтын ажиллагааг бий болгох нь чухал гэж үзэн капиталистуудын холбоотон болсон юм. Эдийн засгийн сонирхлыг хувьсгалт хамтын үйл ажиллагаа болгон өөрчлөх ухамсар бий болох хэрэгтэй. Гэвч энэ ухамсрыг хэн бий болгох вэ? Маркст манлайлалын талаар ч ажилчин ангийн соёлын талаар ч тодорхой үзэл баримтлал байгаагүй учир хувьсгалт хөдөлгөөний боломжоор хангахад шаардлагатай улс төрийн нөхцөл байдлыг гүйцэд тодорхойлж чадаагүй юм” гэж дүгнэжээ.

Маркс, Ленин, Грамши болон Тилли нарын онолуудад хувьсгалын гол элементийг өөр өөр байдлаар тодорхойлсон байдаг. Үүнд:

1. К.Маркс нийгмийн системийг тогтворгүй тэнцвэрийн байдалд оршин харилцан үйлчлэлцэж байдаг элементүүдээс тогтсон нийгмийн байгуулал гэж үзэж байв. Түүнчлэн нийгмийн доторх эдгээр бүлгүүдийн хоорондын зөрчилдөөнийг зогсоож, олонхийн бүлэгт эрх мэдлийг шилжүүлсэнээр нийгмийн шинэчлэлийн асуудлыг шийдвэрлэнэ гэнэ үзсэн нь жам ёсны нийгмийн давхарга, тэдгээрийн оршин тогтнол, ашиг сонирхлын зөрчлийг төдийлөн тооцоололгүйгээр нийгмийн хөдөлгөөнд анхаарлаа хандуулж байв.
2. М.И.Ленин хувьсгал хийх шаардлагатай хөдөлгөөнүүдийг бий болгон, жижиг хэмжээний ашиг сонирхлын тэмцэл бус, боловсон хүчнээс бүрдсэн тодорхой механизм бүхий үйл ажиллагаа явуулахад илүү анхаарсан.

3. А.Грамши намын бүлгийн гол зорилго сонирхлыг хангахад түлхүү анхаарч, ажилчны бүлгүүд өөрсдийн хувийн ашиг сонирхолдоо анхаарч болзошгүйг сайтар тооцоолоогүй.
4. Чарльз Тилли илүү өргөн цар хүрээтэйгээр улс төрийн нөхцөл байдалд анхаарч байсан.

Үүний дараагаар буюу 1970-аад оноос нийгмийн шинжлэх ухааны эрдэмтэд эдийн засагчдын тусламжтайгаар эдгээр асуудлуудыг илүү гүнзгийрүүлэн судалж эхэлсэн байдаг. Өрнөдийн шинжлэх ухаанд Марксизмын эсрэг, нийгмийн хөдөлгөөн үүсэх, өрнөх нөхцлийг тайлбарладаг хоёр гол онол байдаг. Эдгээр нь харьцангуй ядуурлын онол (Relative deprivation theory) ба нөөцийн дайчилгааны онол (Resource mobilization theory) юм.

**Харьцангуй ядуурлын онол:** Энэ онолыг үндэслэгчид Р.Мертон ба Тед Гарр (Ted Robert Gurr) нар үзэхдээ: ядуурал ба шударга бус байдал нь нийтлэг үзэгдэл болсоноор нийгмийн хөдөлгөөнд хүргэдэг гэж үздэг. Улс төр судлаачид, социологичдын үзсэнээр "харьцангуй ядуурал" (ялангуяа цаг хугацааны хувьд харьцангуй ядуу) нь нийгмийн хөдөлгөөн, зөрчилдөөн үүсгэж болзошгүй шалтгаан болж, улс төрийн хүчирхийлэл, терроризм, иргэний дайн, бусад тохиолдлууд гэмт хэрэг зэрэг нийгмийн зөрчлийн уг сурвалж болдог<sup>23</sup> ажээ. Энэ онолоор бол хүмүүс нийгмээс авах эрхтэй гэж бодож байсан үнэт зүйлс болон хуваарилалтын хүлээлт нь горьдлого болон хувирч, нийгмийн шударга ёсны зарчмууд алдагдах, баялагийн хуваарилалтаас үүссэн эрх баригч анги ба иргэдийн хооронд эвлэршгүй зөрчил байдаг дээр үндэслэн хөдөлгөөнийг тайлбарладаг. Олон түмэн өөрсдийн амьдралын түвшинг зарим дээд бүлэгтэй эсвэл урьдынхаа байдалтай харьцуулснаар өдөөгдөн харьцангуй гачигдал, ядуурлын онолын үндэслэл гарч ирдэг(Ted Robert Gurr: 1970).

Харьцангуй ядуурлын онол нь нийгмийн хөдөлгөөний хөгжлийг урьдчилан тодорхойлсон гурван нөхцөл дээр авч үздэг:

- Эхний нөхцөл нь нийгэм, эдийн засгийн аюул сүйрлээр тодорхойлогдох бөгөөд тухайлбал, татварын хэмжээ нь амьдралын үнэмлэхүй түвшинг гэнэт бууруулсныг үзүүлж байдаг. Ихэнх тохиолдолд хүмүүс ямар хууль, дүрэм журам амьдралын чанарыг нь бууруулсаныг сүйрэл нэгэнт ирсэн хойно л сая ойлгож мэдэрдэг байна.

---

<sup>23</sup> Ted Robert Gurr, *Why Men Rebel*, Princeton University Press, 1970; revised edition Paradigm Publishers, 2010

- Хоёр дахь нөхцөл нь хэрэгцээ ба амьдралын бодит стандарт нь хоёулаа өсч байгаа боловч, амьдралын чанар нь нэгэнт буурч эхэлсний дараа хэрэгцээ өсөх нь үргэлжилсээр байгаа үед хүмүүс хууль бус ядуурлыг урьдаас мэдэрдэг.
- Гурав дахь нөхцөлд хэрэгцээ нь амьдралын стандартаас хурдан өсч байгаа учраас эргээд бодит байдал, хэрэгцээ хоёрын хооронд зөрчилдөөн бий болж байдаг.

Харьцангуй ядуурлын онол нь бодит нөхцөл байдал сайжрах юмуу эсвэл өмнөхөөс бага зэрэг ч гэсэн дээшилсэн байх тэр үед нийгмийн хөдөлгөөнүүд бий болдог тухай тайлбар өгдгөөрөө давуу талтай юм. Гэвч энэ онолын талаар хоёр гол шүүмжлэл байдаг:

1. Энэ онол нь хэн илүү гачигдаж байгаа болон ядуурал нь туйлын уу, харьцангуй юу тэдгээр нь нийгмийн хөдөлгөөнд оролцоходоо аль нь илүү нөлөөлсөн зэргийг баталдаггүй. Нийгмийн хөдөлгөөнд оролцогчид нь тухайн өөрсдийн анги давхраанд хүндлэгддэг шилдэг хүмүүс нь байдаг. Мөн олон нөхцөл байдалд хувь хүмүүс нь өөрийнхөө харьяалагддаггүй бүлгийн төлөө нийгмийн хөдөлгөөнд оролцож, удирддаг. Гэвч харьцангуй ядуурлын онолоор бол зөвхөн гачигдаж дутагдсан ядуу хүмүүс л нэгдэх ёстой гэдгийг хэлээд байгаа болохоос үзэл санаагаар нэгдэж нийлэх гэдгийг орхигдуулсанд уг онолын дутагдалтай тал нь оршино.
2. Энэ онол нь чухам ямар харьцангуй гачигдал, ядуурал нь нийгмийн хөдөлгөөн тархах бодит үндэс болсоныг зааж өгч чаддаггүй. Яагаад зарим харьцангуй гачигдал, ядуурал нь нийгмийн хөдөлгөөнийг үүсгээд, зарим нь чаддаггүй юм бэ? гэдгийг тодорхой тайлбарлах хэрэгтэй гэдгийг шүүмжлэгчид цохон тэмдэглэсэн байна. Зарим нэг судалгаагаар харьцангуй гачигдал, ядуурал нь өөрөө нийгмийн хөдөлгөөн гарахад төдийлөн үүрэг гүйцэтгэдэггүй болохыг харуулсан байдаг.

Харьцангуй гачигдал, ядуурлын онол нь хамтын зан үйл үүсэх тухай Смелзерийн үзэл баримтлалтай ямагт холбоотой яригддаг.

**Нөөцийн дайчилгааны онол:** Энэ онолоор бол нийгмийн хөдөлгөөн нь зохион байгуулалттай бүлгүүд ховордсон нөөц баялгийн төлөө хоорондоо тэмцэлдэж байгаа үед үүсдэг. Уг нөөц гэдэгт нь үнэнч үзэл нэгтнүүд, мөнгө, хөдөлгөөнд туслалцаа үзүүлэх чадвартай байгууллага зэрэг нь багтана. Аливаа хөдөлгөөний хувьд зохион байгуулалт бол амин чухал учир зохион байгуулалттай бүлгүүд нь хөдөлгөөний үндсэн нөөц нь болж байдаг. Судлаач Обершаллын

үзлээр: Хэрвээ зохион байгуулалт нь тархай бутархай ганцаардмал хүмүүсээс бүрдвэл хурдан дайчлагаа хийж чадахгүй. Иймд нэгдсэн сайтар зохион байгуулагдсан хамтарч үйл ажиллагаа явуулах чадвартай тэмцэлд дасан зохицсон хүмүүс үнэт нөөц нь болж чадна гэсэн байна. Мөн судлаач Кропусын үзлээр: Хөдөлгөөнд ахин нэгдэх нөхцөлд тухайн гишүүдийнх нь үнэнч байдал чухал нөлөө үзүүлдэг. Энэхүү хүчин зүйл нь нөөцийг улам ч үнэ цэнэтэй болгодог ажээ.<sup>24</sup>

Нөөц дайчилгааны онолыг хоёр лагерьт хувааж болно:

1. Америкийн социологичид болох Жон Д.МкКарти ба Майер Залд (John D. McCarthy and Mayer Zald)<sup>25</sup> нар энэхүү сонгодог эдийн засгийн (бизнес эрхлэгч) онолын хувилбарын зохиогчид төдийгүй гол өмгөөлөгчид юм.
2. Чарльз Тилли ба Донг Мак Адам (Charles Tilly, Doug McAdam) нарын улс төрийн процессийн онол гэж нэрлэгддэг нөөцийн дайчилгааны улс төрийн хувилбарын гол дэмжигчид юм.

Нөөцийн дайчилгааны бизнесийн загвар нь байгууллагын онол болон эдийн засгийн хүчин зүйлсийн үр дүнд бий болсон хамтын үйл ажиллагааг тайлбарладаг. Эндээс үүссэн гомдол нь нийгмийн хөдөлгөөнийг бий болгоход хангалттай бус гэж үзэж маргадаг шүүмжлэгчид бий. Тэд үүний оронд нөөцийн хүртээмж, хяналтыг хянах нь чухал хүчин зүйл. Эрэлт ба нийлүүлэлтийн хэрэгцээний хуулиуд нөөцийн урсгалыг тайлбарлаж, хувь хүний үйлдэл (эсвэл тэдгээрийн дутагдал) нь рационал сонголтын онолоор тодорхойлогддог бөгөөд нөөцийг дайчилж хөдөлгөөн үүсэх боломжгүй гэж үздэг.

Улс төрийн загвар нь эдийн засгийн хүчин зүйлсийн оронд улс төрийн тэмцэл дээр төвлөрдөг. 1980-аад онд нийгмийн байгуулалт, нийгмийн шинэ хөдөлгөөн зэрэг нийгмийн хөдөлгөөнүүдийн бусад онолууд нь нөөцийг дайчлах тогтолцоог бий болгосон. Эдвардс, Маккарти (Edwards and McCarthy) нар нийгмийн хөдөлгөөнд оролцох таван төрлийн нөөцийг олж тогтоосон:<sup>26</sup>

1. Ёс суртахуун: Эв нэгдэлтэй холбоотой дэмжлэг, хууль ёсны байдал, симпатик дэмжлэг зэрэг нийгмийн хөдөлгөөний зохион байгуулалтын нөөц боломжууд. Эдгээр эх сурвалжууд нь бусад эх үүсвэрээс харьцангуй хүртээмжтэй байж, нөөц боломжийг хялбархан татдаг.

---

<sup>24</sup> Д.Оюунцэцэг. Олон нийтийн санал бодлын социологи. УБ., 2000. Тал 147

<sup>25</sup> John D. McCarthy; Mayer N. Zald. Resource Mobilization and Social Movements: A Partial Theory. The American Journal of Sociology. Vol 82. No. 6 (May. 1977). 1212-1241. StaNc URL:

<sup>26</sup> Edwards and McCarthy (2004). The Blackwell Companion to Social Movements. Massachusetts: Blackwell Publishing. pp. 116–152.

2. Соёл: Нийтлэг байж болохуйц өргөн тархсан мэдлэг нь жишээлбэл, жагсаал цуглаан зохион байгуулах, эсвэл интернет, “Social ертөнц-өөр аялах зэрэг тодорхой үүрэг даалгавруудыг биелүүлэх талаар хэрхэн тодорхойлсон бэ гэдгээс хамаарна.
3. Нийгмийн зохион байгуулалт: Мессежийг тараахтай холбоотой нөөцүүд. Тэдгээр нь хөдөлгөөнийг тархаан, дэлгэрүүлэх зорилгоор бүтээгдсэн нийгмийн байгууллагууд юм. Жишээ нь, сурталчилгааны хуудас тараах, олон нийтийн хурал цуглаан зохион байгуулах, сайн дурын ажилтан авах.
4. Материал: Санхүү, биет капитал, ажлын өрөө, мөнгө, тоног төхөөрөмж, хангамж зэрэг орно.
5. Хүний: Тодорхой салбарт хөдөлмөр, туршлага, ур чадвар, туршлага зэрэг нөөц. Бусад (ёс суртахуун, соёл, нийгэм-зохион байгуулалт) -аас илт бодитой, тоо хэмжээг нь тодорхойлоход хялбар байдаг.

Нөөцийн дайчилгааны онол нь эв санааны нэгдлийн онолтой хамтдаа яригддаг. Учир нь нийгмийн хөдөлгөөнийг зохион байгуулагдсан бүлгүүд л үүсгэдэг болохоос ганцаараа бухимдсан хувь хүмүүс үүсгэж чадахгүй. Нөөцийн дайчилгааны онолын дутагдалтай тал нь уур хилэн бухимдлын ач холбогдлыг дорд үзэж нийгмийн хөдөлгөөнийг оньс болдог гэдгийг орхигдуулсанд оршино.

Нөөцийн дайчилгааны онолын нэг онцлог бол нийгмийн хөдөлгөөнийг удирдаж байгаа хүмүүсийн тухай асуудал юм. Хөдөлгөөнийг удирдагчгүйгээр ямар ч нөөцийг дайчлах боломжгүй. Удирдагчид өөрсдийн тодорхой үзэл санааг үг яриа, илтгэл зэргээр ойлгуулж үйлдлийнхээ алсын бодлогыг төлөвлөж байдаг. Нийгмийн хөдөлгөөнд ихэвчлэн ганц удирдагчийн талаар ярьдаг ч хэд хэдэн удирдагч байж болдгийг баримт харуулдаг. Энэ нь шаталсан хэлбэртэйгээр байж ч болдог. Зарим үед эсрэг тэсрэг ашиг сонирхол бүхий хэд хэдэн бүлгүүд нэг үзэл санаа нэгдмэл зорилго дор нэгддэг. Тэд зорилгодоо хүрмэгц тэдний хоорондын харилцааны угт байсан зөрчил нь дахин илэрдэг. (Засгийн эрх мэдлийн ч зөрчил байж болно)

Тухайн хөдөлгөөний хөгжлийн үйл явцад олон хэв маяг бүхий удирдагчид шаардагдана. Хэрэв нийгмийн хөдөлгөөний хөгжилд дөрвөн үеийг онцолж үзвэл тэдгээрт тохирох шаардагдах удирдагчийн хэв маягуудыг дараах байдлаар тодорхойлж болох юм. Үүнд:

- Үйлдэлд өдөөн хатгадаг сурталчлагч хүн.

- Бүх нийтийг хамарсан түгшүүр ажиглагдах үед, хүмүүст үзэл санааны дэмжлэг үзүүлэх, хүмүүсийн дунд санаачпагын эрч хүчийг өдөөж чадах ховсдогч хүн.
- Албан ёсны нэгдмэл зохион байгуулалт үүссэн үед тухайн гишүүдэд шаардлага тавьж, хөдөлмөрийн хуваарийг хянаж, тухайн хөдөлгөөний үйл ажиллагааг хангах болон бусад үүргүүдийг гүйцэтгэдэг хүн.
- Институтжих үйп явц: Энэ үед хөдөлгөөн нь илүү бюрократ шинжийг олж авч, түүнийг нь улс төрийн зүтгэлтэн удирдан явуулна. Ийм удирдагч нь хөдөлгөөнийг бэхжүүлэх тавьсан зорилгуудаа гүйцэлдүүлэхэд нөлөөлж байдаг. Дээр дурьдсан удирдагчийн мөн чанарууд заримдаа нэг хүнд цогцолсон нь ч байдаг.<sup>27</sup>

Н.Смелзер хүмүүсийн хамтын сайн дурын үйлдлүүд нь иргэний хөдөлгөөний үндэс болдог талаарх зургаан нөхцлийг онцлон дурдсан.<sup>28</sup>

- 1) 10. Хамтын зан төлөвт хүргэдэг бүтэцлэг хүчин зүйлс: Нийгмийн бүтэц нь иргэний хөдөлгөөний янз бүрийн хэв маяг үүсэх нөхцлийг дэмжигч хүчин зүйлс болох бөгөөд эсвэл түүнд саад болоход нөлөөлж буй нийгмийн ерөнхий хүчин зүйлс үүнд хамаардаг. Смелзерийн үзсэнээр АНУ-ын нийгэм улс төрийн тогтолцоо нь нийгмийн янз бүрийн бүлэг хүрээнүүдийн харилцаа, иргэний нийгмийн сонирхлоо илэрхийлэх үйл ажиллагаанд төрийн нарийн зохицуулалт байхгүйн улмаас нийгмийн зарим бүлэг, тэдгээрийн үйл ажиллагааны төрийн тодорхой зорилго чиглэлд дайчлахгүй чөлөөтэй орхисон байдаг. Иймэрхүү нөхцөл байдал нь олон нийтийн хөдөлгөөн үүсэхэд илүү тааламжтай нөхцлийг үүсгэдэг ч заримдаа тэдгээрийг үүсгэхгүй байх үндэс болдог. Ихэнх тохиолдолд тэдгээр нийгмийн бүлгүүд асуудлыг өөрсдөө зохицуулах боломжтой байдаг.
- 2) Нийгмийн бүтцийн хурцадмал байдал: Марксын нэр томъёогоор зөрчил нь нийгэм дэх зөрчилт ашиг сонирхлын улмаас үүсдэг. Тодорхойгүй байдал, түгшүүр, хоёрдмол байдал болон зорилгын шууд мөргөлдөөн зэрэг нь ийм хурцадмал байдлын илэрхийлэл болно. Бүтцийн хурцадмал байдал нь нэлээд ерөнхий, эсвэл тухайн тодорхой нөхцөлд хамаарах өвөрмөц шинж чанартай байж болно. Тухайлбал, угсаатны бүлгүүдийн байнгын тэгш бус байдал нь ерөнхий хурцадмал байдлыг үүсгэдэг. Энэ нь жишээлбэл цагаан арьстнуудын

<sup>27</sup> Д.Оюунцэцэг. Олон нийтийн санал бодлын социологи. УБ., 2000. Тал 148-149

<sup>28</sup> Н.Смелзер. Социологи. УБ., 2001. ФСЭХ. Тал 555

хороололд хар арьстнууд суурьшиж эхлэх үед тодорхой зөрчил болон гарч ирдэг.

- 3) Тодорхой итгэл үнэмшил, үнэт зүйлсийн нэгдэл: Олон нийтийн хөдөлгөөнүүд нь ямар нэгэн аюул занал бүдэг бадаг мэдрэгдэх үеэс тэрхүү заналхийлэлд хариу үйлдэл үзүүлэх хэлбэрээр үүсдэг зүйл биш юм. Хөдөлгөөн нь илэрсэн тодорхой асуудалд дургүйцэх хандлагаар үүссэн бөөгнөрөл болон түүний шийдвэрлэх үйлдлийн тодорхой дүр зургийг бий болгогч ямар нэгэн үзэл суртлын нөлөөн дор үүсдэг. Тухайлбал, олон түмний хөдөлгөөн нь оршин буй шударга бус байдлын шалтгаан, түүнээс салах улс төрийн аргуудыг хайсан үзэл санаан дээр үндэслэсэн байдаг.
- 4) Идэвхжүүлэгч хүчин зүйл: Энэ нь хөдөлгөөнд оролцогчдын үйлдлийг эхлүүлж, асаагч механизм болдог үйл явдал бөгөөд ихэвчлэн гэнэтийн явдлууд байдаг. Тухайлбал, 1955 онд Алабама мужийн Монгомери хотод Роза Парксын автобуснууд хар арьстнуудад зориулсан хэсэгт орохоос татгалзсан явдал нь Америкийн иргэний эрхийн төлөөх хөдөлгөөн эхлэх түлхэц болсон байна.
- 5) Зохион байгуулалттай бүлгүүд: Дээрх дөрвөн хүчин зүйлсийн хослолуудыг Смелзер гудамжны үймээн самуун буюу хүчирхийлэл дүрсхийх үндсэн үр дагавар мөн гэж нотолсон. Хэрэв ийм явдал болсон хэдий ч тэдний үйлдлийг дайчлахад бэлхэн зохион байгуулалттай бүлгүүд байхгүй бол, ямар нэгэн хөдөлгөөн үүсэхэд хүргэдэггүй байна. нийгмийн болон иргэний хөдөлгөөн үүсэхэд удирдагчтай байх, гишүүдийн хооронд байнгын харилцах хэрэгсэл, мөн материал, санхүүгийн нөөц байх шаардлагатай байдаг.
- 6) Нийгмийн хяналтын үйл явц: Нийгэмд хяналт тавих гэсэн эрх баригч болон сөрөг хүчнийхэн хурцадмал байдалд хутгалдан оролцож хөдөлгөөн үүсэх, хурцах, идэвхжих нөхцөл болдог. Нөгөө талаар нийгмийн хяналтын үйл явц нь зөрчлийг бууруулж, асуудлыг шийдвэрлэх арга зам бөгөөд энэ нь ихэнхдээ цагдаа болон зэвсэгт хүчний үйлдэлтэй холбогддог.

Смелзерийн үзсэнээр хүчний институтуудын дотоод хагарлын хэмжээ нь хувьсгалт хөдөлгөөн болон оршин буй засгийн сөргөлдөөнийг төгсгөхөд шийдвэрлэгч хүчин зүйл нь болдог ажээ. Түүний загвар нь социал хөдөлгөөн болон хамтын үйлдэл бүрэлдэх үе шатны дарааллыг шинжлэхэд ашигтай байж болно. Түүний үзлээр тухайн гинжин холбооны цагираг бүр нь ерөнхий үр дүнд «жин нэмэх» мэт болгодог бөгөөд дараагийн алхмыг хэрэгжүүлэх нөхцөл болдог байна.

Гэхдээ түүний онолд шүүмжлэх зүйл бий. Хэд хэдэн шалтгаанаар Смелзерийн онолыг шүүмжилжээ. Гол асуудал нь түүнийг бодит амьдралын нөхцөлд хэрэглэхтэй холбогджээ. Шүүмжлэгчдийн үзлээр бол Смелзерийн ялгасан зургаан үе шат нь хамтын зан төлөвийн зарим тохиолдолд тохирохгүй байна. Тухайлбал, Стэнли Мильграм бүтэцлэг зан төлөвийн ямар маяг нь Уоттст бүрэлдсэн нөхцөл байдалд хүргэсэн, мөн ямар хүчин зүйл бослогод хүргэсэн тухай судлаачид элдэв таамаглал дэвшүүлжээ. Баривчллага юу?, Жирэмсэн эмэгтэйн тухай цуу үг үү? Хамтын зан төлөвийн олонхи тохиолдол маш нарийн төвөгтэй учир Смелзерийн онолын зөв бурууг батлах нь бэрхтэй юм. Энэ нь түүний үндсэн дээр таамаглал дэвшүүлэх бололцоог хязгаарлаж байна<sup>29</sup> гэжээ.

Гидденс “Заримдаа социал хөдөлгөөн нь илт сөргөлдөөний утгаар ойлгогдох ямар нэгэн «идэвхжүүлэгч» явдалгүйгээр бэхждэг. Үүний эсрэгээр цуврал өдөөсөн үйлдлүүд нь нөхцөл байдлыг өөрчлөхөд хөдөлгөөнийг зохион байгуулах шаардлагад хүргэж, түүнийг төрүүлдэг. Жишээ нь урьд нь ийм асуудал байгаагүй ч эмэгтэйчүүдийн хөдөлгөөн хүйсийн дарамтыг арилгах, тэгш байдалд хүрэх талаар их амжилтанд хүрч байна. Смелзерийн онол нь социал хөдөлгөөний нөхцөл байдалд өгөх «хариу үйлдэл» хэмээн тайлбарлаж эдгээр хөдөлгөөний гишүүд тодорхой өөрчлөлт хийхийн төлөө гэнэт зохион байгуулагдах боломж байдгийг үл анзаарсан байдаг”<sup>30</sup> гэжээ.

Энэ талаар Смелзерийн үзэл санаа Ален Турены хандлагаас ялгаатай байдаг. А.Турен орчин үеийн нийгмүүдэд зорилгодоо хүрэх активизм буюу идэвхт байдлыг олгож буй ихээхэн ач холбогдлыг нийгмийн хөдөлгөөн тусгаж байдаг гэж онцлон тэмдэглэсэн байдаг.<sup>31</sup> Тэр орчин үеийн нийгмүүдэд түүхэн гэгдэх шинж нийтлэг байдаг бөгөөд өөрөөр хэлбэл бидний оршихуйн социал нөхцлийг өөрчлөхийн тулд хэрэглэдэг социал үйл явцын мэдлэг болох ертөнцийг үзэх үзэл байдаг гэж тэр үзсэн. Тухайлбал, сургууль дээрх тэгш бус байдлын шалтгаан, тархалтыг ойлгосон нь АНУ-д иргэний эрхийн төлөөх хөдөлгөөн өсөх нэг хүчин зүйл болсон. Турен нийгмийн хөдөлгөөний үндэс, нөхцөл төдийгүй мөн тэдгээрийн хүрэхийг уриалсан зорилгыг ч сонирхон үзсэн байдаг. Нийгмийн хөдөлгөөн нь нийгмийн тэгш бус ба шударга бус байдалд хариулагч замбараагүй үйлдэл биш, харин тухайн шударга бус байдлыг даван туулах боломж олгож буй стратегийн дагуу хөгждөг.

---

<sup>29</sup> Milgram, S. A Toctli, H. Collective behavior: Crowds and social movements. In G.Lindzcy & E.Aronson (Eds), The handbook of social psychology (Vol. 4) (2<sup>nd</sup> ed). Boston: Addisson-Wesley, 1969.

<sup>30</sup> А.Гидденс. Социологи. УБ., 2006. НШУС. Социологийн танхим. Тал 527

<sup>31</sup> Tourain Alain. The voice and the Eye: An analysis of Social Movements. Cambridge, 1981.



Нийгмийн хөдөлгөөнийг янз бүрийн холбоодын хоорондох салангид хэлбэрүүд гэж ойлгож болохгүй гэж Турен үзсэн. Тэдгээрийн хөгжил нь бусад бүлгүүд голчлон албан ёсны байгууллагууд, заримдаа өрсөлдөгч хөдөлгөөнтэй зарчмын антагонизмын байдалд явагддаг. Хөдөлгөөн бүрт тэмцэж буй ашиг сонирхол, зорилго, мөн үгүйсгэж буй үзэл санаа, үзэл бодол байдаг. Нийгмийн хөдөлгөөний одоо байгаа онолууд (Смелзер ч бас) хөдөлгөөний зорилгод нөлөөлөгч эсрэг үзэл бодолтнуудтай хэрхэн тэмцдэг, түүнчлэн хөдөлгөөн өөрөө болон өрсөлдөгчдийнхөө үзэл бодол, үйлдлийг хэрхэн өөрчилдгийг зохих ёсоор анхаараагүй гэж Турен үзжээ. Жишээлбэл, эмэгтэйчүүдийн хөдөлгөөний зорилго болон төгс эрхэмлэл нь эрчүүдийн удирдсан институтийн шууд сөрөг хүчин болох гэж бүрэлдээд мөн эдгээр институтуудыг хувирган өөрчлөхөд оршиж байсан. Хөдөлгөөн амжилт, болон ялагдлаас хамаарч зорилго нь өөрөө өөрчлөгдөж байлаа. Эмэгтэйчүүдийн хөдөлгөөний зорилго нь эхний ээлжинд эрэгтэйчүүдийн үзэл бодолд нөлөөлсөн. Дараа нь ертөнцийг үзэх үзлийн өөрчлөлт нь эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг өөрийг нь дахин баримжаа авахад хүргэсэн ба одоо ч энэ үйл явц үргэлжилж байна.

Турен социал хөдөлгөөнийг үйлдлийн талбай гэж нэрлэх дэвсгэр дээр авч үзвэл зохино гэж баталдаг. Энэхүү нэр томъёо нь социал хөдөлгөөн, түүний эсрэг хүч буюу нөлөөллийн хоорондын холбоог илэрхийлнэ. Үйлдлийн тодорхой талбайтай холбогдсон харилцан «гэрээ хэлэлцээр»-ийн үйл явц нь нөхцөл байдлыг өөрчлөх юмуу талуудын байр суурь нийлэхэд хүргэж болно. Аль ч тохиолдолд хөдөлгөөн эсвэл оршин байхаа болино, эсвэл байнга ажиллагч байгууллага болон хувирч институтчилэгдэнэ. Жишээлбэл, Үйлдвэрчний эвлэл гэхэд ажил хаях эрхээ тэмцэн олсны дараагаар албан ёсны байгууллага болон хувирч, ажилчдын хувьд ч эздийн хувьд ч хүлээн авч болохуйц хэлэлцээрийн хэлбэрүүдийг боловсруулсан билээ. Ийм маягаар зөвшилцөл нь өмнө оршин байсан сөргөлдөөн, харилцан хүчирхийллийг халсан юм. Хэрэв зөрчлийн эх булаг хадгалагдан үлдвэл (ажилтан болон ажил олгогчдын харилцааных шиг) шинэ хөдөлгөөн үүсэхийг хүлээж болно.<sup>32</sup>

### **Нийгмийн хөдөлгөөн ба нийгмийн өөрчлөлт**

"Мэйер болон Тарроу нар нийгмийн хөдөлгөөнүүдийн талаарх ойлголтыг "Хүмүүсийн нийтлэг зорилго, эв санааны нэгдмэл байдал нь элит, өрсөлдөгчид, эрх мэдэлтнүүдтэй байнгын харилцаагаар хамтран ажиллахад тулгарч буй

---

<sup>32</sup> А.Гидденс. Социологи. УБ., 2006. НШУС. Социологийн танхим. Тал 527-528

бэрхшээлүүдийн хамтын хүч сорилт юм”<sup>33</sup> гэж тодорхойлжээ (Meyer and Tarrow’s 1998: 4). Энэ тодорхойлолт дээр хоёр онцлог шинж тэмдэг байдаг.<sup>34</sup>

- 1) Нийгмийн хөдөлгөөнүүд нь "хамтын сорилт" (жишээ нь, зохион байгуулалтын зохицуулалтыг өөрчилж, уламжлалт хамтарсан арга хэмжээ авах замаар зохион байгуулах оролдлогуудыг оруулдаг). Эдгээр өөрчлөлтүүд нь судалгааны гол чиг хандлага болсон нийтийн нийгмийн бодлогод төвлөрч, нийгмийн институцийн бүтэц, нийгмийн ашиг тусын хуваарилалт, нийгмийн эрх, үүрэг хариуцлагын ухагдахууныг өргөн хүрээнд өөрчлөх зорилготой юм. Зарим хөдөлгөөн нь албан ёсны хөдөлгөөнтэй байгууллага (SMO) -ийг үүсгэдэг боловч ихэнх нь олон улсын хэмжээнд (Куртис ба Зуререр, 1973) олон нийтийн дунд нийтлэг зорилго, зорилт, үзэл суртал бүхий интерполят сүлжээгээр хоорондоо холбоотой жижиг бүлгүүдтэй ажилладаг (Diani, 1995; Gerlach Hine, 1970). Мөргөлдөөн болон уламжлалт тактикийн аргыг хэрэглэснээр нийгмийн хөдөлгөөнүүд нь зорилтот бүлгүүдийн нүдэн дэх тодорхойгүй байдлыг бий болгож, улмаар тэдгээрийн үйл ажиллагааг өөрчлөхөд түлхэц үзүүлдэг.
- 2) Нийгмийн хөдөлгөөнүүдийн хоёр дахь шинж чанар нь тэдгээрийн уламжлалт улс төрийн шинж чанар юм. Хөдөлгөөний зорилго нь ихэвчлэн эрх мэдэл ба эрх мэдлийн хуваарилалтыг өөрчлөх явдал бөгөөд түүний үр нөлөө бусад улс төрийн оролцогч талууд, ялангуяа улс төрийн холбоотнууд, өрсөлдөгчид, эрх мэдэлтнүүдтэй байнгын харилцан үйлчлэлээс хамааралтай байдаг.

Нийгмийн хөдөлгөөнийг улс төрийн социологийн цөм хэсэгт авчирснаар нийгмийн өөрчлөлтийг бий болгодог үйл явцын талаархи илүү сайн ойлголтыг бий болгож өгдөг.<sup>35</sup> Бид ардчилсан засаглалын хувьд нийгмийн хөдөлгөөн нь нийгмийн өөрчлөлтөд чухал түлхэц болдог хэмээн хэлэлцдэг. Үүнийг хүлээн зөвшөөрснөөр нийгмийн өөрчлөлтийн одоо оршин байгаа онолын гол асуудлуудыг залруулдаг. 1960-аад оны эхэн үеэс стандарт нийгмийн өөрчлөлтийн онолууд (жишээ нь: функционалист, хувьсал, зөрчилдөөн болон тархалтын онолууд) нийгмийн болон улс төрийн өөрчлөлтийн талаар ерөнхий ойлголтыг өгч

---

<sup>33</sup> David S. Meyer, Sidney Tarrow. *The Social Movement Society: Contentions Politics for a New Century*. Oxford 1998. Rowman & Littlefield Publishers, INC.

<sup>34</sup> Thomas Janoski, Robert R. Alford, Alexander M. Hicks, Mildred A. Schwartz. *The Handbook of Political Sociology states, civil societies, and globalization*. Cambridge University Press 2005. P 332.

<sup>35</sup> Ц.Батболд. Улс төрийн социологийн онолын үндэс. УБ., 2018. Арвай принтинг ХХК

чадахгүй байсан. Даниел Чирот ба Чарльз Тилли нарын судлаачид ерөнхий онол боломжгүй бөгөөд түүний илүү сайн хандлага нь хязгаарлагдмал орчинд ажиллаж буй тодорхой бүтэц, зохион байгуулалтын механизмын талаарх болзошгүй маргааныг бий болгодог гэж үздэг.<sup>36</sup>

Ардчилсан засаглалын хувьд нийгмийн хөдөлгөөн нь нийгмийн өөрчлөлтөд чухал түлхэц болдог. Үүнийг хүлээн зөвшөөрснөөр нийгмийн өөрчлөлтийн одоо байгаа онолын гол асуудлуудыг засч залруулахад нөлөөтэй. Өөрчлөлтийн онол нь онолын хувьд хамгийн сайн хөгжиж болох арга зам, түүхэн онцлогоос хамааралтай өөрчлөлтүүдийг харуулдаг тайлбар юм. Ч.Тилли “Бид нийгмийн хөдөлгөөний өөрчлөлтийг ихэвчлэн нийгмийн хөдөлгөөн, тэдний холбоотнууд, өрсөлдөгчид болон эрх баригчдын хоорондох улс төрийн харилцааны тодорхой үр дүнгийн бүтээгдэхүүн гэдэгтэй санал нийлдэг. Жишээ нь, улс төрийн хувьсгал улс төрийн өрсөлдөгчид, үндсэн сүлжээ болон эдгээр харилцааг хязгаарладаг холбоонууд доторх харилцааны хувьд хэсэгчлэн илэрхийлэгддэг” гэжээ (Tilly, 1978:chapter 7).

Ардчилсан шинэчлэлийн мөчлөгт ч үүнтэй ижил үйл явц өрнөдөг (Tarrow, 1998:chapter 10).

Женкинс болон нар төр ба иргэний зөрчилдөөнүүдийн харилцан үйлчлэлийн улс төрийн өгөгдлийн зураглал зурсанаар төрийн дарангуйлал болон нүүр тулсан хүчирхийллийн хүч чадлын золиос болж буй иргэдийн улс төрийн үйл ажиллагааны талаарх индексийг санал болгосон. Тэдгээр нь улс төрийн хүчирхийлэл, хүчирхийллийн дэглэмийн өөрчлөлт, гено-улс төрийн хүчирхийллийн эхэн дэх улс төрийн хямралыг "эрт анхааруулах" дохио болж байсан. Эдгээр дарааллууд нь тодорхой оролцогч талуудын дайралт, шийдвэрээс хамаардаг (ялангуяа хөдөлгөөний удирдагчид болон улс төрийн эрх мэдэлтнүүд), мөн улс төрийн хямралд хүргэх, эсвэл хол байлгах харилцан үйлчилсэн хэв маягийг тодорхойлдог (Jenkins and Bond: 2001).

Хөдөлгөөний зорилго, стратеги нь мөн улс төрийн харилцан үйлчлэл шүүмжлэлтэй хэлбэрээр явагддаг. Гоулдстоун реформист болон хувьсгалт хөдөлгөөнүүд адилхан шударга бус байдал, нөөц, байгууллага болон соёлын эв нэгдлээс бий болдог ч зорилго нь улс төрийн эрх баригчидтай харилцах харьцаанаас хамааран өөр өөр байдаг гэж үзсэн (Goldstone: 1998). Эрх баригчид хүчтэйгээр эсэргүүцэх, хамтран ажиллах эсвэл төвийг сахисан хандлагатай байх, мөн хөдөлгөөнийг зогсоох хүчин чармайлт гаргахгүй байх үед шинэчлэлийн

---

<sup>36</sup> Chirot, Daniel. 1986. *Social Change in the Modern Era*. New York: Harcourt Brace Jovanovich.

хөдөлгөөн гарч ирэх магадлалтай. Төр засаг дарангуйлалыг хориглосон байр суурь баримталж, эсвэл дарангуйлал хэт сул, үр дүнгүй байгаа тохиолдолд ялангуяа улс төрийн өрсөлдөгчидтэй холбоо тогтоох замаар хувьсгалын хөдөлгөөн үүсэх магадлалтай байдаг (Goodwin, 2002).

Улс төрийн үйл явцын ийм төрлийн тайлбар нь одоо оршин байгаа сүлжээ, нөөц баялагийг хуваарилах, одоо байгаа институцийн болон үзэл суртлын бүтцийн хязгаарыг шинжлэх хэрэгцээг үгүйсгэхгүй. Үүнтэй ижил үйл явц байгууллагуудын хүн амын өөрчлөлт болон тодорхой төрлийн нийгмийн хөдөлгөөний байгууллагын оршин тогтноход дэмжлэг үзүүлэх институцийн сонгон шалгаруулах механизмуудыг хамарсан урт хугацааны хувьслын өөрчлөлтөнд ч мөн илэрдэг (Edwards and Marullo, 1995; Hannan and Freeman, 1989; Minkoff, 1995, 1998). Нийгмийн хөдөлгөөнүүд нь нийгэм дэх хувьслын чиг хандлагын эсрэг, эсвэл хамтран ажиллаж байгаа эсэх нь хамгийн чухал асуудал юм. Хөдөлгөөний нийгмийн нөхцөл байдал нь одоо байгаа институцийн хязгаар, түүнчлэн хөдөлгөөнийг өдөөж, тэдгээрийн өөрчлөлтийг үүсгэж болох зөрчилдөөнийг тодорхойлохын тулд авч үзэх ёстой. Эцэст нь нийгмийн хөдөлгөөнүүдэд агуулагдаж буй нийгмийн институциудын хоорондын зөрчилдөөн ба бүтцийн хязгаарыг ойлгох нь чухал юм. Эдгээр бүтэц нь зөвхөн зөрчилдөөн дэх сонирхолыг төдийгүй, тэдний эрх мэдэл, ашиг сонирхол, эмзэг байдал, өөрчлөлтийн эсэргүүцэх чадварыг нь тодорхойлдог интеграцчилагдсан холбоо, харилцан хамаарал зэргийг тодорхойлдог.

Жон Лофланд “Нийгмийн хөдөлгөөний тухай ихэнх судалгаа нь дотогшоо “хөдөлгөөнт төвтэй” байдаг учраас нийгмийн өргөн хүрээнд гарч буй нийгмийн өөрчлөлтийн боломжит үр нөлөөг үл тоомсорлодог”<sup>37</sup> гэжээ (Lofland, 1993:289–91). Нийгмийн хөдөлгөөний үр дүнг судлах явцад тэд өргөн хүрээтэй бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийг бус, ихэвчлэн төрийн бодлогын нөлөөнд илүү анхаарч ирсэн байна.

Нийгмийн хөдөлгөөний үр дүн гэж юу вэ? Гамсон шинэ зүйлийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй гэж үзсэн. Зарим судлаачид (Голдстоун 1980) биет ашгийг хүлээн зөвшөөрөх нь бүтэлгүйтлийн төрөл гэж үздэг. Гэвч, Теилор (1989) хамгийн бага түвшин дэх институт оршин тогтнох эсэх нь эцэстээ хөдөлгөөнийг хурдасгадаг болохыг харуулсан. Ихэнх судалгаа төсвийн нэмэлт зарлагын тухай хуулийг батлах (Бурнштейн, 1985; Санторо, 2002) гэх мэт нүдэнд ил харагдаж буй давуу тал дээр анхаарлаа хандуулдаг (Албриттон, 1979; Жеинэс, 2002; Женнингс,

---

<sup>37</sup> Lofland, John. 1993. *Social Movement Organizations*. New York: Aldine de Gruyter.

1983), гэвч тэд нийгмийн үнэт зүйлс, нөөцийн хуваарилалт (Келли болон Клеин,1980), түүний бүтэц зохион байгуулалт, соёлын өөрчлөлт (Чавез, 1997; Казэнштейн, 1998; Стаггенборг, 1998), бодлогын хэрэгжилтийн тухай асуудлыг орхигдуулсан (Андрюс, 2001) гэж үздэг. Веберийнхээр (1946:8-р бүлэг) бодит ашиг нь нэмэгдсэн статус ба нэр хүнд, соёлын өөрчлөлтүүд болон өдөр тутмын амьдралыг дахин зохион байгуулах гэсэн зүйлсийг багтаадаг гэж үзжээ. Эдгээр өөрчлөлтүүд нь нийгмийн эрх мэдлийн хуваарилалт өөрчлөлтийг тусган харуулжээ.

Нийгмийн хөдөлгөөний өөрчлөлтийг хэд хэдэн шалтгаанаар нийгмийн хөдөлгөөний “амжилт” гэж тодорхойлдог. Нэгдүгээрт, амжилтын тухай асуудал нь ихэвчлэн нийгмийн хөдөлгөөн оролцогч талуудын ашиг сонирхолд болон үр дүнтэй байсан эсэхтэй холбогддог. Үр дүнд хүрэхэд шилжих хөдөлгөөний зөрчилдөөн гардаг ч заримдаа нийгмийн хөдөлгөөнд санамсаргүй үр дүн гарч ирдэг. Мөн зорьсон үр дүн нь үнэхээр ашигтай эсэх гэсэн асуулт урган гарч ирдэг. Аменты, Янг нар гол асуудал нь хөдөлгөөнд оролцогчид нийтийн сайн сайхныг бий болгох гэж үздэг.<sup>38</sup> Нийгмийн хөдөлгөөний үр дүнгийн эдгээр хувилбаруудыг үзнэ үү. Хоёдугаарт, нийгмийн хөдөлгөөний тодорхой шууд үр дагаварын хувьд “амжилт” бол нийгмийн хөдөлгөөний нөлөө гэж дүгнэж болох юм.

Нийгмийн хөдөлгөөний өөрчлөлтөд дүн шинжилгээ хийхэд нийгмийн хөдөлгөөн ба түүний тодорхой үр дүнгийн хоорондох холбоо шаардлагатай гэдгийг харуулж байна. Мөн дүн шинжилгээ нь нийгмийн өөрчлөлт оруулах механизмийг тодорхойлдог. Дүн шинжилгээ нь нийгмийн томоохон байгууллагуудын бүтэц бүхий өргөн хүрээнд үргэлжилж буй нийгмийн өөрчлөлт, төрийн бүтэц, зонхилох улс төрийн холбоо, одоо байгаа үзэл суртал, соёлын нөөц, тухайн өөрчлөлтөд холбогдох асуудлыг агуулдаг.

### **Монгол дахь хөдөлгөөний асуудалд**

Онолын үүднээс авч үзвэл Монголын нийгэмд гарсан 2003 оноос хойш эдүгээ хүртэл үргэлжилж буй нийгмийн идэвхжилийн хэлбэр болох иргэний нийгмийн байгууллагууд, сонирхлын болон шахалтын бүлгүүд, өөрсдийгөө хөдөлгөөн гэж нэрлэсэн янз бүрийн бүлгүүдийн зорилго, тавьж буй шаардлага, үйл ажиллагааны бүтэц хэв маяг, хамрах хүрээ, удирдагчид зэрэг нь нийгмийн хөдөлгөөн гэдэг ангилалд хамруулахад ихээхэн учир дутагдалтай байгаа юм. Онолын хувьд аливаа хөдөлгөөн нь нэг зорилгод нэгдсэн, тодорхой үйл

---

<sup>38</sup> Ц.Батболд. Бюрократ онолын үндэс. УБ.,2013. Тод Магнат ХХК.

ажиллагааны бүтэц хэв маягтай, өргөн хүрээг хамарсан, улс төрийн удирдагчтай байдаг ажээ.

Монголын нийгэмд гарсан 2003-2009 оны хөдөлгөөнүүдийн идэвхжлийг иргэний хөдөлгөөн гэдэг ангилалд хамааруулж үзэх нь илүү зохимжтой байж болох юм. Учир нь хөдөлгөөний идэвхжил нь нийгмийн гишүүдийн олонхийн дэмжлэгийг авч чадаагүй, хамрах хүрээ багатай, хэсэг бусаг шинжтэй төдийгүй хоорондоо зөрчилдөх хандлагатай байсан. Энэ нь хөдөлгөөнүүд нэгдмэл нэг зорилгод бүрэн төвлөрч чадаагүй, улс төрийн лидерүүд нь эрх барьж буй хоёр намд шургалсан, үлдсэн ганц лидерээ зарим бүлгүүд нь хүлээн зөвшөөрөхгүй байсан зэрэг нь түүнийг нийгмийн хөдөлгөөн болж өргөжих боломжийг үгүй хийсэн байж болох юм. Нөгөө талаар нийгмийн хөдөлгөөний нэгдмэл бүтэц зохион байгуулалт бүхий нэгдмэл удирдлага бүрдэж чадаагүй байсан нь нөлөөлжээ. Энэ утгаараа нийгмийн хөдөлгөөн гэдэг ангилалд хамрагдах боломжгүй юм.

Харин иргэний эрхийн хөдөлгөөн нь нийгмийн нэг хэсэг бүлгийн эрх ашгийг хамгаалж идэвхжсэнээр нийгмийн хөдөлгөөн болж хувирах явдал байдаг. Энэ утгаар иргэний эрхийн хөдөлгөөн хэсэг бусаг шинжтэй үүсдэг бол, оршин буй засаглалын бодлого шийдвэр, эрх баригчдын шударга бус үйлдлийг эсэргүүцсэн иргэний эмх замбараагүй эсэргүүцлийн хэлбэрүүд янз бүрийн хөдөлгөөний хэлбэрт шилждэг ажээ. Эдгээр хөдөлгөөнүүдийн тавьж буй шаардлага, эсэргүүцэж буй бодлого нь хоорондоо адилгүй, өвөрмөц шинжтэй байдаг. Энэ хувилбар нь ихэнх тохиолдолд үйлдвэржээгүй, иргэний нийгмийн хөгжил сул, нийгэм эдийн засгийн хөгжлийн түвшин бага орнуудад түгээмэл байдаг ажээ. Яг ийм хэлбэр Монголд 2003-2009 оны хөдөлгөөнүүдийн идэвхжлийн үед тохиосон бөгөөд хамрах хүрээ нь өргөжиж, нийслэл хот төдийгүй хөдөө орон нутгийн уул уурхай бүхий олон газруудад эсэргүүцлийн хөдөлгөөнүүд гарсан юм. Иргэний хөдөлгөөн нь нийгмийг бүрэн хамарч чадалгүй дарагддаг явдал түгээмэл байдаг. Энэ утгаараа иргэний хөдөлгөөн нь хамрах хүрээ багатай, хэсэг бусаг шинжтэй төдийгүй хоорондоо зөрчилдөх хандлагатай байдаг. Мөн олон лидерүүдтэй байдаг бөгөөд тэдгээр лидерүүд нь ихэнхдээ эвлэлдэн нэгдэж чаддаггүй өөр өөрийн зорилго, амбицтай байдаг ажээ. Аливаа хөдөлгөөн нэг зорилго, үнэт зүйлс дээр тулгуурлаж үйл ажиллагаа нь идэвхиждэг бөгөөд тухайн цаг үеийн хөдөлгөөн гэж нэрлэж болох нэг зорилго, үнэт зүйлс нь Оюу Толгойн гэрээтэй холбоотой нөөц баялагийн үндэсний үзэл байсан юм. Энэ утгаар нь иргэний хөдөлгөөн гэдэг ангилалд хамруулж болно.

Зарим улс төрчид, судлаачид үүнийг хөдөлгөөн гэхээс илүүтэй шахалтын бүлэг гэж үзсэн байдаг. 2003 оноос эхэлсэн хөдөлгөөний асуудлыг судалж байхад эхэн үедээ шахалтын бүлгийн хэлбэрээр үүссэн иргэний нийгмийн тэмцэл нь аажмаар нөөц баялагийн үндэсний үзэлд тулгуурласан иргэний хөдөлгөөн болж хувирсан байна. Хэрэв эхнээсээ шахалтын бүлгийн хэлбэрээр үүсээгүй бол, магадгүй нийгмийн хөдөлгөөн болж идэвхжих магадлал өндөр байсан байж болох, эсвэл огт хөдөлгөөн үүсэхгүй байж болох гэсэн хоёр хувилбар гарч ирдэг. Шахалтын бүлгийн хэлбэрээр үүссэнийг батлах логик нь хөдөлгөөний удирдагчдын урвамтгай шинж чанар харуулж байдаг. Шахалтын бүлэг гэдэг бол тодорхой нэг томоохон компаний, эсвэл сөрөг улс төрийн хүчний захиалга, санхүүжилтээр хийгддэг улс төрийн тоглоом юм.

Хэдийгээр иргэний хөдөлгөөн 2009 онд Оюу Толгойн гэрээ хийгдэж дууссаны дараа суларч идэвхгүй болсон боловч, асуудал шийдэгдээгүй улам гүнзгийрч “тартагтаа тулсан” тул, ахин хөдөлгөөн, тэр дундаа нийгмийн томоохон хөдөлгөөн үүсэж, нийгмийн өөрчлөлт явагдах нөхцөл улам бүр нэмэгдсээр байна. Энэ нь Уул уурхай, ашигт малтмалын нөөцтэй холбоотой улс орон ард түмэнд ашиггүй гэрээ хэлцлүүд, янз бүрийн хайгуулын болон ашиглалтын лицензүүд болон ээлжлэн эрх барьдаг хоёр намын засаглалын шударга бус хуваарилалтууд, нийгмийн шударга ёсыг алдагдуулсан хараат шүүхийн тогтолцоо зэрэг олон хүчин зүйлсээр улам бүр засаглалын ялзрал явагдаж байгаагаар илэрч байна. Энэ утгаараа нийгмийн хөдөлгөөний оюун санааны хүрээ аль хэдий нь бий болсон гэдэг тодорхой юм.

#### **Дүгнэлт:**

Монголд 2003-2009 оны хооронд өрнөсөн хөдөлгөөнүүдийн идэвхжлийн үеийг иргэний хөдөлгөөн гэдэг ангилалд хамруулж үзэж болно. Монголд өрнөсөн иргэний хөдөлгөөн нь анх үүсэхдээ шахалтын бүлэг хэлбэрээр үүссэн бөгөөд иргэний нийгмийн тэмцэл нь аажмаар нөөц баялагийн үндэсний үзэлд тулгуурласан иргэний хөдөлгөөн болж хувирсан байна. Хэдийгээр иргэний хөдөлгөөн 2009 онд Оюу Толгойн гэрээ хийгдэж дууссаны дараа суларч идэвхгүй болсон боловч, асуудал шийдэгдээгүй улам гүнзгийрч “тартагтаа тулсан” тул, ахин хөдөлгөөн, тэр дундаа нийгмийн томоохон хөдөлгөөн үүсэж, нийгмийн өөрчлөлт явагдах нөхцөл улам бүр нэмэгдсээр байна.

**Abstract:** The article main aims show that the movements were appeared in society of Mongolia from 2003 to 2009 and their rivals; they were related in theoretical factors of the social movements, in order to identify their essences. In this meaning, as

determining the theoretical approaches which were movements or interest compression groups and political actors in Mongolia? In order to explain the relation between movements and interests or compression groups, whether they were social movements which can be determine their stages of political process of social changes.

**Ашигласан ном, материал:**

- А.Гидденс. Социологи. УБ., 2006. НШУС. Социологийн танхим.
- Н.Смелзер. Социологи. УБ., 2001. ФСЭХ.
- Ц.Батболд. Бюрократ онолын үндэс. УБ.,2013. Тод Магнат ХХК.
- Д.Оюунцэцэг. Олон нийтийн санал бодлын социологи. УБ., 2000.
- Ц.Батболд. Улс төрийн социологийн онолын үндэс. УБ., 2018. Арвай принтинг ХХК
- Jenkins, J. Craig. 1983. "Resource mobilization theory and the study of social movements." *Annual Review of Sociology* 9:527
- Thomas Janoski, Robert R. Alford, Alexander M. Hicks, Mildred A. Schwartz. *The Handbook of Political Sociology states, civil societies, and globalization.* Cambridge University Press 2005.
- Burstein, Paul. 1985. *Discrimination, Jobs, and Politics: The Struggle for Equal Employment Opportunity in the United States, 1940–1980.* Chicago: University of Chicago Press.
- Melucci, A. (1989). *Nomads of the Present: Social Movements and Individual Needs in Contemporary Society*, ed. J. Keane and P. Mier. London: Hutchinson Radius.
- Goffman, E. (1974). *Frame analysis: An essay on the organization of experience.* Cambridge, MA: Harvard University Press.
- Gamson, W. A. & Modigliani, A. (1987) *The changing culture of affirmative action.* *Research in Political Sociology*, 3.
- Snow, D. A., & Benford, R. D. (1988). Ideology, frame resonance, and participant mobilization. In B. Klandermans, H. Kriesi, & S. Tarrow (Eds.), *International social movement research.* Vol. 1, CT: JAI Press.
- Snow,D.A.; Rochford,E. B.; Worden, S. K.; Benford, R. D. (1986). "Frame alignment processes, micromobilization, and movement participation". *American Sociological Review.* 51 (4)
- Tarrow, Sidney G. 1994. *Power in Movement: Social Movements, Collective Action and Politics.* New York: Oxford University Press.
- Form, William. 1985. *Divided We Stand: Working Class Stratification in America.* Urbana: University of Illinois Press.



- Form, William. 1990. "Institutional analysis: An organizational approach." in Maureen T. Hallinan, David M. Klein, and Jennifer Glass (ed.), *Change in Societal Institutions* New York: Plenum.
- Sidney G. Tarrow. *Power in Movement: Social Movements and Contentious Politics*. L., 1994. Cambridge University Press.
- Ted Robert Gurr, *Why Men Rebel*, Princeton University Press, 1970; revised edition Paradigm Publishers, 2010
- John D. McCarthy; Mayer N. Zald. Resource Mobilization and Social Movements: A Partial Theory. *The American Journal of Sociology*. VoL 82. No. 6 (May. 1977). 1212-1241. StaNc URL:
- Edwards and McCarthy (2004). *The Blackwell Companion to Social Movements*. Massachusetts: Blackwell Publishing.
- Milgram, S. A Toeli, H. Collective behavior: Crowds and social movements. In G.Lindzcy & E.Aronson (Eds), *The handbook of social psychology* (Vol. 4) (2nd ed). Boston: Addisson-Wesley, 1969.
- Tourain Alain. *The voice and the Eye: An analysis of Social Movements*. Cambridge, 1981.
- David S. Meyer, Sidney Tarrow. *The Social Movement Society: Contentions Politics for a New Century*. Oxford 1998. Rowman & Littlefield Publishers, INC.
- Chiot, Daniel. 1986. *Social Change in the Modern Era*. New York: Harcourt Brace Jovanovich
- Lofland, John. 1993. *Social Movement Organizations*. New York: Aldine de Gruyter.

**ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГЫН САНХҮҮЖИЛТИЙН  
ЗАРИМ АСУУДАЛД**

**Ё.Довчин**

МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,  
Улс төр судлалын тэнхимийн зөвлөх профессор

**Г.Адьяадэлгэр**

МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,  
Улс төр судлалын тэнхимийн магистрант

**Түлхүүр үг:** иргэний нийгэм, төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагын санхүүжилт

**Товч хураангуй:** Энэхүү өгүүлэлд Монгол дахь иргэний нийгмийн байгууллагын санхүүжилт, татварын зохицуулалтын талаар авч үзэхийн хамт мөн гадаад орнууд дахь иргэний нийгмийн байгууллагын санхүүжилтын зарим туршлага, эрх зүйн үндэслэлийг судалсан болно. Иргэний нийгмийн байгууллагын санхүүжилтыг оновчтой шийдвэрлэх нь иргэний нийгмийг төлөвшүүлэхэд чухал нөлөөтэй болохыг тодорхойлохыг зорилоо .

Ардчилсан өөрчлөлтийн дүнд үр дүнд Монголд иргэний нийгмийн үзэл санаа 1990-ээд оноос дэлгэрч, улмаар шинэ Үндсэн хуульд тусгалаа олсон байна. XVIII зуунаас зах зээлийн эдийн засаг, хувийн өмч, парламентад ёс, хүний эрх, эрх зүйт төр гэх зэрэг шинэ шинэ ойлголт, үзэл санаа бий болсны нэг нь иргэний нийгэм. Иргэний нийгмийн талаарх ойлголт, үзэл баримтлалыг Ж.Локк, А.Фергюсон, Ш.Л.Монтескье, С.Пупендорф, И.Кант нарын сэтгэгчид боловсруулсан байдаг. Ф.Гегель эрх зүйт төр ба иргэний нийгэм нь нэг зоосны хоёр тал гэж үзэж байжээ. Эрх зүйт төр нь хуульд үндэслэн үйл ажиллагаагаа явуулдаг, хүний эрх, улс төрийн олон ургалч байдал, эрх мэдлийн хуваарилалт, хяналт шалгалт гэсэн ойлголт багтдаг.

Манай улс парламентын засаглалтай учир УИХ-ын 76 гишүүн Монгол улсын нийт ард түмний эрх ашгийг төлөөлөн төрийн эрх барих дээд байгууллагад сонгогдон ажилладаг. Гэвч энэхүү төлөөлөл нь үүргээ бүрэн гүйцэтгэж байна уу гэдэг нь эргэлзээтэй байгаа. Тиймээс иргэний нийгмийн байгууллага нь төр,

нийгмийн хоорондох орон зайг нөхөн, энэхүү үүргээс хуваалцан иргэдийн дуу хоолой болж ажиллах эрх бүхий субъект юм. Т.Пэйн “Иргэний нийгэм нь эрхэм сайн зүйл харин төр зайлшгүй үүсдэг хорт муу зүйл тул иргэний нийгэм төгс төгөлдөр болох тусам төр хэрэггүй болно”<sup>1</sup> гэж тэмдэглэжээ. Иргэний нийгэм нь иргэн, төрийг холбож, иргэд хэрэгцээ шаардлага, ашиг сонирхолоо төрөөс хамгаалж төрийн дарангуйлалын эсрэг үзэл бодлоо илэрхийлэн, төрөөс ангид бодит үйл ажиллагаа явуулах орчин гэдэг нь ойлгомжтой байна.

Иргэний нийгмийн нийгэмд гүйцэтгэх үүргийг авч үзвэл: ардчиллыг бэхжүүлэх, нээлттэй, ил тод, хариуцлагатай төрийг бий болгох, авлигатай тэмцэх, нийгмийн хариуцлагыг бий болгох, хүний эрхийг хамгаалах, шийдвэрлэгдээгүй асуудлуудыг илрүүлж гаргах, түүнд анхаарлыг чиглүүлж хяналт тавих, мэдлэг чадвартай хариуцлагатай иргэдийг төлөвшүүлэн иргэдийн оролцоог бүх түвшний шийдвэр гаргах үйл явцад нэмэгдүүлэн улс төр, байгаль орчин, нийгмийн болон орон нутгийн асуудлаар иргэдийн ашиг сонирхлыг илэрхийлэх, зохих байгууллага албан тушаалтанд дуу хоолойгоо хүргэх орчин зэргийг дурдаж болох юм. Иргэний нийгэм нь хамтын хүсэл, сонирхлоо хэрэгжүүлэхээр хүмүүс сайн дураараа нэгдсэн төр, гэр бүл, зах зээлийн хоорондох институт, байгууллага, хувийн хэвслүүдийн нийлбэрийг хамарсан ойлголт юм. Нийгмийн энэ салбарын байгууллагуудыг ерөнхийд нь нийтийн эрх ашигт чиглэгдсэн, ашгийн төлөө бус байгууллага гэж нэрлэдэг. Нийгэмд үйлчилдэг иргэний нийгмийн байгууллагууд дотор төрийн бус байгууллагын үйл ажиллагаа нь соёл урлаг, боловсрол, хүмүүжил, шинжлэх ухаан, эрүүл мэнд, байгаль орчин, хүний эрх, хүн амын тодорхой бүлэг давхаргын эрх ашгийг хамгаалах зэргийг хамруулдаг байна.

Төрийн оролцоо нийгмийн амьдралын бүхий л салбарт нэмэгдэхийн хэрээр түүний бүтэц улам данхайж, шат дамжлага ихсэх тусам хүнд суртал, авлига хээл хахууль нэмэгддэг. Үүнээс зайлсхийх нэг арга зам нь төрийн зарим чиг үүргийг чадварлаг боловсон хүчинтэй, тогтвортой үйл ажиллагаа явуулдаг, чадавхи бүхий иргэний нийгмийн байгууллагад шилжүүлэхэд оршино. Тиймээс чадавхитай иргэний нийгмийн байгууллагыг төлөвшүүлэхэд ардчилалыг бэхжүүлэх, засаглалыг зохистой хуваарилах, хүний хөгжлийг дэмжих, хэвлэл мэдээллийн эрх чөлөө, санхүү эдийн засгийн дэмжлэг, нийгмийн шударга ёс, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, эрх зүйт төрийг хөгжүүлэх нь чухал ач холбогдолтой юм. Гэвч иргэний нийгмийн төрд нөлөөлөх нөөц чадавхийг

---

<sup>1</sup>МУ-ын ШУА –ийн Философи, социологи, эрх зүйн хүрээлэн., Монгол дахь иргэний нийгмийн төлөвшил ЭШБХ-ын илтгэлийн эмхтгэл., ху-18., УБ 2013

дээшлүүлэхэд иргэний нийгмийн байгууллагын санхүүжилтийн асуудал ихээхэн ач холбогдолтой. Үүнд төрийн дэмжлэг зайлшгүй шаардлагатай бөгөөд энэ нь иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагааг тогтвортой, үр дүнтэй, олон нийтэд хүртээмжтэй болгоход гол түлхэц болох учиртай.

Ашгийн төлөө бус байгууллагын хамгийн түгээмэл хэлбэрт үйлдвэрчний эвлэл, улс төрийн нам, шашны байгууллага зэргийг хамааруулж болно. Монгол Улсын Төрийн бус байгууллагын тухай хуулийн 3.1. Энэ хууль нам, үйлдвэрчний эвлэл, сүм хийдээс бусад төрийн бус байгууллагад хамаарна гэж заасан байдаг. Үүнээс үзэхэд эдгээр субъектууд нь санхүүжилтын хувьд ТББ-аас өөрөөр зохицуулалттай байдаг гэж үзэж болохоор байна. Тухайлбал, Монгол Улсад шашны олон урсгалууд нэвтэрч сүм хийдүүд үйл ажиллагаа явуулж байгаа. Эдгээрийн харилцааг зохицуулсан Төр, Сүм хийдийн харилцааны тухай хуулийн 11.4-т “Сүм хийд нь шашин номын үйл ажиллагаагаа эрхлэн явуулах, ахуйн хэрэгцээгээ хангахад зайлшгүй шаардагдах аж ахуйг өмчийнхөө хүрээнд эрхэлж болно” гэсэн заалт байдаг ч, олсон ашиг болон үйл ажиллагаа, санхүүгийн тайлангаа мэдээлэх зохицуулалт байдаггүй, татварын харилцааны зохицуулалт одоогоор байхгүй байна. Улс төрийн нам, үйлдвэрчний эвлэл төрөөс ямар нэг байдлаар санхүүжилт авдаг. Тухайлбал, улс төрийн намын тухай хуулийн 19.1. Улсын Их Хурлын сонгуулиар тухайн намын авсан саналыг нийт хүчинтэй саналын тоотой харьцуулах зарчмаар нэг саналыг мянган төгрөгөөр тооцож, сонгуулийн дүн гарсны дараа гурван сарын дотор багтаан Улсын Их Хуралд суудал бүхий намд төр нэг удаа мөнгөн дэмжлэг үзүүлнэ. Мөн 19.2. Улсын Их Хуралд суудал бүхий намд түүний авсан суудлын тоогоор Улсын Их Хурлын гишүүний нэг суудлыг жилд арван сая төгрөгөөр тооцож, Улсын Их Хурлын тухайн бүрэн эрхийн хугацаанд улирал тутам улсын төсвөөс санхүүжилт олгоно. Энэхүү санхүүжилтийн 50 хувийг Улсын Их Хурлын гишүүдийн сонгуулийн тойрогт явуулах үйл ажиллагаанд зарцуулна. Дээр заасан мөнгөн дүнг мөнгөний ханшийн өөрчлөлтийг харгалзан өөрчлөн тогтоож байна гэж заасан байдаг. Харин төрийн бус байгууллагын тухай хуульд улсын төсвөөс олгосон мөнгө нь санхүүгийн эх үүсвэрийнх нь нэг болно гэж дурдсан байдаг. Гэвч ямар шаардлага хангасан ТББ, төрөөс дэмжлэг авах нь бүрхэг хэвээр байна.

Олон улсад судлаачдын тооцоолсноор иргэний нийгмийн байгууллагын орлогын талаас илүү хувь нь үзүүлсэн үйлчилгээний хөлс, хөрөнгө оруулалт, арилжааны бусад эх үүсвэрийн орлогоос эсвэл зуу орчим хувь нь нийгмийн хамгаалал, халамж болон засгийн газрын байгууллагын үзүүлдэг үйлчилгээг

гэрээгээр гүйцэтгэсний төлбөрийн хэлбэрээр олгодог төрийн сангийн эх үүсвэрээс, 12 хувь нь хүмүүс, сан, бизнесийн байгууллагуудын хандиваас бүрддэг гэсэн тооцоо байна<sup>2</sup>. Энэ нь төрийн бус байгууллагын санхүүжилтийн бүтцийгерөнхийд нь илэрхийлж байгаа юм.

Тиймээс төрөөс иргэний нийгмийн нэг үндсэн бүрэлдэхүүн хэсэг болсон ТББ-ын үйл ажиллагааг бодлогоор дэмжих шаардлагатай нь тодорхой бөгөөд үүнийг бусад улс оронд янз бүрээр хэрэгжүүлж байна. Тухайлбал, Польш улсад төрийн бус байгууллагын санхүүжилтийн 43 хувийг орон нутгийн засаг захиргаа, 14 хувийг Европын холбооноос санхүүжүүлдэг ажээ. Тиймээс 2004 онд засгийн газраас “татварыг хөнгөлөх арга хэмжээ” хэмээх хөтөлбөрийг хэрэгжүүлж татвар төлөгч нь өөрийн төлөх татварын 1 хувийг ашгийн бус байгууллагад хандивлах боломжтой буюу нийгэмд ач тустай үйл ажиллагаа явуулдаг аль нэг төрийн бус байгууллагад зориулан нэр зааж тодорхойлж өгөх”<sup>3</sup> санаачилга байдаг байна. Ийм санаачилгыг Польш улсаас гадна Унгар, Словак, Литва, Румын улсуудын татварынхуульд тусгалаа олсон байна.

Польш улсад дээрх санаачлага нь эхний 2-3 жилд төдийлөн амжилттай хэрэгжээгүй боловч олон нийтэд ухуулга сурталчилгааг сайн явуулсны дүнд татвар төлөгчдийн 30 гаруй хувь нь дээрх аргыг ашиглаж байна.<sup>4</sup> Мөн төрийн бус байгууллагын орлого нь гишүүдийн хандив, орон нутгийн захиргааны нэмэлт олговор, хувь хүн болон хуулийн этгээдийн хандив гэсэн гурван үндсэн эх үүсвэрээс бүрдэж байна. Уг орлогыг хэрхэн зарцуулж байгаа талаар санхүүжүүлэгч субъектүүдэд тайлагнах үүрэгтэй байна. Польш улсад ашгийн төлөө бус байгууллага, төрийн бус байгууллагыг дараах хоёр шалгуурыг хангасан тохиолдолд албан татвараас чөлөөлдөг байна.

1. Дүрмийн дагуу үйл ажиллагаагаа явуулсан
2. Явуулж буй үйл ажиллагаа нь олон нийтийн тусын тулд чиглэсэн байхыг шаарддаг.

Дээрх олон нийтийн тусын төлөөх үйл ажиллагаанд боловсрол, соёл урлаг, спорт, техник технологи, физикийн салбарын ажил, байгаль хамгаалал, зам, харилцаа холбоо, газар тариалан, эрүүл мэндийн, нийгмийн халамж, хөдөлмөрийн чадваргүйиргэдэд туслах, католик сүм ажиллуулах зэрэг үйл ажиллагааг хамааруулан ойлгодог байна.

---

<sup>2</sup><http://www.mapssd.mn/index.php?pageId=2&op=read&item=115>

<sup>3</sup>[http://www.openforum.mn/index.php/index.php?sel=article&obj\\_id=4470](http://www.openforum.mn/index.php/index.php?sel=article&obj_id=4470)

<sup>4</sup>Төрийн бус байгууллагын эрх зүйн зохицуулалтын зарим асуудалд.,Хууль зүйн үндэсний хүрээлэн., УБ.,2013.,ху-31

Иймээс олон улсын хэмжээнд төрийн бус байгууллагын татварын хөнгөлөлтийн нэг хувилбар нь ТББ-ыг тавьсан зорилго, түүндээ чиглэсэн үйл ажиллагаа явуулж байгаа эсэхээр зааглан шалгуур болгож бүхэлд нь татвараар дарамт учруулахгүй байхаар зохицуулалт хийж мөн төрөөс санхүүжүүлдэг нь тодорхой байна. Нөгөө хувилбар бол, ямар ч аж ахуйн үйл ажиллагаа явуулж болно. Ашигтай ажилласныхаа татвараа төлнө. Харин олсон орлогоо хэн нэгэн этгээдэд хуваарилахгүйгээр зорилгодоо нийцсэн ажилд зарцуулах ёстой байдаг. Учир нь иргэний нийгмийн байгууллагад татварыг өндөр тогтоох нь иргэний байгууллагатай байх нийгмийн ашиг сонирхлыг боогдуулна гэж үздэг байна.

Манай улсын хувьд иргэний нийгэм, ялангуяа олон нийтийн байгууллагуудын санхүүгийн чадавх сул, гол төлөв донор байгууллагуудын дэмжлэг, тусалцаанд тулгуурлан үйл ажиллагаа явуулах нь зонхилж ирсэн бөгөөд энэ нь өнөөгийн холбогдох хуульд иргэний нийгмийн байгууллагууд аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх боломжгүй гэж заасан байдагтай холбоотой.

Монгол улсын Үндэсний статистикийн хорооноос явуулсан аж ахуй нэгж байгууллагын 2016 оны тооллогоор ТББ-ууд 2015 онд нийт 1383.1 тэрбум төгрөгийн санхүүжилт авсны 43.9 хувийг олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрөөс, 15.6 хувийг хандив, тусламжаас, 11.7 хувийг гишүүний татвараас, үлдэх 28.8 хувийг бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн байна<sup>5</sup>. Эндээс монгол дахь төрийн бус байгууллагуудын санхүүжилтын эх үүсвэрийг харж болно. ТББ-уудын санхүүгийн боломж, чадавх харилцан адилгүй байгаа ч санхүүжилтийн эх үүсвэр нь тогтвортой бус шинжтэй байна.

Түүнчлэн манай улсын иргэний нийгмийн байгууллагаас төрийн байгууллагын үйл ажиллагааг хянах, хамтран ажиллах боломж ч хязгаарлагдмал байгаа нь нэг талаар санхүүжилт түүний татварын бодлого нөлөөлж байгаа нь илэрхий байна.

“Иргэний нийгмийн тогтвортой хөгжлийг хангах төрийн бодлого” сэдэвт иргэний нийгмийн төлөөлөгчидтэй хийсэн уулзалт дээр: 2011 оны байдлаар Монгол улсын хэмжээнд 12.000 орчим төрийн бус байгууллага, 60 орчим мэргэжлийн холбоод үйл ажиллагаа явуулдаг. Үүнээс татварын тайлангаа өгдөг 178 төрийн бус байгууллага идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгааг албаны эх сурвалж мэдээлэж байсан бол харин 2016 оны байдлаар 12851 төрийн бус байгууллага бүртгэлтэй

---

<sup>5</sup>Аж ахуй нэгж байгууллагын 2016 оны улсын тооллого., Монгол Улсын Үндэсний Статистикийн хороо., УБ., 2017., ху-105

байгаа бөгөөд үйл ажиллагааны төрлөөр нь ангилж үзвэл, 9754 нь буюу 75.9 хувь нь нийгэмд үйлчилдэг, 3097 нь буюу 24.1 хувь нь гишүүддээ үйлчилдэг ТББ байна<sup>6</sup>. Үүнээс татварын албанд бүртгэлтэй, татвар төлөгч төрийн бус байгууллагын тоо 2014-2017 оны байдлаар 147 гэж бүртгэгдсэн байна. Эдгээр 147 төрийн бус байгууллагаас нийгмийн даатгалын шимтгэл төлөгч ажил олгогч, даатгуулагчийн тоо 2014 онд 32, 2015 онд 33, 2016 онд 35, 2017 онд 40 болсон байна<sup>7</sup>.

Татвартай холбоотойгоор төрийн бус байгууллагыг аж ахуйн нэгжийн орлогыналбан татвараас хөнгөлөх, чөлөөлөх тухай хуульд тусгайлсан зохицуулалт байхгүйба “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай” хуулийн 19 дүгээр зүйлийн 19.10. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс үүсгэн байгуулсан төрийн бус байгууллагыг дэмжих зорилгоор аж ахуйн нэгж, иргэнээс хандивласан нэг сая хүртэлх хэмжээний төгрөгийг ийнхүү хандивласан болох нь тогтоогдсон тохиолдолд тухайн татварын жилд уг аж ахуйн нэгжийн албан татвар ногдох орлогоос хасч тооцно” гэж зааснаас үзвэл зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс үүсгэн байгуулсан төрийн бус байгууллагад хандивласан нэг сая төгрөг хүртэлх орлогыг татвараас хөнгөлөхөөр зохицуулсан байна.

Манай улсад мөрдөгдөж байгаа татварын хуулиудаар ТББ нь дараах нөхцөлд татвар төлдөг байна. Үүнд:

1. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн (2015) 5.2 дахь заалтын дагуу үйлажиллагаа, борлуулалтын орлого нь 50 сая төгрөгөөс дээш хувь хүн, хуулийн этгээд НӨАТ төлөгч болох тул ТББ нь НӨАТ төлөгч болно
2. ТББ нь ажил олгогчийн хувьд Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн (2007) дагуу ХХОАТ-ыг суутган төлөгч болно.
3. ТББ нь Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулиар (2008) Монгол улсын хилээр бараа, бүтээгдэхүүн нэвтрүүлэхэд гаалийн татвар төлөгч болно<sup>8</sup>

ТББ-н үйл ажиллагааг явуулахад учирдаг хүндрэл бэрхшээлийн нэг нь гаалийн татвар байдаг байна. Тухайлбал “ манай ТББ-д нь гадны нэг ТББ-аас оффисын тавилга, техник хэрэгслэлийг үнэгүй өгсөн. Үүнийг гаалийн татвараас чөлөөлөх

<sup>6</sup>Аж ахуй нэгж байгууллагын 2016 оны улсын тооллого., Монгол Улсын Үндэсний Статистикийн хороо., УБ., 2017., ху-106

<sup>7</sup><http://shilendans.gov.mn/pdfview?file=adfeb8db0a0265a73b076e1d93284cef.pdf>

<sup>8</sup>Төрийн бус байгууллагын тухай хуулийг шинэчлэн найруулах хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа. (ХЗДХЯ, Швейцарын Хөгжлийн Агентлагын хамтран хэрэгжүүлж буй “Иргэдийн оролцоо II” төслийн захиалгаар)., УБ., 2017., ху-21

боломжгүй гэсэн тул шинэ тутам байгуулагдсан манай ТББ-д их хүндрэлтэй байсан. Цаашид ашигийн төлөө бус байгууллагад нэн хэрэгтэй, ашиг олох зорилгогүй, үйл ажиллагаанд нь ашиглах эд зүйлийг гаалийн татвараас чөлөөлдөг баймаар байна”<sup>9</sup> гэсэн бэрхшээлийг иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл дурьджээ.

Төрийн бус байгууллагын санхүүгийн хяналтынасуудал гарч ирдэг бөгөөд энэ талаар гадаадын зарим орны жишээг авч үзэж байна. Тухайлбал, Япон улс нь 2012 оны 4-р сард шинэчлэн найруулсан “Хуулиартогтоосон ашгийн төлөө бус үйл ажиллагаа явуулах хуулийн этгээдийн тухай хууль”-ийг мөрдөж байна. Японы Иргэний хуулийн 33 дугаар зүйлд хуулийн этгээдийг нийтийн эрх ашгийн төлөө хуулийн этгээд, ашгийн төлөө хуулийн этгээд, бусад гэж 3 ангилсан. Түүнчлэн олон нийтэд мэдээлэл нээлттэй болон хүртээмжтэй байх, томоохон үйл ажиллагаа, хөрөнгөтэй эсхүл олон нийтийн дэмжлэг бүхий ТББ-уудаас санхүүгийн болон үйл ажиллагааныхаа ерөнхий тайланг олоннийтэд зориулан гаргахыг хуулиар шаарддаг байна.

ХБНГУ-д нийтэд үйлчилдэг Холбооны тухай хууль болон Сангийн тухай хуулийн аль алинд нь санхүү, үйл ажиллагааны тайланг аудитаар баталгаажуулан олон нийтэд хэвлэх, нээлттэй байлгах үүрэгтэй байна.<sup>10</sup> Энэхүү арга нь хөндлөнгийн хяналтаар баталгаажуулан олон нийтэд мэдээллэхийг заасан байдаг байна.

Манай улсын хувьд үүнтэй адилтгах заалт гэвэл Төрийн Бус Байгууллагын тухай хуулийн 23.1-т *төрийн бус байгууллага нь жилийнхээ тайлан тэнцлийг гаргаж дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор Татварын албанд өгнө* гэж заасан байдаг. Үүндээ дараах асуудлуудыг тусгана : жилийн орлого, зарлагаа 1. Хандивын 2. дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагааны 3. өвлүүлсэн эд хөрөнгийн гэж тус тус ангилана. Мөн “700,000 төгрөгийн хандив буюу өвийн хөрөнгө өгсөн байгууллага, иргэний нэр, зүйлсийн жагсаалт”, хандив, жилийн орлого зарлагаа тусгасан байх ёстой гэж тодорхой заасан нь ТББ-ыг урвуулан ашиглаж мөнгө угаах мэтийн гэмт хэргээс урьдчилан сэргийлсэн чухал заалт юм. Мөн хуулийн 23.4-т *Төрийн бус байгууллагад өргөсөн хандивыг хэрхэн зарцуулсан тухай хандивлагчдад тайлагнах эсэхээ тэдгээртэй байгуулсан гэрээнд тусгана* гэж хуулиндаа заасан байдаг. Энд албан ёсоор олон нийтэд мэдээллэхийг хуулиар шаардсан заалт байхгүй, гагцхүү татварын албанд

---

<sup>9</sup> Мөн тэнд

<sup>10</sup> Мөн тэнд



тайлангаа өгч байгаа нь санхүүжилт, түүний зарцуулалтын талаар ил тодбишолон нийтэд мэдээлэл хомс байх нэг шалтгаан болж байна.

### **Дүгнэлт**

Манай улсын хувьд дээрх олон улсын туршлага, судалгааны үр дүнг төрийн бодлогодоо тусган хэрэгжүүлэх шаардлага байна. Мөн төрөөс санхүүжилт дэмжлэг өгсөн иргэний нийгмийн байгууллагуудын санхүү болон үйл ажиллагаа зэргийг олон нийтэд нээлттэй, ил тод байлгах нь хяналтын нэг хэлбэр болох давуу талтай. Хүссэн иргэн хүн энэ талаарх мэдээллийг авч чаддаг байх нь иргэдийн оролцоо, идэвхийг дэмжих нэг арга болно гэж үзэж байна. Тухайн төрийн бус байгууллагын үйл ажиллагааны чиглэл, явуулж буй бодитой үйл ажиллагаа, иргэдийн дэмжлэгийг авч байгаа байдал зэргийг харгалзан санхүүжилт өгөх шалгуур болгосноор нийгэмд илүү идэвхтэй үйл ажиллагаагаа явуулах боломжтой болно.

Төрийн бус байгууллагын хуулийн дагуу засгийн газраас ТББ-г зөвхөн төсөл хэрэгжүүлэхэд л санхүүжүүлнэ гэж заасан нь засгийн газар төрийн бус байгууллагын санхүүжилтийг тал бүрээр дэмжих боломжгүй байгаа бөгөөд зөвхөн төсөл хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр олгохоос хэтрэхгүй байна. Үүнээс үүдэн ТББ-ын ажилчдын цалин хөлс, захиргаа аж ахуйн зардал нь ТББ-дад хүнд ачаалал болдог байна. Тиймээс ТББ-ын санхүүгийн дэмжлэгийг дан ганц төсөл хөтөлбөрөөр хязгаарлах бус, төрөөс хэрэгжүүлж байгаа ямар нэг хөгжлийн хөтөлбөрийн зардлын тодорхой хувь нь хөндлөнгийн хяналт, шинжилгээ үнэлгээ хийхэд тусгах өөр хэлбэрийг сонгох зэрэг арга зам байж болно. Үүнийг иргэний нийгмийн байгууллага нь чөлөөт шударга өрсөлдөөнөөр олж авч ажлаа хийдэг, төрөөс чадвартайд нь санхүүжилт олгодог байх боломжийг олгох хэрэгтэй. Мөн энэхүү сонгон шалгаруулалт нь олон нийтэд нээлттэй, ил тод, мэдээлэл сайтай байх шаардлагатай байна.

### **Ашигласан ном, материал:**

Төрийн бус байгууллагын тухай хууль

Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль

Улс төрийн намын тухай хууль

МУ-ын ШУА –ийн Философи, социологи, эрх зүйн хүрээлэн.,Монгол дахь иргэний нийгмийн төлөвшил ЭШБХ-ын илтгэлийн эмхтгэл.,УБ., 2013

Төрийн бус байгууллагын тухай хуулийг шинэчлэн найруулах хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа (ХЗДХЯ, Швейцарын Хөгжлийн Агентлагын хамтран хэрэгжүүлж буй “Иргэдийн оролцоо II” төслийн захиалгаар),УБ.,2017

Монгол Улсын Үндэсний Статистикийн хороо.,Аж ахуй нэгж байгууллагын 2016  
оны улсын тооллого.,УБ.,2017

Хууль зүйн үндэсний хүрээлэн.,Төрийн бус байгууллагын эрх зүйн  
зохицуулалтын зарим асуудалд.,УБ.,2013

<http://www.openforum.mn//>

**СОНИРХЛЫН БҮЛЭГ УЛС ТӨРИЙН БОДЛОГЫН СУБЪЕКТ БОЛОХ НЬ****Г.Цэнд-Аюуш**МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,  
Улс төр судлалын тэнхимийн зөвлөх дэд профессор**Н.Ариунаа**МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,  
Улс төр судлалын тэнхимийн докторант

**Түлхүүр үг:** Бүлэг, сонирхлын бүлэг, сонирхлын артикуляци болон агрегаци, зан байдал, харилцан үйлчлэл

**Товч агуулга:** Аж үйлдвэр хөгжсөн орнуудад аль XIX зууны дунд үеэс л ажилчид, хүн амын янз бүрийн давхрааныхан эрх ашиг, сонирхлоо илэрхийлж, бас хамгаалуулах зорилгоор эвлэлдэн нэгдэж нийтийн сайн сайханы төлөө засгийн газарт янз бүрийн нөлөөллийн арга механизмыг ашиглаж ирсэн түүхтэй. Ардчиллын нөхцөлд төр засгийн институтци, эрх баригчдын бодлого шийдвэр, үйл ажиллагаанд хяналт тавих, хариуцлага тооцох механизмд иргэнийн нийгмийн оролцооны ач холбогдол улам бүр өссөөр байна. Чухам яагаад хувь хүн, хүмүүсийн нэгдсэн бүлгүүд нийгэмд хуримтлагдаад буй асуудлыг шийдвэрлэхэд оролцох хэрэгцээ шаардлага үүсэв? гэсэн асуултад А.Бентлийн “ сонирхлын бүлгийн” онол хариу өгсөн болно.

**Онолын үндэслэл, арга зүй:** Сонирхлын бүлгийн онол, социологи, бихеворист арга зүйн хандлага

Сонирхлын бүлгийн онолыг АНУ-ын улс төр судлаач А.Бентли / 1870-1957/ “засаглалын үйл явц, нийгмийн шахалтыг судлах нь” хэмээх 1908 онд бичсэн бүтээлдээ дэвшүүлсэн байдаг. Анхандаа Бентлийн сонирхлын бүлгийн онолыг түүхийн болон институционал чиглэлийг баримтлагчид төдийлөн ойшоож үздэггүй байсан хэдий ч хожмоо улс төрийн амьдралын бүтцэд жинхэнээр оролцон тоглогчдын үйл байдал, байр суурийг эмпирик аргаар судлан шинжлэх хэрэгцээ, шаардлагын улмаас энэхүү онолын хандлага АНУ-ын төрийн удирдлагын үйл явцын бихевиорист-социологийн судалгаанд хүч түрэн орж ирсэн юм. Ер нь “сонирхлын бүлэг” хэмээх ойлголт улс төрийн институцийг шүтсэн

институционал хандлагын хязгаарлагдмал талыг даван туулах, улс төрийн үйл явцад бодитойгоор оролцон тоглогчдын харилцан үйлчлэлийг шинжлэх зорилгоор улс төрийн шинжлэх ухааны эргэлтэд орж ирсэн байна.

Нийгмийн хэсэг бүлгүүд улс төрийн хөгжингүй системийн чухал бүрдэл хэсэг байж, улс төрийн үйл явцыг эхлүүлэгч, бас тодорхойлогч шинжтэй хүч болдог. Тэдгээр нь өөр өөрийн зүсэн бүрийн хэрэгцээ, ашиг сонирхолтой байхын зэрэгцээ түүнийгээ илэрхийлэн таниулах, хамгаалж хэрэгжүүлэх үйл ажиллагаа зохион байгуулдаг юм. Гэхдээ улс төрийн систем бүрт нийгмийн янз бүрийн бүлгүүд, иргэд өөрсдийн хэрэгцээ, шаардлагыг төр засагт хүргэх тодорхой механизмуудтай байна. Угтаа ашиг сонирхол гагцхүү тэдгээрийг илэрхийлэх тэр үеэс л улс төрийн шинж чанартай болсон гэдэг нь тодорхой. Ийнхүү ашиг сонирхол, хэрэгцээ шаардлагаа дэвшүүлж хамгаалах тэр үйл явцыг улс төрийн шинжлэх ухаанд ашиг сонирхлын артикуляци буюу сонирхлоо илэрхийлэх хэмээн томъёолдог. Тиймээс хүмүүсийг хөдөлгөөнд оруулдаг нэг чухал хүчин зүйл нь яах аргагүй хэрэгцээ, ашиг сонирхол болно. Төрийн удирдлагын процесс хүмүүсийн үйл ажиллагаагаар хэрэгждэг бөгөөд энэ үйл ажиллагаа бол хамтын зохион байгуулалт бүхий ухамсартай үйл ажиллагаа байдаг хэмээн тэд үзсэн байдаг. Хүмүүсийн үйл ажиллагаа хэзээ ч салангид индивидуал байдлаар хэрэгждэггүй, харин сонирхлоороо нэгдэж нийлсэн эсвэл заагран ялгарсан бүлгүүдийн үйл байдал, үйл ажиллагааны шинж чанараар дамжин хэрэгждэг. Сонирхлыг танин мэдэхгүйгээр нийгмийг танин мэдэж чадахгүй. Аль ч нийгэм түүнийг бүрдүүлж буй маш олон янзын нийгмийн бүлгүүдийн нийлбэр цогц мөн хэмээн А.Бентли үзэж байв. Учир юун гэвэл цаана нь хувь хүний, бүлгийн, анги давхрааны бүр цаашлаад макро бүлэг болох үндэстний эрх ашиг, хэрэгцээ, сонирхол байдаг болохыг онцолсон байдаг. Эрх ашгаа хамгаална гэдэг бол дээр дурдсан бүх бүлэгт хамаатай зүйл мөн. Сонирхлоороо нийлж нэгдсэн, басхүү ялгарч зааглагдсан хоёроос дээш хүмүүсийн олонг бүлэг хэмээн үзсэн байна. Иргэдийн сонирхол бол маш олон янз: аж ахуйн, улс төрийн, шашны, нутаг усны, нас, хүйсний, мэргэшлийн гэх мэт олныг дурдаж болно. Үүнээс бид бүхэн иргэдийн улс төрийн сонирхлыг голлох бөгөөд сонирхлоороо нэгдэн үйл ажиллагаа явуулж буй бүлгүүдийн үйл байдлыг судална хэмээн үзжээ.

Сонирхол, бүлэг, үйл ажиллагаа гурав бол өөр хоорондоо холбоотой төрөл ойлголтууд юм. Марксизм нийгмийг формацийн онолын үүднээс ангиудад, тэдгээрийн эвлэршгүй зөрчил тэмцэлд судлаж үзсэн бол А.Бентли нийгмийг

сонирхлоороо нэгдэж нийлсэн, заагран ялгарсан олон янзын үйл байдал бүхий бүлгүүдийн харилцаа холбооны хөгжлийн үйл явцаар тайлбарлахыг эрмэлзсэн байдаг. Ардчилалын нөхцөлд нэг хүн хэдэн ч бүлгийн гишүүн байж болно хэмээн хэмээн тэрбээр үзсэн юм.

Хувь хүний сонирхол бүлгийн сонирхолтой нийлж, нэгдэж байх ёстой хэмээн үзсэн байна. Бас давцаж байх ч албагүй. Энэ нь плюрализмыг хүлээн зөвшөөрч байгаа явдал бөгөөд энэ нь хувь хүний итгэл үнэмшил, үзэл санаа, түүний үйл байдал, бүлгийн үйл ажиллагааны үйл байдлыг тодорхойлоход ач холбогдолтой байдаг нь тодорхой. Ийм учир хувь хүн, бүлгийн үйл ажиллагаа бол нягт харилцан хамааралтай үзэгдэл мөн. Америкийн улс төрийн үйл явцад шахалтын бүлгийн зорилго, чиг хандлага бүлгийн гишүүдийн үйл байдалд тусгалаа олсон байдаг төдийгүй хошуучлагчдын аман илтгэл, хөтөлбөр, илгээлт мэдэгдлүүдэд туссан байдгийг эмпирик ажиглалтаар төвөггүй олж харна. А.Бентлийн үзлээр төрийн удирдлагын бүх үзэгдэл бие биедээ нөлөөлж байгаа, зарим тохиолдолд дарамт шахалт үзүүлж байгаа бүлгүүдийн үйл ажиллагааны үр дүн мөн хэмээсэн байдаг. Ийм учир сонирхлын бүлгүүдийн үйл ажиллагаа тэдгээрийн өөр хоорондын харилцан үйлчлэл байнгын хувьсамтгай шинж чанартай болохыг тодорхойлжээ.

Харин төр улс тогтворжсон, ардчилал боловсронгуй хөгжсөн тохиолдолд бүлгүүдийн үйл байдалд харьцангуй тогтвортой тэнцвэрийн байдал бүрэлддэг байна. Учир нь төрийн бодлого бүх үндэстний эрх ашгийг гол болгосон үйл ажиллагааг хэвшүүлж явуулбал олон нийтийн хүч эрмэлзлийг өөртөө шингээсэн, итгэл даасан үйл ажиллагаа болдог хэмээн үзсэн юм. Эндээс Засгийн газарт сонирхлын янз бүрийн бүлгээс шахалт, дарамт үзүүлэх байдал хязгаарлагдаж хумигддаг хэмээн тодорхойлжээ. Ийм нөхцөл байдал авторитар нийгмийн тогтолцоонд хүчтэй илэрдэг бөгөөд эрх барьж буй нам, суртал ухуулга, зохион байгуулалтын олон хэрэгслийг ашиглан засгийн газарт шахалт үзүүлэх сувгийг хааж чаддаг байна.

Ардчилалын нөхцөл байдалд энэ байдлыг багасгах, хумих боломжтой бөгөөд энэ бол тухайн үндэстний итгэл үнэмшил сайн сайхны баталгаа болсон чинээлэг хангалуун амьдралтай холбоотой хэмээн тайлбарласан байна. Тухайлбал, америкчуудын дунд, чинээлэг давхрааныхан /хүн амын 70 орчим хувийг эзлэх болсон-Г.Ц / аль нам, ямар нэр дэвшигч засгийн эрхэнд гарахад онцын ач холбогдол өгдөг гэхээсээ хавьгүй Америк дахь ардчилал, улс төрийн тогтвортой байдлыг илүүд үздэг байна.

А.Бентли төрийн удирдлагын үйл явцад хүчтэй нь сул бүлгүүдийг өөртөө захируулах тал ажиглагддаг болохыг тэмдэглэсэн байдаг. Ийм учир бүлгүүдийн үйл ажиллагааг зохицуулах, тэнцвэржүүлэх шаардлага гарч ирдэг бөгөөд төрийн удирдлага түүнд зохицох ёстой хэмээн үзжээ. Нийгмийн зөвшилцлийг хангахын тулд ардчилсан нийгэмд зуучлалын бүлгүүд, парламент, засгийн газар, агентлагын дэргэд бүлгүүдийн төлөөлөл ажиллах ёстой гэж үзсэн байна. Тиймээс ерөнхийлөгч, парламент, сонирхлын бүлгүүдийн сонирхлыг нь илэрхийлэгч “албан ёсны төлөөлөл” болдог байна. Эндээс Бентлийн онолоор төрийн удирдлагын шинжилгээ бүлгүүдийн харилцан үйлчлэлийн үр дүнг тусгасан эмпирик судалгаанд тулгуурлах ёстой болж байна. Бүлгүүдийн харилцан үйл ажиллагааны харилцан үйлчлэлд тасалдал, зөрчил гарвал дээр дурдсан албан ёсны институтын үйл ажиллагаанд зөрчил өөрчлөлт гардаг байна.

Улс төр нь тогтвортой, хууль хэвшсэн, иргэд нь чинээлэг амьдарч буй ардчилал өндөр хөгжсөн орнуудад энэ маягийн өөрчлөлт гарах магадлал бага байдаг байна. Сонирхлын энэ олон янз байдал оршиж байгаа нь нийгэмд ардчилал, олон ургалч байдал оршиж буйн бодит илрэл хэмээн тэд үзжээ. Улс төрийн дэглэмийн ялгааг бүлгүүдийн үйл ажиллагааны хэв маягтай холбон үзсэн байдаг. Жишээ нь, деспот /дарангуйлалын-Г.Ц/ ба ардчилсан дэглэмийн ялгаатай байдал түүнийхээр сонирхлын төлөөллийн аргын ялгаатай байдлын тусгал болсон хэрэг<sup>1</sup> юм. А.Бентли ажиглалтанд хамгийн түрүүн өртдөг төрийн удирдлагын үндсэн институтууд болох шийдвэр гаргаж, албадлага хэрэглэдэг хууль тогтоох, шүүх, гүйцэтгэх буюу захиргааны байгууллагуудын эмпирик судалгаанд анхаарлаа хандуулахын ач холбогдлыг тэмдэглэж байв. Мөн улс төрийн намууд, зохион байгуулалттай бусад шахалтын бүлгүүд энэ судалгаанд хамаарагдах ёстой гэж үзсэн юм. Төрийн удирдлага бол институтуудын цуглуулга төдий бус, нарийн нийлмэл үйл явц учраас түүнд нөлөөлөх бүлгүүдийн үйл ажиллагаа, нөхцөл байдлыг судлахыг уриалж байв. А.Бентли үзэхдээ, олонх тохиолдолд бүлгүүдийн зөрчил, мөргөлдөөн ажиглалт хийж буй албан ёсны удирдлагын түвшинд шийдэгдэггүй, харин олон тооны бүлэг, дэд бүлгүүдийн хоорондын өрсөлдөөн, дасан зохицол, зохицуулагдах далдуур үйл явцад шийдвэрлэгддэг хэмээжээ<sup>2</sup>. Өөрчлөгдөн буй нөхцөл байдлын улмаас бүлгүүдийн үйл байдалд өөрчлөлт гарч зарим тохиолдолд бүлгүүдийн хоорондын зөрчил, мөргөлдөөн энхийн замаар шийдэгдэж эвлэрэл, тэнцвэрийн байдал тогтдог. Өөр тохиолдолд

<sup>1</sup> Bentley A. The Process of Government: A Study of Social Pressures. Cambridge, 1967, p. 269, 293

<sup>2</sup> Ibid., p. 209-211

“албан ёсны бүлгүүд” /сонирхлын төлөөлөл болсон-Г.Ц / болох хууль тогтоох, гүйцэтгэх, засаг захиргааны болон шүүх-хууль, эрхийн институтууд, мөн тэрчлэн арми, цагдаа хангалттай хүчтэй байх юм бол мөргөлдөөнд оролцогч хэсэг бусад бүлгүүдийн үйл ажиллагааг зохицуулж, харьцангуй тогтвортой тэнцвэрийн байдлыг тогтоож чаддаг байна. Төрийн удирдлагын тогтвортой чанарын нөхцөлдүүдэг “албан ёсны бүлгүүд” болох засгийн газрын тогтвортой чанар бүлэг хоорондын мөргөлдөөнийг шүүгчийн байрнаас шийдвэрлэх эвлэрлийн боломжтой арга, хувилбарыг сүвэгчлэх чадвараас энэ тэргүүнд шалтгаалах ёстой ажээ.

Тэрбээр нийгэм-эдийн засгийн хүчин зүйлс төр улсын болон улс төрийн хөгжлийн гол эх сурвалж болохыг онцлоод үзэл суртлын хувьд байр сууриа бүлгийн хэрэгцээ, зорилготой холбон тайлбарлаж байв.

А.Бентлийн “сонирхлын бүлгийн” онол америкийн төдийгүй өрнөдийн бихевиорист улс төр судлалын чиглэлийн цаашдын хөгжилд хүчтэй нөлөө үзүүлсээр ирсэн бөгөөд шахалтын бүлгүүд, улс төрийн нам, улс төрийн хошуучлал ба олон нийтийн санаа бодлын үйл байдлын эмпирик судалгаанд тулгуурлан улс төрийн засаглалын үйл явц, төрийн удирдлагад хандах хандлагын онолын чухал эх сурвалж байсаар ирсэн юм. Сонирхлын бүлгүүд улс төрийн системийн тулгуур хөдөлгөгч хүчний үүрэг гүйцэтгээд зогсохгүй, хувь хүн,бүлгүүдийг төрийн засаглалтай холбогч гүүр болдог юм. Сонирхлын бүлгүүдийн үйл ажиллагаа улс төрийн амьдралд хоёр талын ач холбогдолтой. Нэг талаас, иргэдийн төрөөс бус байдлын хэмжээ хязгаарыг нэмэгдүүлэх, нөгөө талаас, эрх мэдлийг хувиарлах олон төв бүрэлдэх нөхцлийг бүрдүүлдэг байна. Сонирхлын бүлэг үүсэх, үйл ажиллагааны чадамж зэрэг нь тухайн улс төрийн дэглэмийн шинж чанар, үндэстний зан чанарын онцлог, шүтлэг бишрэл, иргэний нийгмийн хөгжлийн хүрсэн төвшин зэрэг олон зүйлээс шалтгаалдаг байна. Сонирхлын бүлгүүд нийгмийн янз бүрийн давхрааны хэсэг бүлгийн сонирхлыг төдийгүй бас нийт улс үндэстний эрх ашиг, сонирхлыг хамгаална. Жишээ нь: шударга бус хууль батлахын эсрэг зорилгод нэгдэх бүлэг үүсгэхэд иргэн Та нэгдэхэд бэлэн үү? гэсэн санал асуулгын судалгаанд оролцогсодын АНУ-д хүн амын 56%, Англид 34%, Германд13%, Италид 7% бэлэн гэсэн хариултыг өгсөн байх юм. АНУ-д гэхэд л 11000 гаруй янз бүрийн үйл ажиллагаа /хэрэглэгчдийн эрх ашиг, байгаль орчныг, ан амьтан хамгаалах г.м/ явуулдаг сонирхлын бүлгүүд байдаг байна. Тэдгээр бүлэгт хэн ч нэгдэх боломжтой.

Сонирхлын бүлгүүдийн зорилго тавьсан зорилгоо хэрэгжүүлэхэд гол түлхээс болдог. Жишээ нь: үр хөндөлтийн эсрэг тэмцэж буй бүлгүүд Бүгд найрамдах намаас нэр дэвшигч шилж сонгож гаргахад шууд нөлөөлсөн байна. Мөн засгийн газар тодорхой бодлого боловсруулж хэрэгжүүлэх зорилгоор сонирхлын бүлгийн тусламж дэмжлэг хүсэх тохиолдол олонтаа гардаг байна. Хиллари Клинтоны удирдсан комисс АНУ-ын эрүүл мэндийн хангамжийн системд хийх шинэтгэлийн ажил эмч нарын дэмжлэг орхигдсоноос болж бүтэлгүй болсон байх жишээтэй.

**Краткий обзор:** А.Бентли вывел фундаментальное понятие в теории в американской политологии: “деятельность людей определяется их интересами”. Главными критериями группового интереса являются не устная риторика, не программные заявления, а деятельность группы, поведение ее членов. Политику он рассматривает как постоянное взаимодействие /столкновение, сближение, давление/ различных групп между собой, а также их стремление повлиять на правительство.

#### **Ашигласан ном, материал**

International Encyclopedia of Political Science VOL 4, IPSA, UK: SAGE Publications, Inc. 2011.

Bentley A. The Process of Government: A Study of Social Pressures. Cambridge, 1967.

Г.Цэнд-Аюуш. Өрнийн улс төрийн сэтгэлгээний түүхэн тойм./дэд дэвтэр/ УБ., 2016.



**ПАРЛАМЕНТ ХОЁР ТАНХИМТАЙ БАЙХ АСУУДАЛД**

**Г.Цэнд-Аюуш**

МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,  
Улс төр судлалын тэнхимийн зөвлөх дэд профессор

**Д.Сүхболд**

МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,  
Улс төр судлалын тэнхимийн докторант

**Түлхүүр үг:** Засаглалын хуваарилалт, хоёр танхимтай парламент, хуулийн төсөл, нийгмийн төлөөлөл, Нийтийн танхим, Лордын танхим

**Товч агуулга:** Хоёр танхимтай парламентын үүсэл хөгжил, онолын үндэслэл, түүний улс төрийн ач холбогдол давуу талуудыг өгүүлэв. Тухайлбал парламентыг хоёр танхимтайгаар зохион байгуулснаар төрийн эрх мэдлүүдийн төвлөрлийг сааруулж, тэнцвэржилтийг хангах, хуулийн төслийг парламентын хоёр танхимаар ээлжлэн хэлэлцүүлж, чанартай хууль батлах, нийгмийн төлөөллийг парламентад түлхүү оруулах зэрэг асуудлуудыг хөндсөн болно.

**Онол арга зүйн үндэслэл:** Тус эрдэм шинжилгээний өгүүллэгийн онолын үндэслэл нь Ж.Локк, Ш.Л.Монтесьеке нарын боловсруулсан төрийн эрх мэдэл хуваарилах онол, зарчим, тэр дундаа Ш.Л.Монтесьекегийн парламентыг хоёр танхимд хувааж, хууль тогтоох эрх мэдлийн хүчийг сарниулах, улмаар язгууртны танхим нь хуулийг мэргэн ухаанаар шүүн тунгааж, батлан гаргах зорилго бүхий хоёр танхимт парламентын онол, философи, мөн хоёр танхимтай парламентыг судлан шинжилсэн гадаад, дотоодын судлаачдын үзэл баримтлал, (М.Дюверже, Лүндээжанцан, Ж.Төртогтох, О.Машбат, Л.Өлзийсайхан, А.Юндэндорж, Ю.Атар) зохиол бүтээл, эрдэм шинжилгээний өгүүллэгүүд байв.

Харин арга зүйн хувьд хоёр танхимтай парламентын үүсэл хөгжлийг тодруулж гаргахад түүхэн болон логик арга зүй ашиглагдсан бол төрийн эрх мэдлүүдийн тэнцвэржилтийг хангах, болон хоёр танхимт парламент дахь хуулийн төслийг хэлэлцэх асуудлуудыг шинжлэхийн тулд Монтесьекегийн боловсруулсан хоёр танхимт парламентын онол, загварыг баталгаат онолын эх үндэс гэж үзэж түүнд хамаарах баримт, нотолгоог хийснээрээ аксиоматик арга зүй хэрэглэгдэв.

### **Нэг: Хоёр танхимтай парламентын үүсэл хөгжил.**

МЭӨ V-III зууны үед эртний Грект Афины ардчилал, Ромд Бүгд найрамдах засаглалын хэлбэр үүссэн бөгөөд эдгээр улсуудад яг парламентын хоёр танхим гэж хэлэхгүй ч хууль хэлэлцэн батлах чиг үүрэг бүхий хоёр бүтэцтэй хурлууд үйл ажиллагаагаа явуулж байжээ. Тухайлбал эртний Грект Ардын Хурал болон Таван Зуутын Зөвлөл, эртний Ромд Ахмадын Зөвлөл ба Сенат гэсэн хурлууд үйл ажиллагаагаа явуулж байсан бөгөөд өөрөөр хэлбэл МЭӨ V-III зууны үед эртний Грек, Ром, зэрэг улсуудад хоёр танхимтай парламентын үндэс суурь бие биенээсээ үл хамааран үүсчээ.

Эртний Грек Ромын хоёр бүтэцтэй хурлууд анх үүсэхдээ л аливаа шийдвэрийг зэрэгцээ хоёр хурлаараа ээлжилж хэлэлцдэг, Ардын Хурал болон Таван Зуутын шийдвэрийг мэргэн ухаан, нас, өв хөрөнгөөрөө бусдаас давуутай гишүүдээс бүрдсэн Сенат болон Ахмадын Зөвлөл нь нь хянан хэлэлцдэг байдлаар бүрэлдсэн байх талтайг дээрх хурлуудыг нэрлэсэн нэршлээс харж болох юм.

Харин сонгодог хоёр танхимтай парламентын үүсэл хөгжил Английн парламентын түүхтэй салшгүй холбогдоно. XII-XIII зууны Англид үүсэн бүрэлдсэн эзэн хааны дэргэдэх Их Зөвлөл нь эзэн хааны эрх мэдлийг Лорд ноёдын зүгээс хянаж байх, ноёдын санаа бодлыг хааны шийдвэрт тусгах гол институц болж байсан агаад тухайн үеийн парламентын үйл ажиллагааны доголдлоос зарим ноёдын санаа зоригийг эс тусгах нь томоохон хэмжээний бослого тэмцэлд хүргэж байв. Тухайлбал 1260 онд Симон дэ Монтфорд гэх тайж хааны эсрэг бослого гаргаж, Английг хэдэн сар эзэгнэн захирч ахуйдаа ноёдын дэмжлэгийг авах зорилгоор Их Зөвлөлийн эрх хэмжээг нэмж, төлөөллийн тоог нэмэгдүүлэхээр амласан байна. Ингээд амлалтаа гүйцэлдүүлэхийн тулд тосгон бүрээс хоёр баатар, суурин бүрээс хоёр иргэнийг томилон ирүүлэхээр 1265 онд тогтоосон байна. Үүний үр дүнд Их Зөвлөлд дээд язгууртан ангиас гадна, Лондон зэрэг хот тосгоны дунд ангийн төлөөлөгчид мандаттай болжээ. Энэ парламентыг Английн анхны парламентад тооцдог ажээ.<sup>1</sup> Тухайн үе Монтфордын төрийн эргэлт дарагдсан боловч Их Зөвлөлийн төлөөллийг тогтоосон дээрхи журам нь жишиг болон хадгалагдаж Английн парламентын дээд, доод танхимын үндэс болсон байна<sup>2</sup>. Уг жишиг баттай хадгалагдсны жишээг Эдуард I хаанаас 1295 онд зарлан хуралдуулсан парламентын зарлан дуудах бичгээс харж болно. Тэрээр Магна

---

<sup>1</sup>Л.Өлзийсайхан “Парламент” 23 дахь тал. УБ., 2001

<sup>2</sup>О.Машбат “Бонноос Вестминстерийн зүг” 27 дахь тал. УБ 2007

Картын<sup>3</sup> 14-р зүйл ёсоор парламентыг хуралдуулах гурван зүйл зар бичгийг үйлдэн Епископ буюу шашны төлөөлөгч, Барон буюу язгууртны төлөөлөгч, тосгоны төлөөлөгчид буюу ард иргэдэд хандсан байдаг.Энэ гурван бичгээс шашны төлөөлөгчдөд хандсан бичигт тухайлан дурдахдаа: *“Францын хаан ичгүүргүйгээр Гаксон зэрэг манай газрыг булаан эзэлснийг олон бүгдээр бэлхнээ мэдэж буй билээ. Өдгөө мөн шударга бус, ичгүүргүй үйлдэлдээ үл ханан их усан флот байгуулж, олон цэрэг хураан, манай ханлиг, манай ханлигийн бүх хүн амыг дайсагнан түрэмгийлж, англи хэлийг буй бүгдийн хамт устгахыг эзэрхийлэн санаархаж байна.”* Хэмээн хэлэлцэх асуудлыг товч тодорхой өгүүлжээ.

Харин тосгоны төлөөлөгчид буюу ард иргэдэд буулгасан захианд хэлэлцэх асуудлыг ийм дэлгэрэнгүй тоочоогүй бөгөөд мөн хэрэглэсэн үг хэллэг нь тушаасан байдал илт мэдэгдэхүйц бичсэн байдаг. Үүнд: *“Кантон бүрээс хоёр хөлөг баатар, мөн Кантоны хот бүрээс хоёр иргэн, суурин бүрээс хоёр худалдаачиныг, хойшлуулигүй сонгож, дурдсан цаг, дурдсан газарт ирүүлэхийг шерифүүдэд зарлигдан Кантерберийн гүнгээр гэрчлүүлэн Октябрь сарын 3 дахь өдөр эл захиаг үйлдэн”* илгээсэн байна.

Энэ нь тухайн үеийн Англи орны ангийн ялгааг илтгээд зогсохгүй, хамгийн гол нь парламентын хуралдаанд доод ангийг орхихгүй гэсэн санал санаачилга гарч байгаа юм.Өөрөөр хэлбэл парламентад суух ард ангийн мандатыг тодорхой зааж өгсөн байгааг харж болно.

Тэр үеийн Их Зөвлөл анхандаа хоёр танхимын ялгаваргүйгээр цугтаа хуралдаж байсан байсан боловч аажмаар язгууртнууд болон ард иргэдийн төлөөллүүд хоёр тусдаа хуралдаж эхэлжээ.

Их Зөвлөлийг чухам энэ үеэс парламент хэмээн нэрлэх болсон гэж судлаачид үздэг. Лорд, ноёд, угсаа залгамжилсан тайж нар нэг дор цугларан хуралдаж, харин хөлөг баатар, худалдаачид бас нэг тустаа цугларч, дор дороо хуралдан санал өгдөг болсноор 1352 оноос Английн парламентын Лордын буюу ноёдын танхим, Ардын буюу нийтийн танхим хэмээх үндсэн бүтэц нь бүрэлдэн тогтжээ.<sup>4</sup>

Ийнхүү XII-XIV зууны үед Англид хоёр танхимтай сонгодог парламент язгууртан болон ард ангийн сонирхлын зөрчил дээр тулгуурлаж үүссэн агаад

---

<sup>3</sup>1215 онд Англид батлагдсан дундад зууны үеийн улс, эрх зүйн дурсгалт бичиг. Магна Карта нь олон дэвшилтэт үнэт зүйлсийг тунхагласан бөгөөд хүний эрх, эрх чөлөө, алба татварын асуудлыг зохицуулж, улс төрийн байгуулал талаасаа хааны дэргэдэх Их Зөвлөл буюу парламентыг байгуулсан түүхтэй.

<sup>4</sup>Л.Өлзийсайхан “Парламент” 23 дахь тал. УБ 2001

түүхэн хөгжлийн явцад аливаа хууль болоод шийдвэрийг хоёр танхимаар ээлжлэн хэлэлцдэг, хоёр танхим санал зөрөлдвөл ноёдын буюу Лордын танхим эцсийн шийдвэрийг гаргадаг бүтэцтэй болжээ.

Хожмоо XVII-XVIII зууны үед Францын гүн ухаантан Ш.Л.Монтескье Английн төрийн тогтолцоог судлахын тулд парламентын хоёр танхимын хуралдаанд олон удаа сууж, хөндлөнгөөс ажигласны үндсэн дээр “Англи орны эрх чөлөөт байдлын нууц нь төрийн тогтолцоондоо байна” гэсэн дүгнэлтийг хийжээ<sup>5</sup>. Учир нь парламентаас батлагдан гарах хууль хэд хэдэн шат дамжлагыг дамжиж байж батлагдах ёстой. Тухайлбал Английн парламент нь Нийтийн танхим болон Лордын танхим гэсэн хоёр танхимтай бөгөөд хуулийн төслийг эхлээд Нийтийн танхимд өргөн барина. Нийтийн танхимын хэлэлцэн баталсан хуулийн төслийг Лордын танхим хянан магадлаж, батлах бөгөөд эцэст нь хаан батламжилснаар хуулийн төсөл хүчин төгөлдөр болдог. Ингэж бүхэл бүтэн гурван шат дамжлагыг дамжин байж батлагдсан хууль нь Англи орныг деспотизмд<sup>6</sup> оруулахгүй байх гол баталгаа болдог гэдгийг Ш.Л.Монтескье судлан мэджээ.

Эндээс XVII-XVIII зууны Английн хоёр танхимтай парламентын бүтэц, зохион байгуулалт нь тэр үеийн баруун европийн дэвшилтэт соён гэгээрүүлэгчдийн улс төрийн үзэл санааны эх загвар нь болтлоо боловсронгуй хөгжсөн байсныг харж болно.

Хоёр танхимтай парламентын Дээд танхим анхандаа язгууртны шинжтэй байсан бөгөөд томилгоо юмуу үе залгамжлах замаар бүрддэг байсан бол түүхэн хөгжлийн явцад тухайлбал дэлхийн I дайны өмнөхөн буюу 1815 оны үндсэн хуулиараа Нидерландын 1-р танхим танхим, 1831 оны үндсэн хууль ёсоороо Бельгийн Сенат, зэрэг парламентын дээд танхимууд сонгуулийн замаар бүрддэг болж эхэлжээ.

Цаашид үндсэн хуулийн хөгжлийн явцад дээд танхимыг сулруулах гэсэн оролдлогууд нь зарим тохиолдолд түүнийг бүр үгүйсгэх явдлыг бий болгож байв. Тухайлбал Их Британий 1911, 1949 оны хоёр акт нь хууль тогтоох салбарт Дээд танхим буюу Лордын танхимын эрхийг маш ихээр хязгаарласан байдаг.

Энэ үйл явцыг М.Дюверже дүгнэхдээ “XVII зууны Английн төрийн байгуулалд өнөөдөр нам хэмээх тоглогч хүчтэй түрэн орсны улмаас танигдахгүй болтлоо өөрчлөгдөөд байгаа билээ. Анги давхрааны ялгаа нийгэмд онцын ач холбогдолгүй болсноос үүдэн Ноёдын танхим оршихын төдий үлдэж, харин

<sup>5</sup>А.Юндэндорж, Ю.Атар “Өрнө дорнын мэргэдийн нийгэм-улс төрийн онол, сургааль” II-III дэвтэр 105 дахь тал. Хөх хот., 2003

<sup>6</sup>Дарангуйллын засаглал

Ардын танхим улс төрийн гол эрх мэдлийг авснаар өнөөдөр Британийг нэг танхимтай парламентын жишээ болгон авах нь түгээмэл болжээ<sup>7</sup>”. Хэмээн дүгнэсэн байдаг.

Цаашлаад 1946 оны үндсэн хуулиар Францын IV Бүгд найрамдах улсын зөвлөл нь дээд танхим болох Сенатын эдэлж байсан зарим эрхийг олгоогүй байна.

Мөн түүхэн хөгжлийн явцад Японы парламентын дээд танхим болох Зөвлөхүүдийн танхим хэвээр үлдсэн ч доод танхим болох төлөөлөгчдийн танхим нь дээд танхимдаа хориг тавих онц эрхтэй болоод зогсохгүй засгийн газар нь зөвхөн доод танхимын өмнө хариуцлага хүлээх болжээ.

Энэ бүгд нь парламентын доод буюу ардын танхим нь ард түмний ашиг сонирхлыг төлөөлж бүх нийтийн сонгуулиар сонгогддог болсонтой холбоотойгоос гадна М.Дювержегийн хэлсэнчлэн ангийн сонирхлын ялгаа нийгэмд онц ач холбогдолгүй болох, нөгөө талаас дэлхийн улсуудад засаглалын уламжлалт легитимийн үүрэг ач холбогдол буурч харин хууль ёст легитимийн эрин үе эхэлсэнтэй холбоотой байж болох юм.

Гэсэн хэдий ч одоог хүртэл улс төрийн хувьд консерватив шинжээ хадгалсан буюу дээд танхимаа шинжлэх ухаан, академи, их сургууль зэргээс төлөөлөгч томилон бүрдүүлдэг улсууд байдаг ба дээд танхимыг үе залгамжлал юмуу томилолтоор бүрдүүдэг улсууд ч байна. (Их Британи, Канад)

### **Хоёр: Парламентыг хоёр танхимтайгаар зохион байгуулах улс төрийн ач холбогдол**

Хоёр танхимт парламентын онол судлалын үүднээс авч үзвэл парламентыг хоёр танхимтайгаар зохион байгуулах нь дараах улс төрийн ач холбогдолтой юм. Үүнд:

**Нэгдүгээрт, төрийн эрх мэдлүүдийн төвлөрлийг сааруулж, тэнцвэржилтийг хангахад хоёр танхимтай парламентын гүйцэтгэх үүрэг, ач холбогдол.** Төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх хэмээн хуваарилахаас гадна харилцан тэнцвэртэй байх ёстой гэсэн дэвшилтэт үзэл санааг Францын сэтгэгч Ш.Л.Монтескье гаргасан агаад тэрээр Ж.Локк, Ж.Ж.Руссо нарын хууль тогтоох засаглалыг тэргүүлэх үүрэгтэй хэмээн үзсэнийг хүлээн зөвшөөрөөгүй бөгөөд харин ч эсрэгээрээ хууль тогтоох засаглалыг хязгаарлахын тулд парламентыг хоёр танхимтай байх ёстой гэж үзсэнээрээ дэвшилтэт юм.

---

<sup>7</sup>М.Дюверже “Улс төрийн байгууламж, үндсэн хуулийн нэрхзүй” 130 дахь тал. УБ., 2007 он.

Парламентыг хоёр танхимд хуваасан нь түүнийхээр хууль тогтоох эрх мэдлийг зөөлрүүлэх, дотор нь сарниулахаас гадна язгууртны танхим нь хуулийг мэргэн ухаанаар шүүн тунгааж, батлан гаргах зорилготой.

Судлаач Д.Лүндээжанцан “Монгол улс дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт” бүтээлдээ: “Ш.Л.Монтескье ирээдүйд заналхийлж болох, нэг талыг барьсан аюулыг өөрийн зөнгөөр мэдэрч байсан бололтой. Оновчтой хуулийн үндэслэлээр хүлээн зөвшөөрөгдсөн хууль тогтоох байгууллагыг институцийн маягаар хязгаарласанаар учирч болох аюулыг зайлуулж, үндсэн хүчнүүдийн тэгш хэмийг хадгалах явдлыг эрхэмлэж байв. Монтескьегийн тэмүүлэл юунд байсан бэ гэвэл хууль тогтоогчийн эрх мэдлийг хязгаарлахад оршиж байсан. Учир нь хууль тогтоогчид болон түүний нөлөөллийн эсрэг ямар нэг хязгаар, чөдөр саад байхгүй агаад энэ асуудлыг зохицуулж болох нэг шийдэл нь хоёр танхимтай парламентын систем юм.”<sup>8</sup> Хэмээн бичжээ.

Мөн АНУ-ын Үндсэн хууль тогтоогчдын нэг Томас Жефферсон “Виржины мужийн тухай тэмдэглэлүүд” бүтээлдээ “Төрийн эрх мэдлийн бүрэн эрх нь засаг төрийн байгууллагуудын хооронд аль нэгнээ хууль ёсны эрх мэдлээ хэтрүүлж чадахгүйгээр, харилцан үр нөлөө бүхий хянаж, бие биенээ тогтоон барьж байхаар зохион байгуулагдах ёстой,”<sup>9</sup> гэж бичсэнээс гадна “Төрийн эрхийг нэг гарт, жишээ нь парламентад төвлөрүүлэх аваас ялгаагүй л дарангуйлсан удирдлага буй болдог. Хэдэн зуун дарангуйлагчийн (парламентын гишүүд) дарангуйлал нь хэрэг дээрээ бол нэгэн дарангуйлагч болох хааны дарангуйллаас ялгарах юм нэгээхэн ч үгүй” хэмээсэн нь мөн л парламентын эрх мэдлийг дотор нь задлах тухай Ш.Л.Монтескьегийн үзэл санаатай яв цав нийцэж байна.

Монголын хувьд улс төрийн намууд нь хатуу гишүүнчлэлтэй, засаг захиргааны нэгж бүхэнд намын үүртэй, хатуу дэг журамтай намыг сонгуульд шалгаруулдгаас үүдэн парламентад хэт олонхи, хэт цөөнхийн харьцаа үүсэж, тэр нь төрийн эрх мэдэл төвлөрөх улс төрийн таатай орчинг бүрдүүлдэг. Парламентад хэт олонхи болсон нам хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийг өөртөө төвлөрүүлдэг агаад сонгуулийн дийлэнх олонхийн систем нь засгийн эрх мэдлийн төвлөрлийг бүрэн дэмждэг манайх шиг улсад хууль тогтоох эрх мэдлийн давамгайллыг сарниулахын тулд парламентыг хоёр танхимд хуваасны үндсэн дээр нөгөө хоёр эрх мэдэлтэй нь тэнцвэржүүлэх үзэл санаа нь үндсэн хуулийн

---

<sup>8</sup>Д.Лүндээжанцан “Монгол улс дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт” 41 дэх тал. УБ.,2014

<sup>9</sup>Th.Jefferson. Notes on the State of Virginia. The Portable Jefferson, Led. By M.D. Jefferson. N.Y., 1977 p. 164

өөрчлөлт шинэчлэлтийн асуудал яригдаж буй энэ үед чухал тулгамдсан сэдвүүдийн нэг юм.

*Хоёрдугаарт, хуулийн төслийн боловсруулалт, хэлэлцүүлэг сайжирч, хууль чанартай батлагдана.* Ардын танхимаас гаргасан шийдвэрийг хүчтэй язгууртны танхим хянан хэлэлцэж хориг тавьдаг хоёр танхимт парламентын уламжлалт хэв маяг (Их Британи) орчин үед үр нөлөөгөө алдаж буй боловч судлаачид дээд танхимыг улс төрд доод танхимаа тогтоон барих тоормоз болдог<sup>10</sup> хэмээн үзсэн хэвээр байна.

Олон улсын улс төрийн практикт ч дээд танхимын үүрэг роль төдийлөн буураагүй гэдэг нь дээд танхимын зүгээс хуулийн чанарыг сайжруулах, луйврын захиалгын хуулийг таслан сэргийлэх, удаашруулах үүргээр тодорхойлогдож байна. Сонгогчдын нөлөө, дарамтанд үргэлж өртөж байдаг парламентын доод танхимын яаруу адгуу шийдвэр гаргахаас зайлсхийх боломжийг парламентын дээд танхим олгодог. Парламентын доод танхимаас баталсан хуулийн төслийг парламентын дээд танхим хянан хэлэлцэх нь хуулийн чанарыг сайжруулж, хууль гаргалтыг удаашруулах үүрэгтэй. Нэг үгээр хэлбэл парламентын дээд танхим бол ардын буюу доод танхимын шийдвэрийг мэргэжлийн үүднээс "хянадаг", мэргэшсэн хэсгийн зөвлөх маягийн үйл ажиллагаа байх ёстой бөгөөд "Төлөөлөх" гэхээс илүү хууль тогтоох үйл ажиллагааг мэргэшүүлэхэд чиглэсэн бүтэц"<sup>11</sup> гэж хэлж болно.

Тодруулбал парламент хоёр танхимтай байснаар хуулийн чанарыг сайжруулах, хууль гаргалтыг удаашруулах боломжийг олгодог байна. (ялангуяа улсын төсөв, албан татвар, ҮАБ, тусгаар тогтнол зэрэг асуудлууд) Энэ ч учраас парламентын дээд танхимыг судлаачид "Тунгаан бодох танхим"<sup>12</sup> хэмээн нэрлэсэн байдаг. (House of review)

Ардын төлөөлөгчдийн буюу доод танхим хуулийн төслийг эхэлж баталсаны дараа хууль тогтоох буюу дээд танхим хянан хэлэлцээд эцэс нь ерөнхийлөгч, ерөнхий сайд эсвэл хаан батламжилж байж саяхууль хүчин төгөлдөр мөрдөгддөг хоёр танхимт парламентын жишиг эдүгээ дэлхийн улсуудад хэлбэршин тогтжээ.

---

<sup>10</sup>Ц.Ганболд, Д.Бадамдаш, Ц.Мөнхцэцэг, Ж.Төртогтохнарын хамтын бүтээл. "Европынхолбооныулсуудынпарламент" 5 дахь тал. УБ.,1998

<sup>11</sup>Өдрийн сонин" 2016.11.11-ны дугаар (Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Доктор Лүндэндоржийн ярилцлага)

<sup>12</sup>Ц.Ганболд, Д.Бадамдаш, Ц.Мөнхцэцэг, Ж.Төртогтохнарын хамтын бүтээл. "Европынхолбооныулсуудынпарламент" 5 дахь тал. УБ.,1998

Хэрвээ доод танхимаас баталсан хуулийн төслийг дээд танхим дэмжин батлаагүй тохиолдолд хуулийн төслийг буцаад доод танхим руу шилжүүлнэ. Энэ тохиолдолд доод танхим уг хуулийн төслийг гуравны хоёрын саналаар дахин баталсан бол хуулийг батлагдсан гэж үзээд ерөнхийлөгч, ерөнхий сайд, эсвэл хаанд батламжлуулахаар илгээдэг. (Англи, Япон, Орос, Герман, Польш)

Ялангуяа улсын төсвийн хуулийг батлахад эхлээд заавал парламентын доод танхимаар эхэлж хэлэлцүүлдэг. Яагаад гэвэл “доод” хэмээгдэх бүх нийтээс шууд сонгогдсон танхим нь өв залгамжлал, томилолт, шууд бус сонгууль зэрэг механизмаар бүрэлддэг танхимаас санхүүтэй холбоотой хууль санаачлах эрхтэйгээрээ өвөрмөц байдаг. Учир нь доод танхим татвар төлөгчийг шууд төлөөлдөг юм<sup>13</sup> хэмээн зарим судлаачид бичсэн байдаг.

*Гуравдугаарт, нийгмийн бусад салбарын төлөөллүүдийг парламентад хангалттай оруулах боломж бүрдэнэ.* Парламент бол ард түмний төлөөлийн байгууллага учраас түүнд нийгмийн янз бүрийн салбарын төлөөлөл орсон байх ёстой. Энэхүү нийгмийн салбарын төлөөллүүд заавал сонгуулиар сонгогдох биш, бас улс төрийн бодлогын томилгоогоор хууль тогтоох байгууллагад орох нь чухал байдаг. Учир нь аль нэг намын харьяалалгүй мөртлөө ард түмний дэмжлэгийг хүлээсэн их дээд сургуулийн багш, судлаач, эрдэм шинжилгээний ажилтан, ерөнхийлөгч, ерөнхий сайд байсан хүмүүс гэх мэт нэр хүндтэй иргэд<sup>14</sup> цөөнгүй байдаг агаад тэднийг хууль тогтоох байгууллагад сонгогдож ажиллаасай гэсэн иргэдийн хүлээлт ч их байдаг. Гэвч тэдний ёс суртахуун одоо буй шударга бус тогтолцоог төдийлөн хүлээн зөвшөөрдөггүйн улмаас засаглагч улс төрийн намуудаас хол хөндий байдаг нь нууц биш юм. Тэгвэл парламентыг хоёр танхимтайгаар зохион байгуулснаар ард иргэдийн үлгэр дуурайлал болсон, түмэн олны дэмжлэгийг байнга өөртөө хүлээж байдаг тэр мэт хүмүүсийг дээд танхимд шууд томилж болох нөхцөл бүрдэнэ. Тодруулбал доод танхим бүхэлдээ шууд сонгуулиар сонгогдож байхад дээд танхимын бүрэлдэхүүний заримыг нийгмийн чухал салбаруудын төлөөлөөс шууд томилгоогоор бүрдүүлэх боломжтой. Тухайлбал Францын парламентын дээд буюу Сенатын танхим нь мужуудын төлөөлөл болж сонгогдсон гишүүдээс гадна насаараа томилогдсон цөөн тооны сенатчаас бүрддэг. Тэдгээр бүх насаараа томилогдсон гишүүд нь Италийн ерөнхийлөгч байсан хүмүүс болон нийгэм шинжлэх ухаан урлагийн салбар дахь

---

<sup>13</sup>Hague et all., “Comparative Government and Politics”, 205

<sup>14</sup>Ерөнхий сайд асан Д.Бямбасүрэн, Д.Содном, Хуульч С.Нарангэрэл гэх мэт хүмүүсийг дурдаж болно.



нэр хүнд, ололт амжилтыг нь харгалзан одоогийн ерөнхийлөгчийн томилсон тав хүртэлх тооны гишүүд байдаг.<sup>15</sup>

Эсрэгээрээ нэг танхимтай парламентад намын нөлөөлөл хүчтэй байдаг учраас намд хамааралгүй нийгмийн чухал салбарын дэвшилтэт төлөөллүүд парламентын гадна үлдэх муу талтай байдаг. Ингэснээр нийгмийн боловсон хүчний нөөцийг бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй нөхцөл үүсдэг.

### Дүгнэлт

Дүгнэж хэлэхэд Их Британи, Итали, Канад, Франц, Япон зэрэг улсуудад парламентын дээд танхимыг татан буулгах, эсвэл шинэчлэх асуудал сүүлийн үед ихээхэн сөхөгдөх болсон бол эсрэгээрээ Бангладеш, Украин, Сингапур, Монгол зэрэг улсуудад нэг танхимтай парламентаас хоёр танхимтай парламент руу шилжих асуудлыг хүчтэй тавьж байна. Хоёр танхимтай парламентын бүтцийг халах санал санаачилга гаргадаг улсуудыг ажиглахад иргэний нийгэм төлөвшсөн, эдийн засаг тогтвортой, иргэд нь төртэй хэлэлцээний ширээний ард суух хэмжээний мэдлэг боловсролтой, соён гэгээрсэн, улс төрийн систем нь илүү легитимчлэгдсэн орнууд байгаа бөгөөд эсрэгээрээ хоёр танхимтай парламентын бүтцийг төрийн байгуулалдаа байгуулах гэсэн улсууд ялангуяа Монгол бангладеш, Украин зэрэг улсуудын эдийн засаг, улс төрийн систем нь тогтворгүй байгаа юм. Монголын хувьд улс төрийн систем болоод эдийн засаг тогтворгүй, хямралтай, үүнийгээ дагаад ард иргэдийн мэдлэг боловсрол, соёл, ёс суртахуун уналттай байгаа нь дэвшилтэт төрийн байгуулаллын хэлбэрийг эрж хайх байдал руу оруулж байна.

Их Британи, Итали, Канад, Франц, Япон зэрэг улсуудыг хөгжингүй орон болж хөгжихөд хоёр танхимтай парламентын бүтэц өөрийн үндсэн чиг үүрэг болох шударга ёсыг тогтоох, намын дарангуйлалд оруулахгүй байх, түүхий, цоорхой хуулийг гаргахгүй байх зэрэг хяналтын чиг үүргээ түүхэн цаг үеүүдэд амжилттай гүйцэтгэж байсан нь тодорхой юм. Хэдийгээр дээрх улсуудад хоёр танхимтай парламентаас татгалзах санал санаачилга их гардаг ч одоог хүртэл Шведээс өөр улс парламентын хоёр танхимын бүтцээс татгалзаагүй байна.

Харин буурай хөгжилтэй улсуудын хувьд засаглалын хямралаас шалтгаалж илүү дэвшилтэт төрийн байгууллыг (хоёр танхимтай парламент) эрж хайж байгаа нь зүй ёсны үзэгдэл бөгөөд төрийн эрх мэдлүүдийн тэнцвэржилтийг хангах, хуулийн төслийг парламентын хоёр танхимаар ээлжлэн хэлэлцүүлж чанартай батлан гаргах, нийгмийн салбарын төлөөллүүдийг парламентад хангалттай оруулах, улмаар засаглалыг илүү легитимчлэгдсэн болгоход хоёр танхимтай парламентын бүтэц илүү үр өгөөжтэй юм.

---

<sup>15</sup>Constitution of Italy Art. 59

**Abstract:** Here shows the development of the bicameral parliament, the theoretical basis and its political importance and advantages. For example, by setting up a bicameral parliament these issues are addressed: slow the decentralization of state powers, equilibrium, the draft law was drafted in two parliamentary chapters, to adopt a quality law, to mobilize the representation of the public in the parliament.

**Ашигласан ном, материал**

Ж.Төртогтох “Парламент судлалын гарын авлага” УБ., 2010

Д.Лүндээжанцан “Монгол улс дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт” УБ., 2014

Ц.Ганболд, Д.Бадамдаш, Ц.Мөнхцэцэг, Ж.Төртогтох нарын хамтын бүтээл.

“Европын холбооны улсуудын парламент” УБ., 1998

О.Машбат “Үндсэн хууль: улс төр- эрхзүй-хянал-тэнцэл” УБ., 2015

Ш.Л.Монтескье. “Хуулийн амин сүнс” орч. Төмөрхүлэг УБ., 2008

Ж. Руссо. “Нийгмийн гэрээний онол” УБ., 2002

Д.Лүндээжанцан, Ж.Болдбаатар. “Монголын төр эрх зүйн түүхэн уламжлал” УБ., 1997

Н.Хавх. “Нийгмийн гүн ухаан” УБ., 1996

МУИС “Политологи” сэтгүүл УБ., 2015, 2016

“Ардчилал, иргэний засаглал” Парламент дахь иргэний төлөөлөл хөдөлгөөн УБ., 2012

Юндэндорж, А. Атар, Ю. “Өрнө дорнын мэргэдийн нийгэм-улс төрийн онол, сургааль” II-III дэвтэр Хөх хот., 2003 он

Маклаков. ВВ. Парламенты стран-членов Европейского Союза. М., 1994

Meg Russell “The Contemporary House of Lords” Westminster Bicameralism Print publication date 2013

George Tsebelis, Jeannette Money “Bicameralism” Date Published: June 1997

“Senates, Bicameralism in the Contemporary World” Edited by Samuel C. Patterson and Anthony Mughan., 1999

**УЛС ТӨРЧИЙН ЭРХ ЗҮЙН БА ЁС ЗҮЙН ХАРИУЦЛАГА: ЗААГ ЯЛГАА,  
АЧ ХОЛБОГДОЛ****Д.Оюунчимэг**МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,  
Улс төр судлалын тэнхимийн ахлах багш**Д.Ундрах**МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,  
Улс төр судлалын тэнхимийн дэд профессор

**Товч агуулга:** Өдгөө Монголын улс төрд хамгийн ихээр хөндөгдөж буй атал хамгийн дутагдаж байгаа зүйл бол улс төрчдийн хариуцлага, тэр дундаа тэдний ёс зүйн хариуцлагын асуудал билээ. “Улс төрчдийн хариуцлагыг хэн, хэзээ, хэрхэн тооцох вэ? Улс төрчдөд хуулийн хариуцлага тооцож чадаж байна уу? Хуулийн хариуцлага хүлээлгэж чадсан эсэхээр улс төрчдийн хариуцлагыг дүгнэх нь хангалттай юу? гэх мэт хариу нэхсэн олон асуултыг хөндөж эрх зүйн болон ёс зүйн хариуцлагын зааг ялгаа, ач холбогдлыг тодруулахыг зорьлоо.

**Түлхүүр үгс:** хариуцлага, ёс зүй, парламентын гишүүд, эрх зүйн хариуцлага, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл

Улс төр гэж чухам юу вэ? Улс төр хаана, хэзээ үүсдэг вэ? Хамтын шийдвэрийг ямар нэг арга хэрэгслийн тусламжгүйгээр гаргах боломжгүй үед улс төр үүснэ. Улс төр гэдэг бол нийгэмд үнэт зүйлсийг хуваарилан байршуулах, эрх мэдлийг тогтоох, нийтийн үйл хэрэгт хяналт тавин зохицуулах зорилгоор нийгмийн бүлгүүд, тэдгээрийг төлөөлсөн байгууллага, хүмүүс хоорондоо зөрөлдөж, зөвшилцөж байж нийтээр дагаж мөрдөх шийдвэр гаргаж, түүнийг хэрэгжүүлэх үйл явц юм. Энхүү үйл явц буюу улс төрийн харилцааг зохицуулдаг үндсэн хэм хэмжээнүүд бол “эрх зүйн хэм хэмжээ”, “ёс зүйн хэм хэмжээ”, “бүлгийн хэм хэмжээ”, “улс төрийн уламжлал” юм.

*Эрх зүйн хэм хэмжээ* нь төрөөс тогтоож, төрийн дэмжлэгтэйгээр хэрэгжиж байдаг онцлогтой бол *ёс зүйн хэм хэмжээ* хамгийн нийтлэг үйлчилж, хамгийн чухал үүрэг гүйцэтгэж байдаг онцлогтой. *Бүлгийн хэм хэмжээ* гэдэгт нийгмийн

тодорхой бүлгийн дэг жаяг, тухайлбал улс төрийн намын дүрэм зэрэг орно. Харамсалтай нь манай зарим нэг улс төрийн намын дүрэм хуулин дээгүүр давсан журмыг агуулж байх жишээтэй. Монголын улс төрд *улс төрийн уламжлал*, уламжлалт зан заншлууд, тухайлбал “төрийн тахилгат овоо”, “төрийн золголт” зэрэг нь эерэг, сөргөөр нөлөөлсөөр байна.

Улс төрийн хүрээнд гарч буй аливаа асуудал, зөрчил нэг бол “тогтолцооны шинжтэй”, эсвэл “нөхцөл байдлын шинжтэй” байх бөгөөд цөөн тохиолдолд дээрхи хоёр төрлийн зөрчил давхцах тохиолдол байх боломжтой. Улс төрч хэн байхаас үл шалтгаалан гарч ирж буй зөрчил, асуудал нь тогтолцооны шинжтэй зөрчил бол, харин улс төрчийн буруутай үйл ажиллагаанаас үүдсэн зөрчлийг нөхцөл байдлын шинжтэй, субъектив хүчин зүйлээс шалтгаалсан зөрчил гэж үзэж чухам энд л улс төрчидтэй хариуцлага тооцох учиртай.

Улс төрч гэж хэн бэ? Ямар хүнийг улс төрч гэх вэ? Хэн захирах ёстой вэ? гэсэн асуудал улс төр судлалын үндсэн асуудал байсаар ирсэн, цаашид ч байх буй заа. Суут сэтгэгч Аристотель “аристократууд” захирах ёстой гэсэн бол, Платон “философичид” буюу философи сэтгэлгээтэй хүмүүс захирах ёстой гэх зэргээр эл асуудал олон зууны туршид, олон арван сэтгэгчдийн анхаарлын төвд байсаар иржээ.

Өнөөдөр улс төрч гэж хэнийг хэлэх вэ? гэсэн асуудалд хандах хоёр өөр хандлага оршин байна. Үүнд: Эхний хандлага бол “Улс төрч бусдын адил л хүн. Тиймээс бусад хүмүүсээс ялгарах шаардлагагүй” гэж үзэх хандлага. Дараагийн хандлага бол “Улс төрч бусдын адил бус. Тиймээс бусад хүмүүсээс ялгарч байх ёстой” гэж үзэх хандлага. Эдгээр хандлагын аль нь зөв бэ? Аль аль нь зөв. Улс төрч хүн эдэлж хэрэглэх зүйлсээс эхлээд өдөр тутмын амьдралдаа бусдын адил энгийн байх нь зохистой бол харин үүрэг хариуцлага хүлээх хийгээд мэдлэг, ур чадварын хувьд жирийн иргэнээс давуу байж, ялгарч байх шаардлагатай. Өөрөөр хэлбэл улс төрч, жирийн иргэн хоёрын хэмжүүр, шалгуур, хүлээх үүрэг хариуцлага өөр.

Улс төрчдийг жирийн иргэдээс ялгаж байгаа өөр нэг зүйл бол эрх мэдэл. Эрх мэдэл гэдэг бол төрөлхийн бус, олгогддог зүйл. Хэн, хэнд, хэрхэн олгож байгаа нь гол асуудал. Улс төрийн эрх мэдэл гэдэг бол шийдвэр гаргах, шийдвэр гаргахад оролцох эрх мэдэл бөгөөд Х.Арендтын хэлснээр: “Эрх мэдэл гэдэг бол хамтран хийх үйлдэлд бусдыг өдөөж өгөх чадвар” юм<sup>1</sup>. Өнөө үед эрх мэдэлд хүрэх нь Макиавеллийн дэвшүүлснээс арай өөрөөр өрнөх болсныг Америкийн

---

<sup>1</sup> Ж.Жаргал. Тоталитаризмын тухай Х.Арендтын онолын баримтлал. УБ.2009, 41-р тал.

социологич, сэтгэл зүйч, профессор Дачер Келтнер тодорхойлохдоо өнөө үед эрх мэдэлд хүрэх 5 алхам байна гэж үзсэн<sup>2</sup>. Тэрээр “нийгэм бол ертөнцийг өөрчлөх гэсэн хүний суурь хэрэгцээнд тулгуурласан байгууллага” гэж үзжээ. Тиймээс ёс зүйн зарчмууд гэдэг нь энэхүү хэрэгцээг хэрэгжүүлэх боломжийг нь хүмүүст олгох арга хэрэгсэл юм. Эдгээр зарчмууд бүгд нийлээд өдөр тутмын амьдралдаа эрх мэдэлд хүрэх 5 алхам болно. Үүнд:

1. Эрх мэдлийн мэдрэмжээ ухаарагтун.
2. Даруу төлөв байдлыг дандаа санаж явагтун.
3. Бусдын тухай бодож, өгөөмөр зан гаргаж бай.
4. Хүндэтгэлээ ил гаргаж бай.
5. Эрх мэдэлгүй байдлын сэтгэлзүйн агуулгыг өөрчил гэсэн санааг дэвшүүлсэн

бол, Мишель Фуко “эрх мэдэл нь сүлжээ бүхий байгууллагуудаар дамжин хэрэгжиж, илрэн гардаг” гэж баталжээ<sup>3</sup>. Улмаар Дачер Келтнер орчин үед эрх мэдэл, нэр нөлөөг хэрхэн олдог бас хэрхэн алддаг тухай, улс төрийн коммуникацийн хэлбэр, хэв маяг хэрхэн өөрчлөгдөж буйг судлан дараахи дүгнэлтийг гаргажээ. Үүнд: “Бусдад нөлөөлөх чадвар нь хүмүүстэй тогтоосон харилцаа холбооны сүлжээнээс хамаардаг. Энэ нь өнөө үед фэйсбүүкийн 300 найз, 1200 танил, гэр бүл, 6-8 дотно найзыг (АНУ-ын дундаж тоо) хэлэх бөгөөд тэдгээр хүмүүсийн бусдад нөлөөлөх хэр хэмжээнээс энэ тоо өөрчлөгдөнө<sup>4</sup> хэмээн дүгнэсэн байна. Харин Монголын нөхцөлд энэ тоо баримт илүү өргөн хүрээг хамарч гарах нь тодорхой юм.

Иргэн “хуулиар хориглоогүй болгоныг хийх” эрхтэй бол, харин улс төрч “хуулиар зөвшөөрсөнийг л хийх” эрхтэй байдгаараа ялгаатай. Чухамдаа энэ зарчмыг үл огоорсноос “...би яасан юм? ..би хууль зөрчөөгүй. ...би хуулийн хүрээнд ажилласан. Иймээс намайг ажлаас халах ёсгүй” хэмээн улс төрийн албан тушаалдаа үлдэх гэж шүүхэд ханддаг. Гэтэл эл зарчим жирийн иргэдэд үйлчлэх нь оновчтой бол харин улс төрчдөд оновчтой бус юм.

Өнөөдөр Монголын нийгэмд улс төрчдөд, тухайлбал парламентын гишүүдэд хариуцлага тооцох гол механизм нь тэдэнд хуулийн хариуцлага хүлээлгэх явдал гэж олон нийтийн нилээд хэсэг нь үзсээр байгаа, нөгөө талаас улс төрчид ч “би хууль зөрчөөгүй”, “би буруугүй” гэсэн хандлага давамгайлсаар байна. Хуулийн хариуцлага хүлээлгэх нь улс төрчийн хариуцлагатай эсэхийг

<sup>2</sup> Дачер Келтнер. Эрх мэдлийн парадокс, УБ., 2017, 154-158-р тал.

<sup>3</sup> Дачер Келтнер. Эрх мэдлийн парадокс, УБ., 2017, 48-р тал.

<sup>4</sup> Дачер Келтнер. Эрх мэдлийн парадокс, УБ., 2017, 40-р тал.

бүрэн илтгэх боломжгүй юм. Чухам энд л нэг талаасаа мэдээжийн боловч, нөгөө талаасаа ямагт дутуу анзаарагдсаар ирсэн буруу хандлага оршиж байна.

Улс төрчийн улмаар парламентын гишүүний хариуцлагыг дан ганц “хуулийн хариуцлага”-аар тооцох нь учир дутагдалтай юм. Хуулийн хариуцлага бол хариуцлага тооцох эцсийн хэлбэр. Хуулийн хариуцлагаас өмнө “ёс зүйн”, “улс төрийн”, “захиргааны” зэрэг хариуцлагын өөр өөр хэлбэрүүд байх бөгөөд улс төрчийн, парламентын гишүүний хариуцлагыг эдгээр хэм хэмжээнүүдээр дүгнэдэг байж гэмээнэ сая “хариуцлагатай улс төрчдийг”-ийг төлөвшүүлнэ.

Хувь хүнийг хийгээд улс төрийн бодлого шийдвэрийг “сайн, муу”, “зөв буруу” хэмээн үнэлэх хамгийн суурь хэмжүүр нь ёс зүй. Улс төрийн хариуцлагыг эрх зүйн үүднээс бус, ёс зүйн үүднээс хүлээх болсон нөхцөлд л улс төр цэвэр болох ба эргээд улс төрд ёс зүйн зохицуулалт зонхилох нь ардчилал оршин тогтнох үндэс ажээ.

Улс төрчдийн ёс суртахууны хариуцлагын асуудал нь зөвхөн улс төрчдөөс шалтгаалаад зогсохгүй, нөгөө талаас иргэдийн боловсрол, соёл, хандлагаас ихээхэн шалтгаадаг, хоёр талт харилцан хамаарал бүхий үзэгдэл, үйл явц юм. Жишээ авч үзье. Японд улс төрч эмэгтэй өөрийг нь дэмжиж дэвүүр тараасан ТББ-ын өмнөөс уучлалт гуйн сайдын суудлаасаа татгалзсан. Энэ улс төрч эмэгтэйд Япончуудын олонхи хэрхэн хандах вэ? Монголд үүн шиг уучлалт гуйж сайдын суудлаасаа татгалзсан эмэгтэйд манай иргэд сонгогчид хэрхэн хандах вэ? Энд ялгаа байдаг уу? Японы иргэд, сонгогчдын олонхи нь огцорсон улс төрчийг “мэдрэмжтэй, соёлтой, хүмүүжилтэй улс төрч гэж үзэж дараагийн сонгуулиар өмнөхөөсөө илүүтэйгээр дэмжлэг үзүүлдэг бол харин манайд ингэж огцорсон улс төрчийг “буруу зүйл хийсэн, алдаа гаргасан, ичихгүй дахиад гараад ирлээ, хүн мундсан биш гэх зэргээр дэмжихгүй байх хандлага илт давамгайлдаг явдал Монголын иргэд сонгогчдын нэг нуугдмал ноцтой дутагдал юм.

Иргэд, сонгогчдын зүгээс улс төрчдөд ёс зүйн хариуцлага тооцох арга, механизм, боломж ямар байгаа, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, сэтгүүлчдийн эрх, үүрэг, иргэний нийгмийн байгууллагууд, мэргэжлийн эвсэл холбоодын зүгээс хяналт тавих, хариуцлага тооцох арга механизм ямар байх нь улс төрчдөд ёс зүйн хариуцлага хүлээлгэх үндсэн нөхцөл болно.

Улс төрчдөд хүлээлгэх ёс зүйн хариуцлага нь улс төрийн хариуцлага шиг сонгуулиар, эрх зүйн хариуцлага шиг гэмт үйлдлээр тооцогдохгүй бөгөөд хяналт нь өдөр тутмын, байнгын шинжтэй байж үр нөлөөгөө өгнө.

Олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдийн төрөл, тоо, чанар хурдтайгаар өсөн нэмэгдэж буй өнөө үед иргэд сонгогчдын оролцоо нэн чухал боловч мэргэшсэн сэтгүүлчдийн эрэн сурвалжилж мэргэжлийн түвшинд хяналт тавих, асуудал дэвшүүлэх болон хариуцлага тооцох чадвар нэн чухал билээ.

Улмаар хүний эрх, байгаль орчин, хуулийн хэрэгжилт зэрэг олон асуудлаар улс төрчдийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрт хяналт тавих эрх бүхий мэргэжлийн эвсэл холбоод, иргэний нийгмийн байгууллагууд, төрийн бус байгууллагуудад болон сэтгүүлчдэд үйл ажиллагаагаа явуулах нөхцөл боломжийг нь хуулиар сайжруулж өгөх шаардлагатай.

Ёс зүйн утилитаризмын үүднээс авч үзвэл: “Хүн бүр аз жаргалтай амьдрахыг хүсдэг”. Харин парламентын гишүүн дараахи хоёр асуултанд хариулах хэрэгтэй болдог. Үүнд:

“Би явал аз жаргалтай амьдрах вэ?”

“Би яаж бусдыг аз жаргалтай болгох вэ?” гэсэн асуултауд.

Эхний асуултыг жирийн иргэн өөртөө тавьдаг бол харин улс төрч хоёр дахь асуултанд хариулт олохын тулд л улс төрд орж ирдэг. Үүнийгээ бүрэн ухаараагүй, өөрийн баяжихыг улсын хөгжилтэй андуурдаг, алдаа оноогоо ёс зүйгээр бус хуулиар хэмждэг, түмэн олныхоо төлөө бус төрсөн хүүхдүүд, төрөлх компанийхаа төлөө явдаг “бизнесмен”-ний түвшний сэтгэлгээтэй хүмүүсийг улс төрд олноор нь оруулж буй явдалд улс төрийн намууд төдийгүй иргэд сонгогчид ч дүгнэлт хийхэд илүүдэхгүй.

Парламентын гишүүний эрх, үүрэг, ёс зүйн хариуцлагын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага ямар байх вэ? Парламентын гишүүний эрх, үүрэг хууль, журмаар зохицуулагддаг. Харин ёс зүйн зөрчил дээрхи хууль, журамд тэр бүр тусгагдах боломжгүй. Хэрэв парламентын гишүүдэд ёс зүйн хариуцлага хүлээлгэж байгаа бол нөгөө талаас “урамшуулал” зайлшгүй байх шаардлагатай. Энэ урамшууллыг мөнгөн буюу материаллаг хэлбэрээр төр засгаас олгох гэхээс илүү ёс зүйн талаас нь сонгогчдын зүгээс, олон нийтийн мэдээллээр урамшуулах зэрэг оновчтой арга механизмууд тогтмол үйлчилдэг байх нь чухал. Үүнээс үүдэн тодотговол зохих нэг асуудал бол парламентын гишүүдийн хөдөлмөрт хэн, хэрхэн үнэлгээ өгдөг вэ? гэдэг асуулт юм. Гишүүдийн үйл ажиллагаанд тэдний хуралдааны ирцийг бүртгэхээс хэтрэхгүй шахам байна. Тухайлбал хэдэн хууль, ямар хууль санаачилсан, тэр нь ямар үр дагавар авчирсан зэрэгт үндсэндээ хариуцлага тооцдоггүй гэж болно. Парламентын гишүүн ямар нөхцөлд улс

төрийн болон ёс зүйн хариуцлагатай ажиллах вэ? Үүнд өгөх хариулт дараахь асуултуудтай нягт холбогдоно.

- Парламентад нэр дэвшин сонгогдсон зорилго?
- Зорилгоо хэрэгжүүлэх боломж? (эрх зүйн, эдийн засгийн, улс төрийн, нийгмийн, цаг хугацааны...)
- Зорилгоо хэрэгжүүлэх арга хэрэгсэл, арга зам?
- Зорилго нь сонгогчдын хэрэгцээ шаардлагатай нийцэж байгаа эсэх? зэрэг нь энэ бүхний эх үндэс юм.

Парламентын гишүүн нь төрийн түшээ, түмний төлөөлөл болж буйгаа ухамсарлан тойргийн явцуу эрх ашиг, нам бүлгийн эрх ашигт хөтлөгдөлгүйгээр ажиллая гэвэл наад зах нь улс орны өмнө тулгамдаж буй гол асуудлуудыг судлан тодорхойлж, эрэмблэх чадвартай байх, асуудлуудыг шийдвэрлэх боломжуудыг төрөлжүүлэн ялгах, боломж, бололцоонуудыг нэмэгдүүлэх арга судлан тодорхойлдог байх, асуудлаа шийдвэрлэх арга хэлбэрээ оновчтой сонгох мэдлэг, мэдээлэлтэй байх шаардлагатай. Хэрэв улс төрийн нам, бүлгүүдийн санал зөрөх аваас шийдвэрийн хамгийн оновчтой хувилбар дээр санал нэгдэх арга зам олох, гаргасан шийдвэр, авсан арга хэмжээ, хийсэн ажлын үр дүндээ цаг тухай бүрт нь үнэлэлт өгч, тайлагнаж, мэдээлж байх нь гишүүдэд “тойргоо услах” шударга бус үйлдлээс нь хэд дахин илүү үр ашиг өгнө.

Парламентын гишүүний ёс зүйн хариуцлагыг дээшлүүлэхийн тулд юуны өмнө:

- УИХ-ын гишүүний ёс зүйн дүрэмд өөрчлөлт оруулах, уг дүрэмд гарын авлага дагалдуулдаг олон улсын жишгийг хэрэглэх,
- Парламентын хуралдааны дэгийг шинэчлэн сайжруулах,
- Хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг буруу гаргасан, нуун дарагдуулсан гишүүдэд хүлээлгэх ёс зүйн хариуцлагын механизмыг оновчтой болгох,
- Олон улсын жишигт нийцүүлэн өнөөгийн байдлаар ямар ч эрх, үүрэггүй ёс зүйн дэд хороог ёс зүйн байнгын хороо болгох, бүрэлдэхүүнд нь парламент дахь намуудын төлөөллийг, ялангуяа сөрөг хүчний төлөөллийг хангаж байх,
- Парламентын гишүүдийг улс төрийн эрх мэдэл албан тушаалд томилохдоо тэдний ёс зүйн хариуцлагыг гол шалгуур болгож хэвших,
- Парламентын гишүүдийн ёс зүйн хэм хэмжээ, хариуцлагад олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн үүрэг хариуцлагыг дээшлүүлэх гм.



Улс төрийн ёс зүйн хэм хэмжээг стандартчилж, кодекст оруулж болох уу? Үүний үндсэн зорилго нь юу вэ? Энэ нь легитимчлэл ба хариуцлагыг дээшлүүлэх, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, авилга болон нөлөөллөөс холдуулах, эрх ашгийн эрэмбэ дарааллыг баримтлуулах, олон улсын жишигт нийцүүлэх зэрэг зорилготой<sup>5</sup>. Бичмэл бус хуулийг бичгийн хэлбэрт шилжүүлж хуульчлан сахих хэм хэмжээнд хөрвүүлнэ гэдэг арга зүйн хувьд тийм ч амар бөгөөд хялбар шийдэгдэх ажил биш гэдэг нь тодорхой. Гэвч нэг талаас харьцангуй сайн дурын шинжтэй ёс зүйн хэм хэмжээний өвөрмөц онцлогийг харгалзахын ялдамд түүний нөгөө талд буй олон зуун жилийн турш хүмүүсийн аж амьдралд заншил зуршлаар дархлагдсан, хэрэв хэрэгжүүлж чадвал нийгмийн харилцааг тохинуулахад өөр ямар ч арга хэрэглэх шаардлагагүй хүчирхэг зохицуулагчийн үүрэгтэй ёс зүйн хэм хэмжээний үүрэг, ач холбогдлыг бид дутуу үнэлж, хойш тавьж боломгүй байна<sup>6</sup>. Эцэст нь дахин сануулахад парламентын гишүүдэд нийгмийн зүгээс өгч байгаа үнэлэмж ёс зүйн хэм хэмжээгээр голлон үнэлэгдэж байдгийн учир өдгөө Монголын нийгэмд улс төрчдийн ёс зүйн хариуцлагыг дээшлүүлэх явдал төрт ёсны төлөвшилд төдийгүй ардчиллын бэхжилтэд ч нөлөөтэй амин чухал асуудал юм.

**Abstract:** An issue of responsibility for politicians' is the most widely expressed term, though unfortunately, unresolved one in contemporary Mongolian politics. In the article, we try to explore the importance of responsibility and accountability of politicians and to distinguish legal and ethical responsibilities of those elected officials in Mongolian political practice.

**Abstract:** An issue of responsibility for politicians' is the most widely expressed term, though unfortunately, unresolved one in contemporary Mongolian politics. In the article, we try to explore the importance of responsibility and accountability of politicians and to distinguish legal and ethical responsibilities of those elected officials in Mongolian political practice.

**Ашигласан ном, материал:**

Мэргэжлийн ба хэрэглээний ёс зүй, УБ., 2012

“Ардчилал-Нийгмийн хариуцлага” ЭШХ-ын эмхэтгэл. 2010

Аристотель. “Дээд суртахуун” Адмон. УБ., 2008

Д.Дэмбэрэл. “Ёс зүйт төр” УБ. 2011

Дачер Келтнер. Эрх мэдлийн парадокс, УБ., 2017

---

<sup>5</sup> Д.Ундрах. Парламентийн ёс зүйн судалгаа ба хөгжил. МУИС, Политологи сэтгүүл 2015. #12 (419)

<sup>6</sup> Мэргэжлийн ба хэрэглээний ёс зүй, УБ., 2012, 15-р тал.

- Ж.Жаргал. Тоталитаризмын тухай Х.Арендтын онолын баримтлал. УБ.2009
- Х.Наранжаргал. “Боловсролын засаглал дахь нийгмийн эгэх хариуцлага”  
бодлогын форум. Глоб Интернэшнл төв. УБ. 2016.
- Ц. Даваадулам. Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг.  
УБ., 2010
- Д.Ундрах. Парламентийн ёс зүйн судалгаа ба хөгжил. МУИС, Политологи  
сэтгүүл 2015. #12 (419)
- УИХ-ын гишүүний ёс зүйн дүрэм
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг  
сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль

**АРДЧИЛСАН СОНГУУЛИЙН ҮНДСЭН ЗАРЧИМ, ХЭРЭГЖИЛТ****Д.Түмэнжаргал**МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,  
Улс төр судлалын тэнхимийн ахлах багш

**Түлхүүр үг:** Ардчилал, Ардчилсан сонгууль, Сонгуулийн байгууллага, Сонгуулийн Зарчим, Нам, Сонгогчдын оролцоо, УИХ-ын сонгууль.

**Товч агуулга:** Монгол улсад ардчилсан сонгуулийг зохион байгуулаад 28 жил болсон байна. Энэ хугацаанд УИХ-ын сонгууль 7 удаа, Ерөнхийлөгчийн сонгууль 7 удаа, орон нутгийн сонгууль 7 удаа, УИХ-ын нөхөн сонгуулийг 10 гаруй удаа тус тус зохион байгуулсан. Монголын сонгууль хэдийгээр шударга, чөлөөтэй, тэгш, нууцаар гэсэн ардчиллын үндсэн зарчмуудын дагуу явагдаж ирсэн. Гэвч ардчиллын тулгуур үндсэн зарчмууд нь зарим тохиолдолд зөрчигдөж байна. Дэлхий олон орны ажиглагч, судлаачид Монгол улсад болж өнгөрсөн сонгуулиудыг шударга, ардчилсан сонгуулиуд байж чадсан гэж дүгнэдэг. Гэсэн хэдий ч Монгол улсын ардчилсан сонгуулиудыг явуулахад бэрхшээлтэй асуудлууд тулгарсаар байна. Энэ эрдэм шинжилгээний өгүүллийн хүрээнд ардчиллын үндсэн зарчмуудын хэрэгжилт, түүний гажуудал, тулгамдсан асуудлын талаар багтаан авч үзэж байна.

2015 оны 12-р сарын 25-ны өдөр шинэчлэн баталсан Монгол улсын Сонгуулийн тухай хуулийн 5-р зүйлд сонгуулийн үндсэн зарчмын талаар тусгасан байдаг. Тодруулбал, 5.1.Сонгуулийн тогтолцоо нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд “нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж сонгох” эрхийг хангахад үндэслэнэ. 5.2.Сонгууль “бүх нийтийн” байх бөгөөд түүнд Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэн /цаашид “сонгуулийн эрх бүхий иргэн” гэх/ бүр оролцох эрхтэй. 5.3.Сонгогч сонгуульд “шууд сонгох” эрхийнхээ үндсэн дээр ямар нэг төлөөлөлгүйгээр оролцож, саналаа өөрөө гаргана. 5.4.Сонгууль нь “чөлөөтэй байх” бөгөөд сонгогчоос сонгуульд оролцох эсэхээ бие даан шийдвэрлэх, саналаа чөлөөтэй илэрхийлэхэд хэн боловч албадан нөлөөлж, саад

учруулахыг хориглоно. 5.5.Сонгогч “саналаа нууцаар” гаргах ба хөндлөнгийн нөлөөгүйгээр хүсэл зоригоо илэрхийлж саналаа гаргах боломжоор хангагдсан байна.<sup>1</sup> хэмээн сонгуулийн үндсэн зарчмын талаар дэлгэрэнгүй заасан байдаг.

Мөн Монгол улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 9 дэхь хэсэгт "шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг 18 наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно; насанд хүрсэн иргэд сонгуулийн эрхтэй"<sup>2</sup> гэж хуульчлан баталгаажуулсан байдаг. Гэсэн хэдий ч Монгол улсын сонгуулийн тухай хуульд заасан энэхүү сонгуулийн үндсэн зарчмын талаарх заалтууд зарим тохиодолд хэрэгжихгүй байна. Энэ хуулийн заалтыг зөрчсөн этгээдүүдэд хүлээлгэх хариуцлагын тогтолцоо сул байна.

Монголын иргэний нийгмийн байгууллагууд нь ардчилсан нийгэмд байх жам ёсны үүргээ биелүүлэх хэмжээнд гарч ирж чадаагүй. Мөн улс орноо хөгжүүлэхэд хувь нэмэр оруулж, өөрсдийн ашиг сонирхол, хүсэл эрмэлзлэлээ ч төрийн бодлого шийдвэрт тусгуулж шийдэрлүүлэх хэмжээнд төлөвшөөгүй байна. Иргэний нийгмийн байгууллагуудын боловсон хүчний чадамж, санхүүгийн чадавхи сул, гол төлөв хандивлагч байгууллагын дэмжлэгт тулгуурласан үйл ажиллагаа явуулж байна.

Ардчиллын хөгжилд гарч буй хүндрэл, бэрхшээлүүд нь Монголын сонгогчдын ардчиллын талаар ерөнхий, хийсвэр ойлголттой, улс төрийн соёл, ёс зүй доогуур байгаатай холбоотой. Мөн түүнчлэн Монгол дахь эрх зүйт төр, ардчилсан хөгжлийн явцад учирсан зөрчил, бэрхшээлүүд нь ардчилал, ардчилсан засаглалын өнөөгийн байдал, хөгжлийн цаашдын хандлагад ч нөлөөлж байна. Ардчиллын чанарыг харуулах шалгуур үзүүлэлтэд хүний эрх, эрх чөлөө, эрх зүйт төр, харилцан тайлагнах тогтолцоо, үүрэг хариуцлага, тэгш байдал, оролцоо, өрсөлдөөн гол чухал байдаг. Өөрөөр хэлбэл ардчиллын чанар гэдэг нь хууль ёсыг бүрэн сахиж, төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаагаар иргэдийн эрх чөлөө, улс төрийн тэгш байдлыг баталгаажуулж, олон түмний зүгээс төр засгийн бодлого, үйл ажиллагаанд хяналт тавих асуудал хангагдсан байх ёстой. Ардчилал, сонгууль гэсэн хоёр ойлголт нь нэг зоосны хоёр тал юм. Тиймээс ардчиллын тухай ярьвал сонгуулийн тухай асуудлыг заавал хөндөх ёстой.

---

<sup>1</sup> Монгол улсын сонгуулийн тухай хууль. УБ., 2015 он

<sup>2</sup> Монгол улсын Үндсэн хууль. УБ., 1992 он

Ардчилсан сонгуулийн бүх нийтийн, тэгш, шууд, шударга, чөлөөт сонгууль бол тухайн орны ардчиллын түвшний гол шалгуур болдог. Ардчилсан улс оронд сонгууль **бүх нийтийн байх, шууд байх, тэгш байх, чөлөөтэй байх** гэсэн онолын үндсэн дөрвөн зарчмаар явагддаг. Сонгуулийн эдгээр зарчим нь иргэдийн сонгох, сонгогдох эрхээ хэрхэн хангах, сонгууль хэр зэрэг ардчилсан, шударга байдлаар явагдах нөхцлийг нь хангаж өгдөг. Харин Монгол улсад ардчилсан сонгуулийн эдгээр гол үндсэн дөрвөн зарчмын хэрэгжилт зохих хэмжээгээр хэрэгжиж байгаа боловч бүрэн хэрэгжиж чадахгүй байна. Монгол улсын Үндсэн хуулийн 1-р бүлгийн 1-р зүйлийн 2 дах хэсэгт тэгш эрхийг төрийн тулгуур зарчмын нэг болох тухай заасан<sup>3</sup>. УИХ-ын сонгуулийн тухай хуульд сонгуулийн тэгш эрхийн зарчмыг хуульчлаагүй орхисон.

### **1. Сонгуулийн бүх нийтийн зарчим**

Сонгуулийн бүх нийтийн зарчимд хуулиар насны хязгаарлалт, иргэний харъяаллын хязгаарлалт, оршин суугаа газрын хязгаарлалт, эрхийн чадамжийн хязгаарлалт, шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолын дагуу хорих газар ял эдэлж буй хүмүүс хүмүүс сонгуульд оролцдоггүй зэрэг зарим нэг хязгаарлалт тавигдсан байдаг. Үүн дотроо оршин суугаа газрын хязгаарлалтыг заахдаа Монгол улсын Сонгуулийн хуулинд "... санал авах өдөр эх орондоо байгаа иргэн" сонгох эрх эдлэнэ хэмээн заасан<sup>4</sup>. Энэ заалт нь сонгуулийн санал авах өдөр гадаад улсад албан ажлаар болон хувийн хэргээр зорчиж байгаа иргэд, мөн гадаад амьдарч буй иргэд сонгох эрхээ эдлэх боломжийг шууд хааж байна. Энэ нь бүх нийтийн зарчмыг алдагдуулж байна. Бүх нийтийн зарчмыг хэрэгжүүлэхэд сонгогчдын нэрийн жагсаалтын тухай асуудал чухал юм. Учир нь нэрийн жагсаалтыг хэн, хэрхэн, яаж үйлдэв гэдгээс сонгууль бүх нийтийн болж чадах эсэх нь хамаардаг.<sup>5</sup> Мөн Монголын сонгуулиудаар сонгогчдын санал маш ихээр гээгдэж байгаа нь бүх нийтийн зарчим хэрэгжиж чадахгүй байгааг харуулж байна. Тухайлбал, Тухайлбал: 1992 оны УИХ-ын сонгуульд сонгогчдын 60 орчим хувийн төлөөлөл хангагдаж 40 орчим хувийн төлөөлөл орхигдсон. 2000 оны сонгуулиар сонгогчдын бараг тал хувийн саналыг орхигдуулж байсан. Энэ нь сонгуулийн тогтолцоотой ч холбоотой. Хувь тэнцүүлэх тогтолцооны үед намууд ч, сонгогчид ч хохирох нь бага байдаг.

<sup>3</sup> Монгол улсын Үндсэн хууль. УБ., 1992 он


<sup>4</sup> Монгол улсын Сонгуулийн тухай хууль. УБ., 2015 он

<sup>5</sup> "Сонгогчдын идэвхийг нэмэгдүүлэх, оролцоог дээшлүүлэх асуудлууд". Ж.Нарантуяа. МУ-ын сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох нь. Олон улсын бага хурал. УБ., 2002 он


Монгол улсын Үндсэн хууль, Сонгуулийн хууль тогтоомжид баталгаажуулснаар сонгуулийн санал хураах өдөр Монгол улсын 18 насанд хүрсэн иргэн бүр ямар нэг хязгаарлалтгүйгээр үндэс, угсаа, хэл яриа, арьсны өнгө, хүйсийн байдал, нийгмийн гарал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил алба, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлахгүйгээр сонгох, сонгогдох эрхээ эдэлж саналаа өгөх<sup>6</sup> ёстой. Зарим оронд тухайлбал Бразил, Куба, Иранд 16 нас, цөөхөн оронд 19-21 наснаас эхэлдэг.

Монголын сонгогчид нийгмийн болон төрийн үйл ажиллагаанд оролцох идэвхи сул байна. Нөгөө талаас сонгогчид нь төрийн үйл хэрэгт оролцох, хяналт тавих эрхээ хэрэгжүүлэх боломж хязгаарлагдмал, төлөөллийн механизм ажиллахгүй байна. Мөн төр иргэдийнхээ өмнө хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлж байна" гэсэн Монголын хүний эрхийн байгууллагын дүгнэлт нь одоог хүртэл анхаарах асуудал хэвээр байна.<sup>7</sup>

**Монголын сонгогчдын сонгуульд оролцсон оролцооны хувь  
(УИХ-ын сонгууль 1992-2016 он)<sup>8</sup>**



**УИХ-ын сонгуульд оролцсон сонгогчдын хүчинтэй саналын хуудасны хувь  
(УИХ-ын сонгууль 1992-2016 он)<sup>9</sup>**



<sup>6</sup> Монгол улсын Үндсэн хууль. УБ., 1992 он


<sup>7</sup> Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөтэй байдлын тухай илтгэл. УБ., 2002

<sup>8</sup> Сонгуулийн ерөнхий хороо. УИХ-ын сонгуулийн дүн. УБ., 1992-2016 он

<sup>9</sup> Мөн тэнд

Ардчилсан сонгуулийн жилүүдэд сонгогчдын оролцоо сонгуулийн жил бүр буурсан үзүүлэлттэй байна<sup>10</sup>. Харин хүчинтэй саналын хуудасны тоо өссөн нь манай улсын сонгогчид сонгуульд оролцоходоо хариуцлагатай ханддаг болж байгааг харуулж байна. Сүүлийн сонгуулиар цөөнгүй сонгогчид цагаан сонголт хийсэн<sup>11</sup>. Цагаан сонголтын тоо цаашид нэмэгдэж магадгүй байна. Ер нь Монголын сонгогчид сонголт алга байгаа нь одоогийн төр барьж буй гишүүдийн хариуцлагагүй байдалтай холбоотой. Мөн энэ нь сонгогчдын оролцоо буурах гол шалтгаан болж байна. Үүнийг шийдэхэд гарц хайх нь чухал байна. Сүүлийн жилүүдэд Монголын сонгогчид төрийн бодлого, улс төрчдөд итгэх итгэл буурч, иргэд улс төрийн намуудаас хол хөндий болох хандлага ихэсч байна. Мөн төр засаг, улс төрийн хүрээнийхний авилгалд автсан, амиа хичээсэн, хариуцлагагүй байдал, нийгэмд шударга бус байдал бий болж байгаа зэрэг нь Монголын ардчиллын чанар сул байгааг илэрхийлж байна. Улс төрчид, улс төрийн хүчнүүд, сонгогчид нь ардчилсан үйл явц, ардчилсан өрсөлдөөний горимыг хүлээн зөвшөөрч, улс төрийн шударга өрсөлдөөнд ялж ялагдаж сурах хэрэгтэй байна. Сонгогчдын нэрийн жагсаалтад Монгол улсад байгаа байнга болон түр оршин суугаа Монгол улсын иргэнийг бүртгэнэ гэж заасан. Сонгогчдын нэрийн жагсаалтад сонгуулийн насны бүх иргэд хамрагдаж чадаж байгаа юу?. Үүнийг дараахь тоо баримтуудаас харвал:

**Сонгогчдын нэрийн жагсаалтад бичигдээгүй сонгогчдын хувь  
(УИХ-ын сонгууль 1992-2016)<sup>12</sup>**




**Сонгуулийн насны санал өгөөгүй сонгогчдын хувь**

<sup>10</sup> Мөн тэнд

<sup>11</sup> Сонгуулийн ерөнхий хороо. УИХ-ын сонгуулийн дүн. УБ., 2016 он

<sup>12</sup> Сонгуулийн Ерөнхий Хороо. УИХ-ын сонгуулийн дүн. УБ., 1992-2016 он

(УИХ-ын сонгууль 1992-2016)<sup>13</sup>



Энэ графикт Монгол улсад сонгуулийн насны нийт хүн ам бүгд сонгуульд хамрагдаж чадахгүй байна. Мөн нэрийн жагсаалтад бичигдэх байдал хангалтгүй байгаа нь ч харагдаж байна. Сонгуулийн жилээс жилд сонгуулийн насны сонгогчид нэрийн жагсаалтад бичигдэхгүй орхигдох нь улам ихэсч сонгуулийн бүх нийтийн зарчим алдагдахад хүрч байна. Энэ нь сонгогчдын өөрсдийнх нь хаягийн зөрчил болон бусад бичиг баримтын зөрчил, гадаад улсад түр хугацаагаар ажлаар, сурахаар болон бусад шалтгаанаар явах нь ихэссэн зэрэг шалтгаануудтай холбоотой юм. Монгол улсын иргэний бүртгэл мэдээллийн төв сонгогчдын нэрийн жагсаалтыг гаргадаг болсоор сүүлийн гурван сонгуулийг ардаа орхисон. Энэ байгууллага нь сонгуулийн насны сонгогчдыг бүрэн хамруулах, бүртгэл судалгаагаа сайжруулах зэрэг арга хэмжээ авах шаардлага зүй ёсоор тулгарч байгаа нь ажиглагдаж байна.

Үүнээс гадна ерөнхийлөгчийн сонгуулийн дүнгээс харахад мөн адил сонгуулийн нэрийн жагсаалтад сонгуулийн насны бүх хүмүүс хамрагдахгүй байгаа байдал нь эхний 4 удаагийн сонгуульд нилээд хувийг эзэлж байсан. Харин сүүлийн 3 удаагийн сонгуулиар сонгогчид нэрийн жагсаалтад байгаа эсэхээ шалгаж, идэвхитэй бүртгэл судалгаанд хамрагдаж, хаягийн зөрчлөө арилгаж сонгуульд бүрэн хамрагдаж байна. Энэ нь Монголын ард түмэн төрийн тэргүүн болох Ерөнхийлөгчийн сонгуульд хүндэтгэлтэй ханддагтай холбоотой. Хэдийгээр нэрийн жагсаалтад сонгуулийн насны бүх хүмүүс хамрагдах байдал нь ихэсч байгаа боловч сонгуулийн бүх насны хүмүүс сонгуулиа өгөх байдал хангалтгүй байна. Нэрийн жагсаалтад бүртгүүлсэн мөртлөө сонгуулиа өгөх байдал нь учир дутагдалтай байна. Сонгогчдын сонгуулиа өгөхгүй байдал, сонгогчдын идэвхи оролцоо сул байгаа талаар тусгай бүлэгт дэлгэрэнгүй авч үзсэн тул энд дахин

<sup>13</sup> Мөн тэнд



дурьдах нь илүүц юм. Дээрх сонгуулиудын дүнгээс харахад Монголын сонгууль бүх нийтийн байж чадахгүй байна.

2015 оны 12-р сарын 25-ны өдөр шинэчлэн баталсан Сонгуулийн тухай хуульд 2015 оны 05-р сарын 05-ны өдөр оруулсан нэмэлт өөрчлөлтийн дагуу 2016 оны УИХ-ын сонгуульд гадаадад суугаа иргэдээс санал авахыг хүчингүй болгож, гадаадад амьдарч байгаа Монгол улсын 160 000 орчим иргэдийн сонгуульд оролцох эрхийг хассан. Энэ нь мөн ардчилсан сонгуулийн бүх нийтийн байх зарчмыг ихээхэн алдагдуулсан.

## **2. Сонгуулийн шууд байх зарчим**

Сонгуулийн шууд байх зарчим нь мөн Монгол улсад зарим талаар зөрчигдөж хэрэгжихгүй байна. 2011 оны 12-р сарын 25-ны өдөр шинэчлэн баталсан УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 1-р бүлгийн 5-р зүйлийн 5.3 дахь хэсэгт “сонгогч сонгуульд шууд оролцох эрхийнхээ үндсэн дээр ямар нэг төлөөлөлгүйгээр оролцож саналаа өөрөө гаргана”<sup>14</sup> гэж заасан байдаг. Энэ заалт нь санал өгч байгаа сонгогч гадны ямар нэг оролцоо, хараа хяналтгүйгээр саналаа өөрөө бие даан, чөлөөтэй өгөх үйлдэл юм. Төлөөлөлгүйгээр гэдэг нь саналаа хэн нэгнээр дамжуулж өгөхгүй гэсэн үг. Гэтэл хөгжлийн бэрхшээлтэй, эрүүл мэндийн улмаас саналаа өөрөө өгөх боломжгүй сонгогчид нилээдгүй байдаг. Эдгээр иргэд бодит амьдрал дээр гэр бүлийн гишүүдийн хэн нэгний туслалцааг заавал авах зайлшгүй шаардлагатай болдог. Энэ тохиолдолд тухайн сонгогч саналаа шууд өгөх боломжгүй учир гэр бүлийн болон ойр дотны хэн нэгэн сонгогч тухайн сонгогчийн сонголтыг өөрчлөх, өөрийн дэмждэг хүнээ дугуйлах зэрэг сөрөг үзэгдлүүд гарсаар байна. Энэ нь сонгуулийн шууд байх зарчмыг зарим тохиолдолд алдагдуулсаар байна.

2012 оны УИХ-ын сонгуулийг 2011 оны 12-р сарын 15-ны өдөр шинэчлэн баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 6-р бүлгийн 27.1 дэх хэсэгт заасан нэрийн жагсаалтыг эхний 48-аас илүүгүй нэр дэвшигчийг энэ хуулийн 12-р зүйлд заасан 1-3 мандаттай сонгуулийн 26 тойргоос сонгоно. Харин 28-аас илүүгүй нэр дэвшигчийг 49.1.6-д<sup>15</sup> заасны дагуу гаргасан улс төрийн нам

---

<sup>14</sup> Монгол УИХ-ын сонгуулийн тухай хууль. УБ., 2011 он

<sup>15</sup> Тойрог бүрээс гаргасан 49.1.5 заасан “В” жагсаалт буюу санал өгсөн сонгогчын 28 ба түүнээс дээш хувийн санал авсан боловч УИХ-ын гишүүнээр сонгогдсонд тооцогдоогүй жагсаалтад орсон, энэ хуулийн 48.2, 48.5 д заасны дагуу УИХ-ын гишүүнд сонгогдсонд тооцогдоогүй нэр дэвшигчдийг нам, эвсэл бүрээр нь, “В” жагсаалт дахь авсан саналын хувиар нь дараалалд оруулах ба тэдгээр нэр дэвшигчдийн дараа тойрогт нэр дэвшигчдээс бусад тухайн нам, эвслээс нэр дэвшигчдийг энэ хуулийн 27.5.4 дэх хэсэгт заасан жагсаалтад байгаа дарааллаар нь эрэмбэлж /цаашид..Г жагсаалт гэх/-ыг нам, эвсэл бүрэр нь гаргана. Тайлбар: “Г” жагсаалтыг гаргах явцад нэг нам, эвслээс нэр дэвшигчдийн саналын хувь тэнцсэн тохиолдолд Сонгуулийн Ерөнхий Хороо

буюу улс төрийн намуудын сонгуулийн эвслийн жагсаалтаас сонгоно. Өөрөөр хэлбэл томсгосон тойргоос буюу 1-3 мандаттай 26 тойргоос 48 гишүүнийг сонгосон. Харин үлдсэн 28 гишүүнийг сонгогдын саналаар бус намын нэрийн жагсаалтаар сонгосон. Тодруулбал, эхний 48 гишүүн нь саналын хуудсанд нэр нь бичигдэж хэн илүү санал авсан нэр дэвшигч ялалт байгуулна гэсэн үг. Харин үлдсэн 28 гишүүний нэрийг саналын хуудсанд бичихгүй зөвхөн нам, эвслийн нэрийг бичиж сонгогчид нам, эвслийн нэрийг дугуйлна. Хамгийн олон санал авсан нам, эвсэл өөрийн намын жагсаалтад байгаа нэр дэвшигчдийн эрэмблэсэн дарааллын дагуу УИХ-ын гишүүнд сонгогдсонд тооцно. Энэ тохиолдолд сонгогчид тухайн нам ямар хүний нэрийг 28 гишүүний жагсаалтад бичсэнийг мэдэх боломжгүй. Зөвхөн намын нэрийг дугуйлснаар ард нь 28 хүртэл гишүүн сонгогдсон. 2012 оны УИХ-ын сонгууль ийнхүү холимог тогтолцоогоор явагдсан нь ардчилсан сонгуулийн сонгогч саналаа шууд өгөх зарчмыг ихээхэн алдагдуулсан сонгууль болсон юм. Гэвч 2016 оны 04 р сарын 22 өдөр Үндсэн хуулийн цэц 2 өргөдөлд шуурхай шийдвэр гаргаж сонгуулийн хувь тэнцүүлэх буюу пропорциональ тогтолцоог иргэний "шууд" сонгох үндсэн хуулийн эрхийг зөрчиж байна хэмээн хүчингүй болгосон. Энэ нь нэг талдаа сонгуулийн шууд эрхийн зарчим алдагдах байдлыг таслан зогсоосон <sup>16</sup>. Харин нөгөө талдаа сонгуулийн тогтолцоог сонгууль болох хугацааг тулгаж өөрчилсөн нь сонгуулийн хуулийг сурталчлах, мэдээлэх хугацаа байхгүй дутагдалтай байдал бий болсон. Сонгуульд сонгогч ямар нэгэн төлөөлөлгүйгээр оролцож саналаа өөрөө гаргаж, сонгох эрхээ эдлэнэ. Монгол улсад бие эрхтний согогтой, эрүүл мэндийн байдлаас болон боловсролын байдлаас хамаарч саналаа өөрөө тэмдэглэж чадахгүй сонгогч сонгуулийн эрх бүхий иргэнийг итгэмжилж, түүний тусламжтайгаар саналаа өгч болно.<sup>17</sup>

### **3. Сонгуулийн тэгш байх зарчим**

Сонгуулийн тэгш байх зарчим нь нэг тойрогт нэг сонгогч санал өгвөл нөгөө тойрогт мөн адил байх ёстой. Өөр тойрогт ахиж санал өгөхгүй. Ингэж чадвал тэгш эрхийн зарчим хэрэгжиж байна гэсэн үг. Сонгуулийн тэгш байх

---

тухайн нэр дэвшигчдийн тойрогт авсан саналын тоог үндэслэн дараалалд оруулах зарчмыг баримтлана.

<sup>16</sup> 2011 оны Сонгуулийн тухай хуучин хуулинд холимог тогтолцоо байсан ба 2012 онд бүрэн эрх нь дуусгавар болсон парламент энэ тогтолцоогоор сонгогдсон. 2016 оны 1-р сарын 27-нд гаргасан эхний өргөдлийг Үндсэн хуулийн цэцийн 2012 оны шийдвэрийн дагуу хувь тэнцүүлэх тогтолцоо нь Үндсэн хуулийг зөрчөөгүй байна гэсэн үндэслэлээр няцаасан. 02-р сарын 29-нд Үндсэн хуулийн цэцэд давж заалдахад өргөдлийг авч хэлэлцсэн. 2 дахь өргөдлийг 4-р сарын 13-нд гаргасан бөгөөд эхний өргөдөлтэй нэгтгэсэн.

<sup>17</sup> Монгол улсын сонгуулийн тухай хууль. УБ., 2015 он

зарчим хэрэгжихэд тойрог бүрт ногдох мандатын тоо адил байхыг шаарддаг. Өөрөөр хэлбэл, тойрог бүрийн сонгогчдын тоо ойролцоо байж хэрэгждэг. Газар нутаг уудам, тархай бутархай суурьшилтай, хүн амын амьдрах нягтрал харьцангуй бага Монгол улсын хувьд энэ зарчим хэрэгжихгүй байна. Тухайлбал Монгол улсад тойргийн хэмжээг тогтоохдоо харилцан адилгүй тогтоож байна. Улсын Их Хурал нь Сонгуулийн Ерөнхий Хорооноос ирүүлсэн саналыг үндэслэн сонгуулийн тойргийн нутаг дэвсгэрийг сонгуулийн жил бүр тогтоодог. Ингэхдээ хүн амын тоо, засаг захиргааны нэгжийн хуваарилалтыг харгалзан үзэх ёстой. Гэвч 2016 оны УИХ-ын сонгуулийн тойргийн нутаг дэвсгэрийг хуваарилах үйл явц ил тод биш, олон нийтээр хэлэлцэгдээгүй, тогтоосон шалгуурыг дагаж мөрдөөгүй. 2016 оны 05-р сарын 11-нд СЕХ-ноос сонгуулийн тойрог тус бүрт бүртгэгдсэн сонгогчдын талаар мэдэгдэхүйц ялгааг тусгасан. Сонгуулийн тойргийн нутаг дэвсгэрийг хэрхэн тогтоох тухай саналыг ирүүлсэн<sup>18</sup>. УИХ-ын 2016 оны 05-р сарын 12-нд сонгуулийн тойргийн нутаг дэвсгэрийг дахин хуваарилж 76 тойргийн нутаг дэвсгэрийг батласан. Ингэхдээ 50 тойрог тутамд 25170 сонгогч оногдох улсын дундажаас 15-аас дээш хувиар хэлбийлгэсэн байсан. Хамгийн их зөрүүтэй буюу 66 хувьтай тойрог ч байсан.<sup>19</sup> Тойргууд дээр хүн амын тоо ийм зөрүүтэй байх нь ардчилсан сонгуулийн тэгш эрхтэй байх зарчмыг алдагдуулж байна<sup>20</sup>. Түүнчлэн сонгогчид нь хоёр, гурван тойргийн дунд хуваагдсан 9 сум байгаагаас гадна хил залгаа оршдоггүй хэд хэдэн тойрог байна.<sup>21</sup> Мөн гэмт хэргийн ангиллаас үл хамаарч хорих ял эдэлж байгаа болон шүүхийн шийдвэрээр эрх зүйн чадамжгүй нь тогтоогдсон бүх этгээдээс бусад 18 насанд хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай Монгол улсын бүх иргэн санал өгөх эрхтэй<sup>22</sup>.

---

<sup>18</sup> Жишээ нь 46589 сонгогчидтой Хэнтий аймаг 3 тойрогт хуваагдсан бол сонгогчдын тоо өндөртэй 49276 Дорнод аймаг зөвхөн 2 тойрогт хуваарилагджээ. Ингэснээр Хэнтий аймгийн сонгуулийн тойргууд нь улсын дундажаас хамгийн зөрүүтэй тойрогт орж байна.

<sup>19</sup> Сайн туршлагын дүрмийн 2.2 дээр зөвшөөрөгдөх хэм хэмжээнээс гарах зөрүү нь 10 хувиас ихгүй байх ёстой ба онцгой нөхцөл байдал "төвлөрсөн цөөнхийг хамгаалах хүн ам тархан суурьшсан засаг захиргааны этгээдүүд" -аас бусад тохиолдолд 15 хувиас огт хэтэрч болохгүй гэж зөвлөдөг.

<sup>20</sup> "Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт"-ын 25-р зүйлийн 6-г үзнэ үү. Сайн туршлагын дүрмийн 1.2.2.2 дахь хэсэгт болж өгвөл сонгуулийн бус хугацаанд тойргийг дахин хуваарилах нь зүйтэй бөгөөд энэ нь улс төрийн арга заль хийх эрдслийг хязгаарлана. Сонгуулийн тойргуудын нутаг дэвсгэрийг дахин хуваарилах нь улс төрийн нилээд үр дагавартай учраас энэ үйл явцад нам бусаар хандах нь чухал юм гэж заасан.

<sup>21</sup> Ховд аймагт хамгийн жижиг тойрог 13866 сонгогчтой Улаанбаатар хотын хамгийн том тойрог болох Чингэлтэй дүүргийн 63-р тойрог 41836 сонгогчтой. Мөн Увс аймгийн 33-р тойрог нь зэргэлдээ биш 3 хэсэгт хуваагджээ. Улаанбаатар хотын гадна орших Багануур дүүрэг 4 хэсэгт хуваагдаж хэсэг тус бүр нь Баганууртай хил залгаа бус өөр тойрогт хуваарилагджээ.

<sup>22</sup> Монгол улсын сонгуулийн тухай хууль. УБ., 2015 он

Энэ ерөнхий заалтууд нь тэгш биш хязгаарлалтыг бий болгож байна.<sup>23</sup> Мөн Монгол улсын сонгогчид тойргоо солих, танил тал, ах дүү, хамаатан садан, байгууллагын ажилчдынхаа тойргийг зохион байгуулалттай солих байдал сонгуулийн үед гарсан хамгийн томоохон зөрчил юм. Энэхүү зөрчил нь цаашид даамжирвал сонгуулийн үр дүнд сөргөөр нөлөөлж, сонгуулийн тэгш шударга байх зарчим алдагдах магадлалтай. Мөн улс төрийн жижиг намууд болон бие даан нэр дэвшигчдэд нэвтрүүлгийн цаг бага олддог бөгөөд санхүүгийн байдлаас болж төлбөртэй нэвтрүүлэгт тэр бүр оорж чаддаггүй зэрэг нь мөн л ардчилсан сонгуулийн тэгш эрхийн зарчмыг алдагдуулж байна.

#### **4. Сонгуулийн чөлөөтэй байх зарчим**

Ардчилсан сонгуулийн бас нэг үндсэн гол зарчим нь **чөлөөтэй байх зарчим** юм. 2015 онд шинэчлэгдэн батлагдсан Монгол улсын Сонгуулийн тухай хуулинд илт тодорхой заагаагүй бүх төрлийн сонгуулийн сурталчилгааг хориглосон, сонгуулийн сурталчилгааны хүрээг хэтэрхий хязгаарласан зүйл заалт гаргасан. Бүх сонгуулийн мөрийн хөтөлбөрүүд өнөөгийн хөгжлийн бодлого болон эдийн засгийн чанартай нийцэж байгаа эсэхийг Үндэсний аудитын газраар шалгуулж батлуулсан байх ёстой.<sup>24</sup> Энэ нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хааж, чөлөөтэй байх зарчмыг зөрчиж байна. Мөн улс төрийн олон ургальч үзлийг шаардлагагүйгээр хязгаарлаж байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь ил тод ажиллаж байгаа боловч улс төрийн ашиг сонирхлоос үүдэн хараат бус байж чадахгүй байна. хэвлэл мэдээллийн хэрэгсэл хаалтын гэрээ хийх, захиалгат нэвтрүүлэг болон төлбөртэй сурталчилгааг ихээр цацдаг бөгөөд сонгуульд нэр дэвшигчдэд тэнцвэртэй үйлчлэхгүй байна. Эрх барьж байгаа намын талруу хэт хэлбийж ажилладаг. Мөн түүнчлэн сонгуульд оролцож буй нам, эвсэл, нэр дэвшигчид нь сонгогчдын санал худалдан авах, сонгогчдын саналд хөндлөнгөөс шууд ба шууд бусаар нөлөөлөх, элдэв төлбөрт үйлчилгээ болон урлаг, спортын арга хэмжээ зохион байгуулах болон бусад арга хэрэгслээр сонгогчдын саналыг эргүүлэх зэрэг сөрөг үр

---

<sup>23</sup> Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 25-р зүйлд өгсөн НҮБ-ын хүний эрхийн хорооны 25-р ерөнхий тайлбарын 14 дэхь хэсэгт “хэрэв гэмт хэрэг үйлдсэний төлөө шийтгүүлсэн ялд нь санал өгөх эрхийг нь түдгэлзүүлэх үндэслэл байгаа бол түдгэлзүүлэх хугацаа нь үйлдсэн гэмт хэрэг болон ялтай нь тохирсон байх ёстой” гэж шаарддаг. Мөн “ардчилсан нийгэмд хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах аливаа хязгаарлалтыг холбогдох хуулийн зориулалтуудын аль нэгтэй нь холбох ёстой бөгөөд тухайн хуулийн зорилготой хатуу нийцэж байх ёстой” гэж заасан.

<sup>24</sup> Мөрийн хөтөлбөрүүд нь Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль болон бодлогын баримт бичиг болох “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-тай тус тус нийцсэн байх ёстой.

дагаврууд өмнөх сонгуулиудын үеэр байсан. Энэ нь мөн л сонгуулийн чөлөөтэй, тэгш, шударга байх зарчмыг алдагдуулж байна.

Монгол улсад нэр дэвшигчдийн аль нэгийг нь л тэмдэглэ, өөр тэмдэглэгээ хийвэл санал хүчингүй болно гэж хуульчлаад байгаа нь сонгогч хүчээр нэг хүний төлөө саналаа өгнө эсвэл хуудсаа хүчингүй болгох байдалд хүрдэг байсныг өөрчилж 2016 оны УИХ-ын сонгуулийг явуулах үед сонгуулийн хуульд өөрчлөлт оруулж цагаан сонголтыг хүчинтэй саналын хуудсанд тооцсон. Ингэж өөрчилснөөр хамгийн сүүлийн сонгууль болох 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулиар “цагаан сонголт” хийх боломжоор хангаж нийт сонгогчдын 8.23 хувь нь цагаан сонголт өгсөн. Энэ нь хүчинтэй саналд тооцогдсон бөгөөд 8.23 хувийн санал хүчингүй болох эрсдлээс сэргийлсэн заалт оруулсан нь сайшаалтай юм.


Мөн Монгол улс ардчиллын замд шилжсэнээс хойшхи хугацаанд үзэл баримтлалын ялгарал, хэт улс төржилт, ардчиллын хөгжилд, ардчиллын үндсэн зарчмуудыг хэрэгжүүлэхэд бэрхшээл учруулж байна. Мөн түүнчлэн төрийн эрх мэдэл хуваарилах зарчмын хүрээнд ардчилсан тогтолцоог бүрдүүлсэн ч хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хуваарилсан Үндсэн хуулийн зүйл, заалтууд бодит амьдралд хэрэгжүүлсэн туршлагын хооронд зөрүүтэй, зөрчилтэй байдлыг үүсгээд байна. Парламент, Засгийн газар, Ерөнхийлөгч зэрэг төрийн эрх барих дээд байгууллагуудын хоорондын уялдаа, харилцаанд ойлгомжгүй байдал хурцадсаар өнөөгийн улс төрийн хямралт байдалд хүргээд байна.

Хэдийгээр Монгол улс ардчиллын замд шилжсэнээр дэвшилттэй тал байгаа ч Монгол улсад ардчилал төлөвших болоогүй, бүрэн хэрэгжиж чадаагүй байна. Монгол улсын Засгийн газрын танхмын бүрдэл, төвхнөл, огцруулалт, Үндсэн хуулийн цэцийн маргаан нь дээр дурьдсан бэрхшээлтэй байдлыг харуулж байна. Мөн Засгийн газар олон солигдож, төрийн залгамж чанар алдагдаж байгаа нь ч ардчиллын хөгжилд ноцтой саад учруулж байна. Мөн өмнөх сонгуулиудын жилүүдэд сонгож байгуулсан Засгийн газрын олон удаа тогтворгүй, солигдож ажилласан зэрэг нь ардчиллыг бэхжүүлэх, ардчилсан сонгуулийн үндсэн зарчмуудыг хэрэгжүүлэхэд сөрөг нөлөөлөл үзүүлэх үндэс суурийг бий болгож байна.


**Засгийн газрын байгуулж ажилласан Ерөнхий сайдуудын тоо  
(УИХ-ын сонгууль 1992-2016 он)<sup>25</sup>**

---

<sup>25</sup> Парламентын институтын улс төр, эрх зүйн шинжилгээ сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл. УБ., 2018 он



### Ерөнхий сайдуудын солигдсон шалтгаан<sup>26</sup>



Сүүлийн үед Монгол улсад үүсээд байгаа улс төрийн хямралт нөхцөл байдал, төр барьж байгаа МАН-ын дотоод хагарал, тэмцэлдээн нь ардчиллын хөгжилд ноцтой садаа болж, Монголын улс төрийн түүхэнд сөргөөр ул мөрөө үлдээгээд байна. Монгол улс ардчиллын замд шилжсэнээс хойшхи 28 жилийн дотор Ерөнхийлөгч, УИХ-ын сонгууль, Орон нутгийн сонгууль тус бүрдээ 7 удаа явуулсан. 1912 оноос хойш Монгол улсын түүхэнд нийтдээ 31 хүн сайдаар ажилласан байдаг. Үүнээс 1992 онд Шинэ үндсэн хууль батлагдсанаас хойш буюу УИХ-ын 7 удаагийн сонгуулийн явуулахад хугацаанд нийт 13 сайд ажилласан. Үүнээс: сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд Засгийн газрыг солиогүй тогтвортой барьсан 2 сонгуулийн жил байдаг. Тодруулбал, УИХ-ын 1992 он, 2000 оны сонгуулийн үр дүнд сонгуулиар МАХН (одоогийн МАН) ялалт байгуулж бий

<sup>26</sup> Парламентын институтын улс төр, эрх зүйн шинжилгээ сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл. УБ., 2018 он

болсон П.Жасрай, Н.Энхбаяр нарын тэргүүлсэн Засгийн газрууд бат бөх байж 4 жил тогтвортой ажилласан юм. 1996 оны УИХ-ын сонгуулийн үр дүнд МҮАН, МСДН, Ардчилсан холбоо эвслийн байгуулсан Засгийн газар тухайн сонгуулийн жилд түүхэндээ хамгийн олон удаа буюу 4 удаа Засгийн газар сольсон нам болсон. 2004 оны УИХ-ын сонгуулийн үр дүнд МАХН болон Эх орон ардчилал эвслийн аль нь ялалт байгуулаагүй тэнцсэн тул хамтарсан Засгийн газар байгуулж ажилласан боловч мөн л 3 удаа Засгийн газар нь солигдсон. Харин 2008 оны УИХ-ын сонгуулийн үр дүнд МАН дангаараа олонхийн суудал авч Засгийн газрыг 2 удаа, 2012 оны УИХ-ын сонгуулийн үр дүнд АН, Шударга ёс эвсэл, ИЗННам олонхийн суудал авч Засгийн газрыг 2 удаа, 2016 оны УИХ-ын сонгуулийн үр дүнд МАН олонхийн суудал авч Засгийг газрыг 2 удаа тус тус сольсон байдаг. Нийт 13 Ерөнхий сайд ажилласны 3 Ерөнхий сайд нь сайн дураар огцорсон, 4 Ерөнхий сайд нь бүрэн эрхийн хугацаа дууссан, 5 Ерөнхий сайд УИХ-ын гишүүдийн саналаар ажлын хариуцлага алдсан огцорсон гэсэн шалтгаанаар тус тус огцорсон.

Засгийн газар ингэж тогтворгүй, олон солигдох болсон шалтгаан нь нэгд: улс төрийн намуудын үзэл баримтлал, чиг баримжаа тодорхойгүй, намууд төлөвшөөгүй, намын дотоод ардчилал байхгүй, боловсон хүчний бодлого алдагдсан зэргээс үүдэлтэй. Хоёрт: Монголын улс төрд эрх мэдлийн хуваарилалтыг тодруулбал, Ерөнхийлөгч, УИХ, Засгийн газрын эрх үүргийг тодорхой нарийн чанд зааж өгөөгүйтэй холбоотой. Гуравт: Монголын төрд хариуцлагын хатуу тогтолцоо, эргээд хариуцлага тооцдог механизм байхгүйтэй холбоотой. Дөрөвт: Сонгуулийн тухай хууль болон улс төрийн намуудын тухай хуульд анхнаасаа УИХ-ын сонгуульд нэр дэвшүүлэхдээ өндөр босго, шалгуур үзүүлэлтийг эрх зүйдээ тусгаагүйтэй холбоотой. Тавд: Засгийн газар олон солигдсоноор ардчиллын мөн чанар алдагдаж, төрийн залгамж чанар, бодлого үйл ажиллагаа алга болж, цашлаад ардчилсан сонгуулийн үндсэн зарчмуудыг гажуудуулах нөхцлийг бүрдүүлж байна. Мөн түүнчлэн шат шатны төрийн байгууллагуудын ажил суларч, төрд итгэх иргэдийн итгэл өдрөөс өдөрт суларсаар байна. Тийм учраас Засгийн газрыг тогтвортой ажиллуулах нь хамгийн чухал асуудал юм.

## **ДҮГНЭЛТ**

Монгол улс ардчилсан тогтолцоонд шилжиж, парламентат ёс, түүний институт бүрэлдэн тогтож засаглалыг хуваах зарчим хэрэгжиж, ардчилсан сонгуулийг явуулаад 28 жил болж байгаа хэдий ч эерэг сөрөг олон хүчин зүйлийн

улмаас боловсронгуй болгох, засаж сайжруулах, шийдвэрлэх асуудлууд тулгарсаар байна.

Ардчиллын хөгжлийн нэг гол үзүүлэлт-хэвлэлийн эрх чөлөөний зөрчигдсөн, хэвлэл мэдээллийн чөлөөт байдал Монголд тэгш биш байгаа нь иргэдийн хүсэл сонирхлоо илэрхийлэх, зөв сонголтоо хийхэд нь сөргөөр нөлөөлөөд зогсохгүй ардчилсан сонгуулийн үндсэн зарчмуудыг зөрчиж байна. Энэ байдал нь эрх баригчид, төр, улс төрийн намуудын зүгээс иргэдийн санаа бодолд сөрөг нөлөө үзүүлэх нөхцлийг бүрдүүлж байна.

Монгол дахь ардчилал хөгжих болоогүйг 2008 оны 07-р сарын 01-ний эмгэнэлт үйл явдал тодорхой харуулсан. Энэ үйл явдал нь ард түмний жирийн нэг бухимдал, цаг зуурын, гэнэтийн үзэгдэл биш байсан.<sup>27</sup> Ардчилсан сонгуулийн үр дүнд ард түмний шууд оролцоог үндэслэн төрийн эрх барих Улсын Их Хурал байгуулагддаг. Улмаар Засгийн газар байгуулагддаг учраас сонгууль шударга бус, ёс төдий байж огт болохгүй юм.

Монгол улсад ардчиллын үнэт зүйлсийг бэхжүүлэх, ардчиллыг тогтворжуулах, сонгуулийн үндсэн зарчмуудыг хангах зайлшгүй шаардлага тулгарч байна. Монголын нийгэм, улс төрд үүссэн бэрхшээлүүд нь ихэнхидээ ардчилсан өөрчлөлтийн явцад үүссэн гажуудалтай холбоотой. Ардчиллын чанар **бүх нийтийн, шууд, тэгш, чөлөөт** ардчилсан сонгуулийн үндсэн зарчмуудыг хэрэгжүүлж байгаагаар илрэх ёстой. Өнөөдөр үүсээд байгаа улс төрийн хямралт үзэгдэл, ардчилал, ардчилсан сонгуулийн үндсэн зарчмуудын гажуудал нь эрх зүйн ойлгомжгүй зохицуулалт, сонгуулийн тогтолцоо, улс төрийн намын төлөвшил, нам, нэр дэвшигчдийн сонгуулийн бохир технологи хэрэглэх явдал, хэвлэл мэдээллийн хэрэгслийн тэнцвэргүй ажиллагаа гэх мэт сонгуулийг тойрсон бүхий л асуудалтай холбоотой.

Монголын ардчилсан сонгуулийг явуулахад ардчилсан сонгуулийн үндсэн зарчим, сонгуулийн хууль, сонгуулийн тогтолцоотой холбоотой нилээдгүй бэрхшээлтэй асуудлуудыг цаашид засаж залруулах, сайжруулах зайлшгүй шаардлага тулгарч байна. Ийм учраас алдаа дутагдал, бэрхшээлтэй асуудлуудыг арилгах, боловсронгуй болгох талаарх хэд хэдэн саналыг гаргаж байна.

**Сонгуулийн бүх нийтийн зарчим:** Монголын сонгогчдын оролцоо буурсаар байгаа тул сонгогчдын оролцооноос болж насны хязгаарлалтад өөрчлөлт оруулах эсэх асуудал хөндөгдөж магадгүй юм. Мөн Монгол улсын Иргэний

---

<sup>27</sup> Монгол дахь сонгуулийн үйл явц: онол, практик (эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл). УБ., 2009



бүртгэл хариуцсан газар нь сонгогчдын нэрийн жагсаалтад бүх сонгогчдыг хамруулах арга хэмжээ авах, бүртгэл судалгааг сайжруулах талаар тусад нь дүрэм, журам боловсруулах шаардлагатай бөгөөд хариуцлага алдсан ажилтанд тодорхой хатуу хариуцлага тооцох талаар хуульчлах нь зүйтэй. 2015 онд шинэчлэн гаргасан Монгол улсын Сонгуулийн тухай хуулинд гадаад суугаа Монгол улсын иргэдийн сонгууль өгөх эрхийг хассан. Энэ нь бүх нийтээр сонгууль өгөх зарчмыг алдагдуулж байгаа учраас гадаад улсад амьдарч байгаа Монгол улсын сонгогчдыг сонгууль өгөх боломж, эрхийг олгосон зүйл заалт оруулах зайлшгүй шаардлагатай байна. Мөн Монгол улсад хэрэгжиж байгаа мажоритар тогтолцоо нь сонгогчдын саналыг маш ихээр гээгдүүлдэг тул, цаашид энэ тогтолцоог хэвээр авч үлдвэл хууль болон тусгай журмаар зохицуулж санал гээгдүүлэхгүй байх суурь нөхцлийг бүрдүүлэх хэрэгтэй.

Сонгууль **шууд байх зарчим** нь ямар нэгэн нам, эвслийн сонгуулийн байгууллагын ажилтан, ухуулагч, шадар туслагч, сонгуулийн хороодын гишүүн, ажиглагч нарыг итгэмжилсэн хүнээр сонгохыг хуулиар хориглодог. Гэсэн хэдий ч бодит байдалд энэ хуулийн заалт зөрчигддөг учраас энэ асуудлыг тусгайлан дэлгэрэнгүй тодорхой хуульчилж заах өгөх шаардлагатай. Мөн холимог тогтолцоогоор явуулсан 2012 оны УИХ-ын сонгуулийн үйл явц нь шууд байх зарчмыг алдагдуулсан тул дахин холимог тогтолцоог хэрэглэсэн тохиолдолд нэр дэвшигчдийн нэрсийг сонгогчдод ил тод байлгаж шууд сонголт хийх боломжоор хангах шаардлагатай.

Сонгуулийн **тэгш байх зарчим** нь Монгол улсад тойрог бүрийн сонгогчдын тоо харилцан адилгүй байсаар байна. 2016 оны УИХ-ын сонгуулийг явуулахын өмнөхөн тойргийн тоо баталсан нь тэгш эрхийн зарчмыг алдагдуулсан төдийгүй тойрог бүрт харилцан адилгүйгээр сонгогчдын тоо зөрүүтэй байсан. Үүнийг цаашид анхаарч сонгуулийн хуулинд тойргийн сонгогчдын тоог заахдаа ижил тэнцүү буюу ойролцоо тусгайлан зааж өгөх шаардлагатай байна. Мөн шилжилт хөдөлгөөнийг сонгууль явуулахаас олон сарын өмнө тусгай зохицуулалтын хүрээнд явуулах шаардлагатай байна. Мөн ял эдэлж байгаа болон, шүүхээр гэм буруутай нь тогтоогдсон этгээдүүдтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг тэгш эрхийн зарчмыг зөрчих бүх боломж нөхцлийг хаах хэрэгтэй. Монголд хэрэглэж байгаа олон мандаттай томсгосон тойрогт явуулдаг мажоритар тогтолцооны хувьд сонгогчийн тэгш эрхийн зарчим алдагдуулдаг. Тухайлбал, зарим тойрогт сонгогч 3-4 нэр дэвшигчийн төлөө санал өгч байхад өөр нэг тойрогт сонгогч 1-2 нэр дэвшигчийн төлөө санал өгч байх жишээтэй. Мөн жижиг

намууд болон бие даан нэр дэвшигчдэд нэвтрүүлгийн цаг бага олддог, санхүүгийн байдлаас болж төлбөртэй нэвтрүүлэгт тэр бүр орж чаддаггүй зэрэг нь ардчилсан сонгуулийн тэгш эрхийн зарчмыг алдагдуулж байна. Ийм учраас намын тухай хуульд өөрчлөлт оруулж намын санхүүжилтыг төрөөс зохих хувийг гаргах, хандив, татварын хэмжээг багасгах, намын санхүүжилтыг шилэн болгох зэрэг арга хэмжээ авч эрх зүйн зохицуулалтдаа оруулах нь чухал байна. Ингэж чадвал тэгш эрхийн зарчим хэрэгжих боломж бий болж, том, жижиг улс төрийн намууд тэгш гараанаас сонгуульд өрсөлдөх нөхцлийг бүрдүүлж өгнө. Ийм учраас сонгуулийн тогтолцооны сул талуудыг арилгах арга хэмжээ авах шаардлагатай.

**Сонгуулийн чөлөөт зарчим:** Сонгуульд оролцох, эс оролцох нь хэний ч дарамт шахалтад орохгүй саналаа илэрхийлэх, мөн сонгохоос татгалзах зэргээр чөлөөт зарчим хэрэгждэг. Гэтэл Монгол улсад нэр дэвшигчдийн аль нэгийг нь л тэмдэглэхээр нөхцөл байдал нь сонгогч хүчээр нэг хүний төлөө саналаа өгөх нөхцөл байдлыг бий болгодог. Ер нь Монголын сонгогчид сонголт алга байгаа нь одоогийн төр барьж буй гишүүдийн хариуцлагагүй байдалтай холбоотой бөгөөд ардчилсан сонгуулийн чөлөөтэй байх зарчмыг алдагдуулахаас гадна сонгогчдын оролцоо буурах болсон гол шалтгаан болж байна. Мөн сонгуульд нэр дэвшиж байгаа улс төрийн нам, нэр дэвшигчид нь сонгуулийн үеэр бохир технологи хэрэглэж сонгогчдын саналд нөлөөлөх, дарамт шахалт үзүүлэх, саналыг худалдаж авах зэрэг үйлдэл гаргадаг нь сонгогчид чөлөөтэй санал өгөх боломж нөхцлийг хааж байна. Үүнд анхаарч сонгогчдыг өөрийн үзэл бодол, итгэл үнэмшлээрээ хэний ч дарамт шахалтад оролгүй чөлөөтэй санал өгөх нөхцлийг бүрдүүлэхэд анхаарч эрх зүйн зохицуулалт хийх нь зүйтэй.

Мөн мэргэшсэн, мэргэжлийн өндөр чадавхитай боловсон хүчинг сонгуульд нэр дэвшүүлэхийн оронд намын санхүүжилтээ зузаатгах үүднээс хэн илүү хандив өгч байна гэдгийг гол шалгуур үзүүлэлт болгож гишүүнчлэлээ бүрдүүлж байна. Үүнээс үүдээд нам дагасан бизнесийн бүлэглэлүүд бүрдэж, эцсийн дүндээ өнөөдрийн хямралт байдал бий болж, сонгогчид маань төрд, УИХ-ын гишүүдэд итгэх итгэл улам суларч байгаа нь сонгогчдын оролцоо буурах нэг гол шалтгаан болж байна. Энэ нь ардчиллын үнэ цэнийг алдагдуулахад хүргэх гол шалтгаан нь болоод байна. Сонгуулийн хуулиар сонгуулийн сурталчилгааны хугацааг хэтэрхий багасгаж 18 хоног болгосон нь шинээр олонд төдийлөн танигдаагүй нэр дэвшигчид болон жижиг намуудад сөргөөр нөлөөлж өөрсдийгөө сурталчлах боломж цаг хугацаа хомс байсан дутагдал гарч байсан. Энэ нь мөн чөлөөтэй өөрийгөө сурталчлах, бүрэн таниулах боломжийг алдагдуулж байгаа тул цаашид

хуульд сонгуулийн сурталчилгааны хугацааг заахдаа олон талын хүчин зүйлсийг харгалзан үзэх нь зүйтэй.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл төрийн эрх барьж байгаа намуудад хэт үйлчилдэг байдлыг зогсоож, “хаалтын гэрээ”-г бүр мөсөн арилгаж, улс төрөөс хараат байх нөхцлийг бүрдүүлж өгөх шаардлагатай. Мөн түүнчлэн улс төрийн нам болон нэр дэвшигчид сонгогчдын саналыг нууцаар худалдах, санал өгөхөд нь шууд болон шууд бус нөлөөллийг арилгах арга хэмжээ авч сонгуулийн үйл ажиллагаанд хатуу хяналт тогтоох хэрэгтэй.

Сонгуулийн тухай хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог чангатгах шаардлага зүй ёсоор тулгарч байна. Монгол улсын хуулинд сонгогч сонгуульд заавал оролцож саналаа өгөх үүрэг хариуцлага хүлээх заалт байхгүй. Гэхдээ чөлөөт байдал, иргэний журамт үүргээ зөв хэрэгжүүлэх нь чухал. Сонгогчид саналаа чөлөөтэй гаргаж, сонгохыг хүссэн нэр дэвшигчээ өөрөө сонгох ёстой боловч тэр тойрогт нэр дэвшигчид тухайн сонгогчдод таалагдахгүй сонгохыг хүсэхгүй байж болно. Энэ тохиолдолд өөр нэр дэвшигчийг чөлөөтэй сонгох боломж байхгүй байгаа нь чөлөөтэй байх зарчмыг маш ихээр алдагдуулж байна. Сонгогч ямар нэгэн шахалтгүйгээр саналаа чөлөөтэй илэрхийлэх ёстой. Саналаа чөлөөтэй өгөх нь Засгийн эрх ард түмний гарт байх сонгуулийн үндсэн зарчим хэрэгжинэ. Сонгогч саналаа чөлөөтэй илэрхийлэхэд хэн боловч ямар нэг саад тотгор учруулахыг хуулиар хориглосон байдаг. Сонгогч саналаа нууцаар өгнө. Саналаа нууцлах бүх нөхцлийг сонгуулийн байгууллагууд хангадаг. Нууцлахын гол учир шалтгаан нь: 1. сонгогчдыг аливаа дарамт шахалтад орохоос хамгаалах, 2. авилгал, хээл хахуульд өртөхгүй байхад чиглэгддэг.

Аливаа улс орны сонгуулийн хууль тогтоомжид дээрх ардчиллын онолын 4 үндсэн зарчмуудыг хуульчилсан байдаг. Өндөр настай болон бичиг үсэг үл мэддэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд саналаа нууцаар гаргах боломжгүй байдаг. Тэдний итгэмжлэгдсэн хүн өөрийн үзэмжээр ханддах байдал нь ажиглагдсан. Үүнийг өөрчлөхийн тулд саналын хуудас нэр дэвшигчдийн зураг, хөгжлийн бэрхшээлтэй буюу хараагүй хүмүүст зориулж барилл үсгээр саналын хуудас хэвлэж өөрчлөлт орсон нь сайшаалтай. Гэсэн хэдий ч зарим аймагт зөрчил гарсан тухай мэдээлэл цахим ертөнцөөр тарсан нь саналаа нууцаар гаргах зарчмыг ноцтой зөрчсөнийг харуулсан. Эдгээр зөрчил дутагдлыг арилгахын тулд тусгай томоохон судалгаа шинжилгээ явуулсны үндсэн дээр сонгуультай холбоотой бүхий л эрх зүйн зохицуулалтад тусгайлан нарийн тусгаж өгөх шаардлагатай байна. Сонгогчийг саналаа нууцаар өгөхөд л хамаарахгүйгээс бусад тохиолдолд

сонгуулийн бүх ажил ил тод явагдах ёстой. Сонгууль зарлах, бэлтгэл ажлыг хангах, хандив цуглуулах, зарцуулах, санал хураах, сонгуулийн дүнг гаргах зэрэг сонгууль зохион байгуулж явуулах бүх ажил хэвлэл мэдээллийн хэрэгслээр албан ёсоор нийтэд мэдээлсэн, ил тод байхад анхаарч ажиллах хэрэгтэй. Мэдээлэл үнэн зөв, бодитой байх ёстой бөгөөд бусдыг гүтгэх, доромжлох, нэр төрийг нь гутаах, иргэн хүний хувийн болон захидал харилцааны нууцыг задруулахыг хуулиар хориглосон байдаг. Гэсэн хэдий ч энэ хуулийн заалт хэрэгжихгүй байгаа тул нарийн тодорхой зохицуулалт хийх шаардлагатай.

Монгол улсад ардчилсан сонгуулийн үндсэн зарчмуудын гажуудлыг засахын тулд дээрх бүх өөрчлөлт, зохицуулалтуудыг сонгуулийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомжуудад нэг бүрчлэн тусгаж цаашид гажуудлыг арилгах, дахин гажуудуулахгүй байх бүх нөхцлийг бүрдүүлснээр ардчилсан сонгууль жинхэнэ утгаар хэрэгжих боломжийг бүрдүүлнэ.

**Abstract:** It has been passed 28 years since the first democratic election was held in Mongolia. During this period, the country held seven parliamentary elections, seven presidential election, seven provincial elections as well as 10 parliamentary reelections. Elections in Mongolia is held on the basis of the principles of fairness, justice, equality and freedom. However, in some cases some basic democratic principles are seen to be violated.

Many international scholars and observers concluded that elections in Mongolia have been just and democratic enough. However, there are some challenges and issues exist in running democratic elections in the country. This paper discusses principles of democracy, its failure and issues.

**Key words :** Democracy, Democratic Election, Electoral institution, Electoral principle, Party, Voter's participation, The State Great Hural election.

#### **Ашигласан ном, материал**

Монгол улсын Үндсэн хууль. УБ., 1992 он

Монгол улсын хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль. УБ., 1998 он

Монгол улсын намын тухай хууль. УБ., 2005 он

Монгол дахь сонгуулийн үйл явц: онол, практик \эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл\ . УБ., 2009

Монгол улсын сонгуулийн тухай хууль. УБ., 2015 он

Сонгуулийн Ерөнхий Хороо. УИХ-ын сонгуулийн дүн. УБ., 1992-2016 он

Сонгогчдын идэвхийг нэмэгдүүлэх, оролцоог дээшлүүлэх асуудлууд".

Ж.Нарантуяа. МУ-ын сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох нь.

Олон улсын бага хурал. УБ., 2002 он

Д.Түмэнжаргал. Монголын сонгуулийн систем: эрэл шийдэл. УБ., 2012 он

ШУА.ФСЭХ. Монгол улс дахь төлөөллийн ардчилал ба иргэдийн улс төрийн оролцоо. УБ.2015 он

Монгол улсын төрийн байгуулал дахь институтын талаарх судалгаа. УБ., 2018 он

Парламентын улс төр, эрх зүйн шинжилгээ сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл. УБ., 2018 он.

## ГАДААД БОДЛОГО БА ДИПЛОМАТ АЖИЛЛАГААНЫ ХАРИЛЦАН ХАМААРАЛ

**Д.Долгорсүрэн**  
МУИС, ШУС, Хүмүүнлэгийн Ухааны Салбар,  
Гадаад хэлний төвийн ахлах багш

**Товч агуулга:** Улс орнууд амин чухал асуудлууд дээр санаа нэгдэж, зөв шийдвэр гаргахын тулд дотоод, гадаад бодлогоо ганц нэг улсын, эсвэл бүсийн эрх ашгийн үүднээс явуулж болохгүй цаг үед хүн төрөлхтөн амьдарч байна. Улс хоорондын харилцаа, хамтын ажиллагаа нь гадаад бодлогыг хэрэгжүүлэх арга хэрэгсэл болох дипломат ажиллагааг хэрхэн явуулахаас их хамаардаг. Гадаад бодлого үр дүнтэй хэрэгжих эсэх нь дипломат ажиллагаанаас нь ихээхэн шалтгаалдаг. Тиймд аливаа улс бусад орнуудтай харилцахдаа баримтлах чиг шугам буюу гадаад бодлогоо тодорхойлж, түүнийгээ дипломат ажиллагаагаар дамжуулан хэрэгжүүлдэг учраас гадаад бодлого, дипломат ажиллагаа хоёр харилцан нягт уялдаа холбоотой юм.

**Түлхүүр үг:** Гадаад бодлого, дипломат ажиллагаа, эрх ашиг, хүч, олон нийт, харилцан уялдаа

Улс орнуудын гадаад орчныхоо талаар баримталж, хэрэгжүүлж байгаа байр суурь, цогц үйл ажиллагааг гадаад бодлого гэдэг. Гадаад бодлого нь аливаа улсын оршин тогтнох, хөгжин дэвжихийн чухал хүчин зүйл бөгөөд түүхэн тодорхой нөхцөлд баримтлах ерөнхий чиглэл, чиг шугам нь болдог. Бие даасан, бүрэн эрхт улс бүр олон улсын харилцааны субъектүүдээс өөрийн эрх ашгийг хамгаалахын тулд тодорхой, чиглэсэн зорилготой явуулж буй үйл ажиллагааг гадаад бодлого гэнэ. Гадаад бодлого бол аливаа улсыг дэлхийн бусад орнуудтай холбож, дэлхий нийтийн харилцан уялдаа холбоотой нэгдмэл систем рүү оруулж буй үр өгөөжтэй үйл явц юм. Улс орны дотоодод, мөн дэлхийн хамтын нийгэмлэгт болж буй үйл ажиллагааны аль алиныг нь холбох гол холбоос нь гадаад бодлого болдог. Гадаад бодлогын зорилго нь түүнийг хүрээлж буй нийгмийн орчинтой холбоо бүхий асуудлыг шийдвэрлэх явдал юм.

Улс төрийн шинжлэх ухаанд гадаад бодлогыг аливаа улс нь бусад улс орнуудтай харилцахдаа өөрийн амин чухал эрх ашгийг хамгаалж, цаашид улс орноо авч явах чиг хандлагыг бий болгож, хэрэгжүүлэх зарчим гэж тодорхойлжээ. Мөн “хилийн чанад дахь хувь хүн, бүлэг хүн, улс үндэстнүүдтэй харилцаа холбоо тогтооход нөлөө үзүүлэх зорилгоор засгийн газруудаас гаргасан шийдвэрийг гадаад бодлого гэнэ” гэж олон улсын улс төрийн шинжлэх ухаанд тодорхойлжээ. Өөрийн амин чухал эрх ашиг гэдэг нь чухам юу вэ гэвэл тусгаар тогтнол, аюулгүй байдал, нэгдмэл байдлаа хадгалан хамгаалах нь улсын язгуур ашиг сонирхол юм.

Аливаа улс орны гадаад бодлого гэдэг Засгийн газрынх нь зүгээс олон улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулахын тулд бий болгосон стратеги арга ажиллагаа, өөрөөр хэлбэл тухайн улсын зүгээс бусад оронтой харилцах харилцаа, үйл ажиллагааг чиглүүлэх ерөнхий зорилтууд юм. Эрх баригчид улс орныхоо улс төр, эдийн засаг, ард иргэдийн эрх ашиг, сэтгэл санааны хэрэгцээ шаардлагыг хангахын тулд явуулж буй бодлого, зорьж буй гол зүйлийн үр дүн, хамрах хүрээ, хэмжээ хязгаарыг мэдэж, сайтар тодорхойлсон гадаад бодлогын цогц зорилтыг бий болгох ёстой байдаг. Гадаад бодлого гэдэг бол нэг бүхэл цул зүйл биш харин олон зуун мянган жижиг шийдвэр, зааварчилгаа, алхмууд ажээ.

Дэлхийн улс гүрнүүд гурван төрлийн гадаад бодлого явуулж ирсэн. Үүнд:

1. Их гүрний гадаад бодлого /ОУХ-ны түүхээс үзэхэд их гүрнүүд дэлхийн бараг бүх бүсийн улс орнуудтай харилцаа холбоотой байж, ашиг сонирхлоо дэлхийн түвшинд тодорхойлж байжээ/
2. Төвийг сахисан гадаад бодлого /бүс нутаг, дэлхий дахины элдэв асуудалд хутгалдахгүй гэсэн үг/
3. Эвсэлд нэгдэх, үл нэгдэх гадаад бодлого

Гадаад бодлогыг доорх 3 элементээр тодорхойлж болдог:

а/ Нэгдэх байдал (аливаа улс өөр улстай холбоотны харилцаанд орох, эсвэл төвийг сахих шийдвэр гаргах гэсэн үг)

б/ Цар хүрээ (тухайн улсын үйл ажиллагаа болон ашиг сонирхлын цар хүрээ юм. Аливаа улс бүс нутаг болон дэлхийн дахинтай өргөн дэлгэр эсвэл хязгаарлагдмал харилцаа холбоотой байх нь асуудал, хямралаа шийдвэрлэхэд нь чухал нөлөөтэй)

в/ Модус операнди (гадаад бодлогоо хэрэгжүүлэх арга зам, үүнд нэгд: олон талт байдал буюу олон улсын хүчин чармайлтаар асуудлаа шийдэх хандлага; хоёрт: идэвхтэй байдал буюу үйлдэл, эс үйлдлээр илэрдэг цэрэг, эдийн засаг, дипломатын интервенц ажээ);

Улсын гадаад бодлогын шинж чанарыг тодорхойлох гурав дахь ангилал болох *модус операнди* нь цаг хугацааны явцад өөрчлөгддөг ч улс орнуудын гадаад бодлогоо хэрхэн хэрэгжүүлж буй онцлогийг илтгэн харуулдаг.

Гадаад бодлого нь цаг хугацааны хувьд харьцангуй удаан үргэлжлэх, баримталж ажиллах чиг шугам болж нилээд тогтвортой шинжтэй байдаг бөгөөд гадаад бодлогыг янз бүрийн салбарт хэрэгжүүлэх арга зам нь дипломат ажиллагаагаар хангагддаг. Өөрөөр хэлбэл гадаад бодлогыг явуулахдаа түүний зорилгод тохирох дипломат үйл ажиллагааг сонгодог учраас гадаад бодлого дипломат ажиллагаа хоёр харилцан хамааралтай ажээ.

*"Аливаа улсын гадаад бодлого, дипломат үйл ажиллагаа хоёр нягт холбоотой."* Гадаад бодлогыг тодорхойлох, боловсруулах, улмаар хэрэгжүүлэх арга зам нь чухамдаа дипломат ажиллагаа байдаг. Дипломат ажиллагаа нь гадаад бодлогын хэрэгсэл, харин дайн, эвсэл холбоо, олон улсын худалдаа зэрэг нь гадаад бодлогын илрэл юм. Дипломат ажиллагааны зорилго нь гадаад бодлогыг хэрэгжүүлэхэд хүн хүч, арга хэрэгслээр улс орныг хангах явдал юм. Дипломат ажиллагаа нь гадаад бодлогыг дипломат аргаар хэрэгжүүлэх үйл ажиллагаа бөгөөд гадаад бодлогыг дипломат ажиллагаагаар дамжуулан хэрэгжүүлдэг. Тиймээс гадаад бодлого ба дипломат ажиллагааг нэг зоосны хоёр тал гэх нь ч бий. Учир нь гадаад бодлого нь аливаа улсын хувьд бусад улс гүрнүүдтэй харилцахдаа баримтлах гол чиг шугам, үзэл онол, харин дипломат ажиллагаа бол тэр чиг шугам, онолыг хэрэгжүүлэх арга зам, практик үйл ажиллагаа, өөрөөр хэлбэл уг чиг шугамын дагуу ажиллах арга, үйлдэл нь байдаг.

Аливаа улс гүрний гадаад бодлогын гол зорилго нь үндэсний эрх ашиг нь байдаг. *Үндэсний эрх ашиг нь гадаад бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх тулгын чулуу болдог.* Гадаад бодлогыг боловсруулдаг эрх мэдэл бүхий дээд түвшнийхэн эрх ашгаа хамгаалан бэхжүүлэхийн төлөө шийдвэр гаргаж, гаргасан шийдвэр болох гадаад бодлогыг ухаалгаар хэрэгжүүлэх бодит үйлдэл нь дипломат ажиллагаагаар илэрдэг. Үндэсний язгуур эрх ашгаа хамгийн боломжтой сайн арга замаар хангах, ашиг сонирхлоо хамгаалан бэхжүүлэхийн тулд улс гүрнүүд дэлхийн нөлөө бүхий орнуудтай, ялангуяа хөрш улс орнуудтайгаа тодорхой хэмжээнд харилцаа холбоотой байх шаардлагатай болдог бөгөөд тэрхүү харилцаа холбоог хангах гол арга хэрэгсэл нь дипломат ажиллагаа байдаг.

Аливаа зөрчил, сөргөлдөөнөөс зайлсхийх, бусад улстай хэвийн, сайн харилцаатай байхын сацуу улс орныхоо эрх ашиг, аюулгүй байдлыг хангах зорилгоор олон улсын хууль эрх зүйн хүрээнд явуулж буй гадаад үйл ажиллагааг



дипломат ажиллагаа гэнэ. Дипломат ажиллагаа нь өнө эртнээс улбаатай, мэргэжлийн суурь боловсрол, практик туршлага, харилцах ур чадвар, ёс зүй зэрэг нарийн цогц ажиллагаа, эв дүй шаардсан, улам бүр хөгжиж буй шинжлэх ухааны чухал судлагдахууны нэг юм.

Тууштай гадаад бодлогын үндэс нь тууштай явуулж буй дипломат ажиллагаа байдаг. Улс гүрэн бүрийн гадаад бодлого өөр өөрийн онцлогтой байдаг тул аливаа төр-улс олон улсын харилцааны бусад субъектүүдтэй харилцахдаа өөрийн эрх ашиг, аюулгүй байдлаа хамгаалах зорилгоор явуулж буй үйл ажиллагаа нь тэдний гадаад бодлого болдог. Гадаад бодлогыг хэрэгжүүлэх гол арга хэрэгсэл дипломат ажиллагаа нь нэгдмэл нэг зорилгод хүрэхэд чиглэж, тэрхүү зорилгодоо хүрэхийн тулд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хүч хавсран нэгдмэл байдлаар ажиллах ёстой болдог.

Гадаад бодлого нь бодит хүчин зүйлсийн үр дүн ба тэдгээр хүчин зүйлс нь гадаад бодлогын талаар шийдвэр гаргах үндэс суурь болдог. Гадаад бодлогод тухайн улсын дотоод орчин, гадаад хүчин зүйл буюу бусад улсын бодлого, үйл ажиллагаа, мөн геополитикийн хүчин зүйлс нөлөөлдөг. Жишээ нь, арлын жижиг улсууд цаг уурын өөрчлөлтийг бусад улсаас түрүүлж мэдэрдэг тул цаг уурын өөрчлөлттэй холбоотой асуудал тэдний хувьд гадаад бодлогын амин чухал чиглэл болох нь цөөнгүй. Дэлхийн цаг агаарын өөрчлөлттэй дотоод бодлогоор тэмцэх аргагүй тул түүнтэй тэмцэх гол арга зам нь дипломат ажиллагаа болдог. Тэгэхээр *гадаад бодлого өөртөө тохирсон дипломат ажиллагааг эс сонговол утгаа алдана*. Гадаад бодлогод нөлөөлдөг гол хүчин зүйлс нь ашиг сонирхол, түүнийг хангах арга зам буюу дипломат үйл ажиллагаа, гадаад бодлогын дотоод эх сурвалж нь олон нийт юм. Тиймээс гадаад бодлогод нөлөөлөх хүчин зүйлсийг дараах байдлаар ангилдаг:

1. Системийн хүчин зүйл<sup>1</sup>: улсын гадаад нөхцөл байдал, олон улсын орчин
2. Үндэсний хүчин зүйлс: үндэстэн улсын өөрийнх нь онцлог шинжүүд
3. Индиосинкретик хүчин зүйлс: шийдвэр гаргагч бүлэглэл, сонирхлын бүлгүүд, удирдагчид, хувь хүн

Аливаа улсын гадаад бодлого гурван баганад тулгуурладаг:

---

<sup>1</sup> Судлаачид ОУХ-ны системийн гол хүчин зүйлүүдийг дараах байдлаар тодорхойлдог: Үүнд: а) Оролцогчдын байдал – үндэстэн улс, улс бус оролцогч; б) Хүчний харьцаа, хүчний хуваарилалт; в) Баялгийн хуваарилалт; г) Туйлшралын зэрэг; д) Оролцогчдын зорилго; е) Зорилгоо биелүүлэх боломжтой хэрэгсэл, технологи; ё) Харилцан хамаарлын зэрэг гэж тодорхойлсон байдаг.

- Мэдээлэл
- Дүн шинжилгээ
- Шийдвэр

Гадаад бодлогод нөлөөлөгч дотоодын өөр нэг эх сурвалж нь гадаад бодлогын аппаратын шийдвэр гаргах үйл явц юм. Орчин үед ихэнх улс орон мэдээллээр хангадаг /мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийдэг/, санал зөвлөмж боловсруулдаг, бодлого хэрэгжүүлдэг, зарим үед гадаад бодлого боловсруулдаг захиргааны аппарат буюу засгийн газрын тусгай агентлаг, хэлтэс, газруудтай болсон. Гадаад бодлогыг тодорхой алба хэлтэс /хувь хүн/ хариуцан хэрэгжүүлдэг тул гадаад бодлого, дипломат ажиллагааны гол асуудал нь хүн, хүний итгэл үнэмшилтэй ямар нэг байдлаар холбогддог. Иймд хүнээ /боловсон хүчнээ/ сургаж бэлтгэн, мэргэшүүлэх нь гадаад бодлогын хэрэгжилт болох дипломат үйл ажиллагааны үр дүнд, цаашлаад олон улсын харилцаанд ихээр нөлөөлдөг.

Улс гүрэн бүрийн гадаад бодлогын цаана эх орныхоо нэр хүндийг олон улсын тавцанд өргөх, үндэсний эрх ашгаа хамгаалах, улсынхаа байр суурийг бататгах, олон улсад боломжтой салбаруудад нөлөөний хүрээгээ тэлэх зорилго оршдог. Бие даасан улс бүр гадаад бодлогоо хэрэгжүүлэх, гадаад бодлогын зорилгодоо хүрэхийн тулд үзэл бодол, итгэл үнэмшил, үнэт зүйл, түүх соёлын ололт амжилт зэрэг эерэг сайн гэж үзсэн онцлог талуудаа бусад улс орнуудад сурталчилах, харилцан туршлага солилцох, тусалж дэмжих, байгаагаа хуваалцах, харилцан итгэлцэл төрүүлэх зэрэг дипломат ажиллагааны янз бүрийн арга хэрэгслийг ашигладаг. Улс гүрнүүд өөрсдийн эрх ашигт нийцсэн, үр дүнтэй дипломат ажиллагааг явуулахад голлон анхаарсаар ирсэн билээ.

Гадаад бодлогыг тодорхойлон боловсруулагчдын гол зорилго нь үндэсний эрх ашгаа сахин хамгаалах, дэмжих явдал байдаг. Эрх ашиг гэдэг улс төрийн амьдралын хөдөлгөгч хүч бөгөөд улс орны оршин тогтнох, хөгжин дэвжихийн амин чухал хэрэгцээ шаардлагын илэрхийлэл нь болдог гэж үзэн английн ерөнхий сайд асан Лорд Пальмерстон “Улс гүрэнд мөнхийн анд нөхөр гэж байхгүй, мөнхийн дайсан ч гэж байхгүй, гагцхүү мөнхийн эрх ашиг бий - *Nations don't have permanent friends, they only have permament interests*” гэж хэлжээ. Эрх ашгаа хамгаалах зорилгоор бусадтай найрсаг харилцаж, харилцаагаа бататган бэхжүүлэх, бие биеийн дотоод асуудалд хөндлөнгөөс оролцохгүй байх, онцгой үйл явдал тохиолдсон үед дагах, эс дагах зэрэгт нөлөөлөх гэх мэт адармаатай дипломат ажиллагааг хэрэгжүүлэх үе тулгардаг. Үндэсний эрх ашгийн хүрээ хязгаарын тухай асуудал нь улс орнуудын хоорондын зөрчил маргааны, зарим үед

бүр дайн дажин, зэвсэгт мөргөлдөөний нэг шалтгаан болж ирсэн. Учир нь үндэсний эрх ашгийн хүрээ хязгаар нь бусад улсуудын бүрэн эрхт байдлыг шууд хөнддөг. Эрх ашгийн нөгөө талд хохирол дагаж явдаг. Өөрөөр хэлбэл хэн нэгэн ашиг олж байна гэдэг нь өөр нэгнийг, тэгэхдээ гол төлөв хүч чадал, эрх мэдлээр сул дорой нэгнийг хохироож байна гэсэн үг. Тиймээс эрх ашиг гэдэг ойлголттой хамт хүч гэсэн ойлголт зэрэгцэж явдаг. Эрх ашигт хүч болон үзэл баримтлал, итгэл үнэмшил маш их нөлөөлдөг. Улс үндэстнүүд эрх ашгаа хангахын тулд хүчний болон хүчний бус арга хэрэгслийг хослуулсаар ирсэн бөгөөд эрх ашгийг нь хангах үндсэн зэвсэг нь

Нэгд: Хүч буюу Realpolitik-т (Энэ нь ОУХ-ны гол оролцогчид нь бүрэн эрхт төр-улс, улс орнууд гэсэн үзэл бөгөөд ашиг сонирхол бол гол хөдөлгүүр гэдэг)

Хоёрт: Хэлэлцээ буюу дипломат ажиллагаанд (үзэл бодол, итгэл үнэмшилд) тулгуурладаг.

Realpolitik-ээс үүдсэн олон улсын хүч хэмээх ойлголт ОУХ-нд байдаг. Хүч буюу хүч чадавхи нь реалист онолчдын хувьд хамгийн чухал ойлголт юм. АНУ-ын судлаач Ханс Моргентау “Үндэстнүүдийн бодлого зүй” бүтээлдээ “Хүч чадалтай байна гэдэг нь аливаа хүн бусад хүний оюун санаа, үйлдлийг хянана гэсэн үг” гэжээ. Энэ нь угтаа нөлөөлнө гэсэн үг. Хүч чадавхийг улс орны эзэмшиж буй биет зүйл, тухайлбал хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, дотоодын нийт бүтээгдэхүүн зэргээр ойлгодог. Цэрэг, эдийн засаг, нийгмийн хөгжил дэвшил, мэдээлэл, үзэл суртлын чадавхид тулгуурласан хүчийг олон улсын хамтын нийгэмлэгийн нэгдмэл ажиллагааны илэрхийлэл гэж үздэг ч үнэндээ улс төрийн салбарт ноёлогч хэсэг улсуудын эрмэлзлэл байдаг. Ийм улсуудыг ‘Их Долоо’, ‘Их Хорь’ зэргээр нэрлэдэг.

(Classification-классификация- латин хэлний classis- анги, бүлэг, ай, facio- хийх, дэлгэж тавих, хуваарилах гэсэн үгний нийлбэр бүхий анги, бүлэг болгох, ангилах, ангилж хуваарилах гэсэн утгатай нэр томъёо)- судалгааны объектын нэгдмэл системийг бүрдүүлсэн юмс үзэгдлүүдийг тэдгээрийн адил төстэй чанар, шинж тэмдэгээр нь бүлэгт хувааж ангилах замаар тухайн бүхэл объектын тухай мэдлэгийг системчлэн нэгтгэх зорилгоор хэрэглэдэг шинжлэх ухааны арга зүйн чанартай танин мэдэхүйн логик үйлдэл болно. Ангилал нь танин мэдэхүйд дараах үндсэн хоёр зорилтыг хэрэгжүүлэх үүрэг зориулалттай. Нэгд, хоорондоо ерөнхийдөө төстэй, нийтлэг шинжтэй боловч тодорхой байдлаараа ялгаа онцлогтой юмс үзэгдлүүдийг гол бус, аль нэг тохиолдлын төсөөтэй шинжээр нь, гаднаас нь ажиглаж үзэхэд хялбар ялгагдах тохиромжтой шинж тэмдэгээр нь бүлэглэн ангилаж системчлэх, хоёрт, судалгааны бүхэл, цогц объектыг бүрдүүлсэн олон янзын юмс үзэгдэлүүдийг мөн чанарлаг, гол шинжүүдийн нь адил төсөөтэй болон ялгаа онцлогтой талаар нь ангилж системчлэх замаар уг бүхэл объектын тухай бүрэн бөгөөд үнэн зөв мэдээлэлд үндэслэсэн шинжлэх ухааны ойлголтыг бий болгох явдал юм. Ангилалыг эдгээр үүрэг зорилгоор нь зохиомол ба зүй ёсны гэсэн хоёр хэсэгт хуваадаг. Зохиомол ангилал нь дээр дурдсан эхний зорилтыг хэрэгжүүлэхэд хэрэглэгддэг бөгөөд багагүй тохиолдолд прагматик зориулалттай байдаг. Түүний энгийн жишээ бол номын санд номын каталогийг цагаан толгойн үсгийн дэс дараагаар үйлдэж ангилах явдал юм. Зохиомол ангилал нийгмийн практик, байгаль, нийгмийн шинжлэх ухаанд зохих хэмжээний судалгаа, танин мэдэхүйн ач холбогдолтой болно.

Зүй ёсны ангилал шинжлэх ухааны танин мэдэхүйд арга зүйн болон судалгааны аргын хувьд чухал үүрэгтэй. Эл ангилал судалгааны объектыг бүрдүүлсэн олон янзын юмс үзэгдлүүдийг тэдгээрийн уг чанарыг илэрхийлсэн гол, тогтвортой, мөн чанарлаг шинж илрэлүүдийг нь их хэмжээгээр, цогцолбороор, хамгийн чухал нь угийн жам ёсны ижил төстэй, нэг төрөл зүйл, дүрст багтах шинжээр нь бүлэглэн ангилахад зориулагдна. Эл ангилал үүгээрээ тухайн тодорхой тооны юмс үзэгдэл чухам ямар хэмжээний нийтлэг шинж, ижил төстэй чанартай байна вэ, тэдгээр нь гадаад талын үзэгдэх байдал байна уу, эсвэл үнэнхүү мөн чанарлаг, угийн жам ёсны нэг төрлийн байна уу гэдгийг магадлан тогтооход тус болдог учираас судалгаа, танин мэдэхүйд ихээхэн ач холбогдолтой. Шинжлэх ухааны түүхэн дэх ийм зүй ёсны ангиллын тод жишээ баримт бол оросын химич эрдэмтэн Д.И. Менделеевын (1834-1907) нээсэн химийн элементүүдийн үелэх систем бүхий ангилал, биологийн ухаан дахь филогенетикийн системчлэл, хэл шинжлэлд олон янзын хэлийг уг гарал болон үг зүйгээр нь ангилсан ангилал юм.

Зүй ёсны ангилал их хэмжээний ажиглалт, туршилгын мэдээ материалыг эмпирик түвшинд боловсруулах төдийгүй онолын үүднээс нэгтгэн дүгнэх үндсэн дээр хийгддэг тул шинжлэх ухааны онолын утга агуулгатай болно. Зүй ёсны ангилал түүгээрээ аливаа онолын нэгэн адилаар юмс үзэгдлийн учрыг тайлбарлахын зэрэгцээ тухайн анги бүлэгт багтах шинэ зүйл байж болохыг урьдчилан таамаглах бололцоо олгодгоороо нээлттэй байж цааш хөгждөг. Мөн чанарлаг, гол шинж тэмдгээр нь хийсэн зүй ёсны ангиллыг хэв маягчлал (typology-типология) гэж нэрлэдэг. Тэр нь хэв маяг хэмээх ойлголтод үндэслэж хийгдэх бөгөөд хэв маяг гэдэг бол судлагдаж буй бодит байдлыг санаагаар хийсвэрлэж хуваах нэгж, түүхэн ёсоор хөгжиж буй объектуудын санаалаг загварын нэгж юм.

Шинжлэх ухааны түүхэнд ангилал эртний үеэс хэрэглэгдэж байгаль, нийгэм, соёлын юмс үзэгдлийг гадаад харагдах ижил төстэй шинжээр нь зохиомлоор ангилах явдлаас дотоод мөн чанараар нь ангилах бүтэцийн ангилалд шилжих замаар хэд хэдэн үе шатыг дамжин хөгжиж иржээ. Эртний Грекийн гүн ухаантан, байгаль шинжлэгч Теофраст (Феофраст) (н.о.тооллын өмнөх 327-287 он) бүх ургамлыг мод, бутас, бутанцар, өвс гэж бүлэглэсэн нь биологийн ухаан дахь анхны зохиомол ангилал байв. XVIII зууны Шведийн байгаль шинжлэгч эрдэмтэн Карл Линней (1707-1778) ургамлын аймгийг зохиомлоор ангилах нь учир дутагдалтай, хязгаарлагдмал болохыг ойлгож ургамлын өсөн үржих

морфологийн онцолгийг үндэс болгосон зүй ёсны ангиллыг боловсруулжээ. Ч. Дарвины боловсруулсан хувьсалын онол амьд бие организмууд хоорондоо төсөөтэй байдгийн үндэс шалтгаан нь тэдний гарал үүсэл нийтлэг чанартайд оршино гэдгийг тайлбарлан зааснаар амьтан судлалд филогенетикийн системчлэл бий болж амьтны бүлгүүдийн ангилал нь тэдний хувьсал хөгжлийн зам чиглэл, үндсэн үе шатад нийцэж тохирсон байдлаар хийгджээ.

Шинжлэх хуаанч ангилал ангилсан бүлгүүдийг тус бүрээр нь ул үндэстэй, системтэй, хатуу хэвшиж тогтсон нэрээр нэрлэхийг шаарддаг бөгөөд түүний сонгодог үлгэр жишээг хими, ургамал судлал, амьтан судлалаас үзэж болно.

Ангиллыг нийгэм, улс төр, эдийн засаг, түүх, хүмүүнлэгийн ухааны түүхэнд эртний үеэс хэрэглэсээр иржээ. Түүний жишээ баримтыг философи, нийгэм-улс төрийн сэтгэлгээний түүхээс, тухайлбал төрийн засаглалын хэв маяг, тодорхой хэлбэрүүдийн тухай Платон, Аристотель, Цицерон, Макиавелли, Монтескье, нийгэм, улс төрийн байгуулал, соёл иргэншлийн хэв маяг, хэлбэрийн тухай Гегель, К. Маркс, Ф. Энгельс зэрэг сэтгэгчдийн бүтээлээс олж үзэж болно. Платон төрийн засаглалын хамгийн сайн зохион байгуулалттай хэлбэр бол язгууртны бүгд найрамдах засаг гэж үзээд түүнээс гажсан төрийн муу хэлбэрүүдийг төр барьсан эрх мэдэлтнүүдийн хүч чадалын эх сурвалж (өмч хөрөнгө, эд баялаг, цэрэг, зэвсгийн хүч гэх мэт), санаа зорилго, эрхэмлэл, хувийн зан чанарын онцлогоор нь (дайн хийж олз олж баяжих, алдар хүндэд шунах, демосын эрх чөлөөг хэрээс хэтрүүлэх) тимократи, олигархи, демократи, тирани гэсэн ангилал болгожээ.

Аристотель шавь нарынхаа оролцоотойгоор тэр цагт оршиж байсан төр засгийн 158 дүрс хэлбэрийг ажиглан тогтоож тэдгээрийг нэгд, төр барьсан хүний тоогоор буюу тоон хэмжүүрээр нэг хүний засаглал бүхий монархи (хаант засаг) эсвэл тирани, цөөнхийн засаглал болох язгууртны, эсвэл олигархи засаг, олонхийн засаг болох полити эсвэл ардчилсан засаг, хоёрт, төр засаг хэний эрх ашгийг эрхэмлэж, юуг зорилго чиглэл болгож байна вэ гэдэг чанарын шалгуураар нийгэм, нийт олны сайн сайхныг эрхэмлэн зорьсон зөв зүйтэй төр засаг бүхий монархи, язгууртны, полити засаг, хувийн явцуу ашиг сонирхлыг эрхэмлэж зорьсон гаж буруу төр бүхий тирани, олигархи, демократ засаг гэсэн ангилал хийжээ. Аристотелийн эл ангиллыг заримдаа хэв маягчлал гэж нэрлэдэг.

Улс төрийн шинжлэх ухаан бие дааж хөгжснөөр ангиллыг улс төрийн систем, улс төрийн дэглэм, улс төрийн нам, сонгуулийн систем, улс төрийн үйл

байдал, улс төрийн соёл, хошуучлал зэрэг үзэгдлүүдийг ангилаж судлахад өргөн хэрэглэж байна.

### **Арга зүй**

(Methodology- методология- эртний грек хэлний metodos- угийн ердийн утгаараа чиглэх, зүглэх зам, хожим тогтсон утга нь ажиглах, судлах арга зам;logos- үг, сургаал, ойлголт гэсэн үгсийн нийлбэр бүхий судалгааны аргын тухай сургаал гэсэн утгатай нэр томъёо)- бодит байдлын юмс үзэгдлийг шинжлэн танин мэдэх сэтгэхүйн үйл ажиллагааг зүй зохистой зохион байгуулах ерөнхий удирдамж болж буй онолын үндэслэлтэй зарчим, ойлголт, судалгааны аргуудын систем, мөн уг системийн тухай сургаал юм. Байгаль, нийгмийн аливаа үзэгдэл, үйл явцыг судлаж танин мэдэх нь түүнд баримтлах онол болон арга зүйг заавал шаардна. Юмс үзэгдлийн мөн чанарыг чухамдаа онолын түвшинд, арга зүйн зөв зүйтэй баримтлалын үндсэн дээр танин мэдэх боломжтой. Судалгаанд баримтлах арга зүй бэлээхэн байдаггүй, бас судалгааны явцад өөрөө аяндаа тодорхой болдоггүй. Арга зүйг зөв сонгож баримтлан хэрэглэх нь өөрөө судалгаа, бэлтгэл, дадлага, туршлага шаарддаг мэргэжлийн нарийн хөдөлмөр юм. Зөв зүйтэй сонгон баримталсан арга зүй нь тодорхой асуудлыг судлаж боловсруулах, шийдвэрлэх ерөнхий үндэс суурь, удирдамж болж өгнө. Арга зүйн сонголт, боловсруулалт, баримтлалыг буруу хийснээс болж судалгаа, танин мэдэхүйн үйл ажиллагаа мухардалд орох, шийдэл оновчтой бус, алдаатай болох тохиолдол цөөнгүй гардаг. Судалгааны арга зүйн эрэл хайгуул, сонголт хийх үндэслэл, эх сурвалж бол тухайн судалгаа хийгдэж буй шинжлэх ухааны түүхийн болон орчин үеийн мэдлэгийн систем юм. Арга зүйг сонгож баримтлахад олон чухал шаардлага тавигддагийн нэг нь тухайн арга зүйн баримтлал нь судлах асуудлын шинж чанар, агуулга, онцлог, судалгааны зорилгод тодорхой хэлбэрээр, зүй зохистой нийцэж тохирсон байх явдал юм. Өөрөөр хэлбэл судлагдахуун нь арга зүйг үндэслэлтэй сонгож баримтлахыг шаардна гэсэн үг. Арга зүйн хөгжил нь шинжлэх ухааны танин мэдэхүйн хөгжлийн нэгэн чухал тал болно. Шинжлэх ухааны аливаа шинэ нээлт, хөгжлийн шинэ шат, ололт нь арга зүйн хөгжилд нөлөөлж агуулгыг нь шинэчилнэ. Үүний зэрэгцээ арга зүй нь эргээд шинжлэх ухаан өөрийгөө танин мэдэх, өөрийгөө ухамсарлах хэлбэр болдог.

Шинжлэх ухааны арга зүйг судлагдахууны хүрээ багтаамжийн хэмжээ, хэрэглэгдэх салбар, түвшингээр нь философийн арга зүй, нийт шинжлэх ухааны ерөнхий арга зүй, шинжлэх ухааны тодорхой салбарын болон салбар хоорондын арга зүй гэх мэтээр ялгадаг. Танин мэдэхүйн арга зүйн чанартай ерөнхий зарчим,



ойлголт, үндэслэлүүд анхандаа философид үүсэн бий болж үндсэндээ XIX зуун гартал мөн л тэр хүрээнд боловсрогдон баяжсаар иржээ. Энэ нь философийн ухаан байгаль, нийгэм, хүн, танин мэдэхүйн тухай шинжлэх ухааны янз бүрийн түвшин, хэмжээний мэдлэгийг өөртөө агуулж, <<ухаануудын ухаан>> болж байсантай холбоотой юм. Эртний үе, дундад зуун ба шинэ үеийн философи, түүний сонгодог томоохон төлөөлөгчдийн сургаал, үзэл санаанд судалгаа, танин мэдэхүйн арга зүйн асуудал тодорхой хэмжээнд дэвшин тавигдаж зохих ёсны хариу тайлбарууд гарч байжээ. Шинэ үеэс, ялангуяа XIX зуунаас шинжлэх ухааны уламжлалт болон шинэ салбарууд бие даан эрчимтэй хөгжих болсноор тэдгээрийн арга зүйн асуудал чухлаар тавигдан судлагдаж холбогдох үзэл баримтлалууд боловсрон томъёологджээ. Үүний үр дүнд философийн арга зүй ба тодорхой шинжлэх ухаануудын арга зүйн харьцаа ихээхэн өөрчлөгдсөн байна. XX зууны 50-60-аад оноос тодорхой салбар ухааны мэргэжлийн судалгааны арга зүйн асуудал философийн арга зүйн судалгаа, боловсруулалтын хүрээнээс халин гарч бие даасан чанартайгаар судлагдах болжээ. Гэвч ийм чиглэлийн судалгаа боловсруулалт 1980-аад оны эхэн үеэс багагүй бэрхшээл, мухардмал байдалтай тулгарчээ. Арга зүйн асуудал судалдаг мэргэшсэн эрдэмтэдийн нэлээд нь түүнийг бүрэн бие даалгаж судлах явдал цаашдаа явцгүй болсон, өнөө үед ер арга зүй юунд хэрэгтэй байна вэ, түүний үнэт чанар, үүрэг зорилт юунд оршино вэ, тэрээр орчин үеийн соёл, оюун санааны амьдралд гол зорилгоо биелүүлж байна уу, үгүй юу гэсэн асуулт тавьж хариу тайлбар нэхэх шаардлагатай болсон гэж үзэж байв. Философийн арга зүй ба мэргэжлийн судалгааны арга зүй хоорондоо хэдийгээр ихээхэн ялгаатай боловч бас нягт холбоо хамааралтай байж бие биеэ харилцан нөхөж байх учиртай ажээ. Тухайлбал философи нь оршихуйн (экзистенцийн) мөнхийн асуудлуудыг авч үзэж ертөнцийг үзэхүйн үүрэг гүйцэтгэдэгийн хувьд шинжлэх ухааны судалгааны арга зүйг онтологи, соёл, ёс зүй, үнэт зүйлсийн утга учиртай, чиг баримжаатай болгох, харин арга зүй нь танин мэдэхүй, сэтгэхүйн зүй зохистой технологи ба соёлыг судалдгийн хувьд философийн арга зүйг рационал, рефлекслэг шинжтэй болгоход нөлөөлөх учиртай.

Нийгмийн болон хүмүүнлэгийн ухааны аливаа салбар чиглэлийн нэгэн адилаар улс төрийн сэтгэлгээний түүхэн хөгжил болон орчин үеийн улс төрийн шинжлэх ухааны үүсэл төлөвшил, хөгжилд судалгааны арга зүй чухал үүрэгтэй байсаар ирсэн ба өнөө үед ч хэвээр байна. Улс төрийн шинжлэх ухааны үзэл санааны эх сурвалж нь өмнөх үеийн улс төрийн сургаалын түүхэн хөгжил мөн бөгөөд тэр нь эртнээс XIX зуун гартал үндсэндээ философи ба нийгмийн

сэтгэлгээний (social thought) хүрээнд боловсрон хөгжиж ирсэн учраас тэдгээрийн голлох үзэл санаа, сэтгэхүйн хэв маяг, авч үзсэн асуудлын чиг шугамыг тодорхойлсоор иржээ. Түүхийн урт хугацааны туршид улс төрийн сэтгэлгээнд арга зүйн тодорхой баримтлал төдийлөн боловсрон томъёологдоогүй, улс төрийн үзэгдэл, үйл явцыг авч үзэж тайлбарлан ойлгоход домог ба шашны үзлийн агуулгатай теологийн парадигм, натуралист, антропологийн, хууль зүйн ба нийгмийн парадигм нь арга зүйн шинжтэй ерөнхий чиг баримжаа, үндэслэл болж байв.

XIX зууны сүүлчээс АНУ-д, XX зууны дундаас Европын орнуудад улс төрийн шинжлэх ухаан бие дааж төлөвшин хөгжих болсноор түүнд судалгааны арга зүйн асуудал чухлаар тавигдаж боловсрогдох болсон байна. Үүний үр дүнд орчин үеийн улс төрийн шинжлэх ухаан эмпирик ба хавсарга, онолын болон улс төрийн сэтгэлгээний түүхийн судалгаанд ерөнхий удирдамж болж буй арга зүйн үзэл баримтлалтай болжээ. Түүнийг тоймлон хураангуй өгүүлбэл өнөөгийн улс төрийн шинжлэх ухаан улс төрийн судалгааны арга зүйг улс төрийн бодит байдлыг шинжилж танин мэдэх арга зам, тодорхой арга техникийг зүй зохистой хэрэглэх ерөний үндэслэл хэмээн үздэг. Улс төрийн арга зүй нь (political methodology) нийгмийн шинжлэх ухааны ерөнхий арга зүйтэй олон талаараа нийтлэг шинжтэйн зэрэгцээ багагүй ялгаа онцлогтой. Улс төрийн арга зүй шүүмжлэлт рационализм ба шинжлэх ухааны реализмын танин мэдэхүйн уламжлалт үзэл баримтлалд боловсрон гарч иржээ. Эл арга зүй улс төрийн эмпирик судалгаа, тоон болон чанарын шинжилгээний бүхий л асуудалд холбогдож хамаарна. Улс төрийн арга зүй эмпирик судалгаатай холбогдох нь цэвэр эмпирик судалгаа хийнэ гэсэн үг биш бөгөөд учир нь эмирик судалгаа нь онолын үзэл баримтлалтай, судалгааны арга зүйтэй тодорхой хэмжээгээр холбоотой байдаг. Улс төрийн арга зүй тоон ба чанарын судалгааны харьцаа, хамаарал хийгээд тэдгээрийг хооронд нь холбож зэрэгцүүлж хийснээр улс төрийн судалгаа хэрхэн сайжирч үр дүнтэй болохыг тодорхойлж тогтоох, интернетээр улс төрийн баримт материал цуглуулж боловсруулан судлах нь улс төрийн судалгаанд хөгжлийн шинэ зүйл болж байгааг ойлгоход чухал ач холбогдолтой болно. Улс төр судлалд судалгааны нарийн тодорхой аргуудыг хэрэглэдэгтэй холбоотойгоор улс төрийн арга зүйг хэт математик шинжтэй, ихээхэн нарийн төвөгтэй гэж үзэж байсан үе бий. Гэвч нарийн тодорхой аргуудыг улс төрийн арга зүйгээр зүй зохистой хэрэглэх нь статистик болон аналитик чанартай дүгнэлт гаргаж томъёолоход чухал ач холбогдолтой болох нь тодорхой болжээ.

Улс төрийн судалгаанд ажиглалтын аргыг оновчтой, үр дүнтэй хэрэглэх, цуглуулсан мэдээ баримтыг боловсруулж тайлбарлах, дүгнэлт хийх, бүхэлдээ судалгааны санаа зорилго, ерөнхий дүр зураг, хэрэгжүүлэх үе шат, явц, логик өрнөлийг зүй зохистой, зөв зохион байгуулах үйл ажиллагаа буюу судалгааны дизайныг (Research Design) төлөвлөж бүтээхэд улс төрийн арга зүй ихээхэн ач холбогдолтой болно.

Улс төрийн шинжлэх ухаанд арга зүйн үүрэг, ач холбогдол өсөн нэмэгдэж байгаатай уялдаж АНУ болон Европын олон орны Их дээд сургуульд улс төрийн шинжлэх ухаанаар эрдмийн зэрэгтэй мэргэжилтэн бэлтгэх докторын сургалтад улс төрийн судалгааны арга зүйн асуудлыг тусгай хичээл болгон зааж судлуулдаг.

### **Түүхийн үүднээс тайлбарлахуй**

(Historical Interpretation- Историческая интерпретация- латин хэлний interpretatio- тайлбарлах, таниулах гэсэн үгнээс гаралтай)- түүх, хүмүүнлэгийн ухаан, улс төр судлал, улс төрийн социологи, ялангуяа улс төрийн түүх судлалд хэрэглэгддэг сэтгэхүйн үйлдэл бүхий судалгааны арга зүйн чанартай хандлага юм. Түүхэн үүднээс тайлбарлахуй нь ер тайлбарлалын нэгэн өвөрмөц хэлбэр, хувилбар болно. Тайлбарлал нь ерөнхий утга агуулгаараа нийгэм соёлын үзэгдэл, үйл явдал, бичвэр текст, урлаг, уран зохиол, хөгжмийн бүтээл, хэлний тэмдэг зэрэг хүний оюуны үйл ажиллагааны аливаа илрэлийг тодорхой дүрмээр утга санаатай болгож агуулгыг нь тайлбарлан ойлгох сэтгэхүйн суурь санартай үйлдэл мөн. Тайлбарлал нь үүгээрээ герменевтик ойлгохуйтай нягт холбоотой

Тайлбарлал нь нийгэм, улс төр, хүмүүнлэгийн ухаан, шинжлэх ухааны философи, математик логик, логикийн семантикт тэдгээр тус бүрийн онцлог, судлагдахууны ялгаанаас хамаарч өвөрмөц байдлаар хэрэглэгддэг. Тайлбарлалыг эртний хэл бичгийн практикт бичвэр текстийг ёгт утгатай болгож тайлбарлах, дундад зуунд христийн шашныхан эртний онгон шүтэх хуучин шажны домогийг өөрийнхөөрөө тайлбарлах, Сэргэн мандалт ба Шинэтгэлийн хөдөлгөөний (реформаци) үед мөн шашин, утга зохиолын ном сударыг шүүн тайлбарлах зэрэгээр хэрэглэж байжээ. Тайлбарлалыг шинжилж түүний тухай онолын ойлголттой болох анхны оролдлого XVIII зуунд хийгдсэн бөгөөд тэр нь тухайн үед <<ойлгохуйн урлаг>>-ийн тухай түгээмэл сургаал гэгдэж байсан герменевтикийн үүсэлтэй холбоотой байв. Тайлбарлалыг Ф.Шлейермахер, В.Дильтей, Р. Унгер, Э. Эрматингер, Г. Миша, Г. Башляр, В. Кайзер, Э. Штайгер нар судлан шинжилж өөрсдийн үзэл баримтлалаа боловсруулан гаргажээ. Тэдгээр үзэл баримтлал тайлбарлал нь бичвэр текстийг зохиогчийн нь сэтгэл зүйн болон

соёлын ертөнцөд буулгаж байрлуулах, тэрхүү ертөнцийг судлагч хувийн туршлагаараа сэргээн босгох замаар уг текстийн утга санааг танин барихуй юм; тайлбарлал бол текстийн утга агуулгыг уг текст бүтээгдсэн <<нөхцөл>>, <<шалтгаан>>-ы цогц орчинд шилжүүлэн буулгаж хялбарчлан танихуй юм; текст, зохиол бүтээлийн утга санаа нь тэдгээрийн бүтээгдсэн нөхцөл орчноос хамаарахгүй гэж үзжээ. ХХ зууны 60-аад оноос тайлбарлалыг авч үзэж ойлгох герменевтик ба бүтэц семиотикийн гэсэн үндсэн хоёр хандлагатай үзэл баримтлал боловсрогдож хоорондоо эсрэгцэх болжээ. Герменевтик тайлбарлал нь текст бүхий бичвэр бол эмпирик, эсвэл трансцендент буюу чанагуухь субъект, түүнчлэн бүтээлч бодгаль, эсвэл обьектив оюун санааны өөрийн илэрхийлэл юм гэж төсөөлдөг, түүнд <<бодгаль чанар>>, <<амьдрал>>, <<дотоод туршлага>> гэсэн ойлголтууд нь утга санаа бүрдүүлэгч гол бүрдэл хэсэг болдог. Герменевтик тайлбарлал нь текстийн утга санааг уг текст болзолт уншигчдад хаягласан мэдээ болохын хувьд нь танин мэдэхэд чиглэдэг бол бүтэц семиотикийн тайлбарлал нь тэмдгүүдийн хоорондын харилцан нөлөөллийг нөхцөлдүүлдэг код буюу төлөөлөх тэмдгийг тайлах, тэгснээрээ тэмдгүүдийн утга санааны үүсэл бүрдлийг тайлан ойлгоход чиглэдэг.

Хүмүүнлэгийн ухаан, соёл судлалд түүхийн үүднээс тайлбарлахуй нь В. Дильтейгээс эхэлж <<ойлгохуй>> гэсэн ойлголттой ойролцоо утгаар хэрэглэгдэж янз бүрийн бичвэр текст, утга зохиолын дурсгалт бичиг, соёлын биет ба биет бус өвийн утга санааг тайлан ойлгоход зориулагдаж иржээ.

Улс төр судлал, түүний дотор улс төрийн түүх, улс төрийн сэтгэлгээний түүх, харьцуулсан улс төр судлалд түүхийн үүднээс тайлбарлахуйг нэг талаар тайлбарлалын дээр дурдсан ерөнхий утга агуулга, дүрэм, логикийг ямар нэг хэмжээгээр нийтлэг байдлаар баримтлах, нөгөөтэйгүүр эдгээр албар ухааны судлах зүйл, онцлогийг анхааран тооцож өвөрмөц байдлаар хэрэглэдэг. Түүхийн үүднээс тайлбарлахуй нь улс төрийн бодлогын судалгааны эхэн үед давамгайлан хэрэглэгдэж байсан бөгөөд улмаар улс төрийн шинжлэх ухаанд судалгааны бусад арга, хандлага ч хэрэглэгдэх болсноор түүний хэрэглээ, танин мэдэхүйн үүрэг, ач холбогдол нь тоон болон статистик шинжилгээнд төвлөрсөн арга зүйгээр баяжих болсон байна. Тэгэхдээ түүхийн үүднээс тайлбарлахуй нь улс төрийн үзэгдэл, үйл явцын судалгаанд орчин үед ч нийтлэгээр хэрэглэгдэж тэдгээрийн учир шалтгаан, үр дагаварыг тайлбарлан ойлгоход багагүй үүрэг гүйцэтгэж байна. Тухайлбал харьцуулсан улс төр судлалд тодорхой улс орнуудын улс төр, нийгмийн хөгжлийг харьцуулан судлах, тэдгээрийн ялгаа, өвөрмөц онцлогийг шинжлэн илэрхийлэх,

түүнчлэн нийгэм дэх улс төрийн хөдөлгөөнүүдийн зорилго, зорилтыг судлан ойлгож тэдгээрийн гишүүд, дэмжигчдийг сэдэлжүүлэхэд хэрэглэгддэг ажээ. Судалгааны энэ аргыг АНУ дахь арьсны хөдөлгөөний үед түүний удирдагчид хэрэглэж байв. Түүнийг Карл Маркс нийгэм-улс төр, эдийн засаг, түүхийн судалгаандаа мөн хэрэглэжээ. Харин Юрген Хабермас энэ аргын хэрэглээнд шүүмжлэлтэй ханджээ.

### **Америкжилт**

(Americanization-американизация)- явцуу утгаар АНУ-д цагаачлагсад, суралцах, ажиллах, аялан жуулчлах зорилгоор урт богино янз бүрийн хугацаагаар зорчин очиж оршин суугаа гадаадын иргэд америк маягийн аж төрөх ёс, нийгмийн харилцаа, соёл, үнэт зүйлд зохицон дасаж ижилсэх, өргөн утгаар америкийн соёл, иргэншил дэлхийн бусад орон, үндэстэн, ард түмний нийгэм, соёлын амьдралд нөлөөлж нэвтрэн дэлгэрэх үйл явц юм. Америкжилтыг тээж нөхцөлдүүлдэг нийгэм-соёлын бодит зүйл бол американизм буюу америк ёс (americanism) болно. Американизм нь америк маягийн амьдрал, аж төрөх ёс, уламжлал, ёс заншил, соёл хийгээд тэдгээрийг дагаж баримтлах, талархах, бахархах практик үйлдэл ба оюун санааны зуршмал шинжийн нэгдэл юм.

Американизм нь АНУ-ын үүсэл, түүхэн хөгжлийн явцад бүрэлдэн хэвшжээ. Европоос Америкт зорин очиж анх суурьшигсад тус нутгийг <<бурхнаас заяасан хүслийн дээд орон>>, <<газрын диваажин>> хэмээн үзэж байсан нь улмаар <<бурхан Америкт хайртай>> гэсэн үзэл санаа бий болоход нөлөөлжээ. Үүний хамт Америкт суурьшсан англи саксон гаралтай цагаан арьстнууд өөрсдийгөө угсаатны хувьд гойд давуу чанартай бөгөөд түүгээрээ нутгийн уугуул хүн ам буюу <<дүү нар>>, <<бүдүүлэг харанхуйд бүрхэгдсэн>> ард түмнүүдэд туслаж аз жаргалд хүргэх үүрэг тавилантай гэсэн арьсны үзлийг гаргажээ.

Америкчууд тусгаар тогтнолынхоо төлөө дайтаж тэмцэх явцад <<хувь заяагаа урьдаас тогтоож шийдвэрлэх>> тухай улс төрийн үзэл баримтлал дэвшигдсний үндсэн дээр 1776 онд <<Тусгаар тогтнолын Тунхаглал>> боловсрон батлагдаж түүнд иргэд хуулийн өмнө тэгш байх, хувийн өмчтэй байх, эрх чөлөөтэй хөдөлмөрлөх, үйлдвэрлэн бүтээх, аз жаргалтай, нэр төртэй аж төрөх эрхийг тунхаглан зарлаж, улс төрийн засаг ард түмнээс эх үүсвэртэй тул иргэдийн эрх ашгийг илэрхийлэн хамгаалах ёстойг заажээ. Тунхаглалын эдгээр үзэл санаа, заалт 1787 онд батлагдсан Холбооны Үндсэн хууль, 1791 онд Үндсэн хуулийн нэмэлт болж батлагдсан Эрхийн тухай Хуульд (Билль) тодотгогдон баяжиж

агуулагджээ. Эдгээр нь АНУ тусгаар тогтносны дараах нийгэм, улс төр, эдийн засаг, соёлын ардчилсан, давшингуй хөгжил болон бүхэлдээ америк маягийн амьдрал, аж төрөх ёс, иргэншлийн тулгуур үндэс болсон байна. Энэ явцад гарсан асар их дэвшил, олсон ололт амжилт << Америк дэлхийд гоц гойд >>, <<Америкийн хөгжил, замнал, туршлага хосгүй>> гэсэн үзэл суртлын баримтлалд тусгалаа олж томъёологдсон нь америкжилтын үзэл санааны нэгэн чухал хөдөлгөгч хүч, үндэслэл болжээ.

АНУ-ын сонгосон хөгжлийн замналын явцад хувь хүн, түүний эрх, эрх чөлөө, бүтээлч, ажил хэрэгч прагматик чанар, бизнес, ашиг орлого, ололт амжилтад тэмүүлсэн эрч хүч, өөрийгөө илэрхийлж харуулах чадвар бол нийгмийн үйлдэл, хөгжил дэвшлийн хөдөлгөгч хүч (генератор) юм гэсэн үзэл санаа, үнэлэмж бий болж амьдралд бодитой хэрэгжжээ. Тиймээс америк иргэд хүүхэд ахуй цагаасаа хүн хувийн хүчин чармайлтаараа амьдралын аливаа асуудал, бэрхшээл саадыг даван туулах боломжтой, хүн ашиг орлого, сайн сайхан амьдрал, алдар хүнд, эрх мэдлийн оргилд хүрч болно гэсэн үзэл, итгэл үнэмшлээр хүмүүжиж төлөвшдөг, энэ нь америк маягийн <<үндэсний баатар>>-ын дүрээр дундаж амьдралтай америк иргэдийн ердийн ухамсар, аж төрөх ёсны шинж болж хэвшдэг байна.

Америкийн нийгэм хөгжил дэмшилтэй, ардчилал, хүний эрх, эрх чөлөө, хүн бүр хуулийн өмнө тэгш байх зарчим хангагдсан, иргэдийн амьдралын түвшин өндөр, үйлдвэрлэл, үйлчилгээ, хэрэглээ ухаалгаар стандартчилагдсан зэрэг дотоод амьдралын асар их ололт амжилт, тэдгээрт үндэслэгдсэн американизм, америк маягийн аж төрөх ёс нь америкчуудын бахархах зүйл мөн юм. Нөгөөтэйгүүр американизм нь зөвхөн америкийн нийгмийн хүрээн дотор байх явцуу үнэт чанар биш дэлхийн бусад орон, үндэстэн ард түмний амьдралд үлгэр жишээ, дуурайж дагавал зохих загвар бүхий олон улсын чанартай үнэт зүйл болох тул дэлхийд тархан дэлгэрэх учиртай гэсэн үзэл санаа америкийн улс төрийн болон ажил хэрэгч элитийнхний албан бус үзэл суртал болж тогтсон байна.

Америкжилтын тухай ойлголтын агуулга ба түүний хэрэгжилт нь XIX зууны хоёрдугаар хагас, XX зууны эхэн үед цагаачдыг америкийн нийгэмд дасгаж бүрэн ижилсүүлэх зорилготой нийгмийн хөдөлгөөний хэлбэртэй байв. Улмаар Америкжилтыг гадагшлуулахыг зөвтгөж үндэслэсэн үзэл санаа болон түүний бодит хэрэгжилт 1910-аад оноос эх авч хэд хэдэн үе шатыг дамжин явагджээ. АНУ-ын Ерөнхийлөгч В. Вильсон (1913-1921) гадаад бодлогодоо бодгальч үзэл буюу хувийн эрх ашгийг дээдлэх, бие хүний эрх чөлөө, чөлөөт өрсөлдөөний

зарчмыг хөтөлбөр болгож баримталсан нь түүхэнд <<шинэ ардчилал>> хэмээн тэмдэглэгдэж америкжилтад хүчтэй түлхэц өгчээ. В.Вильсоноос эхэлж америкийн удирдагчид ардчиллыг дэлгэрүүлэх зорилтыг хэрэгжүүлэхэд өргөн олны соёл (mass culture) ба нийгмийн хэрэглээний бараа таваарыг экспортлох явдал чухал үүрэгтэй гэж ил тод хэлэх болжээ.

АНУ ХХ зуунд эдийн засаг, шинжлэх ухаан, техник технологи, цэрэг армийн талаар асар их хөгжиж олон улсын харилцааны системд манлайлах, бусад оронд ихээхэн нөлөөлөх чадвартай дэлхийн хүчирхэг их гүрэн болсноор америкжилтын үзэл санаа, зорилт бодитой хэрэгжих болсон байна. Америкжилтын үйл явц АНУ-ын хүчирхэг эдийн засаг, санхүү, цэрэг арми, бусдыг өөртөө татаж дэлгэрэх хүч нөлөөтэй америк маягийн соёлд тулгуурлана. Америкжилт нь нэг талаар АНУ дэлхий дэх манлайлах, ноёрхох байр суурийг хэвээр хадгалах, улам бэхжүүлж хүчтэй болгох улс төр-геополитикийн бодлогын салшгүй нэг хэсэг болж зорилго чиглэлтэй хэрэгждэг, нөгөөтэйгүүр АНУ ба дэлхийн бусад орны хоорондын олон талтай харилцааны явцад иргэд, гэр бүл, бикнес, санхүү, соёл, хүмүүнлэгийн зэрэг төрийн бус байгууллагуудын түвшинд ердийн байдлаар явагддаг. АНУ-ын улс төрийн гадаад бодлогын түвшин дэх америкжилтыг субъект-объектын хоорондын нэг чиглэлтэй харилцааны хувьд нь америк чиглэл (америкжуулалт) гэсэн нэр томъёогоор илэрхийлж түүний зорилго нь америк маягийн улс төрийн байгууллага (институт), ардчилал, хүний эрх, эрх чөлөө, америк маягийн бизнес, санхүү, үйлдвэрлэл, эрэлт хэрэгцээ ба хэрэглээ, аж төрөх ёс, гэр бүл, нийтийн соёл, ёс суртахуун ба бусад үнэт зүйлс, эрхэмлэлийг дэлхийн улс орнуудад нэвтрүүлж хүмүүсийн амьдрал, үйл ажиллагаанд дэлгэрүүлж ижил дасал болгох, бүхэлдээ бусад орны нийгмийн амьдралыг америк маягаар стандартчилж нийтлэг шинжтэй болгох явдал юм гэж ойлгож болно. Эл зорилго эдийн засаг, улс төр, соёл, үзэл суртлын түвшин дэх гурван том сувгаар дамжиж, тэдгээрт АНУ-ыг төлөөлж ажилладаг хамгийн олон тоотой, хүч нөлөөтэй төлөөлөгч байгууллага, ажилтнуудын үйл ажиллагаагаар хэрэгжидэг.

Америкжуулалт, түүний үр дүн болж гарах америкжилт нь мэдээлэл холбоо, угсаатан, үзэл суртал, техник технологи, санхүү-эдийн засаг, соёл, аж байдал, хэрэглээний хүрээний орон зайд тэдгээрийн тус бүрт нь тохирсон механизм, арга хэрэгслээр дамжин хэрэгждэг байна. Орчин үед мэдээлэл холбооны техник хэрэгсэл үсрэнгүй хөгжиж дэлхий ертөнцийг ороосон хүчирхэг сүлжээ тор болсон явдал америкжилт төдийгүй даяаршилын нэгэн хүчирхэг хэрэгсэл болж байна. Дүрс, дуу авиа бичлэг, бэлэгдлийн тэмдэг хослосон өндөр

хурд, шилдэг технологи, техник хэрэгсэлд тулгуурласан телевиз, интернет, гар утас болон бусад хэрэгсэл суваг нь америк маягийн амьдрал, аж төрөх ёс, соёлыг дэлхийд үзүүлж харуулах, танилцуулж сурталчилах, харь орны ард иргэд тэдгээрийг бодит байдлын шууд тусгал болгож хүлээн авч танилцах, дур сонирхолтой болж таашаах, дагаж дуурайх явдал америкжилтын чухал талбар юм. Америкжилт нь угсаатны орон зайд аялан жуулчилагсад, иргэдийн цагаачлал, шилжих хөдөлгөөн, гадаадын оюутан суралцагчид, соёл хүмүүнлэг, энх тайван, найрамдлын байгууллагуудын элч төлөөлөгчид, ажилтнуудын хоорондын амьд шууд харилцаа, хамтын ажиллагаагаар дамжин хэрэгждэг. Америкжилт нь үзэл суртлын орон зайд нийгэм-улс төрийн онол сургаал, үзэл санааны тархалт дэлгэрэлтээр дамжих бөгөөд үр дүн нь харьцангуй удаан гардаг, тодорхой цаг хугацаа, сонирхол, оролдлого шаарддаг байна. АНУ-ын эдийн засаг, үйлдвэр, аж ахуйн тэргүүний дэвшилт техник, технологи, капитал, мөнгө нь америкжилтыг тээгч биет тодорхой, материаллаг хэрэгсэл болдог, нөлөөлөл нь дам боловч үр дүнтэй.

Олон түмэнд зориулагдсан, хялбар, стандартчилагдсан америк маягийн өргөн олны соёл (mass culture), тухайлбал кино, хөгжим, DVD, ахуйн хэрэглээний бараа таваар, америк аялгуутай ярианы англи хэл нь америкжилтын нэн их нөлөөтэй хэрэгсэл, тээгч болно. Америкийн соёл өөрийн уугуул шинж чанараа хадаглахын зэрэгцээ дэлхийн бусад соёл, иргэншлийн үнэт зүйл, нөлөөг тусган авч өөрийншүүлдэг нь эргээд бусад соёл, хүмүүсийн аж амьдралд нөлөөлж нэвтрэн дэлгэрэх бололцоог бий болгодог. Тэр нь бие хүн, нийгмийн хэсэг бүлгийн соёл (subculture- субкультура), макро соёлын хэмжээ түвшинд хэрэгжидэг. MTV, Macintosh, McDonalds, Levi's, Coca-Cola, Pepsi, Marlboro, Nike, Adidas, Disney зэрэг америкийн том компаниудын соёлын болон ахуйн өргөн хэрэглээний бараа таваар, унд, хүнсний бүтээгдэхүүн нь өөрийн чанар, хялбар дөхөм хэрэглээ, реклам, зар сурталчилгаагаараа америкжилтыг тээж дэлгэрүүлдэг, гадаад орнуудын хүн ард тэдгээргийг хэрэглэх нь тэдний нийгэмд эзлэх байр суурь, аж амьдралын болон соёлын түвшинг илэрхийлэх үзүүлэлт, нэр хүндийн хэрэг болдог байна. Энэ нь хэрэг дээрээ америкжилтын бодит үйл явцын үзүүлэлт юм.

Америкжилт нь америк маягийн нийгэм, эдийн засаг, улс төр, соёлын амьдралын орчин үеийн эерэг, дэвшилттэй, нийт хүн төрөлхтөний шинжтэй нийтлэг үнэт зүйлс нь дэлхийн бусад үндэстэн, ард түмний амьдралын хөгжил дэвшилд зохих ёсоор нөлөөлж ач тустай байгаа нь эерэг сайн талтай бөгөөд харин



АНУ-ын дэлхийд дангаар нөлөөлж ноёрхох түрэмгий бодлого, байр суурийн хэрэгжилтийн нэгэн чухал хэрэгсэл болж байгаагаараа сөрөг үүрэг, үр дагавартай юм. Америкжилтын энэхүү зөрчилтэй эерэг сөрөг шинж чанар нь нэг талаар түүний цаашдын өрнөл, дэлгэрэлтийг нөхцөлдүүлж байгаа бол нөгөөтэйгүүр нийгэм, улс төрийн байгуулал, хөгжлийн зам, загварыг өөрийнхөөрөө сонгосон, уламжлалт соёл, иргэншил, шашин шүтлэг, үндэсний үнэт зүйлсээ эрхэмлэсэн үндэстэн, ард түмнүүд америкжилтад сөрөг хандаж эсэргүүцэхэд хүргэдэг. Тиймээс америкжилт хэдийгээр тархац, дэлгэрэлттэй байгаа боловч дэлхий бүхэлдээ, түүний үндэстэн ард түмнүүдийн амьдрал тус бүртээ бүрэн америкжихгүй ажээ.

### **Гэрээний онол**

(Contract theory- теория договора)- төр, хууль цааз, эрхийн гарал үүсэл, мөн чанарыг хүмүүсийн хоорондоо байгуулсан ухамсартай гэрээний үр дүн хэмээн тайлбарладаг нийгмийн ба улс төрийн философийн сургаал. Нэлээд тохиолдолд нийгмийн гэрээний онол (social contract theory- теория общественного договора) гэж нэрлэдэг.Түүнийг хэд хэдэн сэтгэгч өөр өөрийн байр сууринаас багагүй ялгаатай томъёолон боловсруулсан байдаг боловч ерөнхий утга санаа, агуулга нь нэгдмэл бөгөөд тэр нь:

1. Хүн өөрийн уг чанараараа жам ёсны, өөрөөс нь салшгүй эрхтэй;
2. Уг эрх нь төр, хууль цааз бий болохоос өмнөх хүмүүсийн байгалийн төлөв байдалд хангагдах баталгаагүй байсан;
3. Хүмүүс төргүй, байгалийн төлөв байдлаас гарч нийгэм, иргэний төлөв байдалд шилжин орох, жам ёсны эрхээ баталгаатай болгох зорилгоор хоорондоо сайн дураар нийгмийн (хамтын) гэрээ байгуулж төр ба хууль цаазыг бий болгосон;
4. Төр засгийн дээд эрх мэдэл ард түмний гарт байна гэсэн үзэл санаа бүхий томъёололтой болно.

Европын философи, нийгэм-улс төрийн сэтгэлгээний түүхэнд нийгмийн гэрээний тухай үзэл санааны үр хөврөл Аристотель, Цицерон, софистууд, Эпикур ба Лукрецийн сургаалаас эхтэй. Дундад зуунд Аквины Фома иргэний төр ба бурханы хот бүхий христийн шашны сүм хийдийн эрх мэдэл, гарал үүсэл, хоорондын харьцааг авч үзээд иргэний төрийг хүмүүс бий болгосон тул түр зуурын, болзмол, хоёр дахь нь Бурхнаас гаралтай, мөнхийн гэжээ.

Нийгмийн гэрээний онолыг Шинэ үеийн Европын сэтгэгчид Г. Гроций, Б. Спиноза, С. Пүфендорф, нэн ялангуяа Т. Гоббс, Ж. Локк, Ж. Руссо нар тусгайлан

авч үзэж цэгцтэй онолын баримтлал болгон хөгжүүлжээ. Нийгмийн гэрээний тухай эдгээр сэтгэгчдийн үзэл баримтлал нь консерватив, либерал, эрс шийдэмгий (радикал) гэсэн үндсэн гурван урсгал чиглэлтэй. Тэдгээр нь гэрээгээр төр байгуулагдахаас өмнөх үеийн хүмүүсийн жам ёсны эрх ба байгалийн төлөв байдал ямар байсан, түүнээс гарсны дараа жам ёсны эрхийг хэр зэрэг хэмжээгээр төрд даатгасан, ард түмний бүрэн эрх хэр зэрэг байх ёстой вэ гэдгээр хоорондоо ялгаатай. Үүнийг Т. Гоббс, Ж. Локк, Б. Спиноза, Ж. Руссо нарын үзэл баримтлалын жишээн дээр тод мэдэж болно. Т. Гоббсын үзэл баримтлал консерватив шинж агуулгатай бөгөөд тэрбээр төр байгуулагдахаас өмнөх хүмүүсийн байгалийн төлөв байдал нь хүн уг шинжээрээ туйлын хувиа бодсон байдгийн улмаас бие биедээ дайсагнасан, <<бүхний эсрэг бүхний дайны>> төлөв байдалтай байсан, хүмүүс энэ байдлаас гарах зорилгоор хоорондоо гэрээ хийж нийгэмд энх тайван тогтоох, гишүүдийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй болгож төрийг байгуулсан бөгөөд үүний дагуу өөрсдийн жам ёсны эрхээ төрд даатгаж шилжүүлж эрх чөлөөгөө хязгаарласан, тиймээс төр хэмжээгүй эрх мэдэлтэй болно гэж үзжээ.

Ж. Локкийн үзэл баримтлал аядуу, либерал шинж агуулгатай. Түүний үзлээр хүмүүс төрд нэгдэж орохдоо өөрсдийн жам ёсны салшгүй эрх болох хувийн эрх чөлөөтэй байх, үг хэлэх, шашин шүтэх, өмчтэй байх эрхээ өөртөө хадгалж үлдээх ба төр тэдгээрт үл халдан хамгаалах ёстой, хүмүүс үүний дагуу жам ёсны эрхийнхээ бага хэсгийг л төрд итгэн найдаж даатгана. Төр хэрэв эл үүргийг үл биелүүлж нийгмийн гэрээг зөрчвөл ард түмэн тийм засгийг үл дэмжин шинэ засгийн газар байгуулах эрх эдлнэ. Локк тийнхүү нийгмийн гэрээний онолдоо ард түмэн бол төр засгийн эрх мэдлийн эх сурвалж болох тухай үзэл санааг илэрхийлжээ.

Б. Спиноза хүмүүс нэг талаар тус бүрийнхээ аюулгүй байдлыг хангах, нөгөөтэйгүүр нийтийн сайн сайхны болон хувийн жам ёсны эрхээ хамтдаа баталгаатай эдлэх зорилгоор төрийг хамтын гэрээгээр байгуулсан учир төр нь хувь хүний аз жаргал ба нийт хүмүүсийн хамтын сайн сайхныг өв тэгш хослуулан хангах үүрэгтэй, төр эл үүрэг, зорилгоо биелүүлэхийн тулд бүрэн эрхтэй, хувь хүмүүс төрд хамтдаа бүрэн захирагддаг байвал зохино, ард түмэн бол засгийн эрх мэдлийн цорын ганц эх сурвалж, <<соён гэгээрсэн эзэн хаан>> нь хүмүүсийн жам ёсны эрх хангагдах баталгаа болно гэжээ.

Руссогийн үзэл баримтлал радикал (эрс) чанартай бөгөөд тэрбээр <<соён гэгээрсэн эзэн хааны>> тухай үзэл санааг сөрж нийгмийн гэрээний үр дүнд ард

түмнээс хүнийссэн төр биш, харин ард түмэн өөрөө өөртэйгөө гэрээ хийсний үр дүн болж ард түмний бүрэн эрх, өөрөө өөрийгөө удирдах улс төрийн ардчилсан байгууламж тогтох ёстой гэжээ.

Нийгмийн гэрээний онол, түүний ард түмний бүрэн эрхийн тухай үзэл санаа XVIII-XIX зууны үеийн Европ ба Америкийн нийгэм-улс төрийн хөгжил, Англи, Франц дахь хэмжээгүй эрхт хаант засгийг түлхэн унагаах, Хойт Америкт үндсэн хуульт бүгд найрамдах засаг бүрэлдэн байгуулагдахад үзэл санааны эх сурвалж бүхий үндэслэл болсон, төр засаг бол бурхан буюу эрхэт тэнгэрээс гаралтай гэсэн дундад зууны үеийн шашны номлолд цохилт болж төр, иргэний нийгэм, хууль цааз, эрхийн тухай сургаалын хөгжилд багагүй нөлөөлжээ.

**Abstract:** The author provides detailed interpretation of the concept and terminologies of “Americanization”, “Classification”, “Methodology”, “Contract theory”, “Historical interpretation”, and publishes in dedication to students and readers in the field of social study.

**Ашигласан ном, материал:**

IPSA Encyclopedia, Kurian (eds) Encyclopedia (2010)

Structuralism and Hermeneutics. W.Y., 1982

Новая философская энциклопедия. В 4-х томах 2-е издание. Том II. М., 2010

Гадамер Х.Г. Истана и метод (Перевод с немецкого). М., 1989

Лодой Г. Шинжлэх ухааны судалгааны логик- арга зүйн асуудлууд (Магистрантур, докторантурын сургалтын хэрэглэгдэхүүн) Хоёр дахь хэвлэл. УБ., 2012

IPSA Encyclopedia, Kurian (eds) Encyclopedia (2010)

Новая философская энциклопедия. В 4-х томах. 2-ое изд. М., 2010, Том II.

Философский энциклопедический словарь. 2-ое изд. М., 1989

Социологическая энциклопедия. В двух томах. Том 1. А-М. М., 2003

Политология: Энциклопедический словарь. М., 2003

Улс төрийн шинжлэх ухаан. Сурах бичиг. Нэмж засварласан хоёр дахь хэвлэл. УБ., 2010

IPSA Encyclopedia, Kurian (eds) Encyclopedia (2010)

King, G. (1988) Unifying political methodology: The Likelibood theory of inference. New York: Cambridge University Press

Moses, J., &c Knutsen, T (2007). Ways of knowing: Competing methodologies in social and political research. London: Palgrave.

Новая философская энциклопедия. В 4-х томах. 2-е издание. Том II. М., 2010

Социологическая энциклопедия. В двух томах. Том 1.А-М. М.,2003

Лодой Г. Шинжлэх ухааны судалгааны логик- арга зүйн асуудлууд  
(Магистрантур, докторантурын сургалтын хэрэглэгдэхүүн) Хоёр дахь хэвлэл.  
УБ., 2012

Философи, арга зүй, шинжлэх ухаан. Орос хэлнээс орчуулсан Ү. Нямдорж.  
УБ.,1976

## ЗОХИОГЧИД

Зохиогчийн нэр	Ажил, албан тушаал	E-mail
С.Базарпүрэв	<i>МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн профессор</i>	bazarpurev.s@gmail.com
Б.Насанбат	<i>МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн докторант</i>	nasaa9990@gmail.com
Г.Цэнд-Аюуш	<i>МУИС, ШУС, Нийгмийн Ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн зөвлөх дэд профессор</i>	tsendayush_g@yahoo.com
М.Мөнхзул	<i>ХААИС-ЭЗБС-ХААХЭЗТэнхимийн ахлах багш</i>	<a href="mailto:munkhzul@mul.s.edu.mn">munkhzul@mul.s.edu.mn</a>
Д.Сүхболд	<i>МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн докторант</i>	<a href="mailto:sukheemodun@yahoo.com">sukheemodun@yahoo.com</a>
Д.Оюунчимэг	<i>МУИС, ШУС, Нийгмийн Ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн ахлах багш</i>	<a href="mailto:oyun_de@yahoo.com">oyun_de@yahoo.com</a>
Ё.Довчин	<i>МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн зөвлөх профессор</i>	<a href="mailto:dovchind@yahoo.com">dovchind@yahoo.com</a>
Г.Адъяадэлгэр	<i>МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн магистрант</i>	<a href="mailto:adiyadelger.6888@gmail.com">adiyadelger.6888@gmail.com</a>
Ц.Батболд	<i>МУИС, ШУС, Нийгмийн Ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн дэд профессор</i>	<a href="mailto:Batbold_uts@yahoo.com">Batbold_uts@yahoo.com</a>
Б.Батбаатар	<i>МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн докторант</i>	<a href="mailto:batbaatar_7466@yahoo.com">batbaatar_7466@yahoo.com</a>
Ч.Өлзийсайхан	<i>МУИС, ШУС, Нийгмийн Ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн профессор</i>	<a href="mailto:Chuluun.ulziisaikhan@yahoo.com">Chuluun.ulziisaikhan@yahoo.com</a>
Д.Ундрах	<i>МУИС, ШУС, Нийгмийн Ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн дэд профессор</i>	<a href="mailto:Ddj_undrakh@yahoo.com">Ddj_undrakh@yahoo.com</a>

Зэн-У Хотта	<i>Японы Токиогийн Их Сургуулийн Шинжлэх Ухаан, Технологийн Ахисан Түвшний Судалгааны Төвийн судлаач</i>	z.hotta@euphoria.co.jp
Масато Эгучи	<i>Японы Токио Хотын Их Сургуулийн Хүмүүнлэгийн Төгсөлтийн дараах Сургуулийн судлаач</i>	eguchimasato@gmail.com
Б. Хишигням	<i>МУИС, ШУС, Боловсрол, сэтгэл судлалын тэнхимийн эрхлэгч</i>	khishignyam@num.edu.mn
Д.Бумдарь	<i>МУИС, ШУС, Нийгмийн Ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн дэд профессор</i>	bumdari@num.edu.mn
Д.Бадамдаш	<i>МУИС, Захиргаа, хүний нөөцийн газрын дарга</i>	<a href="mailto:badamdash@num.edu.mn">badamdash@num.edu.mn</a>
Д.Долгорсүрэн	<i>МУИС, ШУС, Хүмүүнлэгийн Ухааны салбар, Гадаад хэлний төвийн ахлах багш</i>	Doyowith4@yahoo.com
А.Жамбал	<i>ШУА, Философи Эрхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан</i>	

## LIST OF CONTRIBUTORS

Name	Affiliation	E-mail
Bazarpurev Sambuu	<i>Professor, Department of Political Science, National University of Mongolia</i>	bazarpurev.s@gmail.com
Nasanbat Baavgaikhuu	<i>Doctoral student, Department of Political Science, National University of Mongolia</i>	nasaa9990@gmail.com
Tsend-Ayush Galsanpiljee	<i>Senior associate professor, Department of Political Science, National University of Mongolia</i>	tsendayush_g@yahoo.com
Munkhzul Myagmarsuren	<i>Senior lecturer, School of Economics and Business, Mongolian University of Life Sciences</i>	<a href="mailto:munkhzul@mul.edu.mn">munkhzul@mul.edu.mn</a>
Sukhbold Dorjderem	<i>Doctoral student, Department of Political Science, National University of Mongolia</i>	<a href="mailto:sukheemodun@yahoo.com">sukheemodun@yahoo.com</a>
Oyunchimeg Dashdondog	<i>Senior Lecturer, Department of Political Science, National University of Mongolia</i>	<a href="mailto:oyun_de@yahoo.com">oyun_de@yahoo.com</a>
Dovchin Yondon	<i>Senior professor, Department of Political Science, National University of Mongolia</i>	<a href="mailto:dovchind@yahoo.com">dovchind@yahoo.com</a>
Adiyadelger Gantulga	<i>Graduate student, Department of Political Science, National University of Mongolia</i>	<a href="mailto:adiyadelger.6888@gmail.com">adiyadelger.6888@gmail.com</a>
Batbold Tserendash	<i>Associate professor, Department of Political Science, National University of Mongolia</i>	<a href="mailto:Batbold_uts@yahoo.com">Batbold_uts@yahoo.com</a>
Batbaatar Battulga	<i>Doctoral student, Department of Political Science, National University of Mongolia</i>	<a href="mailto:batbaatar_7466@yahoo.com">batbaatar_7466@yahoo.com</a>
Ulziisaikhan Chuluun	<i>Professor, Department of Political Science, National University of Mongolia</i>	<a href="mailto:Chuluun.ulziisaikhan@yahoo.com">Chuluun.ulziisaikhan@yahoo.com</a>

Undrakh Davaadorj	<i>Associate professor, Department of Political Science, National University of Mongolia</i>	<a href="mailto:Ddj_undrakh@yahoo.com">Ddj_undrakh@yahoo.com</a>
Zen-U Hotta	<i>Collaborative Researcher, RCAST, The University of Tokyo, Japan</i>	<a href="mailto:z.hotta@euphoria.co.jp">z.hotta@euphoria.co.jp</a>
Masato Eguchi	<i>Researcher, Graduate School of Humanities, Tokyo Metropolitan University, Japan</i>	<a href="mailto:eguchimasato@gmail.com">eguchimasato@gmail.com</a>
Khishignyam Bazarvaani	<i>Head, Department of Education and Psychology, National University of Mongolia</i>	<a href="mailto:khishignyam@num.edu.mn">khishignyam@num.edu.mn</a>
Bumdari Dagva-Ochir	<i>Associate professor, Department of Political Science, National University of Mongolia</i>	<a href="mailto:bumdari@num.edu.mn">bumdari@num.edu.mn</a>
Badamdash Dashdavaa	<i>Director, Department of Administration and Human Resources, National University of Mongolia</i>	<a href="mailto:badamdash@num.edu.mn">badamdash@num.edu.mn</a>
Dolgorsuren Dorj	<i>Senior Lecturer, Center for foreign languages, National University of Mongolia</i>	<a href="mailto:Doyowith4@yahoo.com">Doyowith4@yahoo.com</a>
Jambal A.	<i>Researcher, Institute of Philosophy, Mongolian Academy of Science</i>	